# МОНГОЛ УЛСЫН
# ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАМЫН ЗУРАГЛАЛ
## 2019-2023

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

International
Trade
Centre

TIR MON 1 - Final_Fi.indd 1 07.05.2020 09:16:10

# ТАЛАРХАЛ

Монголын худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураглал (ХХОЗЗ) нь Монгол Улсын Засгийн газрын ивээл дор, Гадаад харилцааны яам (ГХЯ), Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ)-ын манлайллын хүрээнд боловсруулагдав. Түүнчлэн, төр, хувийн хэвшлийн нийгэмлэгүүдийн үнэт санал, удирдамжид тулгуурлан ХХОЗЗ-ийг боловсруулан бэлтгэв. ХХОЗЗ-ийн загвар боловсруулах шатанд Үндсэн ажлын хэсгийг байгуулсан бөгөөд тэдгээр байгууллагуудыг доор жагсаав. Үүнд:

| Байгууллагууд |
|---|
| Гадаад харилцааны яам |
| Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим |
| Үндэсний хөгжлийн газар |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| Сангийн яам |
| Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам |
| Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам |
| Хууль зүй, дотоод хэргийн яам |
| Зам тээвэр, хөгжлийн яам |
| Барилга, хот байгуулалтын яам |
| Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| Гаалийн ерөнхий газар |
| Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар |
| Оюуны өмчийн газар |
| Үндэсний статистикийн хороо |
| Стандарт, хэмжилзүйн газар |
| Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| Эрчим хүчний зохицуулах хороо |
| Монголын экспортлогчдын холбоо |
| Монголын гаалийн зуучлалын мэргэшсэн холбоо |
| Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөл |
| Мал эмнэлэг, үржлийн газар |
| Хөдөө аж ахуйн бирж |
| Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо |
| Монголын ноос, ноолуурын холбоо |
| Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо |
| Монголын махны холбоо |
| Монголын жимс, жимсгэний үндэсний холбоо |

| Байгууллагууд |
|---|
| Монгол Улсын Хөгжлийн банк |
| Монголын банкны холбоо |
| Монгол Улсын их сургууль |
| Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн их сургууль |
| Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төв |
| Бодлого судлалын төв |
| Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв |
| Снөү фийлдз ХХК |
| Монголын бяслаг урлаачдын холбоо |
| Монос групп |
| Инфосистемз ХХК |
| Тэсо корпораци |
| Могол ноос ХХК |
| Монгол шевро ХК |

Түүнчлэн, төслийн шат бүрд НҮБ -ын Хөгжлийн хөтөлбөр, ДБ, ОУСК, АХБ, ШХА (SDC), ХХМЭА (AVSF), ГОУХАН (GIZ), ХХААБ (FAO), ЯОУХАБ (ЖАЙКА) болон бусад хөгжлийн байгууллагуудын хувь нэмэр, үнэт зөвлөмжийг хүлээн авч тусгасан болно. ЕХ-ны Монгол Улсын худалдааг дэмжих ТРАМ төслийн зүгээс ихээхэн дэмжлэг үзүүллэн ажиллав.

Төслийн үйл ажиллагааны туршид Олон улсын худалдааны төвийн (ОУХТ) төслийн баг техникийн дэмжлэг, удирдамж, чиглэлээр хангаж ажилласан болно.

| Нэр | Албан тушаал | Байгууллага |
|---|---|---|
| Хатагтай. Марион Жансэн | Ахлах, Ерөнхий эдийн засагч, экспортын | ITC |
| стратегийн ажлын алба | ОУХТ | ITC |
| Ноён Антон Саид | Дарга, Худалдааны стратеги хөгжлийн хөтөлбөр | ОУХТ |
| Ноён Эрик Бушот | Төслийн удирдагч | ОУХТ |
| Хатагтай Карла Солис | Төслийн техникийн зөвлөх | ОУХТ |
| Ноён Карлос Гриффин | Олон улсын зөвлөх | ОУХТ |
| Ноён Паул Бэйкэр | Олон улсын зөвлөх | ОУХТ |
| Ноён Дэрэк Карнеги | Олон улсын зөвлөх | ОУХТ |
| Хатагтай Хиба Батүл | Олон улсын зөвлөх | ОУХТ |
| Хатагтай Сэнгэлмаа Дашням | Үндэсний ахлах зөвлөх | ОУХТ |
| Хатагтай Сарангуа Батдорж | Үндэсний зөвлөх | ОУХТ |
| Ноён Дамба Галсандорж | Үндэсний зөвлөх | ОУХТ |
| Ноён Хэзү Алэ | График дизайнер | ОУХТ |
| Туслах Хатагтай Кэндис Уайт ба Ноён Срияаш Махэшвари | | |



Photo: © MFA

# Монгол Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Дамдины Цогтбаатар

Монгол улсын эдийн засгийн өсөлтийг хангаж, өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглах боломжийг бүрдүүлэх таван жилийн иж бүрэн төлөвлөгөө буюу “Худалдаа ба хөрөнгө оруулалтын Замын зураглал”-ийг ийнхүү танилцуулж байгаадаа баяртай байна. Үнэ цэнэтэй мэдлэг туршлагаасаа хуваалцсан Олон улсын худалдааны төвд талархал илэрхийлье.

Монгол Улсын бараа бүтээгдэхүүний экспорт ихээхэн хэмжээгээр нэмэгдэж, гадаад худалдааны эргэлт түүхэнд байгаагүй өндөр дүнтэй гарч буй тохиромжтой цаг үед энэхүү санаачилгыг эхлүүлж байна. Уул уурхайн салбар нь Монгол улсын эдийн засгийн тэргүүн эгнээнд байж, хөрөнгө оруулалт татах, экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд томоохон хувь нэмэр оруулж ирсэн. Гэвч, Монгол Улсын хувьд илүү тогтвортой, нийгмийн оролцоог хангасан эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд экспортын бараа бүтээгдэхүүн болон зорилтот зах зээлээ төрөлжүүлж, эдийн засгаа бүхэлд нь сайжруулах нь нэн чухал болоод байна.

Засгийн газраас уул уурхайн бус салбаруудын үйлдвэрлэл болон экспортыг хөхиүлэн дэмжих зорилгоор “Монгол экспорт хөтөлбөр”-ийг 2018 оны 9 дүгээр сард баталсан. Манай дотоодын үйлдвэрлэгчид олон улсын зах зээлд бараа бүтээгдэхүүнээ экспортлоход нь дэмжлэг үзүүлэх “Монгол экспорт хөтөлбөр”-ийн зорилтууд болон уг “Худалдаа ба хөрөнгө оруулалтын Замын зураглал” харилцан уялдаатай хэрэгжих бүрэн боломжтой юм.

Энэхүү Замын зураглал нь төр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татаж, уул уурхайн бус салбаруудын экспортыг хөхиүлэн дэмжих бодит нөөц бололцоо бүхий тэргүүлэх найман салбарыг тодорхойлон гаргасан. Уламжлалт салбарууд болох ноос, ноолуур, мах, сүү сүүн бүтээгдэхүүн зэрэг салбарт нэмүү өртөг шингээхээс гадна сэргээгдэх эрчим хүч болон мэдээлэл, харилцаа холбооны технологийн харьцангуй шинэ салбаруудыг хөгжүүлэх талаар салбар бүрийн стратеги төлөвлөгөө, бодит зөвлөмжийг Үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөндөө тусгаж өгсөн нь олон улсын зах зээлд тэдгээр салбаруудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чухал алхам болох юм.

Уг Замын зураглалыг төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд, хөгжлийн түншүүд, судалгаа шинжилгээний хүрээлэнгүүд зэрэг холбогдох бүх талуудын дунд зохион байгуулсан санал асуулга, дүн шинжилгээ, олон удаагийн хэлэлцүүлэг, үндэсний зөвлөлдөх уулзалтуудын үр дүнд гарсан ололт дүгнэлтэд тулгуурлан боловсруулсан. Иймд уг Замын зураглалыг боловсруулахад хувь нэмэр оруулсан бүх хүмүүст би талархал илэрхийлэхээс гадна, Олон улсын худалдааны төвд мэдлэг туршлагаасаа хуваалцан, дэмжлэг үзүүлж ажилласанд дахин талархал илэрхийлж байна. Та бүгдийн хамтран ажилласан тэрхүү урам зориг, эрч хүч Замын зураглалыг хэрэгжүүлэх үе шатанд ч мөн үргэлжилнэ гэдэгт итгэлтэй байна.

Та бид өөрсдийн нэгдмэл зорилгын төлөө цаашид хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

# Аранча Гонзалес, Гүйцэтгэх захирал, ОУХТ


Photo: © ITC

Монгол Улс нь худалдаа, хөрөнгө оруулалтын багцаа гүнзгийрүүлэн нэмэгдүүлэх өргөн боломж бүхий улс юм. Баялаг түүх соёл, залуу, эрч хүчээр дүүрэн хүн амтай Монгол Улсад худалдаа, жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварыг хөгжүүлэхэд шаардагдах бүх таатай нөхцөл бүрдээд байна. Нийт хүн амын гуравны хоёр нь 35-аас доош насныхан байдгийн хувьд, залуучуудад хөрөнгө оруулах, тогтвортой ажил эрхлэх боломжийг бүрдүүлэх нь тэргүүлэх зорилт байх учиртай.

Гэвч, ашиг малтмалын баялаг нөөц, хөдөө аж ахуйн боломж бололцоо, боловсрлын түвшин өндөр хүн амыг үл харгалзан, Монгол Улс худалдааны боломжоо бүрэн ашиглаж чадахгүй байна. Экспортын бүтээгдэхүүн болон зах зээлийн хувьд хязгаарлагдмал хүрээнд ажиллаж байгаа тул улс орны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн төрөлжүүлэх, худалдааны түншийн харилцааг идэвхтэйгээр нэмэгдүүлэх шаардлага тулгараад байна. Ашигт малтмал, эрдсийн жишээнээс харахад ийм хязгаарлагдмал экспортын сагс нь үнийн хэлбэлзэлд онцгой мэдрэмтгий байдаг.

Үүнийг хийх хамгийн чухал алхам нь ЖДБ-ууд хөрөнгө оруулалт хийхийн зэрэгцээ, худалдаагаар дамжуулан өргөжих боломжийг хязгаарлаж буй бизнесийн орчны бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд туслах явдал юм. Үүний тулд жижиг бизнесүүдийн зээлжих шаардлагыг хангахгүйгээс үүдэн хязгаарлагддаг санхүүжилтийн бэрхшээл болон хангалттай хөгжөөгүй санхүүгийн системд анхаарал хандуулах шаардлагыг бий болгож байна. Олон улсын стандартын хэрэгжилтийг баталгаажуулах системүүд сул, одоогийн боловсролын систем болон маргаашийн ажлын байранд шаардагдах ур чадварын зөрүү их байгаа зэрэг асуудлуудыг тэргүүн эгнээнд анхаарч шийдвэрлэх нь зүйтэй.

Энэхүү Худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураглал нь дээрх бэрхшээл сорилтуудыг даван туулах шинэ замыг дараах найман салбар дээр тулгуурлан тодорхойлж байна. Эдгээр нь ноолуур, сарлаг, тэмээний ноос, мах, сүүн бүтээгдэхүүн, арьс шир, мэдээлэл, харилцаа холбооны технологи, аялал жуулчлал, сэргээгдэх эрчим хүч, эрдэс боловсруулах салбарууд юм.

Холбогдох хамтрагч байгууллагуудтай хийсэн зөвлөгөөнүүд болон нарийвчилсан судалгааны үр дүнд хөрөнгө оруулалт татаж, дэлхийн эрэлт хэрэгцээг хангах боломжтой гэж үзэн дээрх салбаруудыг онцлон сонголоо. Уг салбарууд нь Монголын гэх онцгой ялгаралыг агуулахын зэрэгцээ, байгаль орчны асуудлыг орхигдуулалгүй хөгжих боломж бүхий салбарууд юм.

Гэхдээ бизнесийн орчны шинэчлэл хийгдсэний үр дүнд эдгээр салбарууддад ажиллагаа явуулдаг бизнесүүд өсч хөгжих боломж бүрдэнэ. Худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого, худалдааг хөнгөвчлөх хүчин чармайлт, стратегийн хөрөнгө оруулалт татах сурталчилгааны ажил, санхүүжилтийн хүртээмжийн сайжруулалт, чанарын удирдлага болон ур чадвар хөгжүүлэх хөтөлбөрүүдэд хийх хөрөнгө оруулалтын асуудлуудад анхаарал хандуулж, хүчин чармайлт гаргаж ажиллах нь зүйтэй.

Тийм учраас бодлогын сайжруулалтаас гадна, энэхүү замын зураглал нь компани аж ахуйн нэгжүүдэд зах зээлийн эрэлт шаардлагуудад нийцэж ажиллан, худалдааны хувьд тогтоосон харилцаагаа тогтворжуулахад нь дэмжлэг үзүүлж чадах хүчтэй худалдаа ба хөрөнгө оруулалтыг дэмжиж ажилладаг байгууллагуудыг бэхжүүлж ажиллахын ач холбогдлыг онцлон тэмдэглэж байна. Бизнесийг дэмжигч орчиноор дамжуулан компаниуд худалдааны чадавхиа сайжруулах, бүтээлч байдлаа хөгжүүлэх, мэдлэгт суурилсан салбарууд руу илүүтэйгээр чиглэх боломжтой.

Монгол Улс амжилтанд хүрэх бүрэн боломжтой. ОУХТ нь хөгжиж буй экспортын салбарууд болон шинээр бизнес эрхлэгч залуучууд, эмэгтэйчүүдийн боломжийг бодит болгон хөгжүүлэх хүрээнд тухайн улсыг нь бүрэн дэмжиж ажиллах болно.

Монгол Улсын Худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураглал нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн манлайлагчдын хамтын ажиллагаа юм. Энэхүү хамтын ажиллагаа нь улсын хөгжилд чухал үүрэгтэй бөгөөд ОУХТ нь Монгол Улсын Үндэсний экспортын стратеги боловсруулахад хамтран ажиллахдаа хэзээд бэлэн гэдгийг илэрхийлэхэд таатай байна.

# АГУУЛГА


ТАЛАРХАЛ 2

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ 7

УДИРТГАЛ 8

ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛОХ ӨСӨЛТ, ХӨГЖИЛ 8

АЛСЫН ХАРАА БА СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД 10

ТЭРГҮҮЛЭХ САЛБАРУУД БОЛОН ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 11

БИД ОДОО ХААНА БАЙНА ВЭ? БУЮУ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ 14

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН 14

ХУДАЛДААНЫ ҮНЭЛГЭЭ 16

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ 19

БИД ЮУНД ХҮРЭХИЙГ ЗОРИХ ВЭ? 23

ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 23

ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДЭМЖИХ СҮЛЖЭЭ 23

БИДЭНД ЮУ СААД БОЛЖ БАЙНА ВЭ? 29

БИД ХЭРХЭН ТЭНД ХҮРЭХ ВЭ? УРАГШЛАХ ЗАМ 32

АЛСЫН ХАРАА: “Өв соёл, бүтээлч сэтгэлгээгээ ашиглан худалдаа, хөрөнгө оруулалтад түшиглэсэн өсөлтийг дэмжих замаар хурдацтай хөгжих эдийн засаг бүхий Монгол улс” 32

ТЭРГҮҮЛЭХ САЛБАРУУД 35

НООЛУУР 35

САРЛАГ, ТЭМЭЭНИЙ НООС 39

АРЬС ШИР 48

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ 51

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ 53

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ 56

ЭРДСИЙН ГҮН БОЛОВСРУУЛАЛТ 57

ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД 59

ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ 63
ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СУРТАЛЧИЛГАА 65
САНХҮҮЖИЛТИЙН ХҮРТЭЭМЖ 67
ЧАНАРЫН УДИРДЛАГА 70
УР ЧАДВАРЫН ХӨГЖИЛ 72
ХЭРЭГЖИЛТИЙН УДИРДЛАГЫН ХАМРАХ ХҮРЭЭ 76
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 79

ХАВСРАЛТ: МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ХЯЗГААРЛАЛТУУД (3С ХАМРАХ ХҮРЭЭ) 121
ӨРСӨЛДӨХ 121
УЯЛДАА ХОЛБООГ ХАНГАХ 122
ӨӨРЧЛӨХ 123
НОМ ЗҮЙ 126

# Товчилсон үгсийн жагсаалт

| | |
|---|---|
| **B2B** | Business to business |
| **CITA** | Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны (CAREC) Нэгдсэн худалдааны хөтөлбөр |
| **ОТ** | Оюу Толгой |
| **БОАЖЯ** | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| **БСШУЯ** | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам |
| **ГЕГ** | Гаалийн ерөнхий газар |
| **ГЗЗХ** | Гаалийн зөвлөх, зуучлагчдын холбоо |
| **ГХЯ** | Гадаад харилцааны яам |
| **ГШХО** | Гадаадын шууд хөрөнгө оруулалт |
| **ДНБ** | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| **ДХБ** | Дэлхийн худалдааны байгууллага |
| **ЕХ** | Европын холбоо |
| **ЖДҮ** | Жижиг, дунд үйлдвэрлэл |
| **ЗБДС** | Зээлийн батлан даалтын сан |
| **ЗТЯ** | Зам тээврийн яам |
| **МБС** | Мэргэжлийн боловсрол, сургалт |
| **МТ** | Мэдээллийн технологи |
| **МУИС** | Монгол Улсын их сургууль |
| **МҮХАҮТ** | Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим |
| **МХЕГ** | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| **МХХТ** | Мэдээлэл, харилцаа холбооны технологи |
| **ОУВС** | Олон улсын валютын сан |
| **ОУНӨС** | Олон улсын нэмүү өртгийн сүлжээ |
| **ОУХТ** | Олон улсын худалдааны төв |
| **СХ** | Судалгаа ба хөгжүүлэлт |
| **ҮХГ** | Үндэсний хөгжлийн газар |
| **ХААИС** | Хөдөө, аж ахуйн их сургууль |
| **ХЕС** | Хөнгөлөлтийн ерөнхий схем |
| **ХЗДХЯ** | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| **ХХААХҮЯ** | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| **ХХИ** | Хүний хөгжлийн индекс |
| **ХХОДБ** | Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллага |
| **ХХОДС** | Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих сүлжээ |
| **ХХОЗЗ** | Худалдаа ба хөрөнгө оруулалтын замын зураглал |
| **ХХХ** | Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр |
| **ЧХХ** | Чөлөөт худалдааны хэлэлцээр |
| **ШУТИС** | Шинжлэх ухаан, технологийн их сургууль |
| **эЗТБ** | Эдийн засгийн тусгай бүс |
| **ЭЗТХ** | Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр |

# Зургийн жагсаалт

**Зураг 1.** ХХОЗЗ-ийн стратегийн цар хүрээ 8
**Зураг 2.** ДНБ-ий өсөлт, жилээр, 2000-17 14
**Зураг 3.** Бодит болон нэрлэсэн ханшийн түвшин (2000/12 = 100), 2000-18 14
**Зураг 4.** Өсөлтийн задаргаа, салбараар 2011-17 15
**Зураг 5.** ДНБ, экспорт ба импорт (A) ДНБ-ий өсөлт 2011-2018Q2 (B) 16
**Зураг 6.** Экспортын өсөлтийн задаргаа 16
**Зураг 7.** Монгол Улсын экспорт, бүсээр 17
**Зураг 8.** Монгол Улсын экспорт, салбараар 18
**Зураг 9.** Эд ангийн экспорт, 2002-2016 18
**Зураг 10.** Экспорт тэсвэрлэх чадавхийн магадлал, 2002-2016 19
**Зураг 11.** ГШХО орох урсгал, 2000-2017 он 20
**Зураг 12.** ГШХО салбараар болон улс орноор, 2017 он 20
**Зураг 13.** Монгол Улсын үндэсний бодлогын хамрах хүрээ 23
**Зураг 14.** Монгол Улс дах ХХОДБ-ын төрлүүд 24
**Зураг 15.** ХХОДБ хоорондын харилцаа 27
**Зураг 16.** Монголын ноолууран бүтээгдэхүүний экспортын боломжит зах зээлүүд 38
**Зураг 17.** Сарлагийн хөөвөр, тэмээний ноос үйлдвэрлэгчдийн нэхмэл, сүлжмэлийн хүчин чадал, хэрэглээ (ширхэгээр), 2014 39
**Зураг 18**. Махны үйлдвэрлэл, боловсруулалтын аргаар, 2006-2015 42
**Зураг 19.** Сүүн бүтээгдэхүүний бизнес эрхэлдэг малчид, фермерүүдэд тулгарч буй асуудлууд 46
**Зураг 20**. Монголын арьс ширний тэргүүлэх боломжит зах зээлүүд 49
**Зураг 21.** Монгол Улсын МХХТ салбарын орчин, 2017 52
**Зураг 22**. Жуулчны экспорт болон ирэх олон улсын жуулчны тоо 54
**Зураг 23**. Монгол Улсын экспортын боломжит зах зээлүүд 61
**Зураг 24.** Худалдааг хөнгөвчлөх индекс, 2017 63
**Зураг 25.** Борлуулалтын 10-аас доошгүй хувийг экспортолсон компаний хувь, хэмжээгээр, 2013 65
**Зураг 26.** Зээллэг, компаниар, 2013 68
**Зураг 27.** Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын баталгаажуулалт бүхий аж ахуйн нэгж, компаниудын хувь, хэмжээ 2013 он 70
**Зураг 28.** Нийт элсэлтийн үнэлгээ боловсролын түвшингээр 73

# Хүснэгтийн жагсаалт


**Хүснэгт 1.** Томоохон ХХОДБ-ын үзүүлдэг онцлог үйлчилгээ 25

**Хүснэгт 2.** ХХОДБ-уудын өөрсдийн тодорхойлсон давуу тал, сул тал, боломж ба аюул занал 26

**Хүснэгт 3.** Чадавхийн өөрийн үнэлгээ 28

**Хүснэгт 4.** Гол сорилтууд 29

**Хүснэгт 5.** Монгол Улсын хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүд 60

**Хүснэгт 6.** Худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого: Гол сорилтууд ба ХХОЗЗ-ийн үйл ажиллагаа 62

**Хүснэгт 7.** Худалдааг хөнгөвчлөх: Гол сорилтууд ба ХХОЗЗ-ийн үйл ажиллагаа 64

**Хүснэгт 8.** Худалдаа, хөрөнгө оруулалтын сурталчилгаа: Гол сорилтууд ба ХХОЗЗ-ийн үйл ажиллагаа 66

**Хүснэгт 9.** Санхүүжилтийн хүртээмж: Гол сорилтууд ба ХХОЗЗ-ийн үйл ажиллагаа 69

**Хүснэгт 10.** Чанарын удирдлага: Гол сорилтууд ба ХХОЗЗ-ийн үйл ажиллагаа 71

**Хүснэгт 11.** Ур чадварын хөгжил: Гол сорилтууд ба ХХОЗЗ-ийн үйл ажиллагаа 74


# Хайрцагны жагсаалт


**Хайрцаг 1**. ОЮУ ТОЛГОЙ УУЛ УУРХАЙН ТӨСӨЛ 20

**Хайрцаг 2.** ТҮЛХҮҮР САНАА 21

**Хайрцаг 3**. ХХОДБ-ЫН ХӨТӨЛБӨР, ҮЙЛЧИЛГЭЭ 26

**Хайрцаг 4**. ЧАДАВХЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 27

**Хайрцаг 5**. МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ 28

**Хайрцаг 6**. ИНСТИТУЦИЙН ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА 29

**Хайрцаг 7**. НООЛУУРЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 37

**Хайрцаг 8**. САРЛАГИЙН ХӨӨВӨР, ТЭМЭЭНИЙ НООСНЫ САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 41

**Хайрцаг 9**. МАХ, БОЛОВСРУУЛСАН МАХНЫ ДЭД САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 43

**Хайрцаг 10**. СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДЭД САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 47

**Хайрцаг 11**. АРЬС ШИРНИЙ САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 51

**Хайрцаг 12**. МХХТ-ИЙН САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 53

**Хайрцаг 13**. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 55

**Хайрцаг 14**. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 57

**Хайрцаг 15**. ЭРДСИЙН ГҮН БОЛОВСРУУЛАЛТЫН САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 58

**Хайрцаг 16**. НОГООН ЭДИЙН ЗАСАГ РУУ 59






Зураг 1. ХХОЗЗ-ийн стратегийн цар хүрээ

# УДИРТГАЛ

## ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛОХ ӨСӨЛТ, ХӨГЖИЛ

Сүүлийн жилүүдэд уул уурхайн төслүүдэд оруулсан хөрөнгө оруулалттай холбоотой Монгол Улсын экспорт хурдацтайгаар өссөний үр дүнд, ДНБ-ий өсөлтийн түвшин хоёр оронтой тоонд хүрлээ. Хэдийгээр энэхүү өсөлт нь түүхий эдийн үнийн хэлбэлзэл, ашигт малтмалын экспортоос хамаарал өндөртэй хэдий ч улс орны нийгэм, эдийн засагт ихээхэн үр өгөөжийг авчирсан үйл явдал юм. Эдийн засгийн салбаруудын хэмжээнд олон улсад нээлттэй байдал, түүний үр ашгийн хуваарилалт жигд бус байгаа тул худалдаа, хөрөнгө оруулалтын боломжит үр ашгийг хараахан хүртээгүй байдалтай байна.

Байгалийн хязгаарлагдмал баялаг, цөөн хүн ам, алслагдсан үйлдвэрлэлийн төвүүд бүхий далайд гарцгүй улс орны хувьд, Монгол Улсын үндэсний хөгжлийн зорилгод хүрэх хамгийн тодорхой алхам бол экспортын хэмжээ болон үнэ цэнийг нэн ялангуяа ЖДҮ-ийн хувьд нэмэгдүүлэхэд оршино. Хөрөнгө оруулалтыг татах нь ашигт малтмал, хөнгөн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбаруудад нэмүү өртгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ төрөлжсөн экспортын зах зээлд үзүүлэх үйлчилгээний болон бусад салбаруудыг хөгжүүлэхэд ижил түвшний ач холбогдолтой юм. Монголын өндөр боловсролтой, чадварлаг, залуу ажиллах хүчний хувьд инновацид суурилсан өсөлтийг улс орондоо бий болгоход өрсөлдөхүйц эхлэлийн цэгийг улс орондоо олгох боломжтой.

Монгол Улсын Засгийн газар нь хувийн хэвшлийнхэнтэй хамтран ажиллах замаар худалдаа, хөрөнгө оруулалтыг өөрийн хөгжлийн хөтөлбөрийн гол тулгуур болгон тодорхойлж, нягт уялдуулснаар нийт эдийн засгийн өсөлтийг дэмжин ажиллах төлөвтэй байна. ХХОЗЗ хэмээх нэгдсэн стратегийн бичиг баримт нь бодлогын нэгдмэл байдал, холбогдох байгууллагуудын уялдаа холбоо болон хувийн хэвшлийн дэмжлэгийг чухалчлан онцлох болно.  Зураг 1-д ХХОЗЗ-ийн стратегийн цар хүрээг харуулав..

**АЛСЫН ХАРАА: “Өв соёл, бүтээлч сэтгэлгээгээ ашиглан худалдаа, хөрөнгө оруулалтад түшиглэсэн өсөлтийг дэмжих замаар хурдацтай хөгжих эдийн засаг бүхий Монгол улс”**

**1** Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг хангах замаар урт хугацааны өсөлтийн замыг бий болгох

**2** Монголын компаниудын хэрэгцээнд тохирсон худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжигч байгууллагуудыг бэхжүүлэх

**3** Зах зээлийн шаардлагад нийцэх, экспортын харилцааг тогтвортой байлгах чиглэлээр компаниудыг чадавхжуулах

**4** Бизнес эрхлэх ур чадвар, гарааны бизнесийн орчин нөхцлийг сайжруулж, мэдлэгт суурилсан салбарууд руу нэвтрэх замаар бүтээлч, бизнес эрхлэлтийг хөхиулэн дэмжих




Ноолуур | Сарлаг, тэмээний ноос | Мах,махан, сүүн бүтээгдэхүүн | Арьс шир | МХХТ | Аялал жуулчлал | Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл | Боловсруулсан эрдэс

- Худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого
- Худалдааг хөнгөвчлөх
- Худалдаа, хөрөнгө оруулалтын сурталчилгаа
- Санхүүжилтийн хүртээмж
- Чанарын удирдлага
- Ур чадварыг хөгжүүлэх

# АЛСЫН ХАРАА БА СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД

ХХОЗЗ-ийн алсын хараа , "Өв соёл, бүтээлч сэтгэлгээгээ ашиглан худалдаа, хөрөнгө оруулалтад түшиглэсэн өсөлтийг дэмжих замаар хурдацтай хөгжих эдийн засаг бүхий Монгол улс"-г бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагуудыг бэхжүүлэх, компаниудыг чадавхижуулах, инноваци, бизнес эрхлэлтийг дэмжих гэсэн 4 чиглэлийн стратегийн зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ.

| | |
|---|---|
| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1: БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫГ ХАНГАХ ЗАМААР УРТ ХУГАЦААНЫ ӨСӨЛТИЙН ЗАМЫГ БИЙ БОЛГОХ | Энэхүү стратегийн зорилт нь Монгол Улсын урт хугацааны өсөлтийг дэмжих хөгжлийн зорилтуудтай уялдсан худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх итгэл үнэмшил бий болгоход чиглэгдэнэ. ХХОЗЗ-ийн хүрээнд худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого, институци, үйлчилгээний түвшинд өөрчлөлт хийх, үйл ажиллагааг нь өргөжүүлэх, төр, хувийн хэвшлийн албан хаагчдыг чадавхижуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хувийн хэвшилтэй ярилцлага, зөвлөгөөн хийх замаар ХХОЗЗ-ийн бодлого боловсруулалт, түүний хэрэгжилтийн ил тод, нээлттэй байдал хангагдана. |
| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2: ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ, ТЭДГЭЭРИЙН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ | Энэхүү стратегийн зорилт нь худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлыг хариуцан, дэмжин ажиллаж буй төр, хувийн хэвшлийн байгууллага (ХХОДБ)-ын чадавхийг бэхжүүлэх замаар Монголын компаниуд олон улсын түвшинд үйл ажиллагаа явуулах, гадаадын компаниудын сонирхлыг Монголруу татах, бизнесийн харилцаа холбоо тогтооход нь дэмжлэг үзүүлэхэд оршино. ХХОЗЗ-ийн хүрээнд эдгээр байгууллагуудын уялдаа холбоог хангах, үүрэг хариуцлагыг сайжруулах, худалдаа, хөрөнгө оруулалт, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хэрэгжүүлж буй шинэ санаачилгуудыг дэмжих зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ. ХХОЗЗ нь чанарын удирдлагын тогтолцоог сайжруулна. |
| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 3: ЗАХ ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА ХАНГАХ, МӨН ЭКСПОРТЫН ХАРИЛЦААГ ТОГТВОРТОЙ БАЙЛГАХ ЧИГЛЭЛЭЭР КОМПАНИУДЫГ ЧАДАВХЖУУЛАХ | Компаниудыг экспортод бэлтгэн олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын боломжуудаас үр шимийг нь хүртэхэд туслах зорилгоор ХХОЗЗ нь хувийн хэвшлийн зохицуулалт, зохион байгуулалтыг дэмжин ажиллана. ЖДҮ-үүдийн хувьд олон улсын нэмүү өртгийн сүлжээнд оролцох боломжийг нь хязгаарлаж буй ур чадварыг нь боловсролын системээр дамжуулан сайжруулах арга хэмжээг ХХОЗЗ-д мөн тусгасан болно. Компаниудын зах зээлд нэвтрэхэд тулгардаг асуудлууд, олон улсын маркетинг болон гадаад зах зээлд гарах боломжуудын талаарх мэдлэгийг нь мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх болон компанийн түвшинд дэмжлэг үзүүлэх замаар сайжруулна. |
| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4: БИЗНЕС ЭРХЛЭХ УР ЧАДВАР, ГАРААНЫ БИЗНЕСИЙН ОРЧИН НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛЖ, МЭДЛЭГТ СУУРИЛСАН САЛБАРУУД РУУ НЭВТРЭХ ЗАМААР ИННОВАЦИ, БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ | ХХОЗЗ нь худалдаа, хөрөнгө оруулалтаар дамжуулан инноваци, бизнес эрхлэлтийг дэмжих, эдийн засгийн төрөлжилтийг эрчимжүүлэх зорилготой. Гарааны бизнес эрхлэгчдэд тулгарч буй эрх зүйн зохицуулалтын саад бэрхшээлийг арилгах, тэдгээрт инкубаторын болон бизнесийн санаагаа бодитоор хэрэгжүүлэхэд чиглэсэн (incubators and accelerators services) үйлчилгээ үзүүлэх зэрэг дэмжлэг үзүүлнэ. Замын зураг нь Монгол Улсын боловсролын системээр дамжуулан бизнес эрхлэлтийн ойлголт, зан төлөвийг хөгжүүлж, бизнес эрхлэх сэтгэлгээг дэмжинэ. ЖДҮ-ийг технологийн дэвшилд хөл нийлүүлж, улмаар нэмүү өртгийн сүлжээнд идэвхитэй оролцогч болгох зорилгоор томоохон компаниудыг гарааны бизнесүүдтэй холбох үйл ажиллагаа дэмжсэн механизмыг бүрдүүлнэ. Түүнчлэн мэдлэгт суурилсан салбарт хөрөнгө оруулалт татаж, энэ салбарт өсөлтийг бий болгоход шаардагдах алхмуудыг тодорхойлов. |

# ТЭРГҮҮЛЭХ САЛБАРУУД БОЛОН ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХХОЗЗ-ийн хүрээнд тэргүүлэх салбаруудыг тодорхойлохдоо олон тооны тоон болон чанарын шинжилгээний параметрүүдийг анхаарах шаардлагатай болсон. Дунд хугацаанд экспорт, хөрөнгө оруулалтын өсөлт нь малын гаралтай бүтээгдэхүүн (ноолуур, сарлаг, тэмээний ноос, мах, боловсруулсан мах, сүүн бүтээгдэхүүн, арьс шир), үйлчилгээний салбар (мэдээлэл, харилцаа холбооны технологи, аялал жуулчлал), Монголын байгалийн нөөцөд тулгуурласан салбарууд (сэргээгдэх эрчим, хүч, боловсруулсан эрдэс баялаг)-аас гарч ирнэ.

- Ноолуур: Ноолуур нь үнэ цэнэ, овор хэмжээний харьцаа өндөр тансаг зэрэглэлийн бүтээгдэхүүн тул экспортлоход маш тохиромжтой бүтээгдэхүүний төрөл юм. Монгол Улсын уур амьсгал, газар нутгийн онцлог нь ямаа өсгөхөд маш тохиромжтой тул Монгол Улсын хувьд ноолуур үйлдвэрлэлхийн салбарт өрсөлдөөний давуу талуудтай. Энэ салбар нь Монгол Улсын эдийн засагт ажлын байр, үйлдвэрлэл болон олон улсын худалдааны чиглэлээр чухал байр сууръ эзэлдэг. Дэлхий нийтээр өсөн нэмэгдэж буй зах зээл, төр, хөгжлийн түншүүдийн дэмжлэг болон дотоодын үйлдвэрлэлийн огцом өсөлттэй холбоотойгоор Монгол Улсын хувьд нэмүү өртөг шингээсэн ноолууран бүтээгдэхүүн экспортлоход таатай нөхцөл байдал үүсээд байна.
- Сарлаг ба тэмээний ноос: Сарлаг, тэмээний ноос нь чанарын хувьд ямааны ноолууртай өрсөлдөхүйц хэмжээний түүхий эд болохын зэрэгцээ сарлаг, тэмээ нь бэлчээрт учруулах хор хөнөөлийн хувьд ямаанаас бага, экологид ээлтэй түүхий эд юм. Дэлхий нийтийн зах зээлийн зан төлөв нь тогтвортой үйлдвэрлэл болон гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүний худалдан авалт руу хандаж байгаа энэ үед сарлаг, тэмээний ноосны салбар нь малчдын орлогыг өсгөх боломж болохын зэрэгцээ Монгол Улсын байгаль орчин, өв соёлыг хамгаалан хадгалахад өндөр ач холбогдолтой салбар юм. Үүнээс гадна дотоодын нэмүү өртөг шингээхэд энэ салбарт ихээхэн боломж байна.
- Мах, боловсруулсан махан болон сүүн бүтээгдэхүүн: Мал аж ахуй эрхлэх урт удаан хугацааны уламжлал, нэг хүнд ноогдох малын тоон үзүүлэлт зэрэг нь мах, боловсруулсан махан бүтээгдэхүүний хувьд Монгол Улсын өрсөлдөөний давуу талуудын нэг юм. Мал аж ахуй нь эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэн, энэ салбарын үйлдвэрлэл нь дотоодын эрэлтээс давсан хэдий ч экспортын боломжийг сайжруулахын тулд чанар, хүнсний аюулгүй байдлын асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр хамтарсан хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. Сүү, сүүн бүтээгдэхүүний салбар нь Монголын эдийн засагт дутахгүй чухал үүрэг гүйцэтгэх салбар юм. Тэр дундаа уламжлалт аргаар боловсруулсан бяслаг нь өндөр зэрэглэлийн экспортын бүтээгдэхүүн болон хөгжих боломжтой. Бяслаг үйлдвэрлэлийг шинэчлэн нэмэгдүүлснээр шар сүүний үйлдвэрлэл, дотоодын өвлийн тэжээлийн үйлдвэрлэл болон бусад үр шим өндөртэй сортын өсөлт зэрэг туслах салбарыг сайжруулах ач холбогдолтой юм.
- Арьс шир: Олон улсын эрэлт хэрэгцээ болон Монгол Улсын мал сүргийн тоо толгой өсөн нэмэгдэж байгаа тул арьс ширний салбар нь Монгол Улсын хувьд ихээхэн боломж агуулсан салбар юм. Олон тооны залуучууд, эмэгтэйчүүдийг боловсруулах үйл ажиллагаандаа ажиллуулдгаараа арьс ширний салбар нь нийгэм, эдийн засгийн ач холбогдол өндөртэй. Түүнчлэн, энэ салбар нь түүхий эд боловсруулан, дотоодын нэмүү өртөг шингээх боломжийг олгож байна.
- МХХТ: 1990-ээд онд хийгдсэн либералчлалаас хойш Монгол Улсын МХХТ-ийн салбар нь үсрэнгүй хөгжсөн. Харьцангуй сайн хөгжсөн дэд бүтэц, залуу, боловсрол сайтай хүн амтай тул энэ салбарт хөрөнгө оруулалтыг татах боломж өндөр юм. Салбарын цаашдын хөгжил нь Монголын компаниудад үйлчилгээний экспортын боломжийг нээж өгөх боломжтой бөгөөд эдийн засгийн бусад салбарт МХХТ-г үргэлжлүүлэн нэгтгэх нь бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.
- Аялал жуулчлал: Монгол орны байгалийн өвөрмөц тогтоц, соёл, нүүдэлчин амьдралын хэв маяг нь аялал жуулчлалын салбарын хувьд ихээхэн сонирхол татдаг бөгөөд морь, тэмээ унах, ан агнуур, загасчлал гэх мэт олон чиглэлээр аялал жуулчлал татахуйц газар болдог. Салбар нь дотооддоо ч ач холбогдлын хувьд ихээхэн өсч буй бөгөөд тогтвортой хөгжлийн зарчмууд, үндэсний бодлогын зорилтуудтай уялдуулбал улсын эдийн засагт хүртээмжтэй өсөлтийг дагуулж, ядуурлыг бууруулах хөдөлгүүр болох боломжтой.
- Сэргээгдэх эрчим хүч: Монгол Улс нь өргөн уудам тал нутгийн салхи, нарны эрчим хүчний нөөц арвин тул сэргээгдэх эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт татах бүрэн боломжтой.




Photo: ©Ministry of Foreign Affairs

Түүнчлэн цэвэр эрчим хүчээр хангах, эрчим хүчний аюулгүй байдлыг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад өндөр ач холбогдолтой тул төр засгийн зүгээс энэ салбарыг чухалчлан дэмжиж байна. Монгол Улс нь сэргээгдэх эрчим хүчний ихээхэн боломжтой улс орон болохын хувьд Азийн Супер Сүлжээг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэн, бүсийн бусад улс орнууд болох БНХАУ, ОХУ, Япон, БНСУ зэрэгт ногоон эрчим хүч экспортлох боломжтой.

- Эрдсийн гүн боловсруулалт: Монголын ашигт малтмалын нөөц баялаг, уул уурхайн бүтээгдэхүүний дэхийн хамгийн том хэрэглэгчдийн ойролцоох байршил зэрэг нь уул уурхайн салбар нь эдийн засгийн гол хэсэг, экспортын гол эх үүсвэр болоход нөлөөлдөг. Гэсэн хэдий ч энэ салбарын үйл ажиллагаа нь түүхий эдийн олборлолт, анхан шатны боловсруулалтын хэмжээнд л явагддаг бөгөөд улс орны хэмжээнд хувиргалт үйлдвэрлэлийн түвшин хангалтгүй байдалтай байна. Монгол Улсын өргөн уудам нөөц баялаг дээр түшиглэн, гүн боловсруулсан эрдсийн салбар, тэр дундаа зэс, алтны боловсруулалт хийх замаар нэмүү өртөгийг дэмжих боломжтой.

Дээр тодорхойлсон тэргүүлэх салбаруудаас гадна худалдаа, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх зургаан чиг үүргийг экспортын хөгжлийг дэмжиж Монгол Улсын эдийн засгийн бүхий л салбаруудад хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаанд тэргүүлэх ач холбогдолтой хэмээн тодорхойлсон. Эдгээр дэмжих чиг үүргүүдийн гурав нь олон улсын зах зээл, боломжийг нээхэд тулгардаг асуудлууд (худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого, худалдааг хөнгөвчлөх, худалдаа, хөрөнгө оруулалтын сурталчилгаа) бол үлдсэн гурав нь худалдаа хөрөнгө оруулалттай холбоотой компаниудын ур чадваруудад нөлөөлөх асуудал юм (санхүүжилтийн хүртээмж, чанарын удирдлага болон ур чадварыг хөгжүүлэх зэрэг).

- Худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого: Олон улсын хэлэлцээрүүд, дотоодын шинэчлэлүүдийн үр дүнд Монгол Улс нь гадагшаа чиг хандлагатай эдийн засаг бүхий улс орон болсон. Гэсэн хэдий ч урьдчилан таамаглах боломж, олон улсын гэрээ хэлэлцээрийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогыг бэхжүүлэх, институцийдыг бэхжүүлэх, үндэсний бодлогын зорилтуудыг томъёолж, тэдгээрт хүрэх ажлыг цаашид сайжруулах шаардлагатай байна.
- Худалдааг хөнгөвчлөх: ХХОЗЗ нь Монгол Улсын хүлээсэн үүргийн хэрэгжилтийг дэмжиж, зохицуулалтын хүрээг хялбаршуулахын тулд экспортлогчид хил дамнасан систем дэх орчин үеийн, үр ашигтай горимоос үр ашиг хүртэх боломжийг дэмжих болон нэгдсэн зохицуулалт бүхий үндэсний нэг цонхны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлдэг.
- Худалдаа, хөрөнгө оруулалтын сурталчилгаа: ХХОЗЗ-ийн хүрээнд бүтээгдэхүүн, зах зээлийн төрөлжүүлэлтийг дэмжих, олон улсын үнэ цэнийн сүлжээн дэх Монголын компаниудын оролцоог нэмэгдүүлэх, дотоодын нэмүү өртгийг нэмэгдүүлэх зорилгоор худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагуудын (ХХОДБ) чадавх ба зохицуулалтыг сайжруулна.
- Санхүүжилтийн хүртээмж: Санхүүгийн үйлчилгээний хүртээмж сайжирснаар Монголын ЖДҮ-үүд нь экспортын үйл ажиллагааг эхлүүлэх, өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх, зах зээлийн шинэ хандлага, шаардлагыг хангах, шинэ болон дэвшилтэт бүтээгдэхүүний стандартыг дагаж мөрдөх боломжийг бүрдүүлэх боломжтой юм.
- Чанарын удирдлага: Чанарыг бэхжүүлэх, олон улсын стандартыг дагаж мөрдөх нь экспортыг өсгөх, Монголын компаниудын өрсөлдах чадварыг дээшлүүлэх, шинэ хөрөнгө оруулалтыг татахад чухал ач холбогдолтой юм. Дээрх асуудлуудыг шийдэхдээ ХХОЗЗ нь экспортлогчдод шинэ зах зээл, бүтээгдэхүүнийг өргөжүүлэх болон одоо байгаа зах зээл дэх бизнесийн харилцааг бэхжүүлэх боломжийг олгоно.
- Ур чадварыг хөгжүүлэх: Монгол Улсын хүн ам нь харьцангуй боловсролын түвшин өндөр боловч боловсрол, сургалтын хөтөлбөрийг хувийн хэвшлийн хэрэгцээ шаардлагатай уялдуулах, бизнес эрхлэлтийн боловсролыг дэмжихэд илүү хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна.

ХХОЗЗ-ийн алсын хараагы биелэлт нь Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтээс хамаарна. ХХОЗЗ-ийг дээд түвшинд дэмжиж хүлээн авснаар дээд түвшний зөвлөлийн манлайлал дор дотоодын болон олон улсын дэмжлэгийг дайчлах боломж бий болно. ХХОЗЗ-ийн удирдлага, хэрэгжилтэд мониторингийн хэрэгслүүд, хэрэгжүүлэгч институцийдын хамтын ажиллагаа, хувийн хэвшлийн оролцоо, нөөц боломж, харилцаа холбооны төлөвлөлт зэрэг нь маш чухал юм.



Photo: CC Public Domain



Photo: Mongolian cashmere, ©Gobi YAMA brand

# БИД ОДОО ХААНА БАЙНА ВЭ? БУЮУ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын макро эдийн засгийн орчин, худалдаа, хөрөнгө оруулалтын үзүүлэлтүүдтэй холбоотойгоор дараах чиг хандлагууд ажиглагдаж байна. Олон чухал сайжруулалтууд хийгдсэн хэдий ч ХХОЗЗ-ийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн хүрээнд экспортын үйл ажиллагааг төрөлжүүлэн нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг татах замаар тогтвортой, хүртээмжтэй өсөлтөд шаардагдах бусад асуудлуудыг авч үзэв.

## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

Монголын эдийн засгийн өсөлт нь огцом өсөлт, уналтын давтамжит циклийн нөлөөнд өртөмтгий байсаар байна. Хэдийгээр ДНБ-ий өсөлт сайн байгаа хэдий ч, эдийн засаг нь уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай хэвээр байгаа тул тогтворгүй байдалтай байна. 2011 оны өндөр өсөлт нь улс оронд өрнөсөн уул уурхайн огцом идэвхижилтэй шууд холбоотой байсан бөгөөд түүхий эдийн үнийн өсөлт саарсан, засгийн газар болон хөрөнгө оруулагч хоорондын маргааны асуудал болон гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) буурсан зэрэг шалтгаануудтай холбоотойгоор түүний дараах жилүүдэд эдийн засгийн өсөлт удаашрав. [1] Нүүрсний экспорт, уул уурхайн салбар дах ГШХО болон бизнес эрхлэгчдийн төсөөллийн төлөв сайжирсан зэрэгтэй холбоотойгоор 2017 онд ДНБ-ий өсөлт 5.3 хувьд хүрч сэргэлээ.[2]

Зураг 2. ДНБ-ий өсөлт, жилээр, 2000-17




***Эх сурвалж: Дэлхийн банк*.**

Монгол Улсын валютын бодит ханш тогтворгүй байв Ашигт малтмалын экспорттой холбоотойгоор 2008 оны эхээр чангарч байсан төгрөгийн ханш сүүлийн үед буурах болсон хөрөнгө оруулалттай холбоотойгоор ам.долларын эсрэг суларсан. 2016 онд төгрөг түүхэн хамгийн доод түвшиндээ хүрсэн бөгөөд дэлхийн хамгийн эрчимтэй суларсан валютаар тодров.[3] 2014 онд хоёр оронтой тоонд хүрч байсан үетэй харьцуулахад инфляцийн түвшин тогтвортой байгаа боловч 2016 онд бага болон сөрөг тоонд байсан ХҮИ-ийн түвшин 2018 оны 8-р сараас хурдацтайгаар өсч, 5 хувь давсан байдалтай байна.

**Зураг 3.** Бодит болон нэрлэсэн ханшийн түвшин (2000/12 = 100), 2000-18




***Эх сурвалж:*** Монгол банк.

Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтүүд нь үйлдвэрлэл, үйлчилгээг илүүтэйгээр дэмжих болсон. Үйлчилгээний салбар нь Монгол Улсад хамгийн томд тооцогддог бөгөөд 2017 онд нийт нэмэгдсэн өртгийн 46.5 хувийг эзэлж байна. Үйлчилгээний салбар нь ажил эрхлэлтийн хувьд мөн чухал ач холбогдолтой салбар болж, 2017 онд ажил эрхлэлтийн 50.5 хувийг эзэлсэн байдалтай байна. Хэдийгээр хамгийн том салбар нь биш боловч, уул уурхай, олборлолтын салбар нь өнгөрсөн долоон жилийн гуравт нь нийт нэмэгдсэн өртгийн өсөлтөд хамгийн их хувь нэмэр оруулсан байдаг. 1990-ээд оны дунд үеэс хойш хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасчлал ДНБ-д эзлэх хувиар буурсан.

**Зураг 4.** Өсөлтийн задаргаа, салбараар 2011-17




***Эх сурвалж:*** Статистик мэдээллийн нэгдсэн сан.

[1]KPMG (2016). Хөрөнгө оруулалт Монголд. (p.10) & https://www.bbc.com/news/business-37103608
[2]World Bank (2019). The World Bank in Mongolia. Available from : http://www.worldbank.org/en/country/mongolia/overview
[3]World Bank (2019). World Bank Data https://www.bbc.com/news/business-37103608

Нийгмийн хөгжлийн сайжруулалт хийгдсэн боловч эдийн засгийн өсөлт бүх иргэдэд үр өгөөжөө өгсөнгүй. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын хүний хөгжлийн индекс (ХХИ)-ийн үзүүлэлт сайжирч, 2018 онд нийт 151 орноос 92-р байранд орсон нь амьжиргааны нөхцөл байдал, тэр дундаа боловсрол, нэг хүнд ноогдох орлого сайжирч байгаагийн илрэл юм. Хэдий тийм ч, 2017 онд Ази тивдээ ажилгүйдлийн түвшин хамгийн өндөр буюу 7.3 хувьтай гарсан байна. 2010-2014 оны эдийн засгийн өсөлтийг даган ядуурлын түвшин буурсан боловч, түүнээс хойш өссөн үзүүлэлттэй байна. Ядуурлын түвшин хөдөө орон нутаг, тэр дундаа орон нутагтаа хамгийн өндөр түвшинд байдаг зүүн бүсийн аймгуудаар өндөр үзүүлэлттэй байна.



Photo: (cc) wikimedia commons

# ХУДАЛДААНЫ ҮНЭЛГЭЭ

Худалдаа нь уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай хэдий ч өсөлтийн хөдөлгүүр хэвээр байна. Монгол Улсын ДНБ хоёр оронтой тоогоор өсч байхад худалдааны хэмжээ түүнээс ч илүү хурдацтайгаар өссөн нь 2017 онд худалдаа, ДНБ-ний харьцаа 116.6%-д хүрсэн байдлаас харагдаж байна. Худалдааны өсөлт нь ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортыг БНХАУ-руу экспортлох үйл ажиллагааг эрчимжүүлсэн Оюу Толгой төслийн хэрэгжилттэй ихээхэн холбоотой. Ийнхүү гадагшаа чиглэсэн хандлага нь эдийн засгийг түүхий эдийн үнийн өөрчлөлтөд мэдрэг болгож, ДНБ-ний түвшинд ихээхэн хэлбэлзэл үүсгэдэг хэдий ч, худалдааны үр дүнгээр бий болсон өсөлт нь урт хугацаандаа илүү тогтвортой үр дүн өгдөг. Гадны компаниуд бие даасан байдлаар ажилладаг хөгжиж буй орнуудын жишээнд, олборлох салбар нь орон нутгийн компаниуд болон тухайн орон нутгийн санхүүгийн салбартай нягт хамтын ажиллагаа хөгжүүлэн ажилладаггүй байна..

**Зураг 5.** ДНБ, экспорт ба импорт (A) ДНБ-ий өсөлт 2011-2018Q2 (B)

| A. | B. |
| --- | --- |
|  |  |





***Эх сурвалж:*** ОУВС-ийн Дэлхийн эдийн засгийн тойм мэдээллийн сан, 2018 оны 8-р сард ашигласан; Дэлхийн Банкны Дэлхийн Хөгжлийн Үзүүлэлтүүд, 2018 оны 8-р сард нэвтэрсэн; ОУХТ-ын тооцоо; ОУВС (2018) Улс орны тайлан.

Монгол Улс бүтээгдэхүүн болон зах зээлд шинэчлэл хийхээс илүүтэйгээр уламжлалт бүтээгдэхүүний өсөлтийг хангасан байна. ***бүтээгдэхүүнийг хуучин зах зээлд экспортлох явдлаар хязгаарлагдаж байгаа бөгөөд (ихэнхидээ ашигт малтмалын экспортыг БНХАУ, ОХУ-руу) шинэ бүтээгдэхүүнийг шинэ зах зээлд нийлүүлсэн байдлын эзлэх хувь 0.01% байна. (Зураг 6).***

Зураг 6. Экспортын өсөлтийн задаргаа




***Эх сурвалж:*** ОУХТ-ийн тооцоолол.

Монголын цөөн нэр төрлийн худалдаа нь худалдааны эргэлтийг эрс бууруулж, эрсдэлийг нэмэгдүүлдэг. БНХАУ нь Монгол Улсын экспортын сагсыг давамгайлж, 2017 оны байдлаар Монгол Улсаас 5.2 тэрбум ам.доллар (84.2%)[4] -ын бараа бүтээгдэхүүн худалдан авсан байна. Швейцарь улс 2011 онд Монгол Улсын хоёр дахь том экспортлогч улс болсон бөгөөд үүнд алтны үйлдвэрлэлийн өсөлт нөлөөлжээ. Япон улстай байгуулсан ЭЗТХэлэлцээрийн хүрээнд экспортын зах зээлийг төрөлжүүлж, ялангуяа ноолуур болон малын үс зэрэг ЖДҮ-ийн эрчимжсэн салбаруудад боломж олгож байна. ХЕС+ хөтөлбөрийг үл харгалзан ЕХ-ны зах зээлийн ашиглалт хангалтгүй түвшинд байсаар байна.

**Зураг 7.** Монгол Улсын экспорт, бүсээр




***Эх сурвалж:*** Массачюсетсийн технологийн институт (MIT) Медиа лаб.

[4]Mirror data

Ашигт малтмалын бүтээгдэхүүний худалдааны төвлөрөл нь Монголын эдийн засгийг түүхий эдийн үнийн савалгаанд мэдрэмтгий байдлыг нэмэгдүүлдэг. Ашигт малтмалын бүтээгдэхүүн Монголын экспортын 90%-ийг эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн 90% нь БНХАУ-руу экспортлогддог.[5] Макро эдийн засгийн хэсэгт дурьдсанчилан нэг улсаас ихээхэн хамааралтай байгаа нь валютын ханшийн хэлбэлзэл, огцом өсөлт, уналтын мөчлөг зэрэгт сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улс олон улсын үнэ цэнийн сүлжээнд оролцоо бага байдаг (ОУҮЦС). Монгол Улсын хувьд алтны экспортоос бүрдсэн үнэт чулууны ангиллыг эс тооцвол, экспортын нэг хувьтай тэнцэх цөөн нэр төрлийн бүтээгдэхүүнийг хагас боловсруулсан гэж ангилдаг.

**Зураг 8.** Монгол Улсын экспорт, салбараар




***Эх сурвалж:*** МТИ Медиа Лаб.

[5]IMF (2015). From Natural Resource Boom to Sustainable Economic Growth: Lessons for Mongolia. (p.4)

**Зураг 9.** Эд ангийн экспорт, 2002-2016




***Эх сурвалж:*** ОУХТ-ийн тооцоолол

Монгол Улсын экспортын тэсвэрлэх чадвар маш муу. Энэ нь санхүүгийн хүртээмжтэй байдал хангалтгүй, дэд бүтэц муу, бүтээгдэхүүний чанар муу, найдвартай байдал хангалтгүй зэрэг улс орны бизнесийн орчинд тулгарч буй далд асуудлуудын илэрхийлэл байдаг. Эдгээр асуудлуудаас шалтгаалан, компаниудад шинэ зах зээлд хүрэх, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, экспортын харилцааг хэвийн хадгалахад нь бэрхшээл тулгардаг.

Монгол Улсад ашигт малтмалын бүтээгдэхүүн болон цөөн зах зээлээс хараат байдлыг халж экспортын сагсаа төрөлжүүлэх боломж, боломцоо байна. Өндөр боломжийг агуулах уламжлалт бус бүтээгдэхүүнүүдэд малын үс, ноолуур, мах, самар, буудай зэрэг орно. Эдгээр боломжийг бүрэн ашиглахын тулд олон улсын эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн арга хэмжээ (SPS)-г дагаж мөрдөж буй байдлыг сайжруулах, үндэсний чанарын дэд бүтцийг бий болгох шаардлагатай байна. Экспортын зах зээлийн хувьд БНСВУ, БНХАУ-ын Тайван, Индонези зэрэг улсууд нь Монгол Улс худалдаагаа хөгжүүлэх чиглэлээр онилох ёстой зах зээлүүдийг төлөөлнө. Үүнээс гадна Монгол Улсад худалдааны хөнгөлөлттэй нөхцлийг олгодог ХЕС+ нь ЕХ-ны зах зээлд нэвтрэх томоохон боломж боловч, энэхүү схемийн ашиглалт хангалтгүй байна.

**Зураг 10.** Экспорт тэсвэрлэх чадавхийн магадлал, 2002-2016




***Эх сурвалж:*** ОУХТ-ийн тооцоолол.

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ

ІСүүлийн арван жилийн хугацаанд ГШХО-ын хэмжээ өндөр боловч тогтворгүй байв. Засгийн газар уул уурхайн салбарыг гадаадын хөрөнгө оруулалтад нээсэнтэй холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалт 2000 оны сүүлээр өссөн. Үүний нэг жишээ болох Оюу Толгой том хэмжээний төсөл нь орж ирж буй хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэхээс гадна Монгол Улсыг хөрөнгө оруулалт хийх боломжит газар болгон олон улсад таниулахад ихээхэн хувь нэмэр оруулсан.

## **Хайрцаг 1.** ОЮУ ТОЛГОЙ УУЛ УУРХАЙН ТӨСӨЛ

Рио Тинто тэргүүтэй хэд хэдэн гадаадын хөрөнгө оруулагч болон Монгол Улсын Засгийн газрын хамтран хэрэгжүүлж буй олон тэрбум ам.долларын Оюу Толгойн зэс, алтны уурхайн төсөл нь дэлхийн олборлох аж үйлдвэрийн томоохон төслүүдийн нэг юм. Энэ төсөл нь Монголын эдийн засагт чухал үүрэгтэй. ОТ нь нийт 1,146 бэлтгэн нийлүүлэгчидтэй бөгөөд тэдгээр нь шууд болон шууд бусаар нийт 55,000 ажлын байрыг бий болгодог. Анхны хөрөнгө оруулагч Айвенхоу Майнзийн санал болгосон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр 2.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын дараа бүрэн ажиллагаатай болохоор тусгагдсан боловч Рио Тинтотой нэгдсэнээс хойш нийт хөрөнгө оруулалтын хэмжээг 10 тэрбум илүү ам.доллар байна гэж тэмдэглэсэн. Эдгээр хөрөнгө оруулалтын ирээдүйн өгөөж болон Монгол Улс төслөөс үр ашиг хүртэх цаг хугацаа нь тодорхойгүй байдалтай байна

ДНБ ба нийт капиталын бүтцэд хамаарах ГШХО-ын урсгал 2011 онд хамгийн оргил хэмжээндээ хүрсэн бөгөөд 2012 онд уул уурхай болон бусад салбаруудыг стратегийн ач холбогдолтой салбарууд хэмээн зарлаж, тэдгээр салбарууд, тэр дундаа эрдэс баялаг, банк, санхүү, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо гэсэн салбаруудад гадаадын хувийн болон төрийн эзэмшлийн компаниуд хөрөнгө оруулах үйл ажиллагааг хязгаарласан хууль болох Стратегийн ач холбогдолтой салбаруудад гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг баталснаар ГШХО буурсан (Зураг 11).[6] 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдөр "Хөрөнгө оруулалтын хууль"-ийг шинэчлэн баталснаар тус хуулийг хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2016 онд бодлогын болон хууль эрх зүйн тодорхойгүй байдал, түүхий эдийн үнийн уналт, зарим төслүүдээс ашиг татаалт хийсэн зэрэг хэд хэдэн хүчин зүйлсийн үр дүнд гадаадын олон үндэстэн дамнасан компаниудын компани хоорондын зээллэгтэй холбоотойгоор орж ирэх урсгал сөрөг утгатай болсон.[7]

Монгол Улс ГШХО татаж байгаа салбар болон улс орны төвлөрөл өндөр байна. Хэдийгээр Засгийн газар эдийн засгийн төрөлжилтийг дэмжихэд ГШХО гол үүрэг гүйцэтгэдэг болохыг хүлээн зөвшөөрч байгаа боловч өнөөг хүртэл Монгол Улс уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг ихээр татаж, барилга, аялал жуулчлал, бусад үйлчилгээний хөрөнгө оруулалт багахан хэмжээнд байсаар байна Уул уурхайн бус ГШХО нь газарзүйн хувьд төвлөрөл өндөртэй бөгөөд дийлэнхи нь Улаанбаатар хотод хийгдэж байна[8]. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь улс орны төвлөрлийн хувьд мөн өндөр байгаа бөгөөд, ихэвчлэн БНХАУ, Канадаас орж ирсэн байна.

**Зураг 11.** ГШХО орох урсгал, 2000-2017 он




***Эх сурвалж:*** НҮБХХБХ стат.

**Зураг 12.** ГШХО салбараар болон улс орноор, 2017 он




***Эх сурвалж:*** Монгол банк

[6] IFC (2018) Investment Reform Map for Mongolia. A Foundation for a new Investment Policy & Promotion Strategy.
[7] UNCTAD (2017) World Investment Report 2017. (p.87)
[8] UNCTAD (2013) Investment Policy Review – Mongolia 2013. (p. 1)

Засгийн газрын зүгээс хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн алхмуудыг авч хэрэгжүүлсэн. ОУВС-ийн 434 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл болон дараах хэд хэдэн шинэчлэлтэй холбоотойгоор 2017 онд ГШХО-ын орох урсгал сайжрав. Үүнд: авлага, санхүүгийн түрээс, барьцаа хөрөнгийн борлуулалтын зохицуулалтыг сайжруулах чиглэлээр, тэдгээрийг барьцааны бүртгэлд бүртгэж байхыг шаардах Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай шинэ хууль. Түүнчлэн АНУ-тай хийсэн олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаархи ил тод байдлын тухай гэрээ 2017 онд хүчин төгөлдөр болсон хэдий ч түүнээс хойш хийгдсэн газрын эрх болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, татвар зэрэг хэд хэдэн асуудлын хүрээнд хийгдсэн томоохон өөрчлөлтүүдийг хийхдээ, үүний өмнө биелүүлсэн байх шаардлагатай байдаг олон нийтийн түвшний зөвлөгөөн, зардал, үр ашгийн тооцоо зэргийг гүйцэтгэлгүйгээр хийсэн байдаг. Анхаарал хандуулах дараагийн асуудал нь хөрөнгө оруулагчид хамгийн багадаа 100,000 ам.долларын хөрөнгө оруулах ёстой гэсэн шаардлага бөгөөд энэ нь үндэсний тааламжтай нөхцөл болон хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлтэй зөрчилдөж байгаа юм. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.5."гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуйн нэгжийг хэлнэ

## **Хайрцаг 2.** ТҮЛХҮҮР САНАА

**Тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг төрөлжүүлэлт болон инновациар дэмжинэ.** Өнгөрсөн 10 жилийн хугацаанд экспортын өсөлт нь зөвхөн зэс, нүүрс, алт гэсэн уламжлалт бүтээгдэхүүний арилжааг эрчимжүүлэх замаар бий болсон. Орон нутгийн эдийн засагтай тэдийлэн нягт уялдаа холбоогүй. Өсөлтийг дэмжиж, өрсөлдөх чадвараа улам сайжруулан нэмэгдүүлэх үүднээс Монгол Улсыг илүү шинэлэг, мэдлэгт суурилсан эдийн засагт шилжүүлэх ойрын зорилттойгоор улсын хэмжээнд бүтээгдэхүүнээ төрөлжүүлэх хэрэгцээ тулгамдаад байна. Шинэ зах зээл болон хурдан өсөж буй зах зээлд экспортлох нь мөн чухал юм. Хөрөнгө оруулалтын төрөлжилт - салбар болон улсуудын хувьд - ингэснээр өөрчлөлтийг авчирна.

**Экспортын өрсөлдөх чадварыг сайжруулж, шинэ зах зээлд нэвтрэхийн тулд худалдааны бодлого, чанарын удирдлага зэрэг асуудлуудыг шийдвэрлэх нь чухал.** Дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах болон үйлдвэрлэлийн гарцыг нэмэгдүүлэхэд шаардагдах үндсэн хөрөнгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр зорилтот чиглэлүүдэд худалдааны бодлогын хэрэгслүүд, тэр дундаа импортын хураамжийг өөрчлөх шаардлагатай.

**Хүчин төгөлдөр үйлчилж байгаа худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүдийн хүрээнд хийх ажлыг нэмэгдүүлэх боломжтойн зэрэгцээ шинэ хэлэлцээрүүд үр ашгийг авчирна.** Япон улстай байгуулсан ЧХХ-ийн хүрээнд Японы талаас нээлттэй салбаруудад нь Монгол Улс тэдийлэн өрсөлдөхүйц биш хэдий ч, ЧХХ-ийн хүрээнд бий болж байгаа шинэ зах зээлийн боломжийг ашиглаж чадах эсэхээс энэхүү ЧХХ нь Монгол Улсын хувьд амжилттай хэлэлцээр гэгдэх эсэх нь хамаарна. Шинэ гэрээ, хэлэлцээрүүдийг ч мөн эрэлхийлэх; БНХАУ нь ЧХХ-тэй байх хамгийн боломжит түнш бөгөөд ингэснээр нэхмэл, арьс шир гэх мэт уул уурхайн бус салбарыг нэмэгдүүлж, бүс нутгийн өртгийн сүлжээнд нэгтгэх ач холбогдолтой юм. Бусад боломжит түншүүд - Засгийн газрын зүгээс БНСУ, Евроазийн эдийн засгийн хамтын нийгэмлэгүүдийг судалж байна.

**Институцийн хязгаарлалт нь худалдаа ба хөрөнгө оруулалтын үр ашгийг хязгаарладаг.** Сүүлийн жилүүдэд олон улсын хөрөнгө оруулалтын урсгалыг нээлттэй болгосон шинэчлэлүүд нь Монголын эдийн засгийн олон улсын гарцад сайн нөлөө үзүүлсэн. Эдгээр шинэчлэлийг үл харгалзан хөрөнгө оруулалтын бодлого нь тодорхой бус, үзэмжид суурилсан хэвээр байгаа нь хөрөнгө оруулалтыг төрөлжүүлэн татахад тэдийлэн хангалттай дэмжлэг үзүүлж чаддаггүй. Худалдаа, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлж буй байгууллагуудын үүрэг хариуцлага тодорхой бусаас гадна нөөц бололцоо дутагдалтай байдаг нь үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх боломжийг нь хязгаарлаж байна.

# БИД ЮУНД ХҮРЭХИЙГ ЗОРИХ ВЭ?

## ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Засгийн газар худалдаа, хөрөнгө оруулалтаар дамжуулан дэлхийн интеграцид оролцох зорилготойгоор хувийн хэвшлийг дэмжсэн өсөлтийн стратеги, үндэсний хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр зорьж байна. Тиймээс худалдаа, хөрөнгө оруулалт нь бодлогын хүрээнд хэрэгжих болон боловсруулагдах шатны салбарын стратеги болон төлөвлөгөөтэй уялдаатай байдаг.

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, МХЗ-д суурилсан Үндэсний Хөгжлийн Цогц Стратеги нь үндэсний томоохон үйл ажиллагааны хөтөлбөрийн суурь чиглэл болдог. Хоёр стратегид давхар тусгагдсан үндсэн зорилтуудыг Зураг 13-т үзүүлэв. Эдгээрт, эдийн засгийн бүтээгдэхүүн, зах зээлийн суурийн төрөлжүүлэлт, нэмүү өртгийг нэмэгдүүлэхийг дэмжих инноваци, хүртээмжтэй, тогвортой өсөлт зэрэг орно. Уг графикт Монгол Улс үндэсний алсын хараа болон зорилтуудад хөтлөх үндэсний хөтөлбөрүүдэд тусгасан найман сэдвийг тодорхойлсон. Эдгээр сэдвүүд нь худалдаа, хөрөнгө оруулалт, ур чадварыг хөгжүүлэх, чанарын менежмент, судалгаа зэрэг болно. Үндэсний бодлого, хөтөлбөрүүд нь эдгээр найман сэдвийг янз бүрийн нарийвчлалтайгаар өөртөө агуулан тусгасан байдаг.

**Зураг 13.** Монгол Улсын үндэсний бодлогын хамрах хүрээ

**Үндэсний зорилтууд болон холбогдох сэдвүүд**




TIR MON 1 - Final_Fi.indd 15 07.05.2020 09:16:20

# ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ СҮЛЖЭЭ

Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагууд (ХХОДБ) нь олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын боломжийг бодит болгон хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улсын ХХОДБ-ууд нь хувийн хэвшлийн болон олон нийтийн салбар дах үйлчлүүлэгчдэд хүрч үйлчлэх олон давуу талтай бөгөөд олон төрлийн үнэ цэнэ бүхий үйлчилгээг үзүүлэн ажилладаг.

Түүнчлэн, ХХОДБ-ууд нь ХХОЗЗ-ийг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх ёстой. Эдгээр байгууллагуудын тэргүүлэх чиглэлүүд нь чадавхийг бэхжүүлэх, тэр дунаа экспортлогчдод зориулсан олон улсын зах зээлийн дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчдад өргөн хүрээний үйлчилгээ үзүүлэхэд оршино. Тодруулбал, худалдаа, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх сүлжээг илүү тодорхой болгосон сүлжээ нь ХХОДБ-уудын хамтын ажиллагаа, үүрэг хариуцлагыг хуваарилалтыг сайжруулна.

Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих ажиллагаанд олон байгууллага оролцдог. Монгол Улсын 39 ХХОДБ-ын дөрөвний гурав нь улсын, хувийн буюу төрийн бус байгууллага/ашгийн бус байгууллагууд юм (Зураг 14). Тэдгээрийн дийлэнх нь бодлогын дэмжлэгийн чиглэлээр ажиладаг (36%) бол, нилээд хувь нь худалдаа хөрөнгө оруулалтын үйлчилгээ (24%), бизнесийн үйлчилгээ (22%), иргэний нийгмийн чиглэлээр (18%) ажиллаж байна. Гадаад харилцааны яам (ГХЯ), Хөгжлийн банк (ХБ), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ), Үндэсний хөгжлийн газар (ҮХГ) зэрэг худалдаа, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллагууд нь голчлон бодлогын дэмжлэг үзүүлэх чиглэлд төвлөрдөг.

**Зураг14.** Монгол Улс дах ХХОДБ-ын төрлүүд




***Эх сурвалж:*** ОУХТ тооцоолол.

Хэд хэдэн ХХОДБ нь ХХОЗЗ-ийн тэргүүлэх салбаруудад ажиллах чиглэлтэй. Дараах салбарт чиглэсэн байгууллагууд байдаг. Тэдгээр нь яамд (жишээлбэл: Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрчим хүчний яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам [ХХААХҮЯ], төрийн байгууллагууд (жишээ нь: Мал эмнэлгийн албаны ерөнхий газар), салбарын холбоод (Монголын ноос, ноолуурын холбоо, Монголын арьс, шир үйлдвэрлэлийн холбоо), болон олон улсын донор байгууллагууд (Швейцарийн хөгжлийн агентлаг, Ногоон алт төсөл зэрэг).

Монголын ХХОДБ-ууд нь компаниудын нийлүүлэлтийн хүчин чадлыг хангахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэхэд төвлөрдөг. ХХОДБ-ын хамгийн түгээмэл үйлчилгээ нь үйлдвэрлэл ба/буюу үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн судалгаа, хөгжүүлэлт болон бизнес/экспортын удирдлагын сургалт, зөвлөгөө зэрэг үйлчилгээ байдаг. Хэд хэдэн ХХОДБ нь хөгжил, нийгэм, байгаль орчны асуудлууд, тухайлбал, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчны тогтвортой байдал, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйлчилгээ үзүүлдэг. ХХОДБ нь экспортын зээл, даатгалын үйлчилгээ үүзүүлэхэд оролцоо харьцангуй бага бөгөөд Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ), Хөгжлийн банк болон Сангийн яам зэрэг байгууллагууд нь дээрх үйлчилгээнд илүүтэйгээр оролцдог.

Дотоодын аж ахуйн нэгжүүд нь ХХОДБ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэл юм. Байгууллагуудын үзүүлдэг 25 төрлийн үйлчилгээний талаар асуулга асуухад, судалгаанд хамрагдагсад үйлчилгээг ихэвчлэн дотоодын компаниудад үзүүлдэг бөгөөд дотоодын компаниуд болон Засгийн газарт худалдааны бодлого, зах зээлд нэвтрэх чиглэлийн үйлчилгээ үзүүлдэг гэжээ. ХХОДБ-ууд нь ихэвчлэн дотооддоо төвлөрч ажилладаг ба судалгаанд хамрагдагсдын 78 хувь нь улс орныг бүхэлд нь хамардаг бол 29 хувь нь олон улсад үйл ажиллагаатай хэмээсэн байна.

МҮХАҮТ нь харьцангуй өвөрмөц үйлчилгээг үзүүлдэг – Монгол Улсын нэг юм уу хоёр л томоохон ХХОДБ-ын тодорхой бүлэг үйлчлүүлэгчдэд үзүүлдэг үйлчилгээ – бол бусад томоохон байгууллагууд нь тусгайлсан асуудлуудаар үйлчилгээ үзүүлдэг. Тухайлбал, гаалийн бүрдүүлэлт (ГХЯ), санхүүгийн үйлчилгээ болон брэндинг (Монгол Улсын Хөгжлийн банк), худалдан авагчийн тодорхойлолт, гэрчилгээ (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам)(Хүснэгт 1).

Олон тооны байгууллагууд хөрөнгө оруулагчидтай ажилладаг боловч хөрөнгө оруулалтын бүрэн хэмжээний дэмжлэг үзүүлэх үйлчилгээ байхгүй. Нийт ХХОДБ-ын 82 хувь нь хөрөнгө оруулагчдад мэдээллээр хангаж үйлчилгээ үзүүлдэг. Төр болон хувийн хэвшлийн хэлэлцүүлэг, нэтворкинг/харилцаа тогтоох арга хэмжээнүүд, мэдээллийн арга хэмжээнүүд нь хамгийн түгээмэл бөгөөд хөрөнгө оруулагчдад мэдээлэл түгээдэг ХХОДБ-ууд нь импорт/экспортын журам, зах зээлийн талаар мэдээлэл өгөх нь элбэг. Гэвч омбудсманы үйлчилгээ үзүүлдэг байгууллага байхгүй байна.

ХХОДБ-ууд днь олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын боломжийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн өргөтгөсөн, сайжруулсан үйлчилгээг санал болгосноор ХХОЗЗ-ийн зорилгод хүрэхэд компаниудыг үргэлжлүүлэн дэмжинэ (Хайрцаг 3).

**Хүснэгт 1.** Томоохон ХХОДБ-ын үзүүлдэг онцлог үйлчилгээ

| ХХОДБ | Үйлчилгээний төрөл, чиглэл |
|---|---|
| Монгол Улсын Хөгжлийн банк | • Хөрөнгө оруулалтыг дэмжих санхүүгийн үйлчилгээ (гадаадын ААН, Засгийн газар)<br>• Экспортын зээл (гадаадын ААН)<br>• Даатгалын үйлчилгээ (Дотоодын ААН)<br>• Зах зээлийн судалгаа (Дотоод, гадаадын худалдааг дэмжих байгууллагууд)<br>• Худалдан авагчийг тодорхойлох, бизнесийн дэмжлэг, “зах зээл дэх” дэмжлэг (Дотоодын ААН, Дотоодын худалдааг дэмжих байгууллагууд) |
| Үндэсний Хөгжлийн газар | • Гадаадын шууд хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалтыг татах тодорхой зорилго, зорилтуудын хүрээнд Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг байгуулан ажиллуулж байна (Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020). 2018 оны 11 сараас эхлээд ҮХГ нь ажлын албаны үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>• Хөрөнгө оруулалт, бизнесийн орчинтой холбоотой хууль тогтоомж, журам, бодлогын баримт бичгийг боловсруулж батлах явцад төрийн байгууллагууд, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын тэгш оролцоог хангах зорилгоор “Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо” байгуулагдсан бөгөөд хувийн хэвшил болон төрийн бус байгууллагуудын дуу хоолой, тэдний санаа бодлыг хүргэж, ил тод байдлыг хангаж ажиллаж байна. Тус зөвлөлдөх хорооны даргаар төрийг төлөөлөн Үндэсний хөгжлийн газрын дарга ажиллаж байна.<br>• ҮХГ нь МҮХАҮТ-ын Дэд даргын үүрэг гүйцэтгэдэг.<br>• Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан "Нэг цэгийн үйлчилгээний төв" (2019 он) нь зарим үйлчилгээг шийдвэрлэхэд шаардагдах хугацааг багасгах, хөрөнгө оруулагчдад тулгарч буй хүнд суртлыг багасгах, илүү таатай орчныг бүрдүүлэхэд чиглэгддэг. Энэхүү төв нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдтэй холбогдолтой үйл ажиллагаа эрхэлдэг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол Улсын Татварын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар зэрэг холбогдох төрийн байгууллагуудын олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг. |
| Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | • Баталгаажуулалтын үйлчилгээ (гадаадын худалдааг дэмжих байгууллагууд)<br>• Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой захиргааны ба худалдааны хөнгөвчлөх үйлчилгээ (гадаадын худалдааг дэмжих байгууллагууд)<br>• Зохицуулалтын шинэчлэлийн ухуулга, сурталчилгаа<br>• Мэдээллийн арга хэмжээ, төр-хувийн хэвшлийн хэлэлцүүлэг, стратегийн хамтын ажиллагаа<br>• Импорт/экспортын журмын талаар хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээлэл |
| Сангийн яам | • Хөрөнгө оруулалтыг дэмжих санхүүгийн үйлчилгээ (Засгийн газар)<br>• Экспортын зээл (Засгийн газар)<br>• Даатгалын үйлчилгээ (Засгийн газар)<br>• Зохицуулалтын шинэчлэлийн ухуулга, сурталчилгаа (Засгийн газар)<br>• Худалдан авагчийг тодорхойлох, бизнесийн дэмжлэг, “зах зээл дэх” дэмжлэг (Засгийн газар)<br>• Зөвшөөрөл, лицензийн үйлчилгээ, санхүүгийн дэмжлэг (хөрөнгө оруулалтын баталгаа, зээл, буцалтгүй тусламж, экспортын зээл), хөрөнгө оруулалтын төслүүдэд төр, хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулалтын онцгой статус болон багц хэлэлцээрүүд (тухайлбал, тодорхой хэмжээнээс дээш хөрөнгө оруулалтын төслүүдэд), маргаан шийдвэрлэлт, төр-хувийн хэвшлийн хэлэлцээр, стратегийн хамтын ажиллагаа (ур чадварын хөгжүүлэлт, нийлүүлэгчид, салбарын экосистем гэх мэт) |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | • Хөдөө аж ахуйн дэд салбарыг хөгжүүлэх, экспортыг дэмжих дотоодын бүтээгдэхүүнээр үндэсний орлогыг нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор хууль, бодлого, шийдвэрийг боловсруулах, хянах, үнэлэх, хэрэгжүүлэх<br>• Үндэсний үйлдвэрлэгчид, ЖДҮ-д өрсөлдөхүйц түвшинд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн болон арга зүйн зөвлөмж өгөх, техникийн болон зохион байгуулалтын үйлчилгээг үзүүлэх |
| Гадаад харилцааны яам | • Бодлогын дэмжлэг<br>• Худалдааны бодлого ба зах зээлд нэвтрэх (худалдааны хэлэлцээрүүд)<br>• Зохицуулалтын шинэчлэлийн ухуулга, сурталчилгаа<br>• Худалдааны мэдээллийн үйлчилгээ (дотоод, гадаадын ААН, дотоод, гадаадын худалдааг дэмжих байгууллагууд, засгийн газар)<br>• Зах зээлийн дэмжих үйлчилгээ (засгийн газар)<br>• Харилцаа, холбооны үйлчилгээ (гадаадын ААН, гадаадын худалдааг дэмжих байгууллагууд)<br>• Брэндинг ба сурталчилгаа (Засгийн газар) |
| Байгаль орчин, аялал жуулчлалын яам | • Байгаль орчин, аялал жуулчлалын талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх, зохион байгуулах үүрэгтэй.<br>• Стратегийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд салбарын болон төсвийн хяналтыг уялдуулан зохицуулах, тогтвортой хөгжлийн асуудлаар салбарын болон салбар хоорондын уялдаа холбоог хангах.<br>• Байгаль орчин ба түүний хувьсалын чиг хандлагыг судлах, хүрээлэн буй орчныг хамгаалахад шинжлэх ухаан, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, экологи, эдийн засаг ба зохицуулалтын хөшүүргийг механизмыг ашиглах.<br>• Нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, байгалийн нөөцийн нөхөн сэргээлтийг хангах |

| ХХОДБ | Үйлчилгээний төрөл, зорилтот үйлчлүүлэгчид |
|---|---|
| Гаалийн ерөнхий газар | • Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой захиргааны ба худалдааны хөнгөвчлөх үйлчилгээ (гадаадын худалдааг дэмжих байгууллагууд)<br>• Бизнес/экспортын удирдлагын сургалт зэрэг мэдлэгийг нэмэгдүүлэх үйлчилгээ<br>• Судалгаа, хөгжүүлэлт (үйлдвэрлэл) (Гадаадын худалдааг дэмжих байгууллагууд, Засгийн газар)<br>• Гаалийн үнэлгээ, экспорт/импортын журам, гаальтай холбоотой асуудлуудаар гаалийн ажилтнууд болон оролцогч талуудад зориулсан сургалт явуулах<br>• Импорт/экспортын журам, гадаад худалдааны статистик, тариф, гаалийн мэдээллийн талаар хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх, гаалийн татвар болон бусад татвар тооцох |
| Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим | • Бизнест таатай орчныг бүрдүүлэх<br>• Гадаад, дотоод худалдаа, бизнес эрхлэлтийн чиглэлээр сургалт, судалгааны үйл ажиллагаа<br>• Худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг төрийн болон хувийн хэвшлийн оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлэх<br>• Зах зээлийн судалгаа (гадаадын худалдааг дэмжих байгууллагууд)<br>• Худалдан авагчийг тодорхойлох, бизнесийн дэмжлэг, "зах зээл дэх" дэмжлэг (гадаадын ААН, засгийн газар, гадаадын худалдааг дэмжих байгууллагууд)<br>• Зах зээлийн дэмжих үйлчилгээ (гадаадын худалдааг дэмжих байгууллагууд) |

## **Хайрцаг 3.** ХХОДБ-ЫН ХӨТӨЛБӨР, ҮЙЛЧИЛГЭЭ

- Олон улсын хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, гадаадын компаниудтай хамтран ажиллахад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах (Үйл ажиллагаа 3.3.4)..
- Дотоодын болон гадаадын компаниудад тохирох хөтөлбөрийг бий болгох (Үйл ажиллагаа 4.4.6).
- ГШХО-ын мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажлыг явуулах (Үйл ажиллагаа 4.4.7).

Ихэнх ХХОДБ-ууд нь тодорхой чиг үүрэгтэй хэдий ч хүчин чадлын хязгаарлалттай тулгардаг. ХХОДБ-уудын 86 хувь нь тодорхой дүрэм журмаар зааж өгсөн чиг үүрэгтэй ажилладаг бөгөөд тэдний 66 хувь нь чиг үүргээ тодорхой бөгөөд ямар нэгэн давхардалгүй хэмээн санал нийлдэг. Ихэнх (74 хувь) нь энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд зохих эрх мэдэлтэй байх шаардлагатай гэдэг. Байгууллагууд нь өөрсдийн эрх мэдэл, худалдаа, үйлдвэрлэлийн бүлгийн зөвлөлийн оролцоо, өөрсдийн чиг үүргийн тодорхой байдлыг өндрөөр үнэлсэн бол бизнесийн боломжийг олж илрүүлэх, мэдээллэх, брэндийн менежмент ба гадаадад үйлчлүүлэгчдэд үзүүлэх дэмжлэг үйлчилгээг хамгийн багаар үнэлсэн байна. Өөрсдийн давуу тал, сул тал, аюул занал, боломжийн судалгааг хийхэд ХХОДБ-ууд нь хязгаарлагдмал хүчин чадлыг дотоод бэрхшээл хэмээн тодорхойлсон байна. (Хүснэгт 3).

Экспорт хийхэд дэмжлэг үзүүлэхийн тулд цаашид ажиллах шаардлагатай. Байгууллагуудаас олон улсын зах зээлд дэмжлэг үзүүлдэггүй: ХХОДБ-ын 34 хувь нь үйлчлүүлэгчиддээ гадаадад огт дэмжлэг үзүүлдэггүй эсвэл бага, 24 хувь нь гадаадын зах зээлд мэдээлэл огт өгдөггүй эсвэл хязгаарлагдмал (Хайрцаг 4).

**Хүснэгт 2.** ХХОДБ-удын өөрсдийн тодорхойлсон давуу тал, сул тал, боломж ба аюул занал

| Давуу тал | Сул талууд |
|---|---|
| • Дотоодын болон олон улсын сүлжээ<br>• Санхүүгийн хөрөнгө<br>• Хүний нөөц ба техникийн чадавх<br>• Улс төрийн / Засгийн газрын дэмжлэг<br>• Санал болгож буй үйлчилгээний цар хүрээ<br>• Чиг үүргийн тодорхой байдал | • Хүний нөөц, экспертизийн хязгаарлагдмал байдал<br>• Санхүүгийн болон бусад нөөцийн хязгаарлалтууд<br>• Үйлчлүүлэгчдийн дунд мэдлэг хангалтгүй<br>• Инноваци хангалтгүй |
| **Боломжууд** | **Аюул занал** |
| • Үндэсний хөгжилд худалдааны чиглэлийг нэвтрүүлэх<br>• Компаниудын зүгээс үйлчилгээний эрэлт өсч байна<br>• Шинэ салбаруудын өсөлт<br>• Экспортын зах зээлийн төрөлжилт | • Бодлогын өөрчлөлт ба зохицуулалтын хязгаарлалтууд<br>• Улс төрийн оролцоо<br>• Эдийн засгийн эмзэг байдал<br>• Шинэ технологиудаар солих |

***Эх сурвалж:*** ОУХТ

## **Хайрцаг 4.** ЧАДАВХЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Шинжилгээ ба бодлогын хөгжлийг дэмжихэд ХХОДБ-ын чадавхийг бэхжүүлэх (Үйл ажиллагаа 1.1.1.)
- Тодорхойлсон үүрэг хариуцлага дээр нь төвлөрсөн ХХОДБ-ын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр (Үйл ажиллагаа 2.1.2.)
- МҮХАҮТ (Үйл ажиллагаа 2.2.1.) ба ГХЯ (Үйл ажиллагаа 2.2.2.) эсвэл худалдааны сурталчилгааг хариуцсан ХХОДБ-г чадавхжуулах, бэхжүүлэх
- Худалдааны мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх сургалтыг өргөжүүлэх (Үйл ажиллагаа 2.2.3.)
- ХХОДБ-ыг нарийвчилсан зах зээлийн боломжийн судалгааг боловсруулахад сургах (Үйл ажиллагаа 2.2.4.)

Монгол Улсын ХХОДБ-ын дийлэнх нь бусад байгууллагуудтай хамтран ажилладаг. Сайжруулах боломж бий. Нийтдээ Худалдаа ба хөрөнгө оруулалтыг дэмжигч байгууллагуудын 26-гийнх нь хувьд хоёр талт харилцаанд тулгуурласан 52 ширхэг харилцаагаараа дамжуулан, өөр хоорондоо холбогдон ажилладаг байна (Зураг 15). МҮХАҮТ нь Монгол улс дахь бусад байгууллагуудтай албан ёсны хүрээнд байгуулсан болон байнгын бус нэмэлт 17 харилцааг тогтоож чадсан, хамгийн сайн харилцаа холбоотой ажилладаг Худалдаа ба хөрөнгө оруулалтыг дэмжигч байгууллага (ХХОДБ) болж байна. Гаалийн ерөнхий газар, Гадаад харилцааны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь мөн харилцаа холбоо сайтай байна. Институциудын хоорондын харилцааны мөн чанар нь бодлого боловсруулах, мэдээлэл солилцох, хамтарсан төсөл, үйл ажиллагаа, нөөцийн хамтран ашиглалт, бусад зохицуулалт, хамтын ажиллагааны чиглэлээр хамтрах явдал юм. Албан ёсны харилцаа нь хамгийн нийтлэг бөгөөд 85 хувийг бүрдүүлж байгаа бол шууд тайлагналын харилцаа 43 хувь л байдаг байна.

**Зураг 15.** ХХОДБ хоорондын харилцаа




*Эх сурвалж:* ОУХТ.

## **Хайрцаг 5.** МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхиулэн дэмжихэд Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим гол үүргийг гүйцэтгэдэг. МҮХАҮТ нь улсын хэмжээнд үйл ажиллагааны цар хүрээгээрээ хамгийн идэвхитэй байгууллага юм. МҮХАҮТ нь дотоодын болон гадаадын аж ахуйн нэгжүүдэд өргөн хүрээний үйлчилгээг үзүүлж, Засгийн газартай харилцаа холбоо, санхүү болон бусад асуудлаар, бусад дотоодын ХХОДБ болон гадаадын ХХОДБ-уудад зөвлөгөө өгөх үйлчилгээ зэргээр хамтран ажилладаг. ХХОЗЗ-ийг хэрэгжүүлэхэд МҮХАҮТ үүрэг маш чухал бөгөөд экспортлогчдыг дэмжих, худалдааг хөнгөвчлөх, бизнес эрхлэлтийг дэмжих, хөрөнгө оруулагчдыг дотоодын бизнестэй холбох зэрэг нийт 47 үйл ажиллагаг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг.

ОУХТөвийн МҮХАҮТ-ын удирдлагын болон үйл ажиллагааны гүйцэтгэлд дутагдалтай талуудыг илрүүлж, сайжруулах зорилго бүхий гүйцэтгэлийг сайжруулах замын зургийн ажлын нэг хэсэг болгож, МҮХАҮТ-ын 2016 болон 2018 оны гүйцэтгэлийн үзүүлэлтийг зэрэгцүүлэн үнэлэхэд дорвитой сайн өөрчлөлтүүд гарсан байна. Ажилтнуудын ур чадварыг эргэн харж, түүнд тулгуурлан бүтцийн өөрчлөлт хийсэн, үйлчлүүлэгч төвтэй соёл болон шинэ үйлчлүүлэгчийн удирдлагын арга барилыг боловсруулсан, ур дүнд чиглэсэн хандлагатай болсон, эрсдлийн удирдлагын шинэ арга барил ашигласан, стратеги боловсруулалт зэрэг нь Танхимийн үйл ажиллагааны гол хөтлөгч хүчин зүйлс болон хэрэгжсэн байна. Өөрийгөө үнэлсэн үнэлгээгээр МҮХАҮТ нь өөрийн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх мэдэл, бие даасан байдал, ТУЗ-ийн гишүүдийг томилох ил тод байдал, контент удирдлагын чиглэл зэрэг үзүүлэлтүүдийг хамгийн өндрөөр үнэлсэн байна (Хүснэгт 3). Түүнчлэн стратегид төвлөрөх байдал, оролцогч талуудын хэрэгцээ, үзэл бодлыг ойлгох, стратегийн түншлэлийн удирдлага, үйл явцын үнэлгээ, бизнесийн боломжийг тодорхойлолт, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл, маркетинг, сурталчилгааны төлөвлөгөөний хэрэглээг хамгийн доогуур үнэлсэн байна.

**Хүснэгт 3.** Чадавхийн өөрийн үнэлгээ

| Хамгийн өндрөөр үнэлэгдсэн үзүүлэлтүүд | Хамгийн доогуур үнэлэгдсэн үзүүлэлтүүд |
|---|---|
| • Зохих түвшний эрх мэдэлтэй байх, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд саад тотгоргүйгээр үйл ажиллагаа явуулах боломжтой<br>• Мэргэжил, ур чадварын тодорхой шаардлага болон бизнесийн гол салбаруудын төлөөллийг хангасан байх удирдамжийн дагуу ТУЗ-ийн гишүүдийн томилгооны процесс ил тод бөгөөд томилгоог эсэргүүцэх боломж нээлттэй<br>• Контент боловсруулах, удирдах, хадгалах талаарх цогц удирдамжийн тогтвортой хэрэглээ | • Удирдах зөвлөл нь стратегид төвлөрч ажиллахгүй, үйл ажиллагаанд байнга оролцдог<br>• Оролцогч талуудын хэрэгцээ, үзэл бодлыг ойлгоход чиглэсэн үйл ажиллагаа тогтмолжоогүй<br>• Стратегийн түншлэл нь түр зуурын шинж чанартай байдаг<br>• Үйл явцын хяналт нь тохиолдлын чанартай бөгөөд гүйцэд бус<br>• Бизнесийн боломжийг таниулах, түгээн дэлгэрүүлэх ажлыг тохиолдлын чанартай хийдэг<br>• Бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл хангалтгүй<br>• урталчилгаа болон маркетингийн үйл ажилаагааны төлөвлөгөө нь зорилт болон өртөг зардлын нарийвчлалгүй |

ХХОДБ-ын үр ашгийг дээшлүүлэхэд институцийн шинэчлэл шаардлагатай. Институци хоорондын нэмэлт, тодорхой холбоо харилцаа шаардлагатай. Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих сүлжээг албан ёсны болгох замаар байгууллагуудын үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан баримт бичгээр дамжуулан байгууллагууд мэргэшсэн чиглэлүүд болон үр дүнтэй зохицуулалтаар хамтран ажиллах боломжтой болно. Үүнээс гадна, ХХОДБ болон бусад оролцогчдын хамтын ажиллагааны хүрээг бий болгох нь худалдааны мэдээлэл солилцоо, мэдээлэл түгээлтийг дэмжихэд дөхөм болно. Хөрөнгө оруулалтыг онилон төлөвлөх, сурталчлах, халамжлах зэрэг үйл ажиллагааг цогцлоосон, хөрөнгө оруулалтыг дэмжих чиг үүрэг бүхий агентлаг байх шаардлагатай. Үндсэний хөгжлийн газрын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааг нарийвчлан төрөлжүүлж, тодорхой болгон, хөрөнгө оруулалтын дараах үйлчилгээг үзүүлэх нэгжийг байгуулснаар дээрх үйл ажиллагаа сайжран бэхжих болно (Хайрцаг 6).

## **Хайрцаг 6.** ИНСТИТУЦИЙН ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Худалдааг дэмжих тусгай агентлаг байгуулах (Үйл ажиллагаа 1.5.3.)
- Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг байгуулах (Үйл ажиллагаа 1.5.4.)
- Хөрөнгө оруулалтын орох урсгалыг төрөлжүүлэн, нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх чадавхийг бэхжүүлэх (Үйл ажиллагаа 2.1.3.)
- Хөрөнгө оруулалтыг дэмжих, тээдрийн төлөвлөлт болон Эдийн засгийн тусгай бүсийн үнэ цэнийн сүлжээний бүрдэл хэсгүүдийг эрэмбэлэх (Үйл ажиллагаа 2.1.4.)
- Үндсэн ХХОДБ-ын хооронд үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах үүднээс албан ёсны сүлжээг бий болгох (Үйл ажиллагаа 2.1.1.)
- Засгийн газар, ХХОДБ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны цар хүрээг бий болгох (Үйл ажиллагаа 2.2.6.)

# БИДЭНД ЮУ СААД БОЛЖ БАЙНА ВЭ?

Дараах хэсэгт экспортын , хөрөнгө оруулалтын сонирхлыг түдгэлзүүлэхэд нөлөөлсөн үндсэн хязгаарлагч хүчин зүйлсийг компаниудын ур чадвар, байгууллагын худалдаа, хөрөнгө оруулалтын дэмжлэг ба хүрээлэн буй орчин, бодлого зохицуулалт гэсэн гурван түвшинд авч үзэж, шинжилгээ хийв. Монгол Улсад экспортын хөгжлийг хязгаарлаж, хөрөнгө оруулалтыг татах нөхцөлд сөргөөр нөлөөлж, өрсөлдөх чадварыг дотооддоо хязгаарлаж байгаа хүчин зүйлсийг өрсөлдөх, уялдаа холбоог хангах, өөрчлөх буюу Гурван Си-гийн аргачлалын цар хүрээнд тодорхойлов. Өөрөөр хэлбэл эдийн засаг өрсөлдөх, уялдаа холбоотой байх болон өөрчлөгдөхөд эдгээр хязгаарлагч хүчин зүйлсийг зайлшгүй авч хэлэлцэн шийдвэрлэх шаардлагатай байна. Эдгээр сорилтуудын талаар Хавсралтад дэлгэрэнгүй тайлбарласан бөгөөд Хүснэгт 4-т тоймлов.

**Хүснэгт 4.** Гол сорилтууд

| | Компаниудын ур чадвар | Байгууллагын түвшний ба худалдааны дэмжлэг | Үндэсний бодлого, эрх зүйн зохицуулалтын орчин |
|---|---|---|---|
| ӨРСӨЛДӨХ: Дотоодын болон гадаадын зах зээлд тухайн улсын өрсөлдөх чадварыг хязгаарлагч хүчин зүйлс | • Үйлдвэрлэлийн орцын хүрэлцээ, хүртээмж тодорхойгүй бөгөөд хангалтгүй хэмжээтэй байдаг<br>• Тоног төхөөрөмжийн хангалтгүй байдал болон сайн туршлагуудын талаарх мэдлэг хангалтгүйгээс үүдсэн үйлдвэрлэлийн алдагдал<br>• Гадаад зах зээлийн техникийн зохицуулалт/ шаардлагуудын талаарх ойлголт дутмаг | • Нэмүү өртгийн сүлжээ, тээвэр, логистикийн бүх үе шатанд шаардлагатай түвшинд хүйтэн хэмийг барьж ажиллах горим бүхий дэд бүтэц хангалтгүй<br>• Олон улсад магадлан итгэмжлэгдсэн лабораторийн хүртээмж хангалгүй<br>• Экспортын гэрчилгээ гаргахад хугацаа хойшилдог зэрэг хил дээрх процедур удаашралтай<br>• Гадаадын стандарттай дүйцэхүйц стандартыг боловсруулан хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын чадавх дутмаг<br>• Хөдөө орон нутагт агуулах, зориулалтын зоорь сав дутмаг | • Дэд бүтцийн бэрхшээлүүд (далайд гарцгүй, зам харилцаа холбоо дутмаг, эрс тэс уур амьсгал, цахилгаан хангамжийн асуудал) нь үйлдвэрлэлийн алдагдал болон бизнес эрхлэх зардлыг нэмэгдүүлдэг.<br>• Чанар болон ургамал амьтны эрүүл ахуй, хорио цээрийн стандартын хяналт муу байгаа нь экспортын зах зээлийн төрөлжүүлэлт болон өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлдөг.<br>• Бусад орнуудтай чанар стандартын тохирлын чиглэлээр хэлэлцээ хийсэн нь бага<br>• Бизнес эрхлэлтийн дэмжлэг муу бөгөөд эдийн засгийн төрөлжилтийг хангах үндэсний алсын хараа муу<br>• Гэрээний хэрэгжилт хангах байдал сул<br>• Бизнес эхлүүлэхэд шаардагдах процедур төвөгтэй бөгөөд удаан |
| УЯЛДАА ХОЛБООГ ХАНГАХ: Ханган нийлүүлэгч, зах зээл болон хэрэглэгчийн уялдаа холбоог хязгаарлагч хүчин зүйлс | • Монгол Улсад олгосон зах зээлд хөнгөлөлттэй нөхцлөөр нэвтрэх боломжийг хангалттай түвшинд ашиглах мэдлэг экспортлогчдод дутмаг<br>• Компаниудын худалдааны үзэсгэлэнгүүдэд тогтмол оролцож хамрагдах нөөц боломж хязгаарлагдмал<br>• Компаниудад харилцан ашигтай гэрээ хэлэлцээр хийх мэдлэг чадвар дутмаг<br>• Олон улсын зах зээлд нэвтрэхэд тавигдах шаардлагын талаар мэдлэг дутмаг | • Хилээр нэвтрүүлэх гаалийн бүрдүүлэлтийн шаардлагууд нь төвөгтэй<br>• Монголын бүтээгдэхүүний олон улсад танигдах байдал нь тэдгээрийг сурталчлах үйл ажиллагаа дутмаг байгаатай холбоотой<br>• Төрийн байгууллагууд болон хувийн хэвшлийн харилцаа холбоо хязгаарлагдмал<br>• Зах зээлийн судалгаа болон B2B дэмжлэг хязгаарлагдмал<br>• Дотоодын компаниудыг ханган нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, эсвэл хамтарсан компани байгуулах зэрэг боломжоор гадны компаниудтай холбох ямар нэгэн системтэй хөтөлбөрүүд байхгүй | • Тээвэрлэлтийн дэд бүтэц муу<br>• Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр болон Чөлөөт худалдааны хэлэлцээр (ЭЗТХ / ЧХХ)-үүд цөөн<br>• Засгийн газрын түвшинд худалдааны багцад хангалттай ач холбогдол өгдөггүй |
| ӨӨРЧЛӨХ: Салбарын хувьд өөрчлөгдөж, инновацийг нэвтрүүлж, шинэлэг чиг хандлагуудад оролцох чадварыг хязгаарлагч хүчин зүйлс | • Санхүүжилтийн хүртээмж хязгаарлагдмал. ЖДҮ-үүд зээл авахад шаардагдах үл хөдлөх хөрөнгө эзэмшдэггүй<br>• Бизнесүүд инновацигүй бөгөөд судалгаа шинжилгээнд хийх хөрөнгө оруулалт хангалтгүй<br>• Инновацийн уялдаа холбоо сул, мэдлэг дамжуулан, мэдлэг шингээж буй түвшин маш доогуур<br>• Ур чадварын түвшин доогуур бөгөөд ур чадвар ба ажлын байрны шаардлагын зөрүү их<br>• Мэдээлэл, харилцаа холбоо, технологи дутмаг – Цахим худалдааны платформууд болон бараа материалын систем буюу агуулахын логистик хоёрыг холбосон МХХТ сул хөгжсөн | • Шинжлэх ухааны байгууллагуудын чанар сул<br>• Судалгаа ба бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжүүлэлтийн салбарт, аж үйлдвэрийн салбар болон шинжлэх ухааны академи/ судалгаа шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаа хангалтгүй<br>• Хөрөнгө оруулалтыг сурталчлан таниулагчдын хувьд салбарын нарийн мэдлэг мэдээлэл хангалтгүй<br>• Сургалтын төвүүдийн сургалтын хөтөлбөр нь зах зээлийн хэрэгцээ шаардлагатай уялдаагүй | • Экспортыг төрөлжүүлэх зорилгодоо хүрэх чиглэлээр тодорхой төлөвлөгөө гаргасан боловч, хараахан батлагдаагүй бөгөөд хэрэгжээгүй байна.<br>• Хувийн хэвшлийн хөгжилд ГШХО-ын гүйцэтгэх үүргийн талаарх тодорхой, нэгдмэл ойлголт дутмаг<br>• Хөрөнгө оруулалтын бодлогыг урьдчилан таамаглах боломжгүй байдал<br>• Хөрөнгө оруулалтын сурталчилгаанд чиглэсэн тусгай байгууллага байхгүй<br>• Татварын бодлого нь төвөгтэй<br>• Оюуны өмч хамгаалын бодлого сул<br>• Төрийн өмчит байгууллагууд хувийн хэвшлийн хөгжлийн тушаа болдог<br>• Байгалийн нөөцийн доройтол нэмэгдсэн<br>• Залуусын дунд ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь залуусын нөөц боломцоог дутуу ашиглаж байгаагийн илрэл |



Photo: Mongolian cashmere, ©Gobi YAMA brand



Photo: ©Ministry of Foreign Affairs

# БИД ХЭРХЭН ТЭНД ХҮРЭХ ВЭ? УРАГШЛАХ ЗАМ

Дээрх судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсад бодлогын нэгдэл, институцийн хамтын ажиллагаа, хувийн хэвшлийн дэмжлэгийг бий болгох ерөнхий Худалдаа, хөрөнгө оруулалтын үндэсний замын зураг шаардлагатай байна.

Монгол Улсын төр, хувийн хэвшлийн салбарууд нь худалдаа-хөрөнгө оруулалтын тогтвортой өсөлтийг хангах замд үндэстнээрээ замнахад нь гэрэлт цамхаг, уриа болон ашиглагдах дараах алсын хараан дор нэгдэж байна. Энэ нь::

АЛСЫН ХАРАА: Өв соёл, бүтээлч сэтгэлгээгээ ашиглан худалдаа, хөрөнгө оруулалтад түшиглэсэн өсөлтийг дэмжих замаар хурдацтай хөгжих эдийн засаг бүхий Монгол улс

Энэхүү алсын хараа нь ХХОЗЗ-ийн хэрэгжилтийн таван жилийн хугацаанд чиглүүлэх багана болох дараах дөрвөн стратегийн зорилтоор дэмжигдэнэ. Үүнд:

## СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1: БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫГ ХАНГАХ ЗАМААР УРТ ХУГАЦААНЫ ӨСӨЛТИЙН ЗАМЫГ БИЙ БОЛГОХ

Энэхүү стратегийн зорилт нь, худалдаа, хөрөнгө оруулалтын өсөлтийг хангахад нийцэж тохирсон бизнесийн таатай орчныг хөгжүүлэхэд эерэг хувь нэмэр оруулах юм. Үр дүнтэй бодлого, олон улсын гэрээ хэлэлцээрүүд нь Гадаад харилцааны яам болон бусад яамд, агентлагуудын чадавх сайн байхыг шаардаж байна. Шинжилгээний чадвар, худалдааны идэвхитэй бодлого, хэлэлцээрийн төлөвлөгөө шаардлагатай. Цаашид үүнийг дэмжих үүднээс энэхүү стратегийн зорилт нь бодлогын боловсрол, судалгаа, шинжилгээний экосистемийг өргөн хүрээнд бэхжүүлэхэд чиглэнэ.

Түүнчлэн, энэхүү стратегийн зорилт нь үндэсний хөгжлийн зорилттой уялдсан худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогыг хянах, хөгжүүлэх, хэрэгжүүлэх, бусад холбогдох бодлогын хүрээнд харилцан уялдаатай ажиллах хүчин чармайлт гаргах болно. ХХОЗЗ нь одоогийн болон ирээдүйн худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого, гэрээний хүрээн дэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн алхмуудыг дэмжих болно.

ХХОЗЗ нь ухаалаг либералчлал, худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогыг илүү ил тод, идэвхитэйгээр дэмжиж, бизнесийн орчинг сайжруулах, бодлогын боловсруулалт, хэрэгжилтийн үйл явцад итгэх итгэлийг бэхжүүлэх үйл ажиллагааг дэмжинэ. ХХОЗЗ-ийн хүрээнд Монгол Улсад тулгарч буй сорилт, боломжуудыг тодорхойлохын тулд дотоодын болон гадаадын хувийн хэвшлийн оролцогчидтой албан ёсны зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах бөгөөд худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогын хөгжлийн хүрээнд холбогдох байгууллагыг төлөөлөх экспортын болон хөрөнгө оруулалтын зөвлөлийг байгуулав. Зөвлөл нь Төр, хувийн хэвшлийн зөвлөл, Экспортын зөвлөл, Хөрөнгө оруулалтын зөвлөл зэрэг болон бусад одоо ажиллаж байгаа байгууллага бүтцүүд дээр суурилан ажиллана. Шинэ хөрөнгө оруулалтын шинэчлэлийг үр дүнтэйгээр зохицуулах, хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх нь бизнесийн орчныг таамаглаж болохуйц байдал руу чиглүүлэн дэмжихэд тэргүүлэх ач холбогдолтой юм. Зөвлөл нь Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо (ТХХЗХ), Экспортын зөвлөл, Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл зэрэг үйл ажиллагаа явуулж буй бүтцүүд дээр тулгуурлан хөгжинө.

Хөрөнгө оруулалтын шинэчлэлийг үр дүнтэй зохицуулах, хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх нь илүү таамаглах боломж бүхий бизнесийн орчныг дэмжихэд тэргүүлэх ач холбогдолтой юм.

## СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2: ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ, ТЭДГЭЭРИЙН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ

Энэхүү стратегийн зорилт нь худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжигч байгууллагуудын (ХХОДБ) чадавхийг бэхжүүлэх зорилготой бөгөөд ингэснээр Монголын компаниуд олон улсын түвшинд гарах боломжтой болох юм. Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллага (ХХОДБ)-аас үзүүлдэг үйлчилгээ буюу олон нийтэд сурталчилан таниулж дэмжих, холбоо харилцаа тогтоож өгөх, зах зээлийг нь тэлж хөгжүүлэхэд шууд туслалцаа үзүүлэх зэрэг нь, ихэвчлэн нөөц эх үүсвэр бага, байгууллагын цар хэмжээ, туршлага хомс, гадаадад үйл ажиллагааг нь дэмжих үр дүнтэй экосистем байдаггүйн улмаас худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаанаас үр өгөөж хүртэхүйц холбоо харилцаа тогтоож чаддаггүй ЖДҮ нарт нэн ялангуяа их чухал байна.

ХХОЗЗ-ийн хүрээнд үндсэн чиглэл, үүрэг хариуцлагыг тодорхой болгох, чадавхийг бэхжүүлэх санаачлагууд, ХХОДБ-уудын хоорондын хамтын ажиллагааг дэмжих замаар Монгол Улсын ХХОДБ-уудад тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэхэд туслана. Монголын эдийн засагт өргөн хүрээг хамарсан өсөлтөд хүрэх зорилгоор ХХОДБ-уудад худалдааг дэмжих үйлчилгээ, хөрөнгө оруулагчийг онилох, сурталчилгаа болон хөрөнгө оруулалтын дараах үйлчилгээ зэрэг чиглэлүүдээр туслалцаа үзүүлнэ. Олон улсын худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг олон тооны компаниудад тулгарч буй захиргааны ХХОЗЗ нь худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийж, худалдааны үйл явцыг хурдасгаж, урагшлуулна. Төрийн албаны тогтвортой байдал, мэргэжлийн ур чадварыг сайжруулах зэрэг нь засаглал, бизнесийн орчныг сайжруулахад чиглэгдсэн байдаг.

ХХОЗЗ нь хөгжлийн бусад түншүүдийн хамт Монгол Улсын чанарын удирдлагын тогтолцоог цаашид хөгжүүлэх арга хэмжээг багтаах болно. Чанарын удирдлагыг сайжруулснаар монголын бүтээгдэхүүнийг өндөр үнэ цэнэтэй, экспортын тогтвортой зах зээлд илүү сайн байр суурь эзлэх, өндөр стандартыг шаардаж буй шинэ хөрөнгө оруулалтыг дэмжихэд туслах болно. Санал болгож буй арга хэмжээнүүдэд нь, баталгаажуулалтын үйл явцыг сайжруулж, оролцогч талуудад зах зээлийн мэдээллийн талаар мэдлэг олгох, нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх зэрэг орно

## СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 3: ЗАХ ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА ХАНГАХ, МӨН ЭКСПОРТЫН ХАРИЛЦААГ ТОГТВОРТОЙ БАЙЛГАХ ЧИГЛЭЛЭЭР КОМПАНИУДЫГ ЧАДАВХЖУУЛАХ

Энэхүү стратегийн зорилт нь экспортын харилцааг бий болгох, тогтвортой байлгахын тулд компанийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэнэ. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь шууд ба шууд бус экспорттой өндөр, эерэг хамааралтай байгаа тул ХХОЗЗ нь компаниуд худалдаа, хөрөнгө оруулалтын боломжуудын үр шимийг нь хүртэхэд туслах чиглэлд арга хэмжээ авахыг зорино.

ХХОЗЗ-ийн хүрээнд авах арга хэмжээнүүд нь хувийн хэвшлийн зохион байгуулалт, харилцааг дэмжих замаар компаниудад дэмжлэг үзүүлнэ. Хувийн хэвшлийн хамтрагч бүх талуудын хоорондын уялдаа холбоо нь нэмүү өртгийн сүлжээнд илүү өндөр үр ашигтайгаар оролцох боломжийг олгоно. Түүнчлэн салбарын холбоод нь гишүүдийнхээ хэрэгцээ, шаардлагыг илэрхийлэн төлөөлж, одоогийн хэрэгжиж буй чиглэлүүд болон илүү үнэ цэнтэй үйлчилгээг хүргэх чиглэлд салбарын холбоодын чадавхийг сайжруулан ажиллана.

Экспортын шинэчлэл, шинэ технологийг нэвтрүүлэхэд саад болж буй ур чадварын дутагдлыг арилгахын тулд ХХОЗЗ нь боловсролын тогтолцоог хувийн хэвшлийн хэрэгцээнд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг тодорхойлсон. Эдгээр нь сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, харилцан зөвлөлдөх замаар ур чадварын дутагдлыг тодорхойлох явдал юм. ХХОЗЗ нь зах зээлд нэвтрэх асуудлууд, олон улсын маркетинг болон бусад олон улсын зах зээлийн талаарх стратеги, сургалт, зах зээлийн судалгааны хэрэгсэл, худалдан авагч, хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрүүдээр дамжуулан компаниудын мэдлэгийг нэмэгдүүлэх болно.

## СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4: БИЗНЕС ЭРХЛЭХ УР ЧАДВАР, ГАРААНЫ БИЗНЕСИЙН ОРЧИН НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛЖ, МЭДЛЭГТ СУУРИЛСАН САЛБАРУУД РУУ НЭВТРЭХ ЗАМААР ИННОВАЦИ, БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ

ХХОЗЗ нь бүтээлч байдлыг дэмжин хөгжүүлэх болон худалдаа, хөрөнгө оруулалтын аргуудаар эдийн засгийг төрөлжүүлэхийг дэмжих зорилготой. Ингэхдээ замын зураглал нь бизнес эрхлэгчийн сэтгэлгээг идэвхитэй дэмжих чиглэлийг баримтална. ХХОЗЗ нь гарааны бизнест ээлтэй экосистемийг бий болгоход зорилтот урамшуулалаар дэмжин ажиллана. Гарааны бизнесийг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор, зохицуулалтын саад бэрхшээлийг арилгах, инкубатор хамтран ажиллах ажлын байр, хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт, бусад хэрэгслүүдийг ашиглана. ХХОЗЗ-д залуучуудын бизнес эрхлэлтийн сэдлийг дэмжихэд чиглэсэн тусгай хөтөлбөрүүдийг тусгасан болно.

ХХОЗЗ нь Монгол Улсын боловсролын тогтолцоогоор дамжуулан бизнес эрхлэгчдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх боломжийг эрэлхийлнэ. Ерөнхий боловсролын хүрээнд хувиараа хөдөлмөр эрхлэх карьер боломжийг танилцуулж, хувиараа бизнес эрхлэлтийн талаар мэдээлэл өгөх, ямар боломж, сонголтууд байдаг талаар сургах нь чухал юм. Бизнес эрхлэлтийн сэтгэлгээг тухайн чиглэлийг сонгон суралцах, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, мэргэжил сонголтын семинар, бизнесүүдэд зочлох зэрэг замаар дэмжих нь зүйтэй. Үүнтэй төстэйгээр, мэргэжлийн сургалт, дадлага олгох хөтөлбөрийг сонгон авч, бизнес эрхлэх сургалтыг нэвтрүүлэх, жижиг бизнес эрхлэгчдийг мэргэшлийн чиглэлээр хэрхэн хөгжүүлэх талаар суралцахад нь дэмжлэг үзүүлнэ. Энэхүү стратегийн зорилт нь инкубатор, бизнес эрхлэх төвүүдийг хөгжүүлэн бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх инкубаторуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэнэ. Үүнээс гадна, хувийн хэвшил, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар мэдлэгийн шилжилтийг дэмжинэ.

Бизнес эрхлэлт, технологи, инноваци нь харилцан нэгнээ дэмждэг, хоёр талт харилцаа юм. Технологи нь үр ашгийг дээшлүүлэх, бүтээмжийг сайжруулах шинэ хэрэгсэл бүхий бизнес эрхлэгчдийг төрүүлдэг. Бизнес эрхлэгчид нь харин байгаа бүтээгдэхүүнээ илүү боловсронгуй болгох, арилжааны хэлбэрт нэвтрүүлэх замаар бизнесээ хөгжүүлж технологийн инновацийг дэмждэг Энэхүү стратегийн зорилт нь зорилтот хөрөнгө оруулалтыг татах болон улс орны хэмжээнд оюуны өмчийн зохицуулалтыг сайжруулан бэхжүүлэх замаар Монгол Улсын олон улсын мэдээллийн технологи, технологи, инноваци болон бусад мэдлэгт суурилсан үйлчилгээний чиглэл дэх манлайллыг дэмжин ажиллах юм.

## ТЭРГҮҮЛЭХ САЛБАРУУД

Монгол Улсын худалдаа, хөрөнгө оруулалтын замналыг чиглүүлэх дөрвөн стратегийн зорилтод хүрэхийн тулд ХХОЗЗ-аар найман тэргүүлэх салбарыг тодорхойлсон. Ингэхдээ хэд хэдэн тоон болон чанарын аналитик параметрүүдийг ашиглан сонгов. Дунд хугацаанд экспорт, хөрөнгө оруулалтын өсөлт нь малын гаралтай бүтээгдэхүүн (ноолуур, сарлаг, тэмээний ноос, мах, боловсруулсан мах, сүүн бүтээгдэхүүн, арьс шир), үйлчилгээний салбар (мэдээлэл, харилцаа холбооны технологи, аялал жуулчлал), Монголын байгалийн нөөц (сэргээгдэх эрчим хүч, боловсруулсан ашигт малтмал зэрэг)-д суурилсан эдийн засгийн салбаруудад үүснэ.

## НООЛУУР

Нүүдлийн мал аж ахуйн хоёр мянган жилийн өв соёлд суурилсан ноолуурын дэд салбар нь Монголын эдийн засгийн хүрээнд, тэр дундаа хөдөлмөр эрхлэлтийг бий болгох, үйлдвэрлэл, инноваци, нэмүү өртгийн сүлжээ, олон улсын худалдаанд чухал байр суурь эзэлдэг. Үндэсний статистик тоо баримтаас харвал Монголын ноос, ноолуур, нэхмэлийн салбарын экспортын хэмжээ нь 2014-2018 онд 20.97 хувиар өсч, 2018 онд 409.8 сая ам.долларт хүрсэн байна.[9] Ноос, ноолуурын салбарын үйлдвэрлэлд ажиллах хүч нь нь нийт боловсруулах үйлдвэрийн 12 хувийг эзэлж байгаа бөгөөд эмэгтэйчүүд болон залуучуудын ажил эрхлэлтийн байдлаар дэд салбартаа 85 болон 65 хувийг тус тус бүр бүрдүүлж байна.[10] Монгол ноолуур нь дэлхийн нийт ноолуурын үйлдвэрлэлийн 40 хувийг бүрдүүлж[11], 48-52 хувийг дангаараа бүрдүүлдэг Хятадын дараа эрэмбэлэгдэж байна.[12] Монголын олон улсын худалдаанд эзлэх байр суурийн хувьд ноолуур нь улсын хамгийн том уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүн бөгөөд нийт экспортын гуравдугаарт орж байна. Ноолуур нь үнэ цэнэ, овор хэмжээний харьцаа өндөр, тансаг эдлэл бөгөөд олон улсын зах зээл дээр өндөр үнэд хүрдэг тул экспортлоход амар бөгөөд ашигтай бүтээгдэхүүн юм. Монгол ноолуурын онцлог чанар нь Герман, Хонконг, Америкийн Нэгдсэн Улс, Канад, Япон, Франц зэрэг олон улсын үзэсгэлэн яармагт өндрөөр үнэлэгддэг.

## Ноолуурын дэд салбарт тулгамдаж буй өрсөлдөх чадварын асуудлууд

Салбар нь боловсруулах чадавхийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан, өрсөлдөх чадварын хүндрэлтэй тулгарч байна. Монгол Улсад 298 боловсруулах үйлдвэр үйл ажиллагаа явуулдагаас 250 нь өрхийн жижиг цех, 6 нь жижиг, дунд хэмжээний сүлжмэлийн үйлдвэр, 1 ээрмэл, сүлжмэлийн үйлдвэр, 2 самнах, сүлжмэлийн үйлдвэр, 8 бүрэн автоматжсан, сүлжмэл, нэхмэл, оёдолын машинуудаар бүрэн тоноглогдсон үйлдвэр, 6 самнах, ялгах үйлдвэр, 25 угаах, анхлан боловсруулалтын үйлдвэрүүд байна.[13] Ээрмэлийн үйлдвэрүүд нь их хэмжээний ээрмэл утас үйлдвэрлэх хүчин чадалтай хэдий ч, түүнийхээ дөнгөж 60-70 хувийг л ашигладаг.[14] Дотоодын зах зээл ээлэлтээрээ 93 хувийг бүрдүүлдэг 10 том, гүн боловсруулах үйлдвэрүүдийн хувьд жилд 1,600 тн ээрмэлийн хүчин чадалтай байна[15]

> Ноолуурын салбарт ажиллаж буй жижиг дунд аж ахуйн нэгжүүд ур чадвартай хүний нөөцийн дутагдалтай байгаатай холбоотой бэрхшээл тулгардаг байна.
> **Сноу Филд ХХК-ийн Ерөнхий захирал. Ц.Ган-Өлзий**

Нийт үйлдвэрлэлийн хүчин чадал дараах байдлаар тогтоогдож байна. Үүнд: 12,980 тн ноолуур угаах, 4,606 тн ноолуур самнах, 1,280 тн утас ээрэх, 2.8 сая ширхэг сүлжмэл хувцас, хэрэгсэл, 1,868 метр нэхмэл эдлэл үйлдвэрлэх хүчин чадал байна. Хэдий тийм ч суурилуулсан нийт боловсруулалтын хүчин чадлын зөвхөн угаах процессыг бүрэн ашигладаг бөгөөд үлдсэн гүн боловсруулалтын шатууд нь ашиглалтын хувь харьцангүй бага буюу самнах хүчин чадлын 20 хувь, сүлжих хүчин чадлын 25 хувь, нэхэх хүчин чадлын 70 хувьтай байна

Түүхий ноолуурын боловсруулалтын ихэнх хувь нь хилийн чанадад хийгддэг.[16] Монгол малчдын нийлүүлж буй 9,400 тн түүхий эдээс дөнгөж дөрөвний нэг хэсгийг л дотооддоо хагас боловсруулсан, бүрэн боловсруулсан эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулж, үлдсэнийг нь

боловсруулаагүй түүхий ноолуур, ямааны ноос хэлбэрээр хямд үнээр экспортолж байгаа нь Монгол Улсын нэмүү өртөг шингээх боломжийг алдагдуулж байна.[17] Цаашилбал, ноолуурын гүн боловсруулалтын нөхцөл байдал муу байгааг тус бүр экспортын 5.19, 0.53, 0.08 хувийг[18] л тус тус ээлэх сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүний хэмжээнээс харах боломжтой. Харин нарийн ноолуурын 12-22 хувийн агууламжтай боловсруулаагүй ноолуур, самнасан ноолуур 77.26 болон 14.01 хувийг тус тус бүрдүүлж байна.[17]

Уг салбар нь олон улсын зах зээл, дотоодын институциудтай харилцаа сул байдаг. МАА-н салбар, нэхмэлийн үйлдвэрлэл, боловсролын салбар хоорондын уялдаа холбоо сул байгаа нь чадварлаг оёдлын инженер, техникч, загвар зохион бүтээгчид дутагдалтай байхад нөлөөтэй. Энэ салбартай харьцуулахад өндөр цалин олгодог тул төгсөгчдийн хувьд уул уурхайн салбар илүү таатай сонголт болсон хэвээр байна. Мэргэжилтэй ажиллагсдын дутагдал нь үйлдвэрүүдэд мэргэжлийн бус хүмүүсийг ажиллуулах болон тэднийг сургахад ихээхэн хэмжээний зардал зарцуулахыг шаарддаг. Сургагч багш нар нь өөрсдөө мэргэжлийн бус байдгаас сургалтуудын цар хүрээ нь хангалтгүй түвшинд явагддагаас гадна сургалтын хөтөлбөрийн хүртээмж хангалтгүй байна.

Монгол ноолуурын гол зах зээл нь Хятад улс хэвээр байсаар байна. Монголын ноолуурын салбар нь Европын холбооны ХЕС, Япон улстай байгуулсан ЭЗТХ-ийн дагуу хөнгөлөлттэй тарифтай байдаг. Үүнээс гадна, салбар нь олон улсын стандарт, гаалийн төвөгтэй процедур, олон улсын брэндинг, маркетингийн асуудлуудтай тулгардаг. Түүнчлэн эргэлтийн хөрөнгийн зээлийн хүртээмж дутмаг байдагтай холбоотойгоор үндэсний үйлдвэрүүд нь түүхий ноолуурыг малчдаас худалдан авах боломж нь хязгаарлагддаг. Ингэснээр гадаадын компаниуд түүхий ноолуурыг малчдаас хямд үнээр шууд худалдан авах боломжийг олгож, нэмүү өртөг шингэсэн ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх дотоодын боловсруулагчдад багахан хэмжээгээр оногддог. Тухайлбал, 2018 онд Монгол Улс 251.9 сая ам.долларын боловсруулаагүй буюу угаасан ноолуурыг зөвхөн Хятад улс руу экспортолсон бол, үүнээс хэд дахин бага буюу 24 сая ам.долларын хэмжээний эцсийн боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн болох сүлжмэл нэхмэл бүтээгдэхүүнийг АНУ, Итали, БНСУ, Япон, Их Британи, Хятад, ОХУ, Канад, Герман, Франц, Хонконг улсуудад экспортолсон байна.[18]

Дотоодын зах зээлийн бодлогыг чөлөөлсөнтэй холбоотойгоор боловсруулах үйл ажиллагаанд ямар нэгэн урамшуулал, дэмжлэг үзүүлдэггүй тул түүхий ноолуурын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нь илүү үр ашигтай болж, 1993 оноос 2018 оны хооронд ямааны тоо толгой эрс нэмэгдэж, 6.1 саяаас 27.1 сая болсон байна.[19] Дэлхийн цаг уурын өөрчлөлтийн үүднээс авч үзвэл энэ тэнцвэргүй өсөлт нь байгаль орчны хувьд цөлжилтийг нэмэгдүүлэх, бэлчээрийн талхагдал зэргээр Монголын бэлчээрийн мал аж ахуйн салбарын урт хугацааны тогтвортой байдалд шууд заналхийлж байна.

---

[9]Mongolian Statistical Information Service. Available at http://www.1212.mn/

[10]Data by Mongolian Wool and Cashmere Association

[11]Ministry of Food, Agriculture and Light Industry (2019). “Manufacture of wool and cashmere products”. Available at http://mofa.gov.mn/exp/blog/11/175

[12]Ibid

[13]Ibid

[14]Uniterra, WUSC, Canada (2016) “Value Chain and Market System Analysis Report of Fibre Sub-sector of Mongolia”

[15]EBRD (2018). “Supporting Sustainable Cashmere Production”

[16]Ministry of Food, Agriculture and Light Industry (2019)

### Эдгээр бэрхшээлийг даван туулахад богино болон урт хугацааны өөрчлөлтүүд шаардлагатай

Богино болон дунд хугацаанд одоо үйл ажиллагаа явуулж байгаа дотоодын боловсруулагчдын үйлдвэрлэлийн хүчин чадлыг одоогийн хамгийн том зах зээл болох Хятадад зориулж сүлжмэл, нэхмэл, оёмол, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түлхүү чиглүүлэх хэрэгтэй. Ингэхийн тулд төр, санхүүгийн байгууллагууд, үйлдвэрлэгч нар хамтран, дотоодын үйлдвэрлэгчид түүхий ноолуурыг худалдан авах процесст олгох санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг боловсруулан хөгжүүлэхийг шаардана. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлогчдод татварын хөнгөлөлт үзүүлэх, боловсруулаагүй ноолуурын хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг боловсруулагчдад үзүүлэх дэмжлэгийг авч үзэх хэрэгтэй. Түүнчлэн түүхий эдийн чанарыг сайжруулж, малчдын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр түүхий эдийг ялгах, бэлтгэх чиглэлээр сургалт явуулах шаардлага байна. Хөгжилтэй орнуудын мэргэжилтнүүдийг авчран, нэхмэлийн техник, технологийн чиглэлээр ажиллагсдын сургах шаардлагатай. Инженерүүд зэрэг техникийн ажилтнуудыг бусад улсуудын нэхмэлийн үйлдвэрийн туршлагаас суралцуулах болон үзэсгэлэнд хамруулах нь хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх боломжтой. Шинжлэх ухаан, технологийн их сургууль (ШУТИС) нь ээрэх, сүлжих, нэхэх, оёх лабораторитой бөгөөд богино хугацаандаа ажиллагсдын сургалтыг сайжруулах зорилгоор энэ нөөц боломжид тулгуурлах боломжтой. Загвар дизайн болон бусад холбоотой сургалтууд зэргээр бүтээлч байдлыг дэмжих нь салбарын инноваци, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

[17]Mongolian Customs (2019). Available at http://www.ecustoms.mn/
[18]Ibid
[19]Ibid
[20]Mongolian Customs (2019). Available at http://www.ecustoms.mn/
[21]Mongolian Statistical Information Service. Available at http://www.1212.mn/

## **Хайрцаг 7.** НООЛУУРЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Салбарын боловсруулалтын түвшин доогуур байгаа үндсэн шалтгаан нь санхүүжилт, мэдлэг, технологи ашиглалтын хангалтгүй байдал юм. Салбар дах бэлэн мөнгөний урсгалыг нэмэгдүүлэх нь малчдад түүхий ноолуурын чанарыг сайжруулах урамшуулал олгох, дотоодын боловсруулагчдад түүхий ноолуурыг орон нутгийн малчдаас худалдан авах боломжийг нэмэгдүүлэх, боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлэх, Монголын үйлдвэрлэгчид нэхмэлийн хамгийн сүүлийн үеийн технологиор хувцас, хэрэгсэл үйлдвэрлэх, мэргэшсэн ажиллагсдын дутагдлыг нөхөх сургалтын төв байгуулах зэрэг олон талын ач холбогдолтой. Төрөөс Үйлдвэржилтийн бодлого, "Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөр дэх техник, эдийн засгийн үндэслэл дээр тулгуурлан 21 аймагт 100 боловсруулах үйлдвэр байгуулахыг зорьж байна.

Хөрөнгө оруулалт нь салбартаа хүний нөөцийг бэхжүүлэх боломжийг дагуулдаг.

Шууд утгаараа малчдад зориулсан түүхий эдийн чанарыг сайжруулах сургалт, одоо байгаа үйлдвэрлэлийн хүчин чадлыг бүрэн ашиглах чиглэлээр үйлдвэрлэгчдэд зориулсан сургалт болон инженер, техникч, хувцасны дизайнер зэрэг мэргэшсэн ажилтнуудын ур чадварыг хөгжүүлэх сургалт зэргийг санхүүжүүлэх боломжтой. Лабораторийн зохих техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх зэргээр сүүлийн үеийн дэвшилтэт технологид хөрөнгө оруулалт хийх нь дагалдах ур чадварыг сайжруулах шаардлагад хөтөлдөг. Гадаадын хөрөнгө оруулалт нь олон улсын экспо, худалдааны үзэсгэлэн, семинар, олон улсын судалгаа, үйлдвэрлэлийн туршлагаас судлах зэргээр олон улсын харилцаа, мэдлэгийн урсгалыг сайжруулах ач холбогдолтой. Үүнээс гадна, хөрөнгө оруулагчид нь дотоодын үйлдвэрлэлд ашиг тусаа өгөх менежментийн шинэ туршлага, техникийн ур чадварыг авчирч нутагшуулдаг

Урт хугацаанд “Ноолуур-Үндэсний хөтөлбөр”-т тусгасан орц, боловсруулалт, бодлогын түвшний өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэхэд чиглэх хэрэгтэй. Үүнд: хууль эрх зүй, хөрөнгө оруулалт, татварын орчныг сайжруулах, ямааны аж ахуйг сайжруулах, ноолуурын чанарыг сайжруулах, гүн боловсруулалтын хувийг 60 хувьд хүргэх[20], байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, салбарын хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийг мэргэшүүлэх сургалт зэрэг багтана. ,

“Ноолуур-Үндэсний Хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсний үр дүнд ноолуурын салбарын 5,500 ажлын байрыг хадгалахаас гадна 3,600 ажлын байр шинээр бий болгож, улмаар эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспорт 5.7 дахин нэмэгдэнэ. Түүнчлэн “Ноолуур-Үндэсний Хөтөлбөр”-т дурьдсанчлан ХХААХҮЯ-ны ур чадвартай хүний нөөцийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд утас ээрэх шугамын үйлдвэрлэлийн хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хүний нөөцийг бэлтгэн сургах чиглэлээр ШУТИС-ийн лабораториуд нь орчин үеийн нэхмэлийн машин, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх ёстой бөгөөд түүнээс гадна олон лаборатори нь орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх хэрэгтэй.

Бизнесийг дэмжих үйлчилгээг сайжруулахын тулд ноолуурын болон бусад бүтээгдэхүүнийг гадаадад үр дүнтэй сурталчилахын зэрэгцээ Гадаад улсаас Монгол Улсад суугаа элчин сайдын яамд, Монгол Улсын элчин сайдын яамд, консул, худалдааны төлөөлөгчдийн дэмжлэгийг авах хэрэгтэй.

Ноолуурын хөтөлбөрөөс гадна нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний боломжит зах зээлүүд рүү анхаарлаа шилжүүлэн төвлөрүүлэх хэрэгтэй. Монголын ноолууран хувцасны хамгийн их боломжит зах зээл бол Япон, БНСУ, ОХУ зэрэг бөгөөд АНУ-д хамгийн өндөр эрэлттэй байдаг.[23]

Гарал үүслийн системийг нэвтрүүлж, гаалийн бичиг баримтын дарамтыг багасгах, хилийн хяналт шалгалтыг түргэсгэх зэрэг худалдааг хөнгөвчлөх механизмыг сайжруулах хэрэгтэй. Бодлогын түвшинд ноолуурын үндэсний хөнгөлөлтийг эргэж харах, тарифын болон тарифын бус арга хэрэгсүүдээр дамжуулан угаасан ноолуурын экспорт, хямд үнэтэй нийлэг утасны импортыг хязгаарлах арга хэмжээнүүдийг судалж, нэвтрүүлэх шаардлагатай.

[22]“CASHMERE – NATIONAL PROGRAM 2018-2021”, 2019, PHASE II 2020-2021

**Зураг 16.** Монголын ноолууран бүтээгдэхүүний экспортын боломжит зах зээлүүд




Эх сурвалж: ОУХТ экспортын боломжийн зураг..

[23]ITC'S EXPORT POTENTIAL MAP

## САРЛАГ, ТЭМЭЭНИЙ НООС

Сарлаг, тэмээний ноос нь чанарын хувьд ямааны ноолууртай өрсөлдөхүйц хэмжээний түүхий эд болохын зэрэгцээ сарлаг, тэмээ нь бэлчээрт учруулах хор хөнөөлийн хувьд ямаанаас бага, экологид ээлтэй түүхий эд юм. Дэлхий нийтийн зах зээлийн зан төлөв нь тогтвортой үйлдвэрлэл болон гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүний худалдан авалт руу хандаж байгаа энэ үед сарлаг, тэмээний ноосны салбар нь малчдын орлогыг өсгөх боломж болохын зэрэгцээ Монгол Улсын байгаль орчин, өв соёлыг хамгаалан хадгалахад өндөр ач холбогдолтой салбар юм. Хязгаарлагдмал нөөцтэй холбоотойгоор ноолуурын үнэ өсч байгаа нь өсөн нэмэгдэх эрэлт болон инфляцийн нөлөөллөөр сарлагийн ноосны үнийг өсгөх магадлалтай. Хэдийгээр тэмээний ноос үйлдвэрлэл нь сарлагийн хөөврөөс илүү хэмжээтэй байдаг ч, боловсруулалтын хувьд сарлагийн хөөвөр тэргүүлж байна.[24] Сүүлийн үеийн судалгаагаар сарлагийн хөөврийн 40 хувийг жилд боловсруулдаг бол тэмээний ноосны 25 хувийг л дотоодын боловсруулагчид ашигладаг болохыг харуулсан байна.[25] Энэ нь компаниуд тэмээний ноосыг их хэмжээгээр боловсруулахаас цааргалдагтай холбоотой байх магадлалтай. Учир нь тэмээний ноос нь өндөр хэмжээний элсэнцэр, тоос шороо, хүнсний ногооны үлдэгдэл зэргийн бохирдолтой байдаг бөгөөд түүнийг угааж боловсруулах нь тоног төхөөрөмж, эд ангиудыг гэмтээж, хүрээлэн буй орчинг бохирдуулдаг өндөр зардалтай үйл ажиллагаа юм. Олон улсын худалдааны хувьд ОХУ нь сарлаг, тэмээний ноосон бүээгдэхүүний экспортын гол зах зээл бөгөөд, Герман улс нь сарлагийн хөөврийн бүтээгдэхүүний гол зах зээл юм.[26] Монгол Улсын Засгийн газар нь дэд салбаруудын хөгжилд зориулан хөнгөлөлттэй зээл олгосон бөгөөд энэ нь салбарт эерэг нөлөө үзүүлж байна. Тухайлбал, Эко Вүүл ХХК нь ноосон дулаалгын материал үйлдвэрлэхэд зориулж 6.4 тэрбум төгрөгийн зээл авсан бол Эрдэнэт хивс ХХК нь ноосон хивсэндээ олон улсын чанарын баталгааны шошго болох “Вүүлмарк” авсан нь Монгол Улсдаа анхдагч юм. .



Photo: ©Ministry of Foreign Affairs

### Хэдийгээр сайжирсан ч ноосны салбар нь олон сорилттой тулгарч байна

Энэ салбар нь хангалтгүй чанар, боловсруулалтын хэмжээ бага тул өрсөлдөх чадвар багатай. Ихэнх малчид самнахын оронд хяргах техникийг ашигладаг нь чанар муу, хэмжээ бага гарцад нөлөөлдөг. Энэ нь самнах техникийн талаар малчдын мэдлэг хязгаарлагдмал бөгөөд самнах нь ихээхэн гар ажиллагаа, цаг хугацаа шаардсан ажил байдагтай холбоотой. Өгөөж нь харьцангуй бага тул ийм үйл ажиллагаа эрхлэх хөшүүрэг муу байдаг.[27]

> “Дэлхийн нэхмэлийн зах зээлд өрсөлдөх чадвартай байхын тулд манай дотоодын үйлдвэрлэгчдэд техник, инженер, технологийн нарийн мэдлэг, мэргэжилээс гадна дэлхийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, загвар, өнгө, бүтэц, хэмжээ, биед суух байдал зэргийн өндөр мэдлэг шаардлагатай байна”
> НОЁН. ЭРДЭНЭБАТ, ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ, МОГОЛНООС ХК

[24]The Green Gold Project (2014). Demand Study on domestic and foreign markets
[25]The Green Gold Project (2014)
[26]Mongolian Customs (2019). Available at http://www.ecustoms.mn/
[27]Mongolian Customs (2019). Available at http://www.ecustoms.mn/

**Зураг 17**. Сарлагийн хөөвөр, тэмээний ноос үйлдвэрлэгчдийн нэхмэл, сүлжмэлийн хүчин чадал, хэрэглээ (ширхэгээр), 2014




***Эх сурвалж:*** ШХА, Ногоон алт хөтөлбөр.

Түүнчлэн малчид, боловсруулагчид, санхүүгийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо сул байгаа нь салбарт тулгамдаж буй сорилт юм. Малчид компаниудтай хангалттай уялдаа холбоогүй гэж өөрсдийгөө үздэг бөгөөд энэ нь тэднийг үнэ, чанарыг хүссэнээрээ тогтоох томоохон үйлдвэрүүдэд барьцаалагдахад хүргэдэг. Боловсруулалтын тал дээр компаниудын дийлэнх нь малчдын хоршоодод шууд хүрч чаддаггүй тул, худалдан авах боломжит түүхий эдийн хэмжээ буурч, улмаар боловсруулах зардлыг нь өсгөдөг. Салбар нь санхүүжилт, мэргэжилтэй ажиллагсдын хүртээмж муу, хангалтгүй маркетинг зэрэг саад тотгортой тулгардаг бөгөөд энэ нь өсч хөгжих боломжийг нь хязгаарладаг. Хэд хэдэн үйлдвэрүүд өөрсдийн хэрэгцээт хэмжээний түүхий эдийг худалдан авахад шаардагдах санхүүжилтийг авч чадахгүй байгаа талаар хэлж байв. Салбар нь Хятадаас хямд үнээр оруулж ирдэг хямд нийлэг утастай үнээр өрсөлдөх боломжгүй. Маркетингийн хувьд нийлэг утсыг "Монголд үйлдвэрлэв" шошготойгоор зах зээлд нийлүүлж, улмаар Монгол брэндийн, органик, байгалийн гаралтай утасны үнэ унахад хүрсэн тохиолдлууд гардаг. Цаашилбал, сарлагийн хөөврийг загварын чиг хандлагаас илүү байгаль орчин болон нийгэмд ээлтэй гэсэн хандлагад суурилан сонгодог. Энэ хандлага нь "сарлагийн түүх"-ийг хүүрнэхэд ихээхэн чухал боловч, экспортын зах зээл дэх байр суурийг өсгөхөд төдийлөн ач холбогдолгүй юм. Үүний үр дүнд, сарлагийн хөөвөр нь дунд болон доогуур зэрэглэлийн зах зээлийн сегментүүд болох худалдааны төвүүд, бэлэн хувцас, загварын дэлгүүрүүдээр бараг байдаггүй. Загвар, нэхмэлийн ур чадвар сайтай ажиллагсдын хомсдол нь загвар муутай бүтээгдэхүүн гарахад нөлөөлж, асуудлыг улам хурцдуулдаг.



**Photo:** ©Ministry of Foreign Affairs

Салбарт тулгарч буй бусад бэрхшээлүүд нь Засгийн газрын худалдан авалтын бодлого үр дүнгүй, олон улсын зах зээлд гарцгүй зэрэг юм.

## Эдгээр сорилтуудыг даван туулбал боломжит өсөлтийн түвшинд хүрнэ

Богино болон дунд хугацаандаа малчид ноос самнах хэрэгсэл, туршлагаар хангагдах, одоогийн боловсруулалтын үйлдвэрүүдийн ашиглалтыг нэмэгдүүлэх, ОХУ, Герман зэрэг нэвтрэн орсон томоохон зах зээлүүд рүү нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлоход хүчин чармайлтаа төвлөрүүлэх зэрэг нь чухлаар тавигдана. Түүнчлэн, компаниудад боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийг их хэмжээгээр худалдан авахад нь дэмжлэг, туслалцаа хэрэгтэй. Тухайлбал, малчин-үйлдвэрлэгчийн шууд холбоог бий болгох замаар, үйлдвэрлэлийн зардлыг бууруулах боломжтой. Малчид үйлдвэрлэгчдэд нийлүүлэх борлуулалтаа нэмэгдүүлж, орлогоо өсгөх үүднээс тэмээний ноосыг сайтар цэвэрлэх зэрэг нэмүү өртөг шингээсэн үйл ажиллагааны сургалт хөтөлбөр явуулах хэрэгтэй.

## **Хайрцаг 8.** САРЛАГИЙН ХӨӨВӨР, ТЭМЭЭНИЙ НООСНЫ САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Ноосны салбарт хөрөнгө оруулалт хийх нь үйл ажиллагааг нь хялбарчлах нарийн ширхэгт самнах техник, багаж хэрэгслийг нэвтрүүлэх замаар түүхий эдийн чанарыг сайжруулах ач холбогдолтой. Түүнчлэн, түүгээр дотоодын үйлдвэрлэгчдийн түүхий эдийн худалдан авалт, нэмхэл эдлэл үйлдвэрлэх, ноос угаах, автомат боловсруулах үйлдвэрүүд байгуулах үйл ажиллагаа зэргийг санхүүжүүлж, тэмээний ноосны боловсруулалтыг нэмэгдүүлэх боломжтой. Гадны санхүүжилтээр нэхмэл эдлэл, оёдлын үйлдвэрлэлийн Монголд үйлдвэрлэв брэндийг бий болгох, мөн экспортын өндөр зэрэглэлийн зах зээлтэй холбоход туслах боломжтой. Хөрөнгө оруулалт нь тээвэр, агуулахын дэд бүтцийг сайжруулах, ноос үйлдвэрлэлийн зориулалттай бүсийг барьж байгуулахад туслана.

Урт хугацаандаа шинэ, автоматжуулсан самнах үйлдвэрүүдийг бий болгож, үнэ цэнэ, чанар болон гарал үүслийн мэдээллийг сайжруулах үүднээс байгалийн утсыг ялгах, савлах, хаяглаж, шинэ аргачлалыг нэвтрүүлэх шаардлагатай. Цаашилбал, боловсруулагчид нь олон улсын худалдааны үзэсгэлэнгээр дамжуулан олон улсын маркетингийг сайжруулах болон олон улсын сертификат авахад нь дэмжлэг үзүүлэх байдлаар зорилтот зах зээл рүү гарах гарцыг нь нээж өгөх хэрэгтэй. Экспортлогчид Казахстан, Украин, Япон, БНСУ, Франц, Итали, Турк, Балба зэрэг сарлаг, тэмээний ноосон бүтээгдэхүүний зах зээлийг өргөжүүлэхийг зорих хэрэгтэй. Экспортлогчид нь өөрийн гэсэн байр сууръ бүхий брэндүүдтэй түншлэхэд дэмжлэг үзүүлж, гадаад худалдан авагчдын дизайн, техникийн шаардлагын дагуу бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Загвар дизайн, нэмхэлийн инженер зэрэг нэхмэлийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй ур чадварыг дэмжих шаардлагатай. Бодлогын талаас авч үзвэл, Засгийн газрын худалдан авалтын ур дүнтэй бодлогыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх, ноос боловсруулагч ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх болон боловсруулаагүй түүхий ноосны импортоос илүү боловсруулсан ноосны экспортыг дэмжих урамшууллыг нэвтрүүлэх арга хэмжээг авах хэрэгтэй.

## МАХ, БОЛОВСРУУЛСАН МАХ БОЛОН СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

### Мах, боловсруулсан мах

Цаг агаарын эрс тэс уур амьсгал, нүүдэлчин амьдралын хэв маяг нь тариалан эрхлэхэд тохиромжгүй зэрэг шалтгаантай холбоотойгоор Монголчууд мах, сүүг шим тэжээлийн гол эх сурвалжаа болгон өргөнөөр ашигладаг. Монгол Улсын малын тоо толгой сүүлийн жилүүдэд маш эрчимтэй өсч, нэг хүнд оногдох малын тоо толгойн хувьд хамгийн өндөр буюу нэг хүнд 19 тоо толгой ноогдох хэмжээнд хүрсэн байна.[26] Үүнтэй холбоотойгоор дотоодын махны үйлдвэрлэл нь дотоодын эрэлтийн хэмжээг хол давсан буюу 2015 [27] оны байдлаар 448,000 тн болон 269,000 тн тус тус байсан байна.[29] Мал аж ахуй нь улсын нийт ажиллах хүчний гуравны нэгийг эзэлдэг бөгөөд Монгол нийт 48 ширхэг[28] АА эсвэл ААА [29] зэрэглэлийн мах боловсруулах үйлдвэртэй. Мөн дулааны аргаар боловсруулах 120 үйлдвэр, 15 сортлох болон яснаас салгах үйлдвэрүүдтэй.

БНХАУ, ОХУ гэсэн хоёр том зах зээлтэй хөршлөх газарзүйн таатай байршилтай тул Монгол Улс бүс нутагтаа өрсөлдөхүйц үнээр махны эрэлтийг хангах бүрэн боломжтой.[30] БНХАУ-ын Монголоос 150 мянган тон мах импортлох сонирхол нь тус салбарын экспортын боломжийг илтгэж байна. Нэмж тэмдэглэхэд, Монгол Улсын махны салбар нь Япон улстай байгуулсан ЭЗТХэлэлцээрийн хүрээнд болон ЕХ-ны ХЕС+ статустайгаар хөнгөлөлттэй нөхцөл авсан байдаг.

Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн туршлага, үйл ажиллагаагаараа Монгол Улс нь органик махны үйлдвэрлэл нийлүүлэлтээр өрсөлдөөний давуу талтай юм.

### Боломжуудыг үл харгалзан энэ салбар нь хэд хэдэн сорилтоор хязгаарлагдаж байна.

Салбарын өрсөлдөх чадварыг сааруулах хэд хэдэн асуудал тулгарч байна. Гар аргаар мах бэлтгэх практик өргөн тархсан хэвээр байгаа бөгөөд үйлдвэрийн аргаар бэлтгэх технологиос хол давуу байна (Зураг 18). 2015 онд 448.3 мянган тн. мах бэлтгэсэн байдаг бөгөөд үүнээс зөвхөн 3 хувь нь үйлдвэрийн аргаар бэлтгэгдсэн байна. Үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтын хувь маш бага: нэг боловсруулах компани 80 хувь, таван компани 50 хувь, дөрвөн компани 30 хувь, 27 компани 20 хувийн хүчин чадлаа ашиглаж, үлдсэн үйлдвэрүүд идэвхгүй байна. Нийт 120 дулааны боловсруулах үйлдвэрээс 60 нь одоогоор үйл ажиллагаа явуулж байна. АА болон ААА зэрэглэл авсан хэдий ч боловсруулагчид нь зохих байгууламжийн дутагдалтай байдал, зориулалтын бус орчин, техник, технологийн дутагдлыг тулгамдаж буй бэрхшээлүүд хэмээн онцолсон.[31]

[28]Mongolia International Capital Corporation (2017), "Animal Health, Mongolian Wealth: Unlocking Mongolia's Other Treasure Chest".
[29]Mongolia International Capital Corporation (2017).
[30]Mongolian Meat Association (2016) "Mongolia Meat Value Chain Situation Analyses".
[31]A joint Working Group with representatives of the General Agency for Specialized Inspection, Ministry of Food, Agriculture and Light Industry and Mongolian Meat Association rates facilities against over 120 criteria to determine rating/certification. If a facility meets all requirements at an 80-100% rate, it is graded AAA; if at 60-80%, it is assigned an AA grade.
[32]Mongolia International Capital Corporation (2017)

**Зураг 18.** Махны үйлдвэрлэл, боловсруулалтын аргаар, 2006-2015




***Эх сурвалж:*** Монголын махны холбоо, "Монгол Улсын махны нэмүү өртгийн нөхцөл байдлын судалгаа," 2016.

> "Монгол Улсын дотоодын хүнсний бүтээгдэхүүнийг MNS стандартаар баталгаажуулсан байдаг бөгөөд энэ нь олон улсад хүлээн зөвшөөрөгддөггүй."
> ХАТАГТАЙ. Ц.ГАНЧИМЭГ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ТЭСО КОРПОРАЦИ

Гар аргаар мах бэлтгэх нь эрүүл ахуй, ариун цэвэр, хүнсний аюулгүй байдлын орчин үеийн шаардлагад нийцэхгүй байгаа бөгөөд махны боловсруулалтад технологийн хэрэглээ бага байгаа нь дараа дараагийн асуудлуудын эх сурвалж юм. Гар аргаар мах бэлтгэхэд мал эмнэлгийн үзлэг, гарал үүслийн мэдээлэл, мал нядалгааны орчин үеийн шаардлагын хэрэгжилт болон угааж цэвэрлэх шатууд алдагддаг. Цаашлаад хүйтэн хадгалалтын сүлжээ хангалтгүй бөгөөд тээврийн дүрэм журмыг дагаж мөрдөх байдал дутагдалтай байна. Мал эмнэлгийн үйлчилгээ дутагдалтай байгаа тул малын халдварт өвчний дэгдэлт үүсч, бусад улс орнууд Монгол Улсын махны импорт болон дамжин өнгөрөх тээврийг хязгаарлахад хүрдэг. Олон улсын магадлан итгэмжлэлгүй, чанар муутай мах нь борлуулалт муу байдаг төдийгүй Монгол Улсын махны экспорт нь бага үнэтэй ч өндөр эрсдэлтэйд тооцогддог.[32] Түүнчлэн 2009-2011 онуудын зуднаар малын хорогдол их байсантай холбоотойгоор дотоодод махны үнэ ихээхэн нэмэгдсэн бөгөөд энэ нь боловсруулах үйлдвэрүүд түүхий эдээ илүү өндөр үнээр худалдан авах шаардлагыг бий болгосон. Үүний зэрэгцээ, экспортын үнэ өсөлтгүй байсан нь экспортыг үр ашиггүй болгосон. Тийм учраас 2010 онд 26,071 тн. байсан махны экспорт 2016 онд 4,576 тн. болж буурсан байна.[35]

Бусад бэрхшээлүүд нь махны салбарын чадавхийг бүхэлд нь бууруулдаг. Монгол Улсаас мах экспортлоход зөвхөн импортлогч орон төдийгүй дамжин тээвэрлэлт хийгдэх бусад улсуудаас дамжин өнгөрөх зөвшөөрөл авахыг шаарддаг. Энэ үйл явц нь олон тооны, хүнд суртaлт хяналт шалгалтуудаас бүрддэг бөгөөд ингэснээр экспортлогчоос их хэмжээний цаг хугацаа, зардал шаардагддаг тул Монгол Улсын махны экспортод сөргөөр нөлөөлж байна. Нийт 48 боловсруулах үйлдвэрээс 31 нь экспортлох зөвшөөрөлтэй байхад, 120 дулааны аргаар боловсруулах үйлдвэрээс дөнгөж 4 нь л экспортлох зөвшөөрөлтэй байна. Эдгээр бүх асуудлууд нь махны экспортыг зогсоход хүргэж, гар аргаар нядалсан мах нь дотоодын хэрэгцээг хангаж болж байгаа тул үйлдвэрүүд нь эргэлтийн хөрөнгө, бага орлоготойгоор боловсруулалт хийх нь ашиггүй болж байна. Цаашилбал, махны экспортын квотыг компаниудад хуваарилдаг зарчим нь үзэмжид суурилсан бөгөөд зах зээлийн зарчмыг алдагдуулсан гэж үздэг.

## Асуудлуудаа даван туулснаар махны салбар дэлхийд эзлэх байр сууриа бэхжүүлнэ

Махны экспортыг хязгаарладаг гол хүчин зүйл болон малын өвчлөлийг дунд болон урт хугацаандаа арилгахыг зорин ажиллах нь нэн тэргүүний шаардлага юм. Мал эмнэлгийн ажилтнууд, шаардлагатай эм бэлдмэлийн хүртээмжтэй холбоотой бэрхшээлүүдийг шийдвэрлэхийн тулд мал эмнэлгийн үйлчилгээнд шинэчлэл хийх шаардлагатай. Одоо хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хамрах хүрээ, газарзүйн хүртээмжийг өргөтгөж алслагдсан нутгийн малчдад хүртэл хүртээмжийг сайжруулах хэрэгтэй.

[33] Mongolian Meat Association (2016). "Mongolia Meat Value Chain Situation Analyses."
[34] World Bank (2017). "Mongolia's Red Meat Value Chain".
[35] Mongolian Meat Association (2016).

Өвчний тархалтыг хязгаарлах зорилгоор малын хорио цээрийн бүсийг байгуулна.

Боловсруулалтын хувьд, гар аргаар боловсруулалтаас, үйлдвэрийн боловсруулалт руу аажмаар шилжихэд одоо байгаа боловсруулах байгууламжуудыг бүрэн хүчин чадлаар нь ашиглахыг зорих хэрэгтэй. Дулааны боловсруулалтын 120 үйлдвэр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэр нь хүнсний аюулгүй байдлын шаардлага хангаж байгаа нь тогтоогдсон тул[34], тэдгээрийн ашиглалтыг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай. Ингэснээр аюулгүй хүнс үйлдвэрлэх, тээврийн зардал буурах, ажлын байрыг нэмэгдүүлэх, цаг хугацаа болон ажиллагаа хэмнэх зэрэг ач холбогдолтой. Үйлдвэрийн боловсруулсан махны баталгаажуулах нь дотоодын болон гадаадын томоохон, хүнсний аюулгүй байдлыг чухалчилдаг зах зээлүүд рүү гарахад дэмжлэг, урамшуулал болох юм.

Үүнээс гадна эрэлт нь өсөх хандлагатай байгаа газарзүйн таатай байршилтай, томоохон зах зээл болох БНХАУ руу экспортыг нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулах нь зүйтэй.[35] Энэ нь өвчингүй махнаас гадна, Хятад, Монгол Улсуудын хооронд байгуулсан жижиг үхрийн хөлдүү махны экспорт болон транзит зөвшөөрлийн талаар хэлэлцээрийг эргэн харж, шинэчлэхийг шаардаж байна. Нэмж хэлэхэд өвчингүй бүсийн мах, хяналт шалгалтаар орсны дараа хилээр нэвтрэх бичгийг даруйхан олгодог байх ёстой

## **Хайрцаг 9.** МАХ, БОЛОВСРУУЛСАН МАХНЫ ДЭД САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Махны салбарт хөрөнгө оруулалт хийх нь малчдаас хэрэглэгчдэд хүргэх ложистикийг бүхэлд нь сайжруулах нэмүү өртгийн сүлжээг боловсронгүй болгоход чухал ач холбогдолтой. Мал эмнэлэг, тэжээлийн чанарыг сайжруулах болон бусад үйлдвэрлэлийн түвшний хүчин зүйлсд хөрөнгө оруулах нь хорогдолын түвшинг бууруулна. Хөрөнгө оруулалт нь өвчин эмгэггүй бүсийг бий болгох, эм бэлдмэлийн хүртээмжийг сайжруулах, малын им, бүртгэлийг сайжруулах, малын тэжээлийг сайжруулж, хатуу ширүүн өвлийг давахад анхаарах боломжийг бий болгоно. Судалгаа, хөгжүүлэлтэд хөрөнгө оруулах нь үржил болон бусад үйлдвэрлэлийн процессийг сайжруулна.

Боловсруулалтын шатанд хөрөнгө оруулах нь одоогийн байгаа байгууламжуудыг олон улсын стандартад тохируулан шинэчлэх боломжийг бий болгоно. Одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа ихэнх үйлдвэрүүд нь хуучин үйлдвэрийн барилгуудын барилгад байрлаж байгаа тул мах боловсруулах зориулалтын бус байрууд байна. Түүнчлэн, мах боловсруулах, үйлдвэрийн технологи, тоног төхөөрөмжийг шинэчлэх, үйлдвэрийн ажилтнуудад сургалт явуулах, суурилуулсан шинэ технологийн гадаад мэргэжилтнийг авчрах зэрэг боломжуудыг авчирна. Гадны санхүүжилтээр бүх стандартыг хангасан шинэ үйлдвэрийг барьж байгуулахад шаардлагатай санхүүжилтийн дутагдлыг нөхөх боломжтой. Энэ нь нэмүү өртгийн сүлжээг бүтнээр нь бий болгоход туслах болно (өөрөөр хэлбэл малыг өсгөх, дайвар бүтээгдэхүүн боловсруулах газар болон хүчин чадлыг цогцлоох г.м.). Энэ нь мал худалдан авах, нядлах, бэлтгэх үйл ажиллагааг улирлын нөлөөлөлгүй болгох ач холбогдолтой бөгөөд үүний нэг жишээ нь Гачуурт ХХК юм.

Эцэст нь махыг тээвэрлэхэд шаардлагатай ложистикийн чадавхийг сайжруулахад хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнд: хүйтэн хадгалах байгууламжууд, алслагдсан орон нутгийг холбосон тээврийн сүлжээ зэрэг багтана. Хөргүүртэй ачааны машины хэрэглээ нь тээврийн зайг ихээхэн нэмэгдүүлж, олон нийлүүлэгчийг олон тооны зах зээлтэй холбох ач холбогдолтой.

[36]Ibid
[37]Mongolia International Capital Corporation (2016)

Урт хугацаандаа мал эмнэлгийн үйлчилгээний бүтэц, менежментийг сайжруулахын тулд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хуулиудыг бэхжүүлэн, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эдгээр хуулиудыг хэрэгжүүлснээр малын халдвараас урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх чиглэлд ахиц гарах бөгөөд улмаар худалдааны боломж нэмэгдэх юм. Боловсруулалтын хувьд, дотоодын мах бэлтгэлийн нэгжүүд нь хүнсний аюулгүй байдал, гарал үүсэл болон чанарын баталгааг хангах чадавхтай байх ёстой. Энэ чиглэлээр Мах экспортын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь чухал юм. Дотоодын хувийн хэвшлийн магадлан итгэмжлэлийн байгууллага нь олон улсад танигдсан стандарт шаардлагыг боловсруулан хэрэгжүүлэх боломжоор хангагдах шаардлагатай. Түүнчлэн саяхан батлагдсан Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль тогтоомж зэрэг чухал хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангаж, улс орны хэмжээний дэд бүтцийг сайжруулах хэрэгтэй. Мах экспортлох үйлдвэрүүдэд олон улсын Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт (HACCP) болон ОУСБ (ISO)-ын стандартуудыг нэвтрүүлэх нь Монгол махны имижийг сайжруулах ач холбогдолтой.

Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр экспортын бичиг баримт бүрдүүлэлт болон процедурыг хялбар болгох зорилготой нэг цонхны үйлчилгээг бий болгоно. БНСВУ, Япон зэрэг шинэ зах зээлийг судлах шаардлагатай. БНСВУ улс хэдийнэ Монгол Улсын 8 аж ахуйн нэгжид түүхий болон боловсруулсан ямаа, хонины мах экспортлох зөвшөөрөл олгосон бол Япон улс руу боловсруулаагүй мах экспортлох, Ойрхи дорнодын зарим улсуудад хонины мах экспортлох талаар идэвхтэй хэлэлцээр өрнөж байна. Олон улсад зах зээлээ тэлэх нь маркетингийн ихээхэн хүчин чармайлт шаардах нь тодорхой бөгөөд оновчтой удирдвал Монгол махны брэнд болон хөгжих боломжтой. Махаа олон улсад баталгаажуулсны дараа Монгол Улс нь өөрийн нүүдэлчин өв соёлоор, генийн өөрчлөлтгүй бэлчээрийн аргаар эрхэлдэг уламжлалт мал аж ахуйн дүр төрхөө ашиглан олон улсын зах зээлд үнэ цэнэд хүргэх боломжтой. Ийнхүү уламжлалт аж ахуйгаас гаралтай мах өндөр үнээр худалдаалагдах боломжтой.

## Сүүн бүтээгдэхүүн

Цаг агаарын эрс тэс уур амьсгал, нүүдэлчин амьдралын хэв маяг нь тариалан эрхлэхэд тохиромжгүй зэрэг шалтгаантай холбоотойгоор Монголчууд мах, сүүг шим тэжээлийн гол эх сурвалжаа болгон өргөнөөр ашигладаг. Мал аж ахуйн салбарын нийт бүтээгдэхүүний 61 хувийг мах болон сүүн бүтээгдэхүүн эзэлж байна. Тэр дундаа сүү нь олон өрхийн үндсэн орлогын эх үүсвэр юм. Хот суурин газрын ойролцоо байрлах 300 хүртэл толгой сүрэг эсвэл хагас эрчимжсэн аж ахуйн хувьд өрхийн нийт орлогын 51 хувийг сүү, 20 хувийг мах, 5 хувийг ноолуураас бүрдүүлдэг байна. Сүргийн тоо толгой 800 болон түүнээс дээш үед л өрхийн орлогод махны эзлэх хувь 50 хувьд хүрч байна. Жилдээ 458 сая литр сүү үйлдвэрлэгддэгээс 65 хувь нь үнээний сүү байна. Жилийн нийт эрэлт 403 сая литр байдаг гэж үзвэл энэ салбар нь түүхий сүү болон нэмүү өртөг шингээн боловсруулсан сүүн бүтээгдэхүүн экспортлох боломж өндөр байна. Үйлдвэрлэлийн байгууламжийн хувьд сүү нь уламжлалт байдлаар улсын өнцөг булан бүрд тархсан сүргээс болон хот суурин газруудаар байрлах хагас эрчимжсэн аж ахуйгаас ихэнхдээ үйлдвэрлэгдэн гарч байна. 2015 оны байдлаар 1,156 эрчимжсэн болон хагас эрчимжсэн аж ахуйд нийт 61,981 тоо толгой сүүний үнээ тоологдсон байна.[41]

> "Бяслаг: тээвэрлэхэд төвөгтэй 100 литр сүүг өндөр үнэтэй, хадгалах боломжтой 10 кг бяслаг болгон, жил тойрон тээвэрлэж худалдах боломжтой."
> Монголын Бяслаг Урлаачдын Холбоо

Монголын сүүн бүтээгдэхүүний экспортын хамгийн чухал бүтээгдэхүүн бол бяслаг юм. Бяслаг, ааруул зэрэг бүтээгдэхүүнүүд нь илүү экспортын ач холбогдолтой юм. Өндөр үнэ цэнэ бүхий гар аргаар урласан бяслаг нь байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэх, малчдын орлогыг нэмэгдүүлнэ. Монголын уламжлалт нүүдлийн мал аж ахуйн эдийн засгийг хадгалахад чухал хувь нэмэр оруулан Монгол Улсын нэрийн бүтээгдэхүүн болж хөгжих бүрэн боломжтой. Түүнчлэн, шар сүүний үйлдвэрлэл, дотоодын өвлийн тэжээлийн үйлдвэрлэл зэрэг бусад дагалдах салбаруудын өсөлтөд эерэгээр нөлөөлнө. Бяслаг үйлдвэрлэх уламжлалт мэдлэг, арга техник нь түүнийг брэндинг, ялгарал болгон ашиглаж, Монголын нэрийн бүтээгдэхүүн болгон хөгжүүлэн, өндөр зэрэглэлийн бүтээгдэхүүн болгох боломжтой. Экспортын хувьд Монгол бяслаг одоогоор Япон улсад багахан хэмжээгээр борлуулагддаг.

Төрөөс эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг баталсан.[42] Хөтөлбөрийн хүрээнд мал аж ахуйн менежерүүд, мэргэжлийн холбоодын чадавхийг бэхжүүлэх, кластерын системд шилжүүлэх, өндөр үр шимтэй малын сортыг импорлох, хүнсний аюулгүй байдлыг хангах, шинэ технологи нэвтрүүлэх

[38] Mongolia International Capital Corporation.
[39] World Bank (2015), "Agricultural Productivity and Marketing Report,"
[40] Ibid

TIR MON 1 - Final_Fi.indd 34 07.05.2020 09:16:23

зэрэг арга хэмжээнд 2019-2023 онд 166.3 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсөвлөжээ. Хөтөлбөр хэрэгжсэнээр сүү үйлдвэрлэгчдийн үйлдвэрийн ашиглалт 35 хувиар, малын тоо толгойг хоёр дахин, махны гарцыг 20 хувиар, үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүүний хэмжээг 30 хувиар тус тус нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна. Түүнээс гадна хөтөлбөрийн үр дүнд шингэн сүүний импортыг зогсоож, хуурай сүүний импортыг 30 хувиар бууруулж, эрчимжсэн мал аж ахуйн тэжээлийн хангамжийг 40 хувиар нэмэгдүүлж, техник технологийн шинэчлэлийг 30 хувиар нэмэгдүүлэхийг зорьж байна..

## Салбарын хөгжлийг хэд хэдэн бэрхшээлүүд гацааж байна

Фермерүүдэд тулгарч буй зарим бэрхшээлийг Зураг 19-д үзүүлэв. Монголын сүүн бүтээгдэхүүн нь дотоодын үүлдэр дээр төвлөрсөн хэвээр байгаа бөгөөд энэ нь үйлдвэрлэлийн хүчин чадлыг бууруулж байна. Цэвэр болон эрлийз сүүний үнээ нийт тоо толгойн 3 хувийг л эзэлж байгаа нь сүүний гарц бага буюу жилд 2,000-3,000[43] литр байхад нөлөөлж байна.[44] Бусад улсуудтай харьцуулахад Монголын бүтээмж доогуур байна.[44] Монгол үнээ болон цэвэр цусны үнээний сүүний гарц нь өдөрт тус бүр 2.57 болон 4.4 литр байна.[45] БНХАУ-д нэг үнээний жилийн сүүний гарц жилд 3,700 литр, Шинэ Зеландад 3,838 литр, АНУ-д 8,400 литр байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлтүүд юм.[46] Цаашилбал, малын тэжээл нь чанар муу, бүтцийн тэнцвэр муу байна. Механикжсан сүүний фермүүд хэд хэд байдаг бөгөөд тэнд сүүг гараар эсвэл жижиг саалийн машинаар сааж байгаа нь бүтээмж хангалтгүйгээс гадна бактери, гадны биет орж, сүүний чанарт сөргөөр нөлөөлөхөд хүргэж байна. Түүнчлэн малын удмын сангийн судалгаа, сүүний гарцыг сайжруулах зохиомол хээлтүүлэг, үржүүлгийн чиглэлээр судалгаа, хөгжүүлэлт хангалтгүй байна. Сүү бэлтгэлийн дараах шатанд буюу хадгалалт, тээврийн явцын алдагдал өндөр бөгөөд нэг нэгжид 39 литрийн үзүүлэлттэй байна. Үүнээс гадна сүү Монголд үнэтэй хэвээр байгаа бөгөөд ОХУ-ынхаас илүү өндөр байна[47]. Энэ нь үхрийн чанар муу, тэжээлийн өртөг өндөр, тэжээлээс ферм хүртэл тээвэрлэлт болон хангалттай хэмжээний эдийн засаг байхгүйтэй холбоотой байна.

**Зураг 19.** Сүүн бүтээгдэхүүний бизнес эрхэлдэг малчид, фермерүүдэд тулгарч буй асуудлууд




***Эх сурвалж:*** SECiM, "Үндэсний сүүний хөгжлийн зөвлөлийн нөхцөл байдлын шинжилгээ" 2016.

Бяслаг үйлдвэрлэлийн салбарын хувьд, энэ салбар нь санхүүжилт авах боломж, нийлүүлэлтийн чадавх хязгаарлагдмал, экспортын түншүүдтэй чанар, аюулгүй байдлын талаар харилцан ойлголцол дутмаг тул өрсөлдөх, холбох, өөрчлөх чадавхиуд сул байдаг. Банкууд хөдөө аж ахуйн салбарыг эрсдэлтэй салбар гэж үздэг. Гадаад орнуудыд шинэлэг төслийг хэрэгжүүлэх сонирхол, түүнд зарцуулах хөрөнгө их байдаг боловч, Монгол Улсын хөрөнгө оруулалтын тухай хууль нь хөрөнгө оруулагч тус бүрийн хөрөнгө оруулалтыг 100,000 ам.доллараас багагүй байхаар заасан байдаг нь ЖДҮ-үүд болон гарааны бизнесийн гадаадын хөрөнгө оруулалтын боломжийг хязгаарладаг. Цаашилбал Монгол Улс болон ОХУ гэх мэт боломжит зах зээлүүд хооронд хорио цээрийн протокол байхгүй байгаа нь Монгол бяслагийн

[41]Ibid
[42]Ibid
[43]SECiM (2016). "National Dairy Development Board Situation Analysis"
[44]Montsame (2018). "Cabinet approves National Program on promotion of intensive animal husbandry". Retrieved from https://montsame.mn/en/read/175462
[45]Asia and Pacific Commission on Agricultural Statistics (2016). Livestock Statistics in Mongolia
[46]World Bank (2015)
[47]Agriculture Census of 2011
[48]World Bank (2015)

экспортыг хязгаарлаж байна. Зах зээлүүдэд нэвтрэх боломж хязгаарлагдмал байгаа нь хөрөнгө оруулагчид ба үйлдвэрлэгчид бяслаг үйлдвэрлэлтийн байгууламжид хөрөнгө оруулахыг дэмжихгүйгээр барахгүй, өндөр зэрэглэлийн бяслаг үйлдвэрлэх хүчин чадлыг хязгаарладаг. Монголд сүүний үнэ өндөр байгаа нь бяслаг үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эдийн хүртээмжид нөлөөлдөг. Чанартай үнээ импортлох шаардлагатай хэдий ч тээврийн зардал өндөр байгаа нь саад учруулж байна.

## Салбарыг боломжит түвшинд нь хүргэхийн тулд асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй.

Богино болон дунд хугацаанд удмын сан болон тэжээлийн чанарыг сайжруулах арилжааны практикууд болох эрлийз болон цэвэр үүлдрийн үнээний тоог нэмэгдүүлэх хөтөлбөрүүдийг өргөнөөр хэрэгжүүлэх хэрэгтэй. Ийм судалгаа, практикийн үр дүнгүүд нь фермерүүд шийдвэр гаргахад шаардагдах үйлдвэрлэлийн болон эдийн засгийн мэдээллийг өгдөг. Засгийн газрын зүгээс сүүн бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийг импортын тарифаас чөлөөлж үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх боломжтой. Монгол орны эрс тэс уур амьсгалд амьдарч чадах үхрийн үүлдрийн талаар фермерүүдэд зөвлөгөө өгөх сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Засгийн газар нь өндөр зэрэглэлийн үүлдрийн үхэр импортлох фермерүүдэд дэмжлэг үзүүлэх боломжтой.

Бяслаган бүтээгдэхүүний сав баглаа боодол, брэндингийг сайжруулах замаар бяслагийн экспортыг нэмэгдүүлэх боломжтой. Бяслаг үйлдвэрлэгч, экспортлогчдод гадаадад бүтээгдэхүүнээ сурталчлах институцийн дэмжлэг үзүүлэх нь нэн чухал юм. Тодорхой жишээ дурьдвал, Засгийн газрын үйл ажиллагаанд монгол бяслаг ашиглах, гадаадын элчин сайдын яамд, элчин сайдуудад монгол бяслаг бэлэглэх зэргээр дэмжих боломжтой. Мах, сүүн бүтээгдэхүүний аль алиных нь хувьд экмпортын өмнөх үе шатууд дах чанарын сайжруулалт, зах зээлд тавигдах шаардлагыг малчид, боловсруулагчдад хүргэх ёстой.

### **Хайрцаг 10.** СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДЭД САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хөрөнгө оруулалт нь чанар, олон улсын харилцаа холбоог сайжруулах, одоо байгаа үйлдвэрлэгчдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, салбарын шинэчлэлийг авчрахад туслана. Чанарын хувьд хөрөнгө оруулалт нь үржүүлгийн багцыг сайжруулах, мал эмнэлгийн үйлчилгээг авснаар өвчинөөс урьдчилан сэргийлэх замаар олон улсын сатандартад нийцсэн өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хувь нэмрээ оруулна. Хорио цээрийн бүс байгуулахад хөрөнгө оруулалт хийх нь халдварт өвчний тархалтыг зогсооход тус дөхөм болох ба ингэснээр Монголын сүүн бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлнэ.

Зах зээлийн мэдээллийн хүртээмж бүхий хөрөнгө оруулалт нь олон улсын харилцаа холбоо, удирдлага, маркетинг болон брэндингийн ур чадваруудыг хөгжүүлэх ач холбогдолтой. Сүүн бүтээгдэхүүний шинжлэх ухааныг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах нь салбарын үйлдвэрлэлийг тогтвортойгоор сайжруулах, салбарын хэрэгцээг хангахуйц чадваруудыг ажиллагсдад суулгах боломжтой.

Үүнээс гадна хөрөнгө оруулалт нь бүтээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай нарийн тоног төхөөрөмжийг импортлох, ашиглахад туслана. Үүнд харилцан адилгүй гарцыг нэгтгэн цуглуулах цэгийг бий болгох асуудал багтана. Орчин үеийн хадгалах тоног төхөөрөмж нь сүү, сүүн бүтээгдэхүүнийг хол зайд тээвэрлэх боломжийг олгодог. Тэжээлийн хэсгүүд нь одоогоор тэнцвэргүй байгаа тэжээлийн харьцааг тэгшитгэх ач холбогдолтой. Малын таних систем, зохиомол хээлтүүлгийн тоног төхөөрөмж, генетикийн үржүүлгийн технологи зэрэг нь үржүүлгийг сайжруулна. Энэ нь удмын сангийн банк байгуулах замаар үхрийн сайн үүлдрийг нэмэгдүүлэх зэрэг судалгаа, хөгжүүлэлтийн ач холбогдолтой. Боловсруулалтын хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр, гадаад санхүүжилт нь бяслагны шинэ үйлдвэр байгуулах болон санхүүгийн хүртээмжгүй байдлаас үүдсэн саад бэрхшээлийг арилгах боломжтой.

[49] IFC, "Investment Road Map for Mongolia", 2018

Урт хугацаандаа өндөр зэрэглэлийн үүлдрийн үхэр импортолсны дараа гарцыг өндөр хэвээр нь хадгалах үүднээс малын тэжээлийн чанарыг сайжруулах хэрэгтэй. Хувийн хэвшлийн сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниуд нь саах машин танилцуулах зэргээр фермерүүдэд хоол тэжээл, технологийн чиглэлээр тус болохыг дэмжих хэрэгтэй. Үүлдрийг сайжруулж, улмаар сүүний гарцыг сайжруулах зохиомол хээлтүүлгийн ойлголтыг дэмжих шаардлагатай. Хүний нөөцийн хувьд, сүүн бүтээгдэхүүний шинжлэх ухааны залуу мэргэжилтнүүдэд тэтгэлэг олгох нь зүйтэй. Салбарын тогтвортой өсөлтийн хангахын тулд усны хуваарилалт болон дахин бүсчлэлийг хийх шаардлагатай. Бяслагны бүтээгдэхүүний хувьд засгийн газар нь экспортын түншүүдтэй чанар, аюулгүй байдлын талаар гэрээ хэлэлцээр боловсруулж гаргах нь нэн чухал юм. Бяслагны экспортын зах зээлийг БНСУ, Хятад, Япон, ОХУ-аар өргөжүүлж болох ба эдгээр нь нийлээд 50,000 тн.ын зах зээлийн боломжтой юм. Хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхийн тулд Засгийн газар хөрөнгө оруулалтын доод шаардлага, хөрөнгө оруулагчдын хамгаалалт, бодлогын тогтворгүй байдал зэрэгт анхаарал, мэдрэмжтэй хандах хэрэгтэй. Цаашилбал, салбарын санхүүжилтийн хүртээмжийг бэхжүүлэх шаардлагатай бөгөөд хөдөө аж ахуйн ЖДҮ-ийн санхүүжилтийг тэргүүлэх чиглэл болгох шаардлагатай.

## АРЬС ШИР

Монгол Улс нь өсөн нэмэгдэж буй малын тоо толгойн улмаас арьс ширний салбарт харьцангуй давуу талтай бөгөөд малчдаас дотоодын зах зээлд нийлүүлдэг арьс шир, арьс ширний хэмжээ харьцангуй нэмэгдэж байна. Тус салбарын экспортын нөөц бололцоо нь маш их. Зураг 20-д үзүүлсэн 10 улсууд нь Монголын арьс ширэн бүтээгдэхүүний экспортын хамгийн боломжит зах зээлүүд бөгөөд нийтдээ 32.8 сая ам.долларын экспортын боломжийг агуулж байна.[50]

> "Мал аж ахуйн салбараас гаралтай түүхий эдийг гүн боловсруулан, нэмүү өртөг шингээн, эцэст нь хэрэглэгчдэд өндрөөр үнэлэгдэх үнэлэмжийг бий болгох нь манай гүн боловсруулах үйлдвэрүүдийн эрхэм зорилго юм. Арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн салбар нь тэргүүлэх салбаруудын нэг бөгөөд ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад ихээхэн хувь нэмэр оруулах боломжтой"
>
> НОЁН БАЯРСАЙХАН. "МОНГОЛЫН АРЬС ШИРНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХОЛБОО"-НЫ ТЭРГҮҮН

[50]ITC Export Potential map

**Зураг 20.** Монголын арьс ширний тэргүүлэх боломжит зах зээлүүд

**Сая ам. Доллар**




***Эх сурвалж:*** ОУХТ Экспортын боломжийн зураглал

Салбарт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэгчдийн дийлэнх нь ЖДҮ-үүд байдаг. Эдгээр үйлдвэрлэгчдийн эцсийн бүтээгдэхүүн нь ихэвчлэн хагас боловсруулсан арьс байдаг бөгөөд ихэнхдээ Хятад, Итали, Испанид экспортолдог. Арьс ширний багахан хувь нь гүн боловсруулалтаар орж, гутал, цүнх, хүрэм зэрэг бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дотоодын үйлдвэрлэгчдэд хүрдэг. Үүнээс гадна, энэ салбар нь эмэгтэйчүүд, залуучуудад ажлын байр бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

Арьс боловсруулалт нь 2011-2018 онд 3 дахин өссөн. 2016 онд Монгол Улсад үйлдвэрийн гүн боловсруулалтаар 580 хос гутал, ЖДҮ-ийн гүн боловсруулалтаар 900 мянгаас 1 сая хос гутал, 37 мянган хүүхдийн гутал, 57.7 мянган савхин хувцас, 191.5 мянган цүнх, аксесуар, 250 мянган ширхэг бээлий, 41 мянган ширхэг хонины арьсан хүрэм үйлдвэрлэсэн байна[49]

## Хэдий тийм ч, арьс ширний үйлдвэрлэлийн өсөлтөд хэд хэдэн бэрхшээл тулгарч байна

Энэ салбарын өрсөлдөх чадвар хязгаарлагдмал. Идээлэгдсэн, вайтблю, вэтблю зэрэг хагас боловсруулсан бүтээгдэхүүн нь үйлдвэрлэлийн ихэнх хэсгийг тодорхойлж, хямд үнээр экспортлогдож байна. Үүнээс гадна цөөхөн хэдэд томоохон үйлдвэрлэгчид л нийт хагас боловсруулах хүчин чадлыг эзэмшдэг тул хагас боловсруулсан арьсны нийлүүлэлт доогуур байдаг. Түүнээс ч цөөн тооны үйлдвэрлэгчид гүн боловсруулах хүчин чадалтай. Технологийн дутагдалтай хавсран энэ асуудал нь улам дордож, өрсөлдөх чадварыг улам доройтуулж байна. Ихэнх үйлдвэрлэгчид нь цөөн тооны ажилллагдсад, гар ажиллагаатай ЖДҮ-үүд байдаг.

Салбарт олон улсын стандартын талаар мэдлэг дутмаг. НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага (UNIDO)-ын хүчин чадлын үнэлгээгээр нийт арьс шир боловсруулагчдын гурав нь л Арьс ширний олон улсын зөвлөлийн байгаль орчны гэрчилгээ зэрэг олон улсын сайн дурын стандартуудын талаар мэдлэгтэй байгаа нь тогтоогдсон.[50] Түүнчлэн салбарын өргөтгөл, шинэ боломжуудыг нээхэд санхүүжилтийн хүртээмж муу, арьс шир боловсруулах тоног төхөөрөмж, технологийн хоцрогдол, чадварлаг ажиллах хүчний дутагдал, түүхий эдийн чанар муу (арьс ширний 30 хувь нь механик гэмтэлтэй, 15-30 хувь нь шимэгчийн гэмтэлтэй) үйл ажиллагааны хүндрэлүүд саад болж байна. Шимэгчийн гэмтэл нь 4-5 настай мал нядалгааны практиктай холбоотой бөгөөд энэ нь арьс олон тооны нүхтэй байхад нөлөөлдөг. Түүнчлэн түүхий эд материалын хадгалалт, агуулахын асуудал хангалтгүй байгаа нь бүтээгдэхүүний чанарт сөргөөр нөлөөлж байна. Түүхий эдийн чанар муу байгаа нь нэр бүхий Монголын арьс ширний компаниуд хагас боловсруулсан бүтээгдэхүүн импортоор авч, өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хүргэж байна. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр энэ салбарт мөн бэрхшээл тулгардаг нь нэг ачилт гаргахын тулд 5-6 бичиг баримт шаардлагатайгаас гадна 7 хоногийн ажил зарцуулагддаг байна.

Сүүлийн жилүүдэд Засгийн газрын зүгээс эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлж эхэлсэн нь гутал, цүнх, хүрэм үйлдвэрлэгч ЖДҮ-үүдэд эерэг нөлөөг авчирч байна. Тодруулбал, Дархан Нэхий, Дархан Минж, Мон-Ирээдүй, Эх Эргэлт, Монгол Шевро зэрэг үйлдвэрлэгч компаниуд дэвшилтэт технологи, хүний нөөцөд хөрөнгө оруулалт хийж, улмаар нийт бүтээгдэхүүнийхээ 32 хувийг гүн боловсруулалтад оруулах болсон. Үүнээс гадна, 2018 онд Засгийн газар ЕХ, НҮБ-ын ҮХБ, ХХААБ-тай түншлэлээр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Гутал зохион бүтээлтийн хөтөлбөр боловсруулж нэвтрүүлсэн. Энэ хөтөлбөр нь цахин сургалтын платформоор дамжуулан хүрдэг бөгөөд хөлний анатоми, гутлын материал, гутлын дээд бие, гутлын эцсийн хувилбар, эрчүүдийн дербиний загвар, өөрийгөө шалгах гэсэн 5 модулиас бүрддэг. Цаашид сандаль, спорт гутал, өндөр өсгийт зэрэг олон загваруудыг хамарсан 10 модуль нэмэгдэн өргөжих юм..

## Арьсны салбарыг илүү өрсөлдөхүйц болгохын тулд бэрхшээлүүдээс давсан алхамууд хийх шаардлагатай

Богино болон дунд хугацаанд арьс ширийг шимэгчийн эсрэг биет ашиглах болон мал нядлах, өвчих, халимлах шатуудад механик гэмтлээс зайлсхийх стандарт техник нэвтрүүлэх замаар түүхий эдийн чанарыг сайжруулах шаардлагатай.

Түүнчлэн, одоогийн байгууллагуудын бүтцийн хувьд төрийн байгууллагуудын хоорондын харилцаа холбоог сайжруулах, үйл ажиллагааг нэг цонхны үйлчилгээ болгох, хяналт, шалгалт, бичиг баримтын шаардлагууд зэрэг давхардсан чиг үүргүүдийг цэгцлэх, хүнд суртлыг багасгах зэргээр худалдааг хөнгөвчлөхөд анхаарах хэрэгтэй. Стандартын хувьд, Монгол Улсад 150 хүчин төгөлдөр Монголын Үндэсний Стандарт (MNS) үйлчилдэгээс 10 хувь нь Олон улсын стандарт (ISO) байна. Стандартуудын хэрэгжилтийг сайтар хангаж, хянах шаардлагатай.

[51]UNIDO “Support to Employment Creation In Mongolia”
[52]UNIDO. “Footwear Pattern Engineering”

Урт хугацаандаа идээлэгдэх, хатаах болон хөлдөөх техникүүдийг ашиглан боловсруулалтын практикийг сайжруулах шаардлагатай. Үүнд силикат, оксазолидин ба EWT Granifin F-90 зэргийг ашиглан идээлэгдэх техникүүд багтана. Нано силикатын арга нь хэд хэдэн компанийн хувьд хөгжүүлэлт, ашиглалтын шатандаа явж байна. Эдгээр процессийг нийтэд нь түгээн дэлгэрүүлэх нь маш чухал. Түүнчлэн, лазер эсгэгч болон бүрэн автомат оёдлын машинууд зэрэг бүтээмж сайтай орчин үеийн технологиудыг нэвтрүүлэн, гар ажиллагааг бууруулах шаардлагатай. Үүний зэрэгцээ, ажиллах хүчийг эдгээр машинуудын ажиллагаа болон гүн боловсруулалтын чиглэлээр дахин сургахаас гадна онолын дэвшилтэт болон прагматик мэдлэг бүхий гадаад мэргэжилтнийг Монголд авчрах хэрэгтэй. Салбарын шаардлагад нийцсэн ажиллах хүчин бэлтгэх, орчин үеийн, бүтээлч боловсролын системийг бий болгох үүднээс дотоодын болон гадаадын их сургуулиуд харилцан нэгнийхээ кредитийг хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх шаардлагатай. Стандартуудын хувьд, байгаль орчны гэрчилгээ болон Олон улсын арьс шир боловсруулалтын зөвлөлийн гэрчилгээ зэрэг сайн дурын олон улсын стандартууд болон бусад холбогдох стандартуудын хэрэгжилтийг сайжруулах хэрэгтэй. Эцэст нь шинэ зах зээлүүдийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Ингэхдээ Хятадтай өрсөлдөөнийг бууруулж, онцгой, нийш (niche) зах зээлүүд дээр илүүтэйгээр төвлөрнө. Холбогдох хураамжаас чөлөөлсөн зарим ЕХ-ы зах зээлүүд болон доогуур тарифыг тогтоосон АНУ-ын зах зээлүүдэд идэвхитэй нэвтрэхэд анхаарах хэрэгтэй. Монголын арьс ширэн бүтээгдэхүүнүүд нь эдгээр боломжит зах зээлүүдийн шаардлага стандартыг хангахуйц чанартай байхад анхаарахыг шаардана.

## **Хайрцаг 11.** АРЬС ШИРНИЙ САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Арьс ширний салбарыг хөгжүүлэхэд санхүүжилтийн хүртээмжийн сайн байх нь хамгийн чухал. Хөрөнгө оруулалтаар түүхий эд бэлтгэлийн үеэр эргэлтийн хөрөнгийн хэмжээг ихээхэн нэмэгдүүлэх боломжтой. Одоогийн өвчих процесс нь арьс ширийг гэмтээдэг бөгөөд түүхий эдийн чанар, цаашилбал малчдын орлогыг бууруулах хүчин зүйл болдог. NaOH болон H2O2 ашиглан халимлах процессийг автоматжуулах судалгаа, шинжилгээ нь малчид арьс, хөрсийг гэмтээлгүйгээр өвчих боломжийг бий болгоно. Мөн нэмүү өртөг шингэсэн арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадварлаг боловсон хүчин бэлтгэхэд хөрөнгө оруулалтын ач холбогдол өндөр.

Түүнчлэн бүтээмжийг нэмэгдүүлэх орчин үеийн, ногоон технологийг нэвтрүүлэх боломжийг хөрөнгө оруулалт бий болгоно. Ногоон Хөгжлийн үзэл баримтлалын шаардлагыг хангасан цэвэр, ногоон аргаар боловсруулагдсан “эко шир”, “нано шир” зэрэг нь тогтвортой хөгжлийг ихээхэн чухалчлах болсон дэлхийн зах зээлд Монголын арьс ширэн бүтээгдэхүүнийг “органик” болон “био” хэмээн брэнд болгон хөгжүүлэх боломжтой.

Арьс ширний үйлдвэр технологийн паркийг байгуулах талаар яригдаж байсан бөгөөд 2014 онд “хөнгөн үйлдвэр, технологийн парк”-ийг Эмээлтэд байгуулсан байдаг. Паркийн дэд бүтэц нь одоог болтол баригдаагүй байгаа тул арьс шир боловсруулагч үйлдвэрүүд хотоос энэ паркад шилжин суурьших үйл ажиллагаа явагдаагүй байна. Анхны төлөвлөгөөгөөр ийнхүү шилжүүлэх зорилт орсон тул хотуудад боловсруулагч үйлдвэрүүд нэмж баригдаагүй байдаг. Нэмүү өртөг шингээлтийг дэмжих зорилгоор гүн боловсруулалтын үйлдвэрүүдэд хөрөнгө оруулах шаардлагатай.

## МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ

1990-ээд оны эхээр салбарыг чөлөөлсөнөөс хойш МХХТ-ийн салбар нь маш эрчимтэй хөгжиж, одоогийн байдлаар нийт хүн амын 85 хувь нь смарт утас ашиглаж байна.[51] МХХТ-ийн дэд бүтцийн хөгжил маш өндөр түвшинд байдаг бөгөөд нэг сая хүнд ноогдох баталгаат интернет серверийн тоогоор бусад дундуураас доогуур орлоготой эдийн засгийн дундаж нь 323.8 байхад, Монгол Улсад 1,546 байна. Монгол Улсын хүн ам нь харьцангуй залуу, өндөр боловсролтой тул МХХТ зэрэг мэдлэгт суурилсан салбарын хөгжих нөхцлийг бүрэлдүүлж байна. Дээр дурьдсан хүчин зүйлстэй холбоотойгоор серверийн фарм байгуулах зэрэг чиглэлээр МХХТ-ийн салбар нь гадаадын хөрөнгө оруулагдын анхаарлыг татсаар ирсэн байдаг. Монгол Улсын төр болон залуучууд

[53]IFC (2018)
[54]Oxford Business Group (2015). “The Report of Mongolia - 2015”

аль аль нь энэ салбарыг маш их боломжийг агуулсныг хүлээн зөвшөөрдөг бөгөөд залуус нь энэ салбарт технологийн бизнес эхлүүлэх боломжийг идэвхтэйгээр эрэлхийлдэг. Эдгээр нь энэ салбарт хөрөнгө оруулалт татах, үйлчилгээний экспортыг хөгжүүлэх болон эдийн засгийн бусад салбаруудын бүтээмжийг сайжруулах боломжийн илрэл юм.

Одоогоор үүрэн холбооны зах зээлийг дөрвөн томоохон оператор тодорхойлж байгаа бөгөөд тэдгээрийн хамгийн том нь нийт хэрэглэгчдийн 44 хувийг дангаараа бүрдүүлдэг. Операторууд нь 3G болон 4G LTE зэрэг шинэ технологиудыг танилцуулж нэвтрүүлэхэд үргэлжлүүлэн хөрөнгө оруулсаар байгаа бөгөөд, энэ нь ойрын жилүүдэд нэг хэрэглэгчээс ирэх дундаж орлогын хэмжээг нэмэгдүүлэх хамгийн боломжит арга хэлбэр юм. Сүүлийн хэдхэн жилийн дотор смарт утас болон дата үйлчилгээ маш түгээмэл болсон. 2013 оны сүүлээр Монгол Улсад 1.1 сая 3G үйлчилгээний хэрэглэгчид байсан нь 2012 оны эцэст 500,000 байсан үзүүлэлтээс бүтэн 100 хувийн өсөлттэй үзүүлэлт юм.[52] Хэрэглэгчдийн энэхүү өсөлт нь голчлон хот суурин газруудад төвлөрдөг бөгөөд 2013 оны эцсээр нийт үүрэн үйлчилгээний хэрэглэгчдийн 54 хувь нь Улаанбаатарт байсан байна. Ирэх хэдэн жилүүдэд дундаж давхарга руу шилжих хөдөлгөөн нэмэгдэх хүлээлт болон үүрэн үйлчилгээний хураамж, смарт утасны үнэ буурч байгаатай холбоотойгоор хэрэглэгчдийн тоо өсөх хүлээлттэй байна. Байнгын телефон шугамын хувьд хэрэглэгчдийн тоо тогтмол байна.

## МХХТ-ийн салбарын хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлс

Дэд бүтцийн хөгжил, зарим технологийн хэрэглээ маш сайн хөгжсөнийг үл харгалзан 2017 онд хүн амын дөнгөж 23.7% нь интернэт ашигладаг бөгөөд (Зураг 21) 25 хувь хэрэглэгчид онлайн худалдан авалт хийдэг.[53] Монгол хэл дээрх интернет контентийн хязгаарлагдмал байдал нь интернэт хэрэглэгчдийн тоо бага байхад нөлөөлдөг. Интернэт хэрэглэгчдийн дийлэнх нь интернэтийн орчинд өнгөрөөх ихэнх цагаа Facebook, YouTube, Yahoo зэрэг гадаадын вэбсайтуудаар өнгөрөөж байна. Англи хэлээр ярьдаггүй дийлэнх Монголчуудын хувьд гадаад вэбсайтууд, контентуудыг ашигладаггүй. Түүнчлэн, нийт хүн амын ерөнхий боловсролын түвшин өндөр хэдий ч, бусад орнуудын хэрэглэгчдэд МХХТ-ийн үйлчилгээ үзүүлэхэд гадаад хэл болон салбарын тусгай мэдлэг нь хангалтгүй. МХХТ-ийн хувьд нэгдсэн хөгжлийн бодлого байхгүйгээс гадна цахим худалдааны түгээмэл шаардлагыг хангах үндэсний хэмжээний хууль, дүрэм байхгүй байна. Түүнчлэн бизнес эрхлэгчид болон гарааны бизнесүүдэд үзүүлэх дэмжлэг, инкубаторуудын дутагдал нь МХХТ-ийн салбарт томоохон тоглогч болж хөгжих боломж бүхий Монголын залуучуудын тэмүүллийг хязгаарлаж байна. МХХТ нь банк, санхүүгийн байгууллагууд, төрийн болон хувийн хэвшлийн лидерүүдийн дунд бараа, үйлчилгээ эсвэл оюуны өмч гэсэн утгаар бүрэн танигдаагүй байна. Мөн оюуны өмчийн эрхийн хуулийн хэрэгжилт сул байгаа нь энэ салбарт инноваци, хөрөнгө оруулалтыг хязгаарлаж байна.

> "Оюуны өмчийн эрхийн хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлж чадвал Монголын МХХТ-ийн салбарт асар их боломж байгаа боловч харамсалтай нь тийм соёл, ухамсар, хүлээлт ерөнхийдөө тааруу байна."
>
> НОЁН. Л.ЗАГДРАГЧАА, ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ, INFOSYSTEMS XXK

**Зураг 21.** Монгол Улсын МХХТ салбарын орчин, 2017




[55]IFC (2018)




***Эх сурвалж:*** ITU.

Засгийн газрын зүгээс МХХТ-ийн салбарыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Цахим Монгол хөтөлбөр, МХХТ-ийн салбарын алсын хараа 2021 зэргийг батлан хэрэгжүүлэх алхамуудыг хийгээд байна. Цахим Гарын үсгийн хууль, үйлчилгээг өргөжүүлэн шинэчлэх асуудлыг хамарсан үүрэн холбооны зохицуулалтын зөвлөмжүүд зэрэг хууль эрх зүйн орчныг хөгжүүлэх ажил ч мөн явагдаж байна. Түүнээс гадна, Монгол Улсын Засгийн газар Google-тэй хамтран түүний алдартай орчуулгын үйлчилгээ болох Google Translate-д Монгол хэлийг оруулсан байдаг.




**Photo:** ©Ministry of Foreign Affairs

## Салбарын боломж бололцоог бүрэн хүртэхийн тулд, хууль эрх зүйн, дэд бүтцийн болон ажиллах хүчний асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай

Богино болон дунд хугацаанд цахим засаг, мэдээллийн аюулгүй байдал, мэдээлэл хамгаалал ба оюуны өмчийн зэрэг хуулиудын хэрэгжилтээс эхлэн, одоогоор хийгдээд байгаа алхамуудыг бэхжүүлэн, сайжруулахад чиглэх нь зүйтэй. Цахим гарын үсгийн хэрэглээ болон цахим төлбөрийн системүүдийн сайжруулалтыг эрчимжүүлэн, цахим худалдааны тоглогчдыг дэмжих, тэдэнд тулгамдаж буй бэрхшээлийг хөнгөвчлөхөд анхаарах хэрэгтэй. Ингэснээр цахим худалдан авалт хийдэг Монголчуудын тоо нэмэгдэх төдийгүй, Монгол Улс олон улсын гэрээ хэлэлцээрүүд рүү ахин дэвшихэд бодитой дэмжлэг болох юм.

### **Хайрцаг 12.** МХХТ-ИЙН САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Энэхүү салбарт хөрөнгө оруулснаар МХХТ-ийн үйлчилгээг хот суурин газруудаар хязгаарлалгүйгээр өргөжүүлэх, алслагдсан байршлуудын холболтуудыг сайжруулах ач холбогдолтой юм. Ингэснээр бусад тэргүүлэх салбарууд болон ерөнхий эдийн засагт эерэг үр нөлөөг авчирна. Гадны санхүүжилтүүд нь инкубатор байгуулах, МХХТ-ийн боловсролын хөтөлбөрийг сайжруулах зэргээр бизнес эрхлэх орчинг сайжруулахад дэмжлэг болох боломжтой. Түүнчлэн улс оронд цахим худалдааг хөгжүүлэхэд шаардлагатай цахим төлбөрийн системийн аюулгүй байдлыг хангах шинэ технологийг нэвтрүүлэх боломжтой. Ложистик зэрэг бусад холбогдох салбаруудад хөрөнгө оруулснаар, тээвэрлэлтийн хугацаа болон зардлыг бууруулж, цахим худалдааны хөгжлийг дэмжинэ. .

Урт хугацаандаа, бүх төрийн байгууллагуудын үйл ажиллагааг холбон зохицуулдаг нэгдсэн стратеги бий болох ёстой. 3G ба 4G LTE үйлчилгээ өргөжихийн хирээр хэрэглээний эрэлт нэмэгдэх бөгөөд МХХТ-ийн дэд бүтцийн дутагдлын асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй болно. Бизнес эрхлэх сэдлийг дэмжих хүчин чармайлт нь бусад үйл ажиллагааны чиглэлүүдийг хөгжүүлэх ач холбогдолтой. Үүнд: төрийн болон хувийн хэвшлийн бизнес инкубаторыг байгуулах, гарааны бизнесийг дэмжиж өсөлтөд хүргэх хөтөлбөрүүд г.м. Дижитал хэл болон гадаад хэлний мэдлэгийг бүх шатны боловсролын хөтөлбөрт тусган онцгой анхаарах нь одоогийн ажиллах хүчнийг дахин сургах, ирээдүйн ажиллах хүчнийг бэлтгэхэд чухал ач холбогдолтой. Тиймээс багш нарын сургалтаар дамжуулан бизнес эрхлэх боловсролын хөтөлбөрт МХХТ-ийг суулгаж өгөх хэрэгтэй.

## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Монгол Улсын байгалийн үзэсгэлэн, өвөрмөц соёл, нүүдлийн өв соёл нь жуулчдын сонирхлыг ихээхэн татдаг. 2015 онд Монголд айлчилсан Европчууд болон Хойд Америкчуудын дунд Монголыг зорин ирэх болсон шалтгааныг нь лавласан асуулгаар “Монголын соёл, нүүдлийн амьдралын хэв маяг болон байгалийг үзэж сонирхох” гэсэн хариулт дийлэнх хувийг эзэлсэн байна.[56] Энэ олон улсын чиг хандлага нь Монгол Улсын хувьд томоохон боломж бөгөөд энэ боломжийг ашиглан аялал жуулчлалын эрэлт хэрэгцээг хангах боломжтой. Монгол Улсын аялал жуулчлалын салбар ДНБ-д 527.6 сая ам.долларын шууд хувь нэмрийг оруулах хүлээлт байгаа бол энэ салбарын шууд бус хувь нэмэр нь 2,096.8 сая ам.долларт хүрэх тооцоолол байна.[57] Тиймээс, өндөр үнэ цэнэ бүхий аялал жуулчлалын үйлчилгээг, хариуцлагатай хөгжүүлэлт болон дотоодын нийлүүлэгчдийг бэхжүүлэх замаар төлөвшүүлвэл тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтийг бий болгох боломжтой байна.

2017 онд аялал жуулчлалын салбар нь шууд утгаараа 330.5 сая ам.доллар, шууд бус утгаар 1,233.1 сая ам.долларыг ДНБ-д оруулсан (ДНБ-ийн 3.1 болон 11.4 хувь) бөгөөд аялал жуулчлалаар дамжуулсан экспорт нь 459.3 сая ам.доллар (нийт экспортын 6.7 хувь) байсан байна[58] Үүнээс гадна, тухайн жилд Монгол Улс нийт 36 сая ам. доларын зарцуулалт хийсэн, 54,000 бизнесийн аялагчдыг хүлээн авсан байна. 2017 онд аялал жуулчлалын салбар нь нийт ажил эрхлэлтийн 2.9 хувь буюу 34,000 ажлын байрыг бүрдүүлж байв. Шууд бусаар, энэ салбар нь нийт ажил эрхлэлтийн 10.4 хувь буюу 121,500 ажлын байрыг бүрдүүлэв.[59] Гадны аялагсдын том зах зээл нь Хятад, ОХУ, БНСАУ бөгөөд Япон, АНУ, Европын холбооны улсууд удаалж байна.

Жуулчдыг татах гол арга хэмжээ нь явган аялал, морь, тэмээ унах, майхантай аялал зэрэг хэвээр байсаар байгаа бөгөөд эдгээрийн чанар нь бүс бүсээр харилцан ялгаатай байна. Тухайлбал, төвийн бүс нутгуудаар үндэсний паркууд нь жуулчдын сонирхлыг илүүтэйгээр татдаг. Эдгээр паркууд нь нийслэлтэй ойр байрладаг тул бусад бүс нутгуудтай харьцуулахад олон тооны зочид хүлээн авдаг. Паркууд нь хөтөлбөрт арга хэмжээнүүдийг санал болгохоос гадна барууны тав тухын шаардлагад нийцүүлсэн гэр зочид буудлын үйлчилгээг үзүүлдэг. Хойд, өмнө, баруун, зүүн зүгийн нутгаар тухайн нутаг орны хөтөч, нүүдэлчин айлуудын зохион байгуулсан аялалын үйл ажиллагаануудыг санал болгодог бөгөөд тэдгээр нь илүү бодит, жуулчдын нөлөөлөлд автаагүй аялалыг бүрдүүлдэг.

### Салбарын өсөлтийг хязгаарлагч хүчин зүйлс

Сүүлийн жилүүдэд энэ салбарын харилцаа холбооны чадавх дутмагтай холбоотойгоор жуулчдын тоо буурсан эсвэл өсөлтгүй байдалтай байна (Зураг 22). Монгол Улсын аялал жуулчлалын салбар нь хангалттай хэмжээний агаар, төмөр болон авто замын дэд бүтэцгүйгээс ихээхэн хязгаарлагддаг. Чанар нь муудсаар байгаа авто замын нөхцөл байдал нь алслагдсан бүс нутагт хүрэх боломжийг хязгаарлахаас гадна цөөн тооны онгоцны буудал, нислэгийн сонголтууд нь олон улсын хүртээмжийг хязгаарлаж, салбарын хөгжлийг чөдөрлөж байна. Түүнчлэн 2016 онд хил дээр виза авах боломжит 40 улсыг 20 болгож бууруулсан нь аялал жуулчлалын салбарын хөгжлийг хойш нь татсан алхам болсон. .

---

[56]Acorn Tourism Consulting Ltd for CBI Ministry of Foreign Affairs (2015). CBI Tailored Study: Cultural Tourism to Mongolia. The Hague, Netherlands.
[57]World Travel and Tourism Council (2018). Travel & Tourism: Economic Impact 2018: Mongolia. Available at: https://www.wttc.org/-/media/files/reports/economic-impact-research/countries-2018/mongolia2018.pdf

TIR MON 1 - Final_Fi.indd 42 07.05.2020 09:16:24

**Зураг 22.** Жуулчны экспорт болон ирэх олон улсын жуулчны тоо




***Эх сурвалж:*** Дэлхийн Аялал, Жуулчлалын Зөвлөл, Аялал, Жуулчлал : Эдийн засгийн үр нөлөө 2018: Монгол Улс.

Аялал жуулчлалын салбарт нэгдсэн маркетингийн стратеги байхгүй байгаа нь олон улсын зах зээлүүдтэй харилцаа холбооны түвшинд болон харагдах байдлын хувьд хангалтгүй байдалтай байна. Тухайлбал, Монгол Улсад нийт 450 дотоодын аялал жуулчлалын компаниуд үйл ажиллагаа явуулж байгаагаас 13 хувь нь л олон улсын зах зээл дээр идэвхтэй сурталчилгаа хийн ажиллаж байна.[58] Дотоодын болон гадаадын компаниудын түншлэл сул. Монголд үйл ажиллагаа явуулдаг олон улсын сүлжээнүүд нь бараг бүгд дотоод эх сурвалжаас илүү гадаад, тэр дундаа Хятад эх сурвалжаас мэдээллээ авч байна. Зочид буудлын тоо цөөн байгаа нь салбарын өрсөлдөх чадварт нөлөөлж байна. Тухайлбал, Монгол Улсын аялал жуулчлалын төв болох Улаанбаатар хотод хоёр л таван одтой зочид буудал ажиллаж байна.

Тогтвортой байдлын хуулийн хэрэгжилтийн хангалтгүй байдал нь байгаль орчны экосистемд сөргөөр нөлөөлж байна. Салбарын өөрчлөгдөх боломж чадвар нь чадварлаг ажиллах хүчний дутагдалтай холбоотойгоор хязгаарлагдаж байна. Аялал жуулчлал нь улирлын нөлөөлөл ихтэй салбар тул, ажил мэргэжлийн төдийлөн эрэлттэй сонголт биш бөгөөд чадвар дутагдал, жуулчдын урсгал бага, салбарын ажил эрхлэлтийн байдал бага гэсэн цикл үргэлжилсээр байна

Монголын Аялал Жуулчлалын Холбооноос хэрэгжүүлсэн "Nomadic by Nature" компанит ажил болон Засгийн газрын зүгээс салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах Үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг нь дээрх бэрхшээлүүдийг даван туулах алхамууд юм.

[58]World Travel and Tourism Council (2018).
[59]Ibid

TIR MON 1 - Final_Fi.indd 43
07.05.2020 09:16:25

## Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд нэмэлт хүчин чармайлт хэрэгтэй

Богино болон дунд хугацаанд Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь нэн чухал. Визаны шаардлагыг зөөлрүүлэх арга хэмжээ авбал жуулчдын хөдөлгөөнийг нэмэгдүүлдэг нь батлагдсан тул энэ боломжийг эргэн харах нь зүйтэй. Цахим болон хил дээр виза олгох боломжийг нэвтрүүлбэл зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх ач холбогдолтой. Байгаль орчин хамгааллын хуулиудын хэрэгжилт нь аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг хангахаас гадна Монголын байгаль, соёлын өвийг хадгалан хамгаалахад ач холбогдолтой. Одоогийн ажиллах хүчнийг зочлох үйлчилгээний чиглэлээр мэргэшүүлэн сургах нь үйлчилгээний чанарт эерэгээр нөлөөлнө. зах зээлүүдийг судлах хэрэгтэй. Онцолбол, төрийн зүгээс ЕХ, Австрали болон бусад зорилтот зах зээлүүдэд үйлчилж байгаа визаны шаардлагыг эргэн харахаас гадна, одоогийн бодлого журмыг НҮБ-ын ДХБ-ийн зөвлөмж, тэргүүн туршлагатай харьцуулж үнэлэх шаардлагатай. Түүнчлэн, аялал жуулчлалын байгууламжуудын үйлчилгээний олон улсын стандартыг боловсруулж, аялал жуулчлал, зочлох үйлчилгээний удирдлагын чиглэлээр ур чадварыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийх замаар үйлчилгээний чанарыг сайжруулах хэрэгтэй. Салбарын улирлын нөлөөллийг багасгах үүднээс аялалын зардлыг хямдруулах, бизнес аялагчдад хандах, жуулчдад зориулсан арга хэмжээний цар хүрээг баяжуулах зэргээр бусад улирлаар жуулчид татах стратеги барьж хэрэгжүүлэх нь зүйтэй.

### **Хайрцаг 13.** АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хөрөнгө оруулалтаар салбарт тулгамдаад буй хоёр үндсэн бэрхшээлийг шийдвэрлэх боломжтой. Тэдгээр нь: хоцрогдсон бааз болон хүний нөөц юм. Зочид хүлээн авах бааз суурь, түүн дотроо зочид байрлуулах дэд бүтэц болох зочид буудлууд, хостел, кэмп, амралтын газруудыг олон улсын стандартад нийцүүлэн өргөжүүлэхэд хөрөнгө оруулалт шаардлагатай. Ажиллах хүчний хувьд, аялал жуулчлалын боловсролын хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулахаас гадна эдгээр хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хувийн хэвшлийн хувь нэмрийг татан оролцуулах нь салбарын чадавхийг дээшлүүлэн, олон улсын үйлчлүүлэгчдийн хүлээлтэд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бий болгоно. Үнд хүрэхэд стандарт боловсруулалт маш чухал бөгөөд байгаль орчны стандартын хэрэгжилт нь эко-жуулчлалыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Дотоодын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх санаачлагууд болон аялал жуулчлалын салбар дах ЖДҮ-үүдийн санхүүжилтийн хүртээмжийг сайжруулахад хөрөнгө оруулалт дэмжлэг болно.
.

Урт хугацаандаа, агаар, авто болон төмөр замын дэд бүтцийг сайжруулан хөгжүүлэх арга хэмжээг авах хэрэгтэй. Улаанбаатарын шинэ онгоцны буудал ашиглалтад орохтой зэрэгцэн нислэгийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх нь зүйтэй. Институцийн түвшинд, Засгийн газрын агентлаг хоорондын (БОАЖЯ, ҮХГ болон ГХЯ) уялдаа холбоог сайжруулж, тэдгээр байгууллагуудын оролцооны бүтээмж болон үр дүнтэй байдлыг нэмэгдүүлж, нэгдмэл, аялал жуулчлалын үндэсний стратегийг боловсруулах шаардлагатай. Түүнээс гадна, шинэ



Photo: © Government of Mongolia

[60]CBI, MFA of the Netherlands by Acorn Tourism Consulting Ltd (2014). “Cultural Tourism to Mongolia” Final Report, April 2014,

## СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Техникийн нөөц боломж өндөр, хүн амын нягтаршил бага зэрэг үзүүлэлт нь Монгол Улсыг Ази тивийн их өсөлтийн эрин зууныг энергиэр хангах нарны болон салхин парк байгуулахад таатай нөхцөл байдлыг бий болгож байна. Олон Улсын Сэргээгдэх Эрчим Хүчний Агентлагийн тооцоолсноор Монгол Улсын нар болон салхины эрчим хүчний боломж нь 2.6 ТВт, (2,600,000 МВт)[59] хүртэл буюу 6 тэрбумын хөрөнгө оруулалттай дүйцнэ. Ийнхүү тооцоолсон нөөц боломж дээр үндэслэн, Монгол Улс нь Азийн Супер Сүлжээнд нэгдэж бүсийн томоохон хэрэглэгчид болох Хятад, ОХУ, БНСАУ болон Японтой холбоо тогтоохыг эрмэлзэж байна.

2017 онд Монгол Улс нийтдээ 7,611.6 ГВт эрчим хүч ашигласны, үйлдвэрлэл 6,089.1 ГВт (80%), импортоор 1,522.5 ГВт (20%) байсан байна.  Задаргааны хувьд, нийт эрчим хүч үйлдвэрлэлийн 95.7 хувь (5,826.9 ГВт) нь Дулааны цахилгааны станцаар, 4.2 хувь (262.2 ГВт) нь салхи, нар, усан цахилгаан станцаар, 0.06 хувь нь дизель үүсгүүрээр үйлдвэрлэгдсэн байна[60]

### Харамсалтай нь Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний салбар экспортлох боломжгүй байна

Улс орны сэргээгдэх эрчим хүчний салбар нь өрсөлдөх чадварын хувьд хязгаарлагдмал байна. Супер Сүлжээний хүрээнд өссөн эрэлтийг хангахад шаардагдах сэргээгдэх эрчим хүчний суурилуулсан хүчин чадлын дутагдалтай байна. Монгол Улсын дотоодын эрчим хүчний салбарын төвийн бүсийн эрчим хүчний сүлжээний суурилуулсан хүчин чадал нь 1,174.8 МВт бөгөөд үүний 20 хувийг нь ОХУ-аас импортолж байна. Энэ нь ойрын хугацаанд Монгол Улс сэргээгдэх эрчим хүч ихээхэн хэмжээгээр экспортлох чадамжгүй байдлыг батлан харуулж байна. Говийн бүсээр холболтууд бий болгон хөгжүүлэхэд тулгарах техник, санхүү, улс төрийн бэрхшээлүүд нь сэргээгдэх эрчим хүчний экспортыг хөгжүүлэхэд тушаа болох магадлалтай.

Эрчим хүчний тарифын дундажаар Монгол Улс нь хөрш зэргэлдээ улсуудтай харьцуулахад өрсөлдөхүйц боловч эрчим хүчний чанарын хувьд өрсөлдөөний сул талтай байна. Түүнчлэн, одоогоор үйл ажиллагаа явуулж буй салхин паркууд нь үйл ажиллагааны зардал болон тарифын хязгаарлалттай холбоотойгоор үндсэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаа бөгөөд үр ашиг авчрахаасаа илүү улсын өрийг нэмэгдүүлэн, төрийн татаас хөнгөлөлт шаардаж байгаа талаар маргах нь бий. Цаашилбал, эрчим хүчний сектор нь төрийн зохицуулалт ихтэй тул Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн дагуу Эрчим Хүчний Зохицуулалтын Хороо нь сэргээгдэх эрчим хүчний үнэ тарифыг тогтоох шаардлагыг тавьсан. Ийм төрийн зохицуулалт, оролцоотой салбарт хөрөнгө оруулагчийн хувьд үр ашиг олох нь бараг боломжгүй зүйл. Сэргээгдэх эх үүсвэрээс их хэмжээний эрчим хүчийг хураах асуудал нь сорилт хэвээр байсаар байна. Нүүрсэн цахилгаан станцууд болон тэдгээрийн холбогдох цахилгааны сүлжээ нь сэргээгдэх эх үүсвэрээс хураасан цахилгаантай автоматаар нэгтгэх боломжийг хязгаарладаг. Монгол Улсын цахилгааны дэд бүтэц ижил орлогын түвшин дэх улс орнуудтай ижил төстэй хэдий ч, 2016 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 81.7 хувь нь цахилгаантай бөгөөд цахилгаан дамжуулалт түгээлтийн алдагдал нь 2014 оны байдлаар 14.8 хувь байна.[61]

Богино хугацаандаа хөрөнгө оруулалтын тэргүүлэх зорилтууд нь худалдааны тэргүүлэх зорилтуудтай төдийлөн давхцахгүй байгаа хэдий ч, Монгол Улсын эрчим хүчний үйлдвэрлэл нь урт хугацаандаа экспортын томоохон боломжийг агуулах салбар юм. Тухайлбал, Сайншанд дах 55 МВт-ын, Ферроштаалын, салхин паркийн төсөл нь нийт 100 сая ам.долларын ГШХО авчрах хүлээлттэй байгаа нь сэргээгдэх эрчим хүчний салбарыг даруй ГШХО-ыг татах үзүүлэлтээрээ, уул уурхайн бус, худалдааны бус, тэргүүлэх зэргийн салбар болгон тодорхойлж байгаа юм. Цаашилбал, Монгол Улсын Ногоон Хөгжлийн Бодлогын Үйл Ажиллагааны Төлөвлөгөөний дагуу сэргээгдэх эрчим хүчний нийт эрчим хүчний үйлдвэрлэлд эзлэх хувийг 2020 онд 20 хувь, 2030 онд 30 хувьд хүргэн хүлэмжийн хий ялгаруулалтыг бууруулахыг зорьж байна. Тиймээс үндэсний зорилтуудад хүрэхийн тулд энэ салбарыг хөгжүүлэх явдал нь тэргүүлэх ач холбогдолтой юм.

Салбарын хөгжлийг дэмжих зорилгоор, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэлд дэмжих тариф ашиглах зэргээр тодорхой арга хэмжээ авч байна. Түүнчлэн, Азийн Хөгжлийн Банк болон Монгол Улсын Засгийн газар хооронд Япон улсын тусламжаар 41 МВт-ийн сэргээгдэх эрчим хүчний станц барих зөвшилцөлд хүрсэн байна.  Энэхүү санаачилга нь Ферроштаалын салхин парктай нийлээд нийтдээ 200 гаруй сая ам.долларын өртөгтэй төслүүд юм.

[61]Green Climate Fund (2017) Renewable Energy Program #1 – Solar – Funding proposal. Available at: https://www.greenclimate.fund/documents/20182/574760/Funding_Proposal_-_FP046_-_XacBank_LLC._-_Mongolia.pdf/dd828555-bd41-44be-b7e8-67794f57bf76
[62]CHPP-4 65.3%, DCHPP 4.7%, ECHPP 2.8%, UKhCHPP 2.0%, DorCHPP 4.0%, DzCHPP 0.1%, CHPP-2 2.6%, CHPP-3 18.5%.
[63]Wind power (58.9%), solar photovoltaic (7.5%), and hydro power plant (32.2%).
[64]Energy Regulatory Commission of Mongolia, 2017 Statistics on energy performance.
[65]World Bank (2016). “Access to electricity”. Available at https://data.worldbank.org/indicator/EG.ELC.ACCS.ZS?locations=mn

## Салбарын экспортын боломжийг бодит болгоход стратегийн алхмуудыг хэрэгжүүлэх шаардлагатай

Богино болон дунд хугацаанд, одоо байгаа байгууламжууд болон бэлэн байгаа нөөцийг капиталжуулах шаардлагатай. Тухайлбал, Ногоон хөгжлийн бодлогод дэвшүүлсэн зорилтод хүрэхийн тулд одоогийн эрчим хүчний үйлдвэрлэлийн систем болон бусад үйлдвэрлэлийн технологийг шинэчлэх шаардлагатай. Хэт хэрэглээ, алдагдлыг бууруулах, үнийн бодлогыг оновчтой болгох шаардлагатай. Мэргэжлийн чадварыг сорьж, туршлага хураан сайжруулах зорилгоор жижиг төслүүдийг түрүүлэн хэрэгжүүлж, гадаад, дотоодын компаниудын хоорондын зохицуулалт, мэдлэг солилцох үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж болно.

### **Хайрцаг 14.** СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монгол Улс сэргээгдэх эрчим хүчийг экспортлох бололцоотой; хэдий тийм ч энэ боломжийг ашиглахад шаардагдах чадавхийг бий болгохын тулд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс гадна хөрөнгө оруулалтаар эрчим хүчний экспортыг нэмэгдүүлэхэд шаардагдах дэд бүтцийг бий болгох боломжтой. Тухайлбал, үйлдвэрлэсэн илүүдэл эрчим хүчийг зохицуулах сүлжээ, бүсийн цахилгаан эрчим хүчний эрэлтийг хангах зорилгоор Азийн Супер Сүлжээ рүү цахилгаан дамжуулах шугамууд г.м. Түүнчлэн, хөрөнгө оруулалт нь одоо байгаа эрчим хүчний дэд бүтцийг сайжруулж, алдагдлыг бууруулах, аажмаар технологи, системийг илүү үр өгөөжтэй болгох зэргээр Ногоон Хөгжлийн Бодлогод дэвшүүлсэн зорилтууддаа хүрэхэд тусална. .

Урт хугацаандаа, эдгээр төслийн хүрээнд үүссэн улсын өрийг хувийн эзэмшилд шилжүүлэн сольсноор салбарын хөгжлийг хурдасгах боломжтой. Худалдан авах баталгаа өгөх, зах зээлийн зарчимд тулгуурлан салбарыг либералчлах замаар салбар дах хөрөнгө оруулалтыг дэмжих боломжтой. Түүнээс гадна, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс бий болсон эрчим хүчний илүүдлийг хураах сүлжээ болон түүнийг дотоодод болон олон улсад дамжуулах дэд бүтцийг сайжруулах шаардлагатай байна.

## ЭРДСИЙНГҮНБОЛОВСРУУЛАЛТ

2018 онд Монгол Улс нь уул уурхайн салбар үүсч хөгжсөний 96 жилийн ойгоо тэмдэглэсэн бөгөөд энэ салбар нь улсын эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулагч салбар юм. Нүүрс, алтны чиглэлд үйл ажиллагаа нь төвлөрдөг байсан салбар нь өдгөө зэс, төмөр, ган, газрын тос зэргээр өргөжин хөгжиж ирсэн. Монгол Улс нь 173 тэрбум тн. нүүрс, 1 тэрбум тн. төмрийн хүдэр, 93.3 сая тн. зэс, 2000 тн. алт, 332.6 сая тн. газрын тосны нөөцтэй, ашигт малтмалын арван баялаг нөөцтэй улс юм.

Ашигт малтмалын салбар нь Монголын эдийн засгийн чухал хэсэг бөгөөд үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 68 хувь, ДНБ-ий[62] 21 хувь, улсын төсвийн орлогын 30 хувийг[63] бүрдүүлэхийн зэрэгцээ 40,000 ажлын байрыг бүрдүүлж байна.[64] Үүнээс гадна, ашигт малтмалын салбар нь нийт экспортын 85 хувь, ГШХО-ын 70 хувийг бүрдүүлдэг.[65]

### Салбарын боловсруулах үйл ажиллагаа дутмаг байна

Түүхий эдийн олборлолт, анхан шатны боловсруулалт дээр л голчлон үйл ажиллагаа явуулдаг тул Монгол Улсын гүн боловсруулалтын салбар нь өрсөлдөх чадвар доогуур. Уул уурхайн үйлдвэрлэлийн бараг 97 хувь нь технологийн чадавхтайгаа холбоотойгоор хагас боловсруулсан бүтээгдэхүүнээс бүрддэг бөгөөд экспортын орлого нь голчлон нүүрс (48%), зэсийн баяжмал (35%), алт (10%) болон төмрийн хүдрээс (6%) бүрдэж байна.[66]

[66]Country Snapshot: Mining in Mongolia 2017. Available at https://www.ausimmbulletin.com/feature/country-snapshot-mongolia/
[67]Export.gov (2017). "Mongolia – Mining". Available at https://www.export.gov/article?id=Mongolia-Mining
[68]Country Snapshot: Mining in Mongolia 2017.
[69]Export.gov (2017). "Mongolia – Mining"

Үүнээс гадна ашигт малтмалын боловсруулалт хийх үйлдвэрүүд нь хүчин чадлаасаа доогуур түвшинд үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, нүүрс угаах, боловсруулах үйлдвэрүүд, гангийн үйлдвэрүүд нь өөрийн бүрэн хүчин чадлын тэн хагас буюу түүнээс бага түвшинд ажиллаж байна. Зэсийн боловсруулалт, зэс бүтээгдэхүүний хувьд Монголын компаниуд нь өрсөлдөх чадваргүй буюу ОХУ, БНСАУ-ын хямд үнэтэй зэс утастай өрсөлдөх боломжгүй байдаг. ОХУ болон Хятадын зүгээс тавигддаг импортын татвар нь Монголын зэс утасны экспортыг бүр ч илүү хүндрүүлдэг. Газрын тосны хувьд Монгол Улс өөрийн улс орны хэрэгцээг хангах боловсруулах үйлдвэргүй бөгөөд импортоос бүрэн хамааралтай. Үүнтэй адилаар, алт боловсруулах үйлдвэр байхгүйгээс Монгол Улс нь өөрийн алтаа Их Британи, Япон, Швейцар зэрэг орнуудад боловсруулдаг нь тээвэрлэлтийн өндөр зардалтай байдаг.

Сүүлийн хэдэн жилийн хугацаанд Монгол Улс нь аж үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх чиглэлээр хэд хэдэн бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ирсэн. Жишээлбэл, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийт экспортод эзлэх боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүний хувийг 2014 онд 17 хувь байсныг 2030 онд 50 хувьд хүргэх, шатахууны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах, ашигт малтмалын боловсруулалтын түвшинг сайжруулах, хууль эрх зүй, татварын бодлогоор дамжуулан нэмүү өртөг шингээх үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хадгалан хамгаалалах зэрэг зорилтууд багтсан байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын Үйл ажиллагааны төлөвлөгөө 2016-2020, Эдийн засгийг эрчимжүүлэх хөтөлбөр болон Алт-2 хөтөлбөр зэрэгт зэс, газрын тос, алт боловсруулах үйлдвэрүүдийн мега төслүүд болон ган, шатахуун, нүүрс болон химийн үйлдвэрийн байгууламжуудыг хөгжүүлэх төлөвлөгөөнүүд багтсан байдаг.

## Эрдсийн гүн боловсруулалтын боломжит өсөлтийг бий болгох дараах алхамууд

Богино болон дунд хугацаанд Монгол Улс тодорхойлсон зорилтууддаа хүрэхэд туслах төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх боломжийг хангасан замын зураглал боловсруулахад анхаарах хэрэгтэй. Зэс, төмрийн хүдэр, түүхий нефть, нүүрс зэрэг одоо байгаа боловсруулах үйлдвэрүүдийг оновчтой ашиглахад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Монгол Улс нь ашигт малтмалын хөрөнгө оруулагчдын дунд сайтар танигдсан тул, ГШХО-ыг энэ салбарт татахад төдийлөн хүндрэлгүй юм. Орж ирж буй ГШХО-г цаашдын эрэл хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд чиглүүлэхээс илүүтэйгээр боловсруулах үйл ажиллагаанд чиглүүлэх нь зүйтэй.

### **Хайрцаг 15.** ЭРДСИЙН ГҮН БОЛОВСРУУЛАЛТЫН САЛБАР ДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Ерөнхийдөө хөрөнгө оруулалт нь Монгол Улсын төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, тэдгээрт тусгагдсан зорилтуудыг биелүүлэхэд тусална. Салбарын технологийн чадавхийг дээшлүүлэхэд хөрөнгө оруулалт хийх нь боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх ач холбогдолтойгоос гадна энэ нь салбарын бүтээмжийг нэмэгдүүлж гадаадын компаниудтай өрсөлдөх боломжийг олгоно. Хөрөнгө оруулалт нь алт, зэс, газрын тосны зэрэг шинэ боловсруулах байгууламжуудыг байгуулахад түлхэц болохоос гадна ингэснээр ашигт малтмалыг гадаадад боловсруулдаг өндөр зардлыг бууруулна..

Урт хугацаандаа, нүүрсний химийн үйлдвэр, алт, зэсний боловсруулах үйлдвэрүүд, гангийн төслийг хөгжүүлэхийн зэрэгцээ татварын, санхүү, эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд чиглэж ажиллах хэрэгтэй. ГШХО болон дотоодын хувь хөрөнгө оруулагчдыг татахуйц үйлдвэрлэлийн цогцолборыг системтэйгээр хөгжүүлэх шаардлагатай. Ингэхийн тулд хууль, бодлого, журмын хэрэгжилтийг дэмжих замаар урьчилан тооцоолж, таамаглах боломж нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай. Хөрөнгө оруулалтын стратеги нь салбарын боловсруулах үйл ажиллагааг нэмэгдүүлэх алсын хараатайгаар боловсруулагдах хэрэгтэй тул эдийн засгийн болон экспортын төрөлжүүлэлт, сайжруулалтад хувь нэмэр оруулахуйц үйл ажиллагаануудад чиглэх нь зүйтэй.

[70]Mongolian Customs (2019). Available at http://www.ecustoms.mn/

## **Хайрцаг 16.** НОГООН ЭДИЙН ЗАСАГ РУУ

Монгол Улсын байгаль орчинд хор хөнөөл ихтэй салбараас бүрдсэн экспорт болон хөрөнгө оруулалтын суурь нөхцөлтэйгээр эдийн засгийн хөгжилд хүрэх замнал нь байгалийн нөөц баялгийг хяналтгүй ашиглахад хүргэж байна. Энэхүү хандлага нь уур амьсгалын өөрчлөлттэй зэрэгцэн, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж байна. Тухайлбал, жилийн дундаж агаарын температур 2.2 хэмээр нэмэгдсэн бөгөөд халуун өдрүүдийн тоо 8-10 хоногоор нэмэгдэж, хур тунадасны хэмжээ нэмэгдэж, хөрсний чийгийн хэмжээ багасч улмаар тариалангийн талбай багасгасан.

Уул уурхайн үйл ажиллагаа нь байгаль орчинд хор хөнөөлтэй хэвээр байна. Засгийн газраас саяхан хийсэн шалгалтаар уул уурхайд ашигласан 22,752 га газраас, 4,256 га нь уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн, нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон байна. Зөвхөн 9,100 га талбайг өмнөх байдалд нь хүртэл нөхөн сэргээх ажил хийгдсэн байдалтай байна. Байгаль орчны стандартууд сул, байгаль орчны хууль тогтоомж, дүрэм журмыг сахиулах чадавхи сул байдал нь мөнгөн ус, цианит гэх мэт химийн бодисын хяналтгүй ашиглалттай хосолбол экологийн хохирлыг улам доройтуулж болзошгүй юм.

Түүнчлэн, түүхий ноолуурын төлөө ямааны тоо толгой асар хурдацтай нэмэгдэж, уламжлалт нүүдлийн мал аж ахуйн аргачлалын хэсэг болох нутаг сэлгэн нүүдэллэх нь багассан нь Монгол Улсын тал хээр, бэлчээрийн доройтлыг нэмэгдүүлж байна. Энэ нь ихэвчлэн уур амьсгалын эрс тэс өөрчлөлт, байгалийн гамшиг, ган зуд зэрэг байгалийн гамшигт үзэгдлээс үүдэлтэй юм. Үүний үр дүнд нийт нутаг дэвсгэрийн 77.8% нь цөлжилтөд нэрвэгдэж байна.

Байгаль орчны бусад асуудлууд нь зэрлэг амьтдын хууль бус худалдаа, хууль бус мод бэлтгэл, ойн нөөцийн хомсдол, хязгаарлагдмал усны эх үүсвэрийн устгал, хөдөөгөөс хот суурин газар руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэйгээр хот, суурин газрын хил хязгаар тэлэхийн хэрээр агаар, ус, хөрсний бохирдол нэмэгдэж байна. Эдгээр нь гол төлөв эрс тэс уур амьсгалын өөрчлөлт болон дотоодын мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүний хил дамнасан худалдаа төдийлөн үр ашиггүйгээр хийгддэгтэй холбоотой байна

Монгол Улсын байгаль орчны салбарын хууль эрх зүй, зохицуулалтын хүрээг олон улсын стандартын дагуу шинэчилсэн. Өнөөдөр Монгол Улс байгаль орчныг хамгаалах талаар 27 хууль, 18 үндэсний хөтөлбөрийг баталсан байдаг. Түүнчлэн олон улсын 12 конвенци, 5 протоколд гарын үсэг зуран нэгдсэн бөгөөд дэлхий даяар 30 гаруй улстай хоёр талт хамтын ажиллагааны гэрээ байгуулаад байна. Үүнээс гадна, байгаль орчны үнэлгээ, аудитын стратегийн эрх зүйн орчинг бүрдүүлж, 2,087 байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланг хүлээн авлаа.

Сангийн яамны дэмжлэгтэйгээр БОАЖЯ нь тогтвортой худалдаа, ногоон худалдааны холбогдох хууль тогтоомжийг баталгаажуулахын тулд одоо байгаа "Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-д ногоон худалдааны холбогдох гол заалтуудыг нэгтгэн оруулсан. Яам нь үйлдвэрлэл, үйлдвэрлэгчдийн эрх зүйн орчинг сайжруулах, тэдний өртгийн сүлжээг илүү тогтвортой байлгахын тулд хууль эрх зүйн зарим санаачлагыг боловсронгуй болгож чадсан байна.

Гэсэн хэдий ч байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт нь гол асуудал юм. Тухайлбал, байгаль орчны салбарын орон нутгийн төсөвт 61.6 тэрбум төгрөг төвлөрснөөс, 2016 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулсан нийт зардлын 29 хувийг л зарцуулсан байна. Байгаль орчны стратегийн үнэлгээ болон байгаль орчны аудитыг хуульд заагдсаны дагуу гүйцэтгэж, холбогдох яам, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчид, аж ахуйн нэгжүүд дээрх арга хэмжээг эрчимжүүлэхийн тулд эдгээр үнэлгээ, аудитын талаархи удирдамж, мэдээлэл өгөх шаардлагатай.

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам (2017 он). Монгол Улсын байгаль орчны төлөв 2015-2016; Жеффери Рийвз(2011). Монголын байгаль орчны аюулгүй байдал ба Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам (2014). Монгол Улсын ногоон эдийн засагт шилжих нь

# ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

Тэргүүлэх салбаруудаас гадна, худалдаа хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэг зургаан чиг үүргийг Монгол Улсын бүхий л салбарын экспортыг дэмжих, хөрөнгө оруулалт татахад онцгой ач холбогдолтой хэмээн тодорхойлсон болно. Эдгээр дэмжих үйл ажиллагаануудын гурав нь олон улсын зах зээл, боломжуудтай холбоо тогтоон сайжруулахад тулгарч буй сорилт, бэрхшээлүүдийг онцолсон (худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого, худалдааг хөнгөвчлөх, худалдаа, хөрөнгө оруулалтын сурталчилгаа) бол нөгөө гурав нь худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой компаниудын өөрсдийн чадавхийн асуудлыг (санхүүжилтийн хүртээмж, чанарын удирдлага, ур чадварын хөгжүүлэлт) хөндөж авч үзсэн болно.



Зураг: ГХЯ. Монголын ХХОЗЗ хоёр дугаар зөвлөлдөх уулзалт 2019 оны 1 сар.

## ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

Худалдаа, хөрөнгө оруулалтын Монгол Улсын эдийн засгийг өөрчлөх боломж чадавх нь бодлого боловсруулалт, хэрэгжүүлэлт нь үндэсний хөгжлийн төлөвлөгөөтэй хэр нягт уялдаатай байхаас хамаарна. Монгол Улсад либералчлал, нээлттэй байдал улам нэмэгдэж байгаа хэдий ч, шийдвэрлэх шаардлагатай бодит бэрхшээл, хүндрэлүүд нь хүчин төгөлдөр болон боломжит худалдаа, хөрөнгө оруулалтын гэрээнүүдийн хараахан бодит болоогүй үр ашиг, хувийн хэвшлийн сектортой хамтын ажиллагаа нь албан бус бөгөөд ил тод байдал хангалтгүй, төрийн салбарын чадавх сул зэрэг болно.

## Либералчлал болон нээлттэй байдал нь Монгол Улсад шинэ боломжуудыг авчирсан

Гадаад харилцааны яам болон бусад худалдааны бодлого боловсруулалт, хэрэгжилтийг хариуцаж ажилладаг байгууллагуудын либералчлал, бодлогын шинэчлэл, олон улсын эдийн засгийн хэлэлцээрүүд зэрэг ажлууд нь үр дүнтэй байна. Монгол Улс нь эдийн засгийн өсөлт хөгжлийг нь хөдөлгөгч гол хүчин зүйл болсон гадагш чиглэсэн эдийн засаг болон хувирч байна.  Монгол Улс, одоогийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй 37 хоёр талт хөрөнгө оруулалтын гэрээ болон үзэглэсэн 6 гэрээ хэлэлцээртэй байна. (Хүснэгт 5). .

**Хүснэгт 5.** Монгол Улсын хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүд

| Хүчин төгөлдөр | | |
|---|---|---|
| • Австри | • Энэтхэг | • Польш |
| • Беларусь | • Индонези | • Румын |
| • Бельги-Люксембургийн эдийн засгийн холбоо | • Израил | • ОХУ |
| • Канад | • Итали | • Сингапур |
| • Хятад | • Казахстан | • Швед |
| • Куба | • БНСУ | • Швейцари |
| • Чех | • Кувэйт | • Таджикистан |
| • Дани | • Лаос | • Турк |
| • Египт | • Литуан | • Украин |
| • Финлянд | • Малайз | • Их Британи |
| • Франц | • Нидерланд | • АНУ |
| • Герман | • Филиппин | • БНСВУ |
| • Унгар | | |

| | | |
|---|---|---|
| Үзэглэсэн | | |
| • Болгар | • Хорват | • БНСУ |
| • Киргизистан | • Катар | • АНЭУ |
| Цуцалсан | | |
| • Япон | | |

***Эх сурвалж:*** НҮБХХБХ (2019), Олон улсын хөрөнгө оруулалтын гэрээний лавлагаа.

## Бодлого боловсруулалт, хэрэгжилтийн хувьд чадавхийг сайжруулах шаардлага байна

Худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогыг бэхжүүлэх чиглэлд илүү хүчин чармайлт тавих шаардлагатай байна. Тухайлбал, Монгол Улс нь бүс нутагтаа гадаадын хөрөнгө оруулалтад хамгийн нээлттэй эдийн засаг бүхий улс орнуудын нэг боловч, хөрөнгө оруулалтын нээлттэй байдлыг хангах төрийн бодлогын тогтворгүй байдал нь хөрөнгө оруулалт, тэр дундаа ГШХО-г саарулах тодорхой бус орчинг бий болгож байна. Хувийн хэвшлийн хөгжилд гүйцэтгэх ГШХО-ын үүрэг, ач холбогдлын талаар төрийн зүгээс тодорхой алсын хараагүй байдал болон ойр ойрхон гарах бодлогын өөрчлөлтүүд нь урт хугацааны хөрөнгө оруулалтын стратегийн үр шимийг хүртэх боломжийг хязгаарлаж байна. Газар өмчлөлийн асуудал, гадаадын хөрөнгө оруулалтын 100,000 ам.долларын босго шаардлага, бүртгэлийн асуудлууд, хөрөнгө оруулалтын хуулиар зааж өгсөн эрх, хөнгөлөлтийг эдлүүлэхээс татгалзсан ямдын талаар хөрөнгө оруулагчдын гомдол саналууд зэрэг нь хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж байна.

Ихээхэн хэмжээний худалдааны боломж ашиглагдалгүй байсаар байна. ОУХТ-ийн Экспортын боломжийн зураглалаас үзвэл Монгол Улсын ашиглагдаагүй экспортын боломж 253.2 сая ам.доллар байна. Абсолют утгаараа экспортын ашиглагдаагүй боломж хамгийн өндөр улсаар БНСВУ (51.8 сая ам.доллар), Индонези (24.4 сая ам.доллар), Хятад (22.6 сая ам.доллар), Итали (21.4 сая ам.доллар) зэрэг улсууд дурьдагдсан байна. Бүтээгдэхүүний хувьд авч үзвэл, адууны мах (56.3 сая ам.доллар), самар (50 сая ам.доллар), зэсийн баяжмал (40.1 сая ам.доллар), самнаагүй нарийн ноос (13.3 сая ам.доллар) зэрэг болно.

**Зураг 23.** Монгол Улсын экспортын боломжит зах зээлүүд




***Эх сурвалж:*** ОУХТ (2019), Экспортын боломжийн зураглал.

Монгол Улсын худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагууд нь компаниудад олон төрлийн үйлчилгээг үзүүлж байгаа хэдий ч, тэдгээр байгууллагууд хооронд үйл ажиллагааны зохицуулалт байхгүй, шаардлагатай чадварын дутагдал байдаг нь үзүүлж буй үйлчилгээний үр дүн, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна. Ялангуяа жижиг компаниуд нь зах зээлд нэвтрэх нөхцлийн талаар найдвартай, цаг үеийн мэдээллээр дутагдаж байдаг.

Засаглалын сул байдал, ил тод байдлын дутагдал нь худалдаа, хөрөнгө оруулалтын үр дүнтэй бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд саад учруулж байна. Дэлхийн банкны Дэлхийн засаглалын индексээр Монгол Улс 2017 онд дэлхийн доод 50 хувьд (Засгийн газрын үр дүнтэй үйл ажиллагаа (42.1%), хуулийн засаглал, авлига (41.8%), хээл хахуулийн хяналт (41.8%) багтжээ. Байгууллагын чадавхийг төрийн үйлчилгээг мэргэжлийн болгох чиглэлээр бэхжүүлэх нь ГШХО-ын орох урсгалын зохицуулалтын шийдвэрийг улс төржүүлдэг байдлыг багасгахад тустай.

Үүний зэрэгцээ эдийн засагт томоохон үүрэг гүйцэтгэдэг төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нь хувийн хэвшлийн хөгжлийг гацааж, гадаадын хөрөнгө оруулалтын боломжийг нь хязгаарлаж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессыг зохион байгуулахад чиглэсэн институцийн тусгайлсан чиглэл дутмаг байгаа нь төрийн өмчит аж ахуйн нэгжийн хэлбэрийг түгээмэл ашиглахад хүргэсэн бөгөөд энэ нь эргээд монополь тогтох үндэс болдог. Жишээ нь ашигт малтмалын боловсруулалтын салбар. Тухайлбал, төрийн өмчит МИАТ компани нь тээвэр зуучийн зах зээл дээр монополь болсон нь агаарын тээвэр, цаашилбал экспортын зардлыг нэмэгдүүлж байна.

## ХХОЗЗ дах худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого

ХХОЗЗ нь худалдаа, хөрөнгө оруулалтын бодлоготой холбоотой гол асуудлуудыг онцлов (Хүснэгт 7). Үүнд төрийн болон бодлого боловсруулагч экосистемийн өргөн хүрээг хамарсан чадавхийг хөгжүүлэх, одоогийн болон боломжит олон улсын гэрээний боломжуудыг үнэлэх зэргээр худалдаа хөрөнгө оруулалтын ашиглаагүй боломжийг гаргаж ирэх үйл ажиллагаанууд багтана. Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх шатанд ил тод байдал дутмаг байгаа тул мэдээлэл солилцох шинэ механизмыг бий болгох, төрийн үйлчилгээн дэх хэрэгжүүлэх чадавх болон мэргэжлийн байдлыг сайжруулах арга хэмжээг авах хэрэгтэй.

**Хүснэгт 6.** Худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого: Гол сорилтууд ба ХХОЗЗ-ийн үйл ажиллагаа

| Гол сорилтууд | Дараагийн асуудлууд | Авах арга хэмжээнүүд |
|---|---|---|
| • Худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого, гэрээнүүд нь эдийн засгийн боломжийг дэмжих боломжтой | • Үр ашигтай худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулах чадавх хязгаарлагдмал<br>• Хөрөнгө оруулалтын бодлогын тодорхойгүй байдал нь ГШХО-д сөргөөр нөлөөлж байна<br>• Хувийн хэвшлийн үзэл санаа нь бодлого боловсруулах ажиллагаанд тогтмол тусгалаа олдоггүй | Бодлогын шинжилгээ, боловсруулалтыг дэмжих чиглэлд ХХОДБ-ын чадавхийг бэхжүүлэх (1.1.1)<br>• Үндэсний хөгжлийн төлөвлөлттэй уялдсан худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулах (1.1.2)<br>• Үндэсний экспортын бүрэн хэмжээний стратеги боловсруулах (1.1.3)<br>• Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх (1.1.4)<br>• Монголын Экспорт, Хөрөнгө оруулалтын зөвлөл (1.5.1) байгуулж, ХХХОЗЗ-ийн тэргүүлэх салбаруудын ашиг сонирхлыг төлөөлөх салбарын хороодыг зөвлөлийн хүрээнд байгуулах (1.5.2)<br>• Хувийн хэвшлийн харилцан зөвлөлдөх, мэдээлэл түгээх харилцааг хөгжүүлэх зохицуулалтыг (3.1.1), бизнесийн бүлгүүдийн харилцааг хөгжүүлэх (3.1.2), хувийн хэвшлийн санал гомдлоо илэрхийлэх боломжийг нэмэгдүүлэх (3.1.3).. |
| | • Өнөөгийн болон боломжит олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн үр ашгийг бүрэн хүртээгүй | Олон улсын гэрээ хэлэлцээрүүд<br>• Гүйцэтгэлийн үнэлгээ хийх замаар одоогийн худалдаа, хөрөнгө оруулалтын гэрээнүүдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх (1.3.1)<br>• Боломжит түншүүдийг харьцуулах, шинжилгээ хийх замаар ирээдүйд байгуулах худалдаа хөрөнгө оруулалтын гэрээнүүдийн үнэ цэнийг сайжруулах (1.3.2) |

| | | |
|---|---|---|
| • Бодлого боловсруулан хэрэгжлүүлэхэд ил тод байдал дутмаг | • Бодлого боловсруулалтад ил тод байдал, харилцаа холбоо, хамтын ажиллагаа дутмаг<br>• Компаниудад худалдааны боломжийн талаарх мэдээлэл дутмаг | • Худалдааны бодлогын олон нийтийн порталыг бий болгох (1.4.1)<br>• Хэлэлцээр хийхэд хувь нэмрээ оруулах хувийн хэвшлийн техникийн хороог албан болгох (1.4.3) |
| | • Дүрэм журмын хэрэгжилт үзэмжид суурилсан<br>• Бүрэн бус хэрэгжилттэй журмууд | • Бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг дэмжих замаар урьдчилан тооцоолон таамаглах боломжийг нэмэгдүүлэх (1.2.1, 1.2.2, ба 1.2.3)<br>• Төрийн албаны шинэ хуулийн хэрэгжилтийг хангах замаар мэргэжлийн төрийн үйлчилгээг байгуулах (2.6.1) төрийн захиргааны чадавхийг бэхжүүлэх (2.6.2) |

## ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ

Худалдааг хөнгөвлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь худалдаанд шаардагдах зардал, цаг хугацааг ихээхэн бууруулах ач холбогдолтой юм. Олон улсын хэмжээнд Монгол Улс харьцангуй сайн үзүүлэлттэй бөгөөд цаашид сайжруулалтыг хийхийн ач холбогдлыг ухамсарлаад байгаа хэдий ч, Олон улсын үүргийн хэрэгжилт, хил дамнасан системийг сайжруулах болон үндэсний нэг цонхны бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр арга хэмжээ авах шаардлагатай байна.

## Худалдааг хөнгөвчлөх цаашдын арга хэмжээг төлөвлөсөн

ДЭЗХАХБ-ын Худалдааг хөнгөвчлөх индексээс харвал, Монгол Улс нь худалдааны нийгэм, хураамж шимтгэл, дотоодын хил хамгаалах байгууллагын хамтын ажиллагаа, засаглал болон хараат бус байдлын хувьд өөрийн орлогын ангилалд харьцангуй сайн үзүүлэлттэй байна (Зураг 25). Урьдчилсан бүрдүүлэлт, гадаад хилийн байгууллагын хамтын ажиллагаа, бичиг баримтын бүрдэл болон автоматжуулалтын чиглэлд сайжруулалтуудыг голчлон хийх нь зүйтэй.

**Зураг 24.** Худалдааг хөнгөвчлөх индекс, 2017




***Эх сурвалж:*** ЭЗХАХБ (2018), Худалдааг хөнгөвчлөх индикаторууд.

Монголын тогтвортой хөгжлийн зорилт 2030 нь дэд бүтэц, логистикийн сүлжээг хөгжүүлэх, экспортын зардал, цаг хугацааг бууруулах зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан худалдаа, үйлчилгээг сайжруулахыг зорьж байна. Сүүлийн жилүүдэд Монгол Улс худалдааг хөнгөвчлөх чигэлэлээр тодорхой алхмууд авч хэрэгжүүлснээс, 2016 онд Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг баталсан нь одоогоор 23.5 хувийн хэрэгжилттэй байна. Үүний зэрэгцээ, Монгол Улс нь ХХХ-ийн хэрэгжилтийг дэмжих зорилготой Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах үндэсний хороог байгуулж, Худалдааг хөнгөвчлөх үндэсний замын зургийг боловсруулсан. Цаашид, экспортын процессыг түргэтгэх зорилгоор МХЕГ-ын байранд Нэг цэгийн төвийг байгуулна.

төлөвлөгөөг тусгасан бөгөөд тэдгээрийг үндсэн ХХХ-ийн зарчмыг тусгах замаар дотоодын хууль журмыг сайжруулах, олон улсын хамтрагч байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах, МТ-ийн бүтцийг сайжруулах, чадавхийг бэхжүүлэх гэсэн үндсэн дөрвөн хэсэгт ангилах боломжтой.

Дэд бүтэц, хилийн хүчин чадлын хангалтгүй байдал нь худалдааны зардлыг өсгөдөг. Өндөр ачаалал, хяналт шалгалт, шалган нэвтрүүлэх цэгүүд дээр ажиллагсдын тэнцвэргүй хуваарилалт, захиргааны саатал зэрэг нь хилийн худалдаанд хүндрэл учруулдаг. Худалдаатай холбоотой захиргааны дарамт маш өндөр. Хилийн шалган нэвтрүүлэх цэг хоорондын процедур (үүнд татвар, хураамж төлөх арга хэрэгсэл г.м.), чадавхийн түвшин харилцан адилгүй байна.

## Хилийн үйл ажиллагааны дутагдал нь худалдааны өртгийг өсгөдөг

Дээрх арга хэмжээг үл харгалзан, хилийн үйл ажиллагааг сайжруулах шаардлага байсаар байна. ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт тусгагдсан олон улсын үүрэг хариуцлагууд бүрэн хэрэгжээгүй байгаа бөгөөд худалдааны бодлогуудыг Худалдааг хөнгөвчлөх үндэсний замын зурагтай уялдуулах шаардлага хүлээгдэж байна. Худалдааг хөнгөвчлөх үндэсний замын зурагт 39 зорилт, 98 үйл ажиллагааны

## ХХОЗЗ дах худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ

Худалдааг хөнгөвчлөх зорилгоор ХХОЗЗ-ийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр болон Худалдааг хөнгөвчлөх үндэсний замын зургийн хэрэгжилтийг дэмжих, хил дамнасан систем, дэд бүтцийг сайжруулах, болон үндэсний нэг цонхыг хэрэгжүүлэх зэрэг багтана (Хүснэгт 7).

**Хүснэгт 7.** Худалдааг хөнгөвчлөх: Гол сорилтууд ба ХХОЗЗ-ийн үйл ажиллагаа

| Гол сорилтууд | Дараагийн асуудлууд | Авах арга хэмжээнүүд |
|---|---|---|
| • Экспортлоход томоохон саад, нэмэлт зардлууд компаниудад тулгардаг | • Худалдааг хөнгөвчлөх талаарх амлалтууд хэрэгжээгүй байна | • ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан удирдах (1.1.5) |
| | | • Худалдааны бодлогыг ХХХ-ийн ил тод байдлын мэдэгдлүүдийг хэрэгжүүлэх чиглэлд “Худалдааг хөнгөвчлөх үндэсний хөтөч зураг”-тай уялдуулах (1.4.2) |
| | • Хил дамнасан системүүд нь харилцан хүлээн зөвшөөрч, уялдаа холбоогүй ажилладаг<br>• Хийлийн боомтын дэд бүтэц, хяналтын тоног төхөөрөмж, сургалтанд хамрагдсан ажиллагсад дутмаг | • Харилцан хүлээн зөвшөөрлийг эргэн харах ба хилийн дэд бүтцийг сайжруулах (2.3.1.)8 хилийн хяналт, шалгалтыг сайжруулах (2.3.2), зөвшөөрөлтэй экспортлогчийн програмыг хэрэгжүүлэх (2.3.3) болон нэг цэгийн үйлчилгээний төвөөр дамжуулан үйчлүүлэгчийн сэтгэл ханамжийг судлах (2.3.4) зэргээр хил дамнасан системийг сайжруулах. |
| | • Захиргааны дарамт өндөр байдаг нь экспортлогчдод нэмэлт зардал үүсгэдэг | • Худалдааг хөнгөвчлөх нэг цонхны төслийн зорилтыг тодорйхолох (3.3.1), болон нэг цонхыг ашиглах талаар компаниудыг сургах ажилд хувь нэмрээ оруулах (3.2.1). |

## ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СУРТАЛЧИЛГАА

Худалдааны сурталчилгааны үйл ажиллагаатай нэгэн адилаар хөрөнгө оруулалтын үр дүнтэй сурталчилгаа нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар түүний өсөлт, хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд тустай. ГШХО-ын урсгалыг төрөлжүүлж нэмэгдүүлэх нь олон улсын нэмүү өртгийн сүлжээнд оролцоог хангах болон шинэ салбарын экспортыг өргөжүүлэх ач холбогдолтой. ХХОДБ-уудын чадавх, зохицуулалтыг сайжруулах, хөрөнгө оруулалтыг сурталчилах үйл ажиллагаанд төвлөрөх, хувийн хэвшлийн зохицуулалтыг

сайжруулах, мэдээллийн хүртээмжийг сайжруулах, ЖДҮ-ийг олон улсын компаниудтай холбоход туслах зэрэг алхмуудыг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## Хэд хэдэн ХХОДБ-ууд идэвхитэй ажиллаж байна …

Монгол Улс нь олон нийт, хувийн хэвшил, олон улсын зэрэг худалдаа хөрөнгө оруулалтыг дэмжих чиг үүрэг бүхий олон байгууллагуудтай. Тэдгээр нь компаниуд болон Засгийн газарт бодлогын дэмжлэг, худалдаа, хөрөнгө оруулалтын болон бусад үйлчилгээг үзүүлдэг. МҮХАҮТ нь бусад томоохон байгууллагуудын үзүүлдэггүй хэд хэд үйлчилгээг санал болгодгоороо онцгой, чухал үүрэгтэй. Дээрх ХХОДБ-ууд өөрсдийгөө үнэлсэн судалгааны үр дүнгээс харахад, ихэнхи нь тодорхой, чухал чиг үүргүүдтэй бөгөөд чиг үүргээ хэрэгжүүлэх эрх мэдэл хангалттай гэж үнэлсэн байна.

## … чадавх болон зохицуулалтын түвшинд бэрхээлүүд тулгардаг ч…

Монголын экспортлогчид гадаадын томоохон зах зээлүүдэд хөнгөлөлттэй нөхцлөөр нэвтрэх боломжтой байдаг. Гэсэн хэдий ч Монголын компаниуд дэлхийн хэмжээний худалдаанд оролцох нь хязгаарлагдмал хэвээр байна. ХХОДБ-ууд нь компаниудад, ялангуяа жижиг компаниудад экспортын боломж, экспортлох зах зээлийн шаардлагыг хангах, зорилтот зах зээлд сурталчлах талаар мэдээлэл хүргэхэд чухал үүрэгтэй. Компаниудын хамгийн жижиг ангилалд багтах буюу 5-19 ажиллагсадтай компаниудын 9.1 хувь нь 2013 онд нийт борлуулалтынхаа 10-аас багагүй хувийг экспортолсон бол, 20-99 ажиллагсадтай компаниудын 7.7 хувь, 100-аас дээш ажиллагсадтай компаниудын талаас илүү нь буюу 54.6 хувь нь экспортлогчид байна (Зураг 26). Үүнтэй адилаар ХХОДБ нь ГШХО-оор бий болох боломжуудыг өгөөжтэй ашиглах үүднээс дотоод, гадаад эзэмшлийн компаниудын харилцааг хөгжүүлэх чиглэлд ажиллах боломжтой.

**Зураг 25.** Борлуулалтын 10-аас доошгүй хувийг экспортолсон компаний хувь, хэмжээгээр, 2013




***Эх сурвалж:***Дэлхий банк (2019), Байгууллагын судалгаа – Монгол Улс, 2013.

Монголын ХХОДБ-ууд нь компаниуд болон Засгийн газарт олон төрлийн үйлчилгээг үзүүлдэг боловч, хувийн хэвшлийн зохицуулалт, зөвлөгөөн зэрэг үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд дотоод зохион байгуулалт болон хүчин чадлын хязгаарлалттай тулгардаг. Институци хоорондын албан бус харилцаа холбоо нь ХХОДБ-ын албан сүлжээнээс үр дүн муутай байдаг. Монгол Улс хөрөнгө оруулалтын сурталчилгааны үйл ажиллагаанд илүү анхаарал хандуулах шаардлагатай байна . Хөрөнгө оруулалтын газрын чиг үүрэг Үндэсний хөгжлийн газарт шилжсэнээр хөрөнгө оруулалтын сурталчилгааны чиг үүрэг ихэд суларсан.

ХХОДБ-ууд нь ГШХО-ын ашиг тусын талаарх ойлголтыг сайжруулан түгээхэд мөн чухал үүрэгтэй. Төрийн болон хувийн хэвшлийн салбарууд аль аль нь ГШХО-ыг дотоодын компаниудыг санхүүжүүлэх нэг хэлбэр эсхүл Монголын компаниудын хүссэн технологи, ур чадвар, зах зээлийн харилцаа холбоог гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан компани байгуулан бий болгодог тодорхой бус эх сурвалж хэмээн харах нь бий. Грийнфийлд төслүүд, төрийн концесс зэрэг нь дэд бүтэц болон уул уурхайн чухал салбаруудыг гадаадын хяналтад өгөх вий гэсэн болгоомжлолыг мөн дагуулдаг.

## ХХОЗЗ-ийн хүрээнд худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих нь

Институцийн болон бусад сорилтууд нь Монгол Улс дах худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих

үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг хязгаарлаж байгаа бөгөөд үүнийг сайжруулах боломжтой. ХХОДБ-ын гол тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд байгууллагын чадавх, зохицуулалтыг сайжруулах, хөрөнгө оруулалт, холбогдох үйл ажиллагааг дэмжих, хувийн хэвшлийн зохицуулалтыг сайжруулах, мэдээллийн урсгалыг сайжруулах болон ЖДҮ-үүдэд олон улсын компаниутай холбоо тогтоох боломжийг олгох шаардлагатай. (Хүснэгт 8).

**Хүснэгт 8.** Худалдаа, хөрөнгө оруулалтын сурталчилгаа: Гол сорилтууд ба ХХОЗЗ-ийн үйл ажиллагаа

| Гол сорилтууд | Дараагийн асуудлууд | Авах арга хэмжээнүүд |
|---|---|---|
| • ХХОДБ-уудад компаниудад үйлчилгээгээ үр дүнтэйгээр хүргэх чадавх, зохицуулалт дутагдаж байна | • ХХОДБ-ын үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхэд байгууллагын чадавх дутмаг | • ХХОДБ-ын албан ёсны сүлжээ (2.1.1.), чадавхийг бэхжүүлэх (2.1.2.), хөрөнгө оруулалтын дэмжлэгийн чадавх (2.1.3.), ба ҮХГ-ын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа (2.1.4.)-аар дамжуулан ХХОДБ-ын үр ашиг, зохицуулалтыг сайжруулах |
| | • Хөрөнгө оруууулалтын чиглэлээр ажиллаж буй ХХОДБ-уудад чиглэл, зохицуулалт дутмаг байна | • Худалдааг дэмжих тусгай агентлаг байгуулах (1.5.3)<br>• Хувийн хэвшлийн холбоодын чадавхийг бэхжүүлэх (2.2.1), худалдааг дэмжих чадавхийг бий болгох (2.2.2), зөвлөх үйлчилгээ үзүүлэх сургалтыг сайжруулах (2.2.3), зэх зээл, эдийн засгийн судалгааг явуулах (2.2.4), экспортыг дэмжих худалдааны төлөөлөгчид болон дипломат байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх (2.2.5), худалдааны мэдээллийн хамтын ажиллагааны цар хүрээг бий болгох (2.2.6), ба брэндинг, маркетингийг сайжруулах (2.2.7) замаар худалдааны мэдээлэл, дэмжлэг үзүүлж байгаа байгууллагуудын сүлжээг бэхжүүлэх. |
| | • Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжихэд нэмэлт төвлөрөл шаардлагатай | • Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг (1.5.4), хөрөнгө оруулалтын тал дээрх төрийн ажлын зохицуулалтын механизм (1.5.5)<br>• ҮХГ-ын концесс хариуцсан хэлтсийн чадавхийг бэхжүүлэх (1.5.6)<br>• Хөрөнгө оруулалтын омбудсманы үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэх үүднээс Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалал зөвлөлийг шаардлагатай эрх мэдэл, нөөц боломжоор хангах (1.5.7) |
| • Компаниудад худалдаа, хөрөнгө оруулалтын боломжуудын талаар хангалттай мэдээлэл дутмаг | • Компаниуд гадаад харилцагч, төлөөлөгч, дистрибьюторуудтай харилцан ашигтай гэрээ байгуулж чадахгүй байна | • Салбарын холбоодын гишүүддээ үйлчилгээгээ хүргэх (3.1.1),бизнес бүлгүүдийн хоорондын харилцааг хөгжүүлэх (3.1.2), хувийн хэвшлийн салбарт тулгарч буй асуудлын талаар дуу хоолойгоо илэрхийлэх боломжийг сайжруулах (3.1.3). чадавхийг бэхжүүлэх |
| | • Компаниуд худалдааны хэлэлцээрүүд болон тэдгээрийн боломжуудыг мэддэггүй | • Худалдааны нөхцлүүд, тарифын болон тарифын бус арга хэмжээний талаарх тодорхой, салбар тус бүрээр мэдээллийг цахим болон бусад мэдээллийн хэрэгслээр байнга хүргэж, шинэчилж байх (3.3.3)<br>• Олон улсын хөрөнгө оруулалтаас ашиг шимийг нь хүртэх (3.3.4), харилцан ашигтай гэрээ байгуулах (3.3.5) чиглэлээр компаниудыг сургах<br>• Тэргүүлэх салбаруудын холбоод болон ЖДҮ-ийн кластерууддад зөвлөх үйлчилгээ үзүүлэх (3.3.6)<br>• Зах зээл дэх сурталчилгааны үйл ажиллагааг өргөжүүлэх(3.3.7)<br>• Экспортлогчдод үйлчилгээ үзүүлэх зөвлөхүүд болон байгууллладгын мэдээллийн сан байгуулах (3.3.8) |
| | • Компаниуд, ялангуяа ЖДҮ-үүд нь олон улсын түншүүдтэй холбоо тогтооход бэрхшээлтэй | • Нэтворкинг арга хэмжээ (4.3.6), гарааны бизнесийг туршлагтай компаниудтай холбох арга хэмжээг (4.3.7) зохион байгуулах<br>• Сургалт, солилцооны хөтөлбөрүүд (4.4.5), гадаадын болон дотоодын компаниудад тохирсон ҮХГ хөтөлбөр бий болгох (4.4.6), болон ГШХО-ын мэдлэгийг дээшлүүлэх компанит ажил зохион байгуулах (4.4.7) зэргээр олон улсын хамтын ажиллагаа, мэдлэг солилцоог дэмжих. |

## САНХҮҮЖИЛТИЙН ХҮРТЭЭМЖ

Монгол Улсын ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмж хангалтгүй байгаа нь тэдний өдөр тутмын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, экспортыг эхэлж, өргөжүүлэхэд нь саад болж, хөрөнгө оруулалт, өсөлтийг удаашруулж байна. Эдгээр бэрхшээлүүдийг шийдвэрлэхийн тулд хэд хэдэн институцийн болон бусад шинэчлэлүүд хийгдэж байгаа боловч зээл авах процесс нь хүндрэлтэй, зардал ихтэй хэвээр, татвар урамшуулал нь ЖДҮ-ийн хэрэгцээнд тохиромжгүй, жижиг компаниудын хувьд санхүүгийн боловсрол хангалтгүй байна.

### Институцийн шинэчлэл нь санхүүгийн хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ

Санхүүгийн тоогтоолцооны хувьд шинээр бүтэц, институцийн шинэчлэл хийх замаар ЖДҮ-үүдэд тулгардаг санхүүжилтийн хүртээмжийн асуудлыг шийдвэрлэхээр хүчин чармайлт гаргаж байна. ЖДҮ-ийн санхүүжилтийг дэмжих зорилгоор ЖДҮ-ийн Хөгжлийн Сан (ЖДҮХС) нь урт хугацааны хөнгөлөлттэй зээлийг олгох, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн санхүүгийн лизинг санал болгох, компанийн үйл ажиллагааг сурталчлах, сургалт зохион байгуулах, зээлийн батлан даалт гаргах зэргээр ажиллаж байна. 2013 онд Засгийн газар, Азийн Хөгжлийн банктай хамтран Монголын зээлийн батлан даалтын сан (МЗБДС)-г байгуулсан бөгөөд ЖДҮ-үүдэд зээлийн батлан даалт гаргах үйл ажиллагаа явуулж байна. Зээлийн батлан даалтын схемүүд нь зээл олгогчдод учирч болзошгүй эрсдлийг бууруулах болон барьцааны шаардлага хангаагүй жижиг компаниудад зах зээлийн ханшаас доогуур хүүтэй зээл олгох нөхцлийг бүрдүүлэх зэрэг чиглэлээр ажиллана. Экспортын чиглэлийг түлхүү анхаарах болсон бөгөөд 2017 оны Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулинд нийт олгосон зээлийн 60-аас доошгүй хувь нь экспортын чиглэл бүхий компаниудад олгох шаардлагыг тусгасан байна.

Урт хугацааны туршид зээлийн барьцаа хөрөнгөд зөвхөн үл хөдлөх хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг байсан бол 2017 оны 2-р сард Олон улсын санхүүгийн корпораци, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон бусад оролцогч талууд хамтран , хөдлөх хөрөнгийн барьцааны цахим бүртгэлийг ашиглалтад оруулснаар хөдлөх хөрөнгийг барьцаалж зээл олгох боломжийг нэвтрүүлсэн. Энэхүү мэдээллийн сан нь "Хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн харилцааг хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд байгуулагдсан бөгөөд 2017 оны 3-р сард батлагдсан "Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль"-ийн дагуу хэрэгждэг юм.

Тусгайлан хөдөө аж ахуйн салбарын санхүүгийн хөгжлийг дэмжих шинэ арга хэрэгслийг нэвтрүүлж байна. 2013 онд үйл ажиллагаагаа эхлүүлсэн Хөдөө аж ахуйн бирж нь 2017 оны 12-р сард Санхүүгийн зохицуулах хорооноос үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө авсан бөгөөд тэр үеэс хойш форвард хэлцлүүдийг нөхцөлдүүлсээр байна. Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн Экспортын даатгалын газар нь худалдааны зээлийн даатгал болон эргэлтийн хөрөнгийн даатгал зэргийг 2019 оноос эхлэн санал болгоход бэлэн болсон байна.

Санхүүгийн хөгжлийн зорилтууд нь Монгол Улсын үндэсний хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан болно. 2016 онд гарсан "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын хоёрдугаар зорилтод зохицуулалтыг сайжруулснаар "санхүү, санхүүгийн зах зээлийн системийн хөгжлийг хангах", бөгөөд гурав дах зорилт нь хөгжлийн санхүүгийн системийг бий болгох хэмээн тусгагдсан байдаг.

Монгол Улсын санхүүгийн салбарын хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх шинж тэмдгүүд ажиглагдаж байна. Зээлийн харилцаа нь маш нийтлэг болон өргөжсөн бөгөөд 2004 онд 1000 хүн тутмын 138.5 байсан зээлдэгчийн тоон үзүүлэлт 2016 онд мянгад 382.6 болон өсчээ. Гүйлгээний зардал ч мөн тодорхой хэмжээнд буурч байна. 2009-2017 оны хооронд хадгаламж, зээлийн хүүний зөрүү 8.4 хувиас 7.1 хувь болсон байна.

### … хэдий тийм ч, ЖДҮ-ийг үр дүнтэйгээр дэмжихийн тулд хийх ажлууд их байна

Жижиг, дунд хэмжээний компаниуд нь томоохон компаниудаас илүүтэйгээр хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зориулж банкны зээлд итгэл найдвараа тавьдаг бол, сүүлийн зээлийн хүсэлтэндээ татгалзсан хариу авсан хувиар тэд мөн илүү өндөр байна (Зураг 27). Тиймдээ ч ЖДҮ-үүд нь санхүүжилтийн хүртээмжийн асуудлыг үйл ажиллагааны үндсэн бэрхшээл гэж тодорхойлдог бөгөөд, 2013 онд 100-аас дээш ажиллагсадтай компаний хувьд 3.1 хувь нь, 5-19 ажилллагсадтай компаний хувьд 25.6 хув нь 20-99 ажиллагсадтай компаний хувьд 42.1 хувь нь санхүүжилтийн хүртээмжийн асуудлыг үйл ажиллагааг нь хязгаарлагч хэмээн тодорхойлсон байна.

**Зураг 26.** Зээллэг, компаниар, 2013




***Эх сурвалж:*** Дэлхийн банк (2019), Байгууллагын асуулга-Монгол - 2013

Санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах чиглэлд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үйл ажиллагаа нь үр дүн муутай байдаг. Хэдийгээр ЖДҮХС нь жижиг компаниудын санхүүжилтийн хүртээмжийг сайжруулахад туслалцаа үзүүлж байгаа ч, харьяалах яаманд нь олон тооны өөрчлөлт оруулах зэргээр институцийн бүтцийн өөрчлөлт хийх нь үйл ажиллагааны тогтворгүй байдалд нөлөөлж байна. 2013-2016 онд нийт 1,864 компанид 276.1 тэрбум төгрөгийн зээлийг олгож байсан боловч, санал болгож буй санхүүгийн бүтээгдэхүүний төрөл нь цөөхөн тул зорилтот хэрэгцээг бүрэн хангаж чаддаггүй. Монголын зээлийн батлан даалтын сан (МУ-ын ЗБДС) хязгаарлагдмал нөөц, үйл ажиллагааны бэрхшээлүүд зэрэг ижил асуудлуудтай тулгарч, ЖДҮ-ийг дэмжих зээлийн батлан даалтын схемийн хэрэгжилт төдийлөн сайн биш байна.

Жижиг компаниуд, тэдний санхүүжилтийн түүх, туршлагын талаарх мэдээлэл хязгаарлагдмал байдаг нь санхүүгийн салбарт тэдний хэрэгцээнд тохирсон бодлого, туршлагыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэж байна. Жижиг компаниуд нь банк болон бусад санхүүгийн байгууллагуудын санал болгодог зээлийн хүү нь өндөр, хугацаа нь богино байдаг талаар мэдээллэсэн. Монгол Улсын хувьд барьцаа хөрөнгийн шаардлага онцгой өндөр байна.[67]

Зээлийн хүсэлт гаргахад шаардагдах процедурын тоо нь энэ салбар дах үйл ажиллагааны зохицуулалт хангалтгүй байгаагийн илрэл бөгөөд, жижиг компаниудын зээлийн зардлыг өсгөж байна. Жижиг компаниудын санхүүгийн боловсрол доогуур байгаа нь нэмэлт бэрхшээл юм. 2016 онд Олон нийтийн санхүүгийн боловсролын дээшлүүлэх хөтөлбөрийг баталсан хэдий ч, түүнд ЖБД-үүдийг тусгайлан чиглэсэн бүлэг ороогүй юм.

## ХХОЗЗ дэх санхүүжилтийн хүртээмж

ХХОЗЗ-ийн үйл ажиллагаа нь ЖДҮ-ийг худалдааны болон хөрөнгө оруулалтын боломжоос хязгаарлаж байдаг гол бэрхшээлүүдийг авч үзэв (Хүснэгт 9). Эдгээр үйл ажиллагаа нь ЖДҮ болон санхүүгийн байгууллага хоорондын зөрүүг арилгах, зээлийн зардал болон зохицуулалтын бэрхшээлийг бууруулах, жижиг компаниуд болон гарааны бизнесийг дэмжих татвар, урамшууллын системийн дахин үнэлгээ, шинэчлэл хийх, ЖДҮ-ийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зэрэг юм.

**Хүснэгт 9.** Санхүүжилтийн хүртээмж: Гол сорилтууд ба ХХОЗЗ-ийн үйл ажиллагаа

| Гол сорилтууд | Дараагийн асуудлууд | Авах арга хэмжээнүүд |
|---|---|---|
| • ЖДҮ-үүд банкуудаас зээл авахад бэрхшээлтэй тулгардаг. Өөр сонголт хязгаарлагдмал байдаг | • Зээлийн хүсэлт гаргах журам нарийн төвөгтэй, барьцаа хөрөнгийн шаардлага өндөр, зээлийн өртөг өндөр<br>• ЖДҮ-үүдийн санхүүгийн хэрэгцээ, туршлагын талаарх мэдээлэл дутмаг<br>• Орон нутгийн ЖДҮ-ийн хувьд банкны салбарын хүртээмж муу<br>• Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хугацаа нь үйлчлүүлэгчдийн хэрэгцээтэй уялдаагүй | • Хувийн хэвшилтэй татварын бодлогын талаар зөвшилцөх замаар санхүүгийн байгууллагууд, ЖДҮ хоорондын зөрүүг нөхөх (2.5.1.), зээлийн хүртээмжид нөлөөлөх барьцаа хөрөнгийн шинэ хуулийн үр нөлөөг үнэлэх (2.5.2.), ЖДҮ-ийн Хөгжлийн Сангийн зээлийн нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах (2.5.3.), ЖДҮ-ийн хэрэгцээнд таарсан үйлчилгээ үзүүлэх идэвхийг сайжруулах (2.5.4.) |
| • Татварын тогтолцоо нь ЖДҮ-үүд болон гарааны бизнесийн эсрэг ажиллах талтай | • Татварын хөнгөлөлтийн хөтөлбөрүүд компаниудын хэрэгцээг хангадаггүй<br>• НӨАТ-ын шинэчлэл нь жижиг компаниудын дарамтыг нэмэгдүүлсэн | • Гарааны болон экспортын чиглэлтэй компаниудад зориулсан татварын урамшууллыг нэвтрүүлэх (4.1.5.)<br>• Гарааны бизнесүүдэд зориулсан татварын тогтолцоог үнэлэх (4.3.5.)<br>• ЖДҮ-үүд судалгаа, шинжилгээний байгууллагуудаас СХ худалдан авалтыг дэмжих санхүүгийн механизмыг боловсруулах боломжийг тодорхойлох(4.4.3) |
| • ЖДҮ-үүдийн хэмжээнд санхүүгийн боловсролын түвшин доогуур | • Компаниуд санхүүжилтийн талаар, тэр дундаа санхүүжилт авах талаар хангалттай мэдээлэлгүй | • Бизнес инкубатороор дамжуулан гарааны бизнесүүдэд санхүүжилтийн хүртээмжийн талаар сургалт нэвтрүүлэх (4.3.4) |

## ЧАНАРЫН УДИРДЛАГА

Чанарыг сайжруулах болон олон улсын стандартыг дагаж мөрдөх нь Монгол Улсад экспортыг өсгөх, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, мөн шинэ хөрөнгө оруулалт татахад нэн чухал юм.. Монгол Улсад чанар болон баталгаажуулалтыг сайжруулахад чиглэсэн тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Гэвч, экспортыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд чанарын удирдлагын тогтолцоонуудыг олон улсын шаардлагатай илүү сайн уялдуулах хэрэгтэй байна.

### Сүүлийн үед ахиц, дэвшил гарсаар байна.

Ургамал амьтны эрүүл ахуй, хорио цээрийн стандартын арга хэмжээ (УАЭАХЦСАХ)-ний талаарх хууль тогтоомж, стандартууд, эрсдэлд суурилсан УАЭАХЦСАХ-ний импортын хяналтын тогтолцоо, олон улсын итгэмжлэгдсэн лабораториудын сүлжээг байгуулах болон Үндэсний чанарын бодлого, хөтөлбөрийг боловсруулах зэргээр ЖДҮ-ийн чанарын удирдлага, баталгаажуулалтад хамрагдах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Бусад хязгаарлагдмал, салбарын онцлогт тохирсон, “Монголын хаан ширхэгт” (самнасан ноосны үндэсний брэнд) зэрэг санаачилгууд бий болсоор байна.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)-аас гаргасан санаачилгууд нь чанарын удирдлагын хүний нөөцийн тухай асуудалд анхаарал хандуулж байна. СХЗГ-ын Үндэсний чанарын удирдлагын хөтөлбөрт ур чадварын хөгжилд төвлөрсөн бүрэлдэхүүн хэсгүүд багтдаг. Тус байгууллага нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам (БСШУЯ)-тай хамтран ажилладаг ба 2014 оноос эхлэн Монгол Улсын Стандартчилалын тогтолцоог шинэчлэх хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх үүднээс Европын холбоотой хамтын ажиллагаагаа эхлүүлжээ. Чанарын удирдлага ба баталгаажуулалтын тогтолцоо нь ихэнхдээ олон улсын шаардлагатай уялдаагүй байдаг.

Экспортын бүтээгдэхүүн, зах зээлийг төрөлжүүлэхийн тулд техникийн зохицуулалт, УАЭАХЦСАХ, тохирлын үнэлгээний үйл ажиллагааны талаарх чанарын удирдлагын тогтолцоог цаашид бэхжүүлэх шаардлагатай. Тус

[71] OECD (2016), Peer Review Note: Enhancing access to finance for micro, small and medium-sized enterprises in Mongolia.

улс дахь жижиг аж ахуйн нэгж, компаниудын хувьд хүртээмж, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх нь тун чухал юм. Их хэмжээний зардал болон мэдээллийн дутмаг байдлаас шалтгаалан олон ЖДҮ чанарын баталгаажуулалтад хамрагдаж чаддаггүй бөгөөд Монгол Улсад 2013 оны байдлаар 5-19 ажилтантай компаниудын 8.6%, 20-99 ажилтантай компаниудын 19.0% нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын баталгаажуулалтад хамрагдсан байсан бол 100 эсхүл түүнээс дээш тооны ажилтантай компаниудын 66.2% нь тус баталгаажуулалтад хамрагдсан байжээ (Зураг 28). Хувийн хэвшлийн холбоод болон бусад ХХОДБ нь чанарын удирдлага ба баталгаажуулалтын үйл явцын талаар жижиг аж ахуйн нэгж, компаниудад мэдээлэл өгөх чиг үүрэг гүйцэтгэх боломжтой.

**Зураг 27.** Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын баталгаажуулалт бүхий аж ахуйн нэгж, компаниудын хувь, хэмжээ 2013 он




***Эх сурвалж:*** Дэлхийн банк (2019), Бизнес эрхлэгчдийн судалгаа, (Монгол Улс- 2013).

Олон улсын хамтын ажиллагаа мөн шаардлагатай байна. Монгол Улс болон түүний гол экспортын зах зээлүүд хооронд Эрүүл ахуйн хороо цээрийн стандартуудыг харилцан хүлээн зөвшөөрсөн байдал дутагдалтай байгаа нь хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааг хязгаарлаж, үр дүнд нь хэт их журмын зохицуулалтын улмаас экспортлогчдын зардал өсдөг.

Махны салбар нь тархмал, нүүдлийн үндсэн шинжтэйн улмаас онцгой сорилтуудтай тулгардаг бөгөөд гар хөл, амны өвчин болон амьтны гаралтай бусад нийтлэг өвчнөөс хамаарч хязгаарлагддаг. Хэдийгээр хяналтын тогтолцооны дутагдалтай тал нь малын эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн урамшууллыг үр дүнгүй болгодог боловч, мал эмнэлгийн тогтолцоо сул байдаг нь эдгээр сорилтуудын шийдлийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг. Үүнтэй адилаар, дотоодын зах зээлд худалдаалдаг арьс шир нь чанараар ангилах, үнэ тооцох болон бэлтгэн нийлүүлэгчдэд холбогдох урамшуулал олгох асуудлыг төвөгтэй болгодог.

Худалдааг хөнгөвчлөхөд олон улсын стандартад нийцсэн хяналтын нэмэлт чадварууд шаардлагатай байна. Чанарын баталгаажуулалтын дэд бүтцийн дутагдалтай байдлаас шалтгаалж, олон улсын стандартын хэрэгжилтийг хангах үүднээс, экспортлогчид нь худалдан авагчидтай шууд хамтран ажиллах хүсэлтэй байдаг. Эдгээр эрсдэлүүд нь хэлцлийн зардлыг нэмэгдүүлэн, худалдан авагчдын дунд өрсөлдөөнийг бууруулж, шинэ болон боломжит экспорлогчдын боломжийг хязгаарлаж байна.

## ХХОЗЗ дах чанарын удирдлага

Чанарын удирдлагыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг эрэмбэлэхдээ зах зээлийн хүртээмжийг тэлэх болон дотоодод нэмүү өртөг бий болгох боломжуудыг харгалзан үзвэл зохино. ХХОЗЗ-ийн дагуу чанарын удирдлагын асуудлуудад хандсан арга хэмжээ нь чанарын баталгаажуулалтын дэд бүтэц болон тогтолцоог бэхжүүлэх; үндэсний стандартчилал, чанар ба итгэмжлэлийн дэд бүтцийн олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлыг сайжруулах; болон чанараа сайжруулах талаар мэдээлэл, дэмжлэгийг авах аж ахуйн нэгж, компаниудын оролцоог бэхжүүлэх зэрэг болно (Зураг 10).

**Хүснэгт 10.** Чанарын удирдлага: Гол сорилтууд ба ХХОЗЗ-ийн үйл ажиллагаа

| Гол сорилтууд | Дараагийн асуудлууд | Авах арга хэмжээнүүд |
|---|---|---|
| • Аж ахуйн нэгж, компаниуд нь зохих баталгаажуулалтгүйн улмаас өндөр зардал эсхүл хязгаарлагдмал боломжтой тулгардаг | • Техникийн зохицуулалтууд, УАЭАХЦСАХ болон тохирлын үнэлгээ нь ЖДҮ-дэд сорилт болдог<br>• Чанарын удирдлага болон баталгаажуулалтын сорил явуулах чадавх хангалтгүй<br>• Мөшгих ба хяналт хангалттай бус | • Олон улсын түншүүдэд хүлээн зөвшөөрөгдөх үүднээс, холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах (2.4.1), байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах (2.4.2), зохицуулалтын чадавхийг бий болгох (2.4.3), мөшгих тогтолцоог байгуулах (2.4.4) болон Органик хүнсний тухай хуулийг хэрэгжүүлэх (2.4.5) замаар чанарын баталгаажуулалтын дэд бүтцийг бэхжүүлэх. |
| | • Баталгаажуулалтын талаарх олон улсын шаардлага болон хүлээлтэд нийцдэггүй | • Худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээр болон хоёр талт УАЭАХЦСАХ/ Худалдааны техникийн хязгаарлалтын талаарх урьдчилсан хэлэлцээрийн Монголын экспортлогчдод хүрэх үр ашгийг нэмэгдүүлэх (1.3.1, 1.3.2-т заасан үйл ажиллагаанууд)<br>• Стандартчилал, чанар, итгэмжлэлийн үндэсний тогтолцоог бэхжүүлж, олон улсын худалдааны хамтрагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлэх (2.4.1-ээс 2.4.4-т заасан үйл ажиллагаанууд) |
| • Аж ахуйн нэгж, компаниуд чанар сайжруулах талаар мэдээлэл дутмаг | • Стандарт болон шаардлагуудын талаар мэдлэг муутай<br>• Чанарын асуудалд анхаарал хандуулахад нь ЖДҮ нарт үзүүлэх дэмжлэг бага | • Худалдааны мэдээлэл болон дэмжлэг туслалцаа үзүүлдэг байгууллагуудын сүлжээг бэхжүүлэх (2.2.1, 2.2.2, 2.2.3, 2.2.6-т заасан үйл ажиллагаанууд)<br>• Салбарын холбоодыг чанаржуулж, хувийн хэвшил дэх үлдаа холбоог сайжруулан, ил тод сүлжээг хөгжүүлэх (3.1.1-т заасан үйл ажиллагаа) |

# УР ЧАДВАРЫН ХӨГЖИЛ

Ур чадварыг сайжруулах нь өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд нэн чухал. Экспортын төрөлжүүлэлт, сайжруулалт, мөн технологийн шилжүүлгийн нөөц бололцоо болон хөрөнгө оруулалтын бусад үр ашгийн талаарх ойлголт нь ур чадварыг дээшлүүлэх болон сургалт, боловсролыг хувийн хэвшлийн хэрэгцээ шаардлагатай нийцүүлэхээс хамаардаг. Монгол Улс нь харьцангуй өндөр боловсролтой хүн амтай хэдий ч хувийн хэвшлийн хэрэгцээнд ур чадварыг уялдуулах, хувиараа бизнес эрхлэлтэд дэмжлэг үзүүлэхийн тулд багагүй зүйлийг хийх шаардлагатай байна.

## Монгол Улс нь харьцангуй өндөр боловсролтой хүн амтай

Монгол Улс нь бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн хувиар 96.1 буюу харьцангуй өндөр боловсролтой хүн амтай улс юм (НҮБХХ, 2016). Монгол Улс дахь боловсролын хүртээмж нь нэн ялангуяа дээд боловсролын түвшинд нэмэгдэж байгаа бөгөөд нийт элсэлтийн түвшин нь ижил орлоготой улсуудтай харьцуулахад дунджаас дээгүүр байна (Зураг 29). Мөн тус улсад Техник, мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдийн тогтолцоо баттай суурьшсан бөгөөд 83 Техник, мэргэжлийн боловсрол сургалтын төвүүд, богино хугацааны сургалтын үйлчилгээ үзүүлэгчид 1,200 байна. 2018 онд нийтдээ 37,000 оюутнууд мэргэжлийн боловсрол эзэмшихээр өдрийн ангид сурч байснаас гадна 20,000 богино хугацааны дадлагажигчид суралцжээ.

**Зураг 28.** Нийт элсэлтийн үнэлгээ боловсролын түвшингээр




***Эх сурвалж:*** Дэлхийн банк (2018), Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд.

Боловсрол ба ур чадварын хөгжлийн ач холбогдлыг бүрэн хүлээн зөвшөөрсөн байдаг. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 нь сургуулийн өмнөх боловсрол нийтэд хүртээмжтэй байх, боловсролын тэгш байдлыг нэмэгдүүлэх, Техник, мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдийн хөтөлбөрийг сайжруулах, гуравдах шатны боловсролын тогтолцоог шинэчлэх болон шинжлэх ухаан, аж үйлдвэрлэлийн салбарын хамтын ажиллагаа, уялдаа холбоо зэргийг хамруулсан ур чадвартай, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлэхийг зорилтоо болгосон байна.

Тус улс дахь боловсрол, сургалтын хөтөлбөрүүдийн ач холбогдлыг нэмэгдүүлэхийн тулд тодорхой арга хэмжээнүүд авсаар байна. Дээд боловсролын шинэчлэл төслийн гол зорилт нь дээд боловсрол ба магадлан итгэмжлэлийн чанарыг сайжруулахад оршино. Хөдөлмөрийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр ажилтныг дагалдан ажиллуулах хугацаа зэрэг сургалттай холбоотой асуудлуудын зохицуулалтыг тодорхой болгосон.Түүнчлэн, хөгжлийн хамтрагчид нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-наас 2018 онд байгуулсан Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийг бэхжүүлэх замаар академик болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхтэй дэмжиж байна.

Өрсөлдөх чадварт суурилсан сургалтыг 2008 оноос явуулж эхэлсэн бөгөөд ХНХЯ нь Техник, мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдийн дадлагажигч, албан ёсны төгсөгчдийн өрсөлдөх чадварыг үнэлэх чиг үүрэг бүхий мэргэжлийн сургалтын байгууллагуудын үнэлгээний төвийг байгуулсан. ХНХЯ нь Техник, мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдийн бүх төгсөгчдийн мэдээллийг агуулсан мэдээллийн санг үүсгэхээр ажиллаж байгаа ба 2019 оны эцсээр бэлэн болох төлөвтэй байна. Сургалтын хөтөлбөрийг хоёр түвшинд шинэчилсэн. Богино хугацааны үйлчилгээ үзүүлэгч нарын хувьд үнэлгээний төв нь сургалтын хөтөлбөрийг хянах үүрэг хүлээдэг.

## Ур чадварын нийцэлгүй байдал ба хувиараа бизнес эрхлэлтийн сургалтын хүртээмжгүй байдал нь гол сорилтууд хэвээр байна.

Ур чадварын дутагдал байсаар байгаа нь Монголын аж ахуйн нэгж, компаниудын нөөц бололцоог хязгаарлаж байна. Монголын бизнесийн орчны судалгаа (2017) ба Европын холбооноос Монгол Улсын худалдаанд дэмжлэг үзүүлэх төслийн судалгаанд дурьдсанаар маш олон компаниуд боловсруулалт, экспортын үйл ажиллагаанд шаардлагатай цогц ур чадвар, хэлний мэдлэг эзэмшсэн ажилтан олоход бэрхшээлтэй тулгардаг байна. Шинжлэх ухаан, технологид түлхүү чиглэсэн ур чадварын хөгжил, сургалтыг сайжруулах нь МХХТ-ийн салбарын хөгжил, Монгол улсыг хамарсан цахимжилтыг дэмжих ач холбогдолтой. Ерөнхий болон нарийн мэргэжлийн ур чадварын аль аль нь хэрэгтэй.

Сургалтын хөтөлбөртэй холбоотой хувийн хэвшлийн хамтын ажиллагаа хангалттай бус байгаагаас гадна, хувийн хэвшлийн түншүүд нь техник, мэргэжлийн боловсрол сургалтын салбарт идэвхтэй оролцох нөөц бололцоотой боловч хангалттай оролцдоггүй. Энэ нь ихэвчлэн мэдээллийн хангалтгүй байдал, төрийн оролцоо хэт өндөр байдал, хувийн хэвшлийн оролцоог бүрэн хангах боломж олгодоггүй бодлогын хэрэгжилтийн цоорхойгоос шалтгаалдаг.

Мөн Монголын аж ахуйн нэгж, компаниуд нь бизнес эрхлэлт болон экспортын талаарх мэдлэг, ур чадвар сул байдалтай холбогдон сорилтууд

үүсдэг талаар мэдээллэжээ. Бизнес, хувиараа аж ахуй эрхлэлтийг үндэсний сургалтын хөтөлбөрт хангалттай тусгаагүй нь шинэ аж ахуйн нэгж, компаниудын хөгжлийг удаашруулах нөхцөл болдог. Боловсролын тогтолцоо нь экспорт болон гадаадын хөрөнгө оруулалттай компаниудтай харилцаа тогтооход саад учруулдаг гадаад хэлний чадвар, гадаад улсуудтай харилцах туршлага дутмаг байдалтай холбоотой хязгаарлалтуудад анхаарлаа хандуулахад тусалж чадна.

## ХХОЗЗ дах ур чадварын хөгжил

Монгол Улсын нөөц бололцоог бүрэн ашиглахын тулд ажил олгогчийн шаардлагад нийцэхгүй байгаа ур чадварууд болон бизнес эрхлэгчдэд зорилсан сургалт, мэдээллийн хүртээмжгүй байдалтай холбоотой сорилтуудыг анхааралдаа авах шаардлагатай. Ур чадварын хөгжилтэй холбоотой үндсэн сорилтуудад чиглэсэн ХХОЗЗ-ийн үйл ажиллагаанууд нь Техник, мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдийг хамруулсан боловсролын тогтолцооны шинэчлэл, сургалтын хөтөлбөрийг ажил олгогчийн шаардлагатай уялдуулах, шинжлэх ухаан, технологийн ур чадварыг бэхжүүлэх, бизнес эрхлэлтийн талаарх боловсрол ба бизнес эрхлэгчдэд зориулсан дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, сүлжээг сайжруулах зэргийг хамаардаг (Хүснэгт 11). .

**Хүснэгт 11.** Ур чадварын хөгжил: Гол сорилтууд ба ХХОЗЗ-ийн үйл ажиллагаа

| Гол сорилтууд | Дараагийн асуудлууд | Авах арга хэмжээнүүд |
|---|---|---|
| • Ажил олгогчид шаардлагатай ур чадвар бүхий ажилтан олоход хүндрэлтэй байдаг | • Гадаад хэлний мэдлэг гэх мэт хувийн хэвшлийн байгууллагаас шаарддаг ур чадвартай ажиллах хүчний дутагдал<br>• Эдийн засгийн салбарууд болон хөтөлбөрүүдийн уялдаа холбоо хязгаарлагдмал | • Эрэлт хэрэгцээнд ур чадварыг тохируулах (3.2.1), мэргэжлийн сургалтыг Англи болон Хятад хэлээр зохион байгуулах хөтөлбөр боловсруулах (3.2.2), бизнес, олон улсын харилцааны хөтөлбөрүүдийг өргөжүүлэн хөгжүүлэх (3.2.3), солилцооны хөтөлбөрийг өргөжүүлэх (3.2.4), болон Техник, мэргэжлийн боловсрол сургалтын салбар дах хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх (3.2.6) зэрэг замаар боловсролын салбарын нийлүүлэлтийг хувийн хэвшлийн эрэлттэй нийцүүлэх. |
| | • Шинжлэх ухаан, технологид суурилсан салбарт хэрэгцээтэй ур чадваруудын түвшин сул | • Бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх технологи болон инженерийн их сургуулиудыг Улаанбаатар хотод салбараа байгуулах талаар санал тавих (4.5.3), ерөнхий боловсролын сургуулийн түвшинд мэдээллийн технологийн боловсрол олгоход анхаарлаа хандуулах (4.5.4), Оюуны өмч (ОӨ)-ийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг дэмжих тодорхой санал боловсруулах (4.5.5), болон судалгааны төвүүдэд ОӨ-ийн эрхийн талаар сургалт явуулах (4.5.6). |
| • Гарааны бизнесүүд өсөлт, экспортын үйл ажиллагаанд сорилттой тулгардаг | • Үндэсний сургалтын хөтөлбөрт хувиараа бизнес эрхлэлтийн талаар оруулдаггүй | • Бага, дунд сургуулиудыг оролцуулан (4.2.2), Техник, мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдээр дамжуулан (4.2.3) бизнес эрхлэлтийг боловсролын бүхий л түвшинд таниулах (4.2.1) |
| | • Бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх сүлжээ хангалтгүй | • Бизнес эрхлэлтийн сургалтын багш нарын сүлжээг бий болгох (4.2.4), бизнес эрхлэлтийн арга хэмжээ зохион байгуулах (4.2.5), амжилттай яваа бизнес эрхлэгчдийг тодорхойлж, хурал зохион байгуулах (4.2.6), оюутан бизнес эрхлэгчдийн клубыг бэхжүүлэх (4.2.7), ба төгсөгчдийн сүлжээнд тулгуурлах (4.2.8). |
| | • Хувиараа бизнес эрхлэх болон хэрхэн экспортлох талаар мэдлэг, ур чадвар муу | • Гарааны бизнесийн экосистемийг төлөвлөх, чадавхийг бий болгох замаар инкубаторуудын гарааны бизнесүүдтэй холбогдох, зохих үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх (4.3.1), инкубаторуудыг байгуулах эсхүл өргөжүүлэх боломжийг үнэлэх (4.3.2), сургагч, дадлагажуулагч багшийн санаачлагыг хэрэгжүүлэх (4.3.3), санхүүжилтэнд хамрагдах талаар сургалт зохион байгуулах (4.3.4), гарааны бизнесийг чиглэсэн татварын урамшууллын схемийг үнэлэх (4.3.5), харилцаа холбооны сүлжээ үүсгэх арга хэмжээ зохион байгуулах (4.3.6), болон гарааны бизнесүүдийг компаниудтай холбох. |



**Photo:** ©Ministry of Foreign Affairs

## **Хүснэгт 17.** МОНГОЛЫН ЭМЭГТЭЙ ЭКСПОРТЛОГЧДЫН НӨӨЦ БОЛОЛЦООГ БҮРЭН НЭЭН ГАРГАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ АВАХ

Монгол нь бүс нутгийнхаа бусад улсуудтай харьцуулбал хүйсийн тэгш байдал харьцангуй өндөр, нийгэм дэх хүйсийн тэгш бус байдлыг бууруулах талаар маш том ахиц гаргасан улс юм. Монгол эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрчүүдийнхээс өндөр байдаг. Мөн түүнчлэн эмэгтэйчүүд нь бүрэн дунд (86.1% эмэгтэй, 77% эрэгтэй) болон дээд боловсролын (76.4% эмэгтэй, 53.5% эрэгтэй) сургуульд элсэлтийн түвшингээр өндөр байдаг нь боловсрол эзэмшсэн байдлаар эрчүүдээс илүү болохыг харуулдаг[72]. Сургуульд хамрагдалт, төгсөлтийн үзүүлэлтээр дээд боловсролын түвшинд Монгол эмэгтэйчүүд илүү боловч, эрчүүдтэй харьцуулбал ажилд орох магадлал бага хэвээр байгаа бөгөөд дунджаар тооцоолоход эмэгтэйчүүдийн цалин эрчүүдийнхээс бага байна.

Нөгөө талаар, Монгол эмэгтэйчүүдийн бизнес дэх оролцоо хүчтэй байдаг. Эмэгтэй бизнес эрхлэгч нар нь МҮХАҮТ дэх Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл зэрэг холбоод, танхимуудад төлөөлөгчөөр ажилладаг бөгөөд түншлэл хөгжүүлэхэд чиглэсэн хэд хэдэн төслүүдийг хэрэгжүүлж байна. Аж ахуйн нэгж, компаниудын ойролцоогоор 61% нь эмэгтэй хувьцаа эзэмшигч эсхүл хамтран эзэмшигчтэй байгаа бол компаниудын 55% нь эмэгтэй гүйцэтгэх удирдлагатай нь байна. Монгол Улсад эмэгтэйчүүдийн эзэмшдэг бизнес нь эрчүүдийн эзэмшдэг бизнесээс илүү худалдаа, үйлдвэрлэлд оролцох хандлагатай байдаг бөгөөд бусад эмэгтэйчүүдийг ажилд авах сонирхол их байдаг.[73] Эмэгтэйчүүд нөөц бололцоогоо бүрэн ашиглаж чадсан тохиолдолд экспортод чиглэсэн эдийн засгийн өсөлтөд нэмэлт дэмжлэг болохын зэрэгцээ эмэгтэй ажил эрхлэлтийн хэтийн төлвийг сайжруулах ач холбогдолтой. Хэдий тийм ч, хүйсийн ялгаатай байдал бизнесийн салбарт байсаар байна. Монгол эмэгтэйчүүд нэн ялангуяа бизнесийн ур чадвар олж авах, сүлжээнд нэвтрэх болон санхүүжилт татах зэрэгт бизнесийн нөөц бололцоогоо бүрэн ашиглахад нь саад болдог хязгаарлалтуудтай тулгарсан хэвээр байна.

Эдгээр сорилтууд нь хөдөө орон нутагт илүү ноцтой түвшинд байдаг.
Дээрхийг хүлээн зөвшөөрч, худалдаатай холбоотой үйл ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн оролцоог хөнгөвчлөх, байр суурийг бэхжүүлэхэд чиглэсэн тусгай үйл ажиллагаануудыг дор тоймлов:

1. Эмэгтэйчүүдэд төвлөрсөн бизнесийн холбоодоос явуулж буй худалдааг дэмжих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.
   - » Монголын холбоодын чиг үүрэг, үйл ажиллагаа ба хамрах хүрээ, мөн тухайн холбоод дахь МҮХАҮТ дэх Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл гэх мэт бизнест эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх асуудал хариуцсан, хүйсийн тэгш байдлыг хангах үүрэгтэй нэгжүүдийг тодорхойлж, дүн шинжилгээ хийх.
   - » Улмаар тэдгээрийн ялгарах байдлыг сайжруулах, эрх үүргээ хэрэгжүүлэх чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цуврал үйл ажиллагаа зохион байгуулах. Дараах хэсгүүдээс бүрдэнэ:
   - » Ажилтнуудын олон түвшинд зориулсан сургалт
   - » Нөөц баялгийг эргэлтэнд оруулах
2. Бодлогын талаар мэдээлэл өгөх, стратегийг оновчтой төлөвлөх үүднээс жендерийн талаарх хэд хэдэн хэсгээс бүрдсэн мэдээллийг сайжруулах
   - » Холбогдох байгууллагууд ба экспортын үйл ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн болон нийгмийн бусад бүлгүүдийн оролцооны тухай мэдээлэх цогц үзүүлэлтүүдийг тодорхойлох.
   - » Тэдгээр үзүүлэлтүүдэд тогтмол шинэчлэл хийх ба ХХОЗЗ санаачлагатай, оролцоог хангасах байхын тулд засварлах арга хэмжээ авах.

[72]Дэлхийн эдийн засгийн форум (2018), Дэлхийн жендерийн тэгш бус байдлын тайлан 2018.
[73]АйЭфСи (2014), Монгол Улс дахь ЖДҮЖДҮ ба Эмэгтэйчүүдийн өмчлөлийн ЖДҮЖДҮ – Зах зээлийн судалгаа.

3. Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санаачлагыг нэмэгдүүлэх, дэмжих.
4. Эмэгтэй бизнес эрхлэгчдээс бараа ажил үйлчилгээ илүү худалдан авахыг дэмжсэн төрийн худалдан авах ажиллагааны бодлого боловсруулах талаар төлөвлөнө. Тус төлөвлөгөөнд үйл ажиллагааны талаар мэдээлэл, ойлголт авах эмэгтэйчүүдийн боломж ба шаардлагыг хангах чадварыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг хамруулна.Эмэгтэйчүүдийг зах зээлийн боломжуудыг ашиглах бололцоогоор хангах.

- Эмэгтэйчүүд давамгайлдаг салбаруудад (жишээ нь гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл) бэлэн экспортын ба чадавхи сайжруулах тусгайлсан арга хэмжээ зохион байгуулах.
- Эмэгтэйчүүдийн өмчлөлийн ЖДҮ-дэд бүсийн ба олон улсын зах зээл дэх боломжит худалдан авагчтай бизнесийн харилцаа тогтооход нь хамтрагч түншээ олох үйлчилгээ, арга хэмжээгээр дамжуулан дэмжлэг үзүүлэх (тухайлбал Олон улсын худалдааны төвийн ТэрЭмэгтэйХудалдаалдаг төсөл)
- Эдгээр үйл ажиллагаа төлөвлөх, хэрэгжүүлэхэд олон төлөвт, хэсэг хэсгээс бүрдсэн хандлага шаардлагатай. Гадаад харилцааны яам, Жендерийн үндэсний хороо болон хувийн хэвшил зэрэг оролцогч талуудын хамтарсан хүчин зүтгэл маш чухал.

# ХЭРЭГЖИЛТИЙН УДИРДЛАГЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Экспортын тогтвортой хөгжлийг бий болгох, бизнесийн орчныг идэвхжүүлэхэд ХХОЗЗ-ийг эцэслэн батлах нь дангаараа хангалттай бус юм. ХХОЗЗ-ийн стратегийн чиглэл, зорилтод хүрэхэд шаардлагатай үйл ажиллагаа нарийвчлан боловсруулах, зохицуулах хэрэгцээ байна. ХХОЗЗ-ийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хэрэгжилтийг хангах орчин нөхцөл, тогтолцоог бий болгох шаардлагатай.

Монгол Улсад стратегийг үр дүнтэй хэрэгжүүлж, тогтвортой үргэлжлүүлэн, урт хугацаанд үр ашгаа өгөхөд хамгийн чухал нөхцөлүүдийг дор харуулав:

**ХХОЗЗ-Д ДЭЭД ТҮВШНИЙ ДЭМЖЛЭГ АВАХ**

ХХОЗЗ-ийн хэрэгжилтэнд хамгийн чухал алхам бол түүнийг дээд түвшний дэмжлэг авах явдал юм. Ийнхүү албан ёсны дэмжлэг аваагүй тохиолдолд, ХХОЗЗ нь экспорт, хөрөнгө оруулалтын өсөлтийг үр дүнтэйгээр зохион байгуулах, бий болгоход шаардлагатай үндэсний ба олон улсын дэмжлэг, туслалцааг авах бололцоогүй болно.

**ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗОХИЦУУЛАЛТЫН БҮТЭЦ**

ХХОЗЗ-ийн амжилтын хамгийн чухал нөхцөл нь түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах, явцыг хянах болон нөөц баялгийг эргэлтэнд оруулах тухайн улсын чадвар юм. Зохицуулалтын ба хэрэгжилтийн хариуцлагын тогтолцоо нь мөн чухал ач холбогдолтой. Нийтийн болон хувийн хэвшлийн салбарын гол байгууллагуудаас бүрдсэн Экспорт, хөрөнгө оруулалтын зөвлөлийг байгуулах эсхүл (хэрэв Экспортын зөвлөл гэх мэт ижил төстэй байгууллага аль хэдийнэ байгуулагдсан бол) дэмжлэг үзүүлэхийг зөвлөж байна.

ХХОЗЗ-ийн дээд түвшний зөвлөл нь дараах үндсэн чиг үүрэгтэй байна:

i. Худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураглал хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих

ii. Худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураглал хэрэгжилтэнд шаардлагатай эх үүсвэрийг тодорхойлж, хуваарилалтыг санал болгох

iii. Худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураглал үр ашигтай байдал, үр нөлөөг үнэлэх

ХХОЗЗ-ийн дээд түвшний зөвлөлд замын зураглалын хэрэгжилтийн удирдлагатай холбоотой, өдөр тутмын ажлуудыг гүйцэтгэхэд нь Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газар дэмжлэг үзүүлнэ. Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газар нь дараах үндсэн чиг үүрэгтэй байна:

- ХХОЗЗ-ийн үйл ажиллагааны хэрэгжилтэд шаардлагатай төсвийг тусгасан төслийн санал боловсруулах;

- ХХОЗЗ-ийг сурталчилахад чиглэсэн харилцаа холбооны төлөвлөгөө, баримт бичиг боловсруулах;

- Жилийн болон хоёр жил тутмын ажлын төлөвлөгөө боловсруулан ХХОЗЗ-ийн дээд түвшний зөвлөлөөр батлуулах;

- Төслийн хэрэгжилтийн талаар мэдээлэл цуглуулж, хяналтын тайланг тогтмол бэлтгэн ХХОЗЗ-ийн дээд түвшний зөвлөлд хүргүүлэх;

- Дээд түвшний зөвлөл, салбарын хороод ба дэд зөвлөлийн хяналт, үнэлгээний хурлыг товлох;

- Дээд түвшний зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлыг гүйцэтгэх;

- ХХОЗЗ-ийн дээд түвшний зөвлөл ба ХХОЗЗ-ийн бүх баримт бичиг, архивыг цуглуулж, төвлөрүүлэн, хадгалах;

- ХХОЗЗ-ийн талаар төр, хувийн хэвшлийн түншүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

- Дээд шатны зөвлөлөөс даалгасан, шаардсан ажлыг гүйцэтгэх

## АМЖИЛТТАЙ УДИРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ: АМЖИЛТАНД ХҮРГЭХ ХҮЧИН ЗҮЙЛС БА ЗАЙЛСХИЙВЭЛ ЗОХИХ АЛДААНУУД

ХХОЗЗ-ийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах үйл ажиллагааны гол нөхцөлд дараах алхмуудыг ойлгоно:

### НӨӨЦИЙГ ҮР ДҮНТЭЙГЭЭР ХУВААРИЛЖ БУЙ ЭСЭХЭД ХЯНАЛТ ТАВИХ

Дээд шатны зөвлөл болон түүний Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газар нь ХХОЗЗ-ийн хэрэгжилтэнд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй. Тайлан, мэдээллийг үр дүнтэйгээр ашигласнаар ололт амжилтыг хүлээгдэх үр дүн, хуваарилсан нөөцтэй харьцуулан үнэлэх боломжийг хангах ач холбогдолтой. Хяналт тавьснаар хүлээгдсэн болон хүрсэн үр дүнд үндэслэн хуваарилалтыг үр дүнтэй хийх мөн шаардлагатай бол, дахин хуваарилалт хийхийг зөвшөөрнө. Энэ нь үйл ажиллагаатны үр дүнтэй хэрэгжилтийг хангахаас гадна ХХОЗЗ-ийг стратегийн зорилтдоо хүрэх боломжоор хангаж, амжилттай хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулна.

### ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨМЧЛӨЛИЙГ БИЙ БОЛГОХ ЗОРИЛГООР ИДЭВХЖҮҮЛЭХ

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан үндсэн хэрэгжүүлэгч байгууллагуудад ХХОЗЗ-ийн агуулга болон цаашдын хөтөлбөрийн талаар ойлголт өгөх шаардлагатай. Ийнхүү идэвхжүүлэнх нь цаашид өмчлөлийг бий болгоход чухал үүрэгтэй бөгөөд ингэснээр дунд, урт хугацаанд болон нэн даруй хэрэгжүүлж болох үйл ажиллагааг баталгаажуулах зорилгоор байгууллагууд ҮАТ-г эргэн харах боломжийг олгоно. Энэ арга барил нь хариуцагч агентлагуудын хүрээнд нөөцийг оновчтой хуваарилах боломжийг олгоно. Энэ хуваарилт нь байгууллагын төлөвлөгөө, хөтөлбөрт ХХОЗЗ-ийн үйл ажиллагааг тусгах байдлаар албажих боломжтой. Санхүүгийн өгөгдөл зайлшгүй шаардлагатай хэйи ч хүний нөөцийн элемент түүнээс дутуугүй чухал юм.

### ХУВИЙН ХЭВШЛИЙН ДЭМЖЛЭГ БА ОРОЛЦОО

Хувийн хэвшлийн түвшинд ХХОЗЗ-ийн хэрэгжилтийн үр нөлөө нь дараах үр ашгийг дагуулна Үүнд: бүтээмжийн чадавх сайжрах, бизнем эрхлэх зардал буурах, захиргааны журмууд боловсронгуй болох, санхүүжилтийн хүртээмж нэмэгдэх г.м. Хувийн хэвшлийн зүгээс, стратеги боловсруулах үйл ажиллагааны явцад, шууд болон төрийн байгууллагуудтай хамтарсан түншлэлийн хэлбэрээр, ХХОЗЗ-ыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах сонирхолтой байгаагаа тодорхой илэрхийлсэн байна. Тэд байгууллагуудад бизнесийн мэдээлэл өгөх, хөгжлийн төсөлд оролцох, боловсруулах нэгжүүд бий болгох, зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэргээр хэрэгжилтэнд хувь нэмрээ оруулах боломжтой. Товчхондоо, хувийн хэвшлийн бизнес эрхлэн явуулах практик мэдлэг нь ХХОЗЗ-ийн үйл ажиллагаанууд үр дүнтэй төлөвлөгдөх, хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой.

### ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ҮҮДНЭЭС САНХҮҮГИЙН НӨӨЦИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭХ

Нөөцийг төвлөрүүлэх нь шийдлийн зөвхөн нэг хэсэг боловч стратегийн хэрэгжилтэд орлуулшгүй чухал үүрэг гүйцэтгэдэг. ХХОЗЗ-г батлагдсан даруйд нөөцийг төвлөрүүлэх төлөвлөгөөг боловсруулна. Нөөцийг төвлөрүүлэх гэдэг нь хандивлагчидтай харилцаа холбоо, төслийн дизайн, төслийн санал/хүсэлт, нөөцийн цуглуулалт, удирдлага зэргийг төлөвлөн эрэмбэлэх үйл ажиллагааг хамаарна. Энэ нь тогтвортой, хүртээмжтэй хэрэгжилтийг хангах, үндэсний нөөц, хөгжлийн байгууллагуудын тусламж, хувийн хөрөнгө оруулалт зэрэг олон төрлийн санхүүгийн эх үүсвэрийн үр нөлөөг бэхжүүлэн, хөшүүргийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

- шууд төсвийн дэмжлэгээр үндэсний нөөц хөрөнгө: Засгийн газар нь ХХОЗЗ-г хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн доод хэмжээг баталгаажуулах шаардлагатай. ХХОЗЗ-ийн үйл ажиллагаанд шууд төслийн дэмжлэг үзүүлэх нь Засгийн газрын зүгээс санаачилгыг хэрэгжүүлэх зорилгын илрэл болно.

- Хандивлагчдын дэмжлэг туслалцаа болон оролцоог ХХОЗЗ-тай уялдуулах: ХХОЗЗ-ийн төлөвлөлтийн үйл ажиллагааны явцад олж авсан боломжийг ХХОЗЗ-ийн хэрэгжилтийг үр дүнтэйгээр үргэлжлүүлэх хөшүүрэг болгон ашиглахад хүчин чармайлт гаргах ёстой.

ХХОЗЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь дээд шатны зөвлөл, мөн түүнчлэн үндэсний байгууллагуудад харилцаа холбоогоо сайжруулах, хэлэлцээг хөнгөвчлөх, хөгжлийн тусламжийн хүрээнд өгсөн үүрэг амлалтуудын төлөвлөлт, хамтын ажиллагаа ба үнэлгээг хийх, нэн ялангуяа стратегийн тэргүүлэх ач холбогдолтой салбартай уялдуулан хөтөлбөр, төслийг боловсруулахад нь ач тусаа өгнө.

- Үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалт: Хөрөнгө оруулалтын урсгал нь экспортыг хөгжилд чухал ач холбогдолтой хүчин зүйл юм. Тэргүүлэх салбаруудын хөгжилд хувь нэмрээ оруулахын тулд тодорхой зорилтод чиглэх шаардлагатай. Экспорттой холбоотой боломжууд (гол салбарын үнэ цэнийн сүлжээний өсөлт, өрсөлдөх чадварт үндэслэн) хөрөнгө оруулалтыг чиглүүлэх, дэмжих санаачилгын сэдэв байх ёстой.

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төрийн болон хувийн хэвшлийн түншүүдэд мэдээлэл өгөх, идэвхжүүлэхэд чиглэсэн зорилтот харилцаа холбоо шаардлагатай. Иймд ХХОЗЗ-ийг үргэлжлүүлэн сурталчлах, эрч хүчийг сааруулахгүй хадгалах болон хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхийн тулд одоогийн харилцаа холбооны төлөвлөгөөг дэлгэрүүлэх шаардлагатай. Нийтийн болон хэрэгжүүлэгч байгууллагуудад мэдээлэл өгөх нь ХХОЗЗ-т итгэх итгэлийг бий болгож, дэмжлэг үзүүлэхэд түлхэц болдог.



Photo: © Ministry of Foreign Affairs



Photo: ©Ministry of Foreign Affairs

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1: БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫГ ХАНГАХ ЗАМААР УРТ ХУГАЦААНЫ ӨСӨЛТИЙН ЗАМЫГ БИЙ БОЛГОХ**

| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэмбэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх бололцоотой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 1.1. Тогтвортой өсөлтийг дэмжихийн тулд худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулалт, хэрэгжилтийг хангалттай түвшинд хангаж ажиллах | 1.1.1. Худалдаа, хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх байгууллагуудад, бодлого боловсруулахад чиглэсэн худалдааны дүн шинжилгээ хийх чадавхийг бий болгох:<br>• Мэдээлэлд хийх дүн шинжилгээ хийх ба худалдааны нөлөөллийн тооцооллын загварчлалын талаар худалдааны байгууллага, албан тушаалтнууд (жишээ нь Гадаад харилцааны яам, Худалдааг хөнгөвчлөх хороо), академи болон голлох экспортын байгууллагууд (жишээ нь МҮХАҮТ)-д сургалт явуулах<br>• Монгол Улсад орчин үеийн ЭсЭйЭм (SAM)-ийг бий болгох, ЖиТиЭйПи. Ви10 (GTAP.V10)-тай холбогдсон улсын СиЖиИ (CGE)-г үүсгэж, хэрхэн хэрэглэх талаар албан тушаалтнуудад сургалт явуулах. СиЖиИ (CGE)-г олон нийтэд нээлттэй болгох үүднээс хэрэглэгчтэй харилцах хэсгийг бүтээх.<br>• Эдгээр арга хэмжээний төгсгөлд Монгол Улсад олон нийтэд нээлттэй байгаа арга хэрэгслүүдийн талаар семинар, хэрэглэх зааварчилгааг танилцуулах арга хэмжээ зохиох<br>• Тарифын болон тарифын бус бодлогоор үндэсний үйлдвэрлэлийг дэмжих худалдааны бодлогын нөлөөллийн судалгаа хийх | 2 | | | | | | • Богино хугацааны эрчимжүүлсэн сургалтын хүрээнд мэдээлэлд дүн шинжилгээ хийх жил бүрийн сургалт явуулах<br>• СиЖиИ (CGE)-г хөгжүүлж, олон нийтэд нээлттэй болгох<br>• Ирээдүйд байгуулах гэж буй Чөлөөт худалдааны хэлэлцээрүүд (ЧХХ)-ийн нөлөөллийг үнэлгээ дүгнэлт хийсэн байна.<br>• Ерөнхий сургалтын хүрээнд 2 семинар зохион явуулах | Европын Холбооноос Монгол Улсын худалдаанд дэмжлэг үзүүлэх төсөл (EU-TRAM)<br><br>Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр (CAREC)-ийн Худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр (CITA), Азийн хөгжлийн банк | ГХЯ,<br>УХГ<br>Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо, МҮХАҮТ, Хөгжлийн банк (ХБ), ГЕГ,<br>Тарифын зөвлөл, БОАЖЯ |
| | 1.1.2. Монгол Улсын экспортын нөөц боломжийг нэмэгдүүлэхийн тулд Үндэсний хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан уххаалаг, зорилтот, уялдаа холбоотой худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах:<br>• Худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого болон тэргүүлэх ач холбогдолтой асуудлыг урт хугацааны үндэсний хөгжлийн ба хот/бүс нутгийн төлөвлөлттэй уялдуулах (нэн ялангуяа Улаанбаатар хотыг тойрсон тогтвортой хөгжил ба бүс нутгийн эдийн засгийн тулгуур төвүүдийг дэмжих). | 1 | | | | | | • Гадаад худалдааны бодлого болон хөрөнгө оруулалтын бодлогыг харилцан уялдаатай боловсруулж, Засгийн газрын хэрэг эрхлэх газраар батлуулсан байна.<br>• Хэвтээ төлөвлөлт дэх зохицуулгын арга хэрэгслийг бий болгосон байна | АйЭфСи (Дэлхийн банк) | ГХЯ,<br>УХГ<br>МҮХАҮТ, ХХААХҮЯ, БОАЖЯ, ХБ болон бусад холбогдох байгууллагууд |
| | 1.1.3. Үндэсний иж бүрэн экспортын стратегийг (ҮЭС) боловсруулах. ҮЭС нь ХХОЗЗ-ийн судалгааны үр дүн болон стратегийн чиг баримжаанд тулгуурлан байна. ҮЭС нь экспортын өрсөлдөх чадвар болон бизнесийг хөгжүүлэх Монгол Улсын дотоодын төлөвлөгөө болж өгнө. ҮЭС нь зорилтот дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ:<br>- Үндэсний түвшний стратегийн баримт бичиг ба Үйл ажиллагааны төлөвлөгөө<br>- Салбарын стратегиуд болон үүний бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөө<br>- Худалдаа дэмжих үйл ажиллагааны стратегиуд болон үүний бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөө | 1 | | | | | | • Үндэсний экспортын стратегийг боловсруулсан байна | | ГХЯ, МҮХАҮТ<br>ХХААХҮЯ, БОАЖЯ болон бусад холбогдох яамдууд |
| | 1.1.4. Засгийн газар ба төрийн байгууллагуудын зүгээс Хөрөнгө оруулагчдын өмнө хүлээх үүргийн талаар төрийн байгууллагын албан хаагчдад сануулах замаар Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүд, хууль тогтоомжийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх. | 1 | | | | | | • Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хуулийн талаар жилд 2 семинар зохион байгуулсан байна | Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл (Азийн хөгжлийн банк) | УХГ<br>Хөрөнгө оруулагчдыг хамгаалах зөвлөл, МҮХАҮТ, ГХЯ |
| | 1.1.5. "Худалдааг хөнгөвчлөх үндэсний хөтөч зураг", Худалдааг хөнгөвчлөх Үндэсний хорооны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө'-ний хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулж, хэлэлцээрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ. | 1 | | | | | | • Монгол Улсын ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хүрээнд авсан үүрэг амлалтийг хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.<br>• Худалдааг хөнгөвчлөх үндэсний хөтөч зураг бүрэн хэрэгжсэн байна | | Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо, МҮХАҮТ<br>ГХЯ, ГЕГ, МХЕГ |

| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1: БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫГ ХАНГАХ ЗАМААР УРТ ХУГАЦААНЫ ӨСӨЛТИЙН ЗАМЫГ БИЙ БОЛГОХ | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэмбэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх боломжтой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 1.2. Хууль, эрх зүйн бодлогын тогтвортой байдлыг хангах замаар урьдчилан таамарлаж болохуйц байдлыг сайжруулна | 1.2.1. Тэргүүлэх салбаруудын зохицуулалтад ил тод, урьдчилан таамарлаж болохуйц, харилцан зөвлөлдөх арга барил ашиглан, тууштай хэрэгжүүлэх | 1 | | | | | | • Харилцан зөвлөлдөх механизмийг бий болгон, хэрэгжүүлсэн байна | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хууль зүй, тодоод хэргийн яам (ХЗДХЯ)<br>БОАЖЯ, тэргүүлэх салбаруудын холбоод |
| | 1.2.2. Салбарын тохируулагч зохицуулагч нар ажил үүргээ Төрийн өмчит компанийн менежмент ба олборлох салбарын концесс ба Төр хувийн хэвшлийн түншлэлийн удирдлага зэрэг олон улсын шилдэг стандартын дагуу гүйцэтгэхэд шаардлагатай сургалт, эх үүсвэрүүдээр хангах. | 2 | | | | | | • Салбарын тохируулагч зохицуулагч нарыг сургах сургалтын хөтөлбөр бэлэн болсон байх | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ҮХГ<br>ХЗДХЯ,<br>БОАЖЯ, тэргүүлэх салбаруудын холбоод |
| | 1.2.3. Олборлох үйлдвэрлэлийн салбар дахь эрдэс баялгийн нөөцийн удирдлагын хувьд төрийн өмчит компаниудад хандах сүүлийн үеийн хандлагыг өөрчилж, Төр хувийн хэвшлийн түншлэл, концесст ээлтэй байдлаар шийдсэнээр, технологи, арилжааны ашигт байдал, удирдлага зохион байгуулалтын мэргэшлийн түвшинг ахиулах. | 2 | | | | | | • Олборлох үйлдвэрлэлийн салбар дахь концесс болон Төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих механизмыг бий болгох | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам,<br>ҮХГ<br>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, ХЗДХЯ, МҮХАҮТ, тэргүүлэх салбаруудын холбоод |
| 1.3. Монгол Улсын экспортлогч аж ахуйн нэгжүүдэд зориулж худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн үр өгөөжийг нэмэгдүүлэх | 1.3.1. Одоогоор үйлчилж буй худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүдийн хэрэгжилт, тэр дундаа хэлэлцээрийн дунд бий болсон хамтын ажиллагааны хөгжлийн түвшинг хянан үзэж, хэлэлцээрийн ач холбогдлыг бататгах.<br>• Олон улсын худалдааны хэлэлцээрийн ЭЗТХ / ЧХХ дагуух худалдааны гүйцэтгэлийн үр дүн, импортын огцом өсөлт, зах зээлд нэвтрэх нөхцөл зэргийг хүлээсэн үүрэг (хүлээлт)-тэй харьцуулан шалгаж, экспортлогчдийн санаа бодлыг сонсох зорилгоор зөвлөлдөх хэлэлцүүлэг зохион байгуулах.<br>• Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байдлыг сунгах заалтын дагуу дахин хэлэлцэх шаардлагатай хэлэлцээр дэх асуудлуудыг тодорхойлох мөн гэрээний хувьд бүрэн хэрэгжээгүй хэсгүүдийг нь олж тогтоох.<br>• Одоогоор үйлчилж буй худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүдийн хэрэгжилтийг эргэн нягтлах, боловсронгуй болгох. | 1 | | | | | | • Жилийн эцсийн хяналт үнэлгээг бий болгож, хэрэгжүүлсэн байна | | ГХЯ,<br>ҮХГ<br>ХХААХҮЯ, БОАЖЯ, Сангийн яам, БСШУЯ МҮХАҮТ, ГЕГ, хувийн хэвшлийн холбоод, Монголын гаалийн зөвлөх, зуучлагчдын холбоо (МГЗЗХ) |
| | 1.3.2. Хамтран ажиллах боломжтой байгууллагыг тогтоон, зах зээлд нэвтрэх нөхцлүүд, хөрөнгө оруулалтын боломжит харилцаанууд зэрэгт дүн шинжилгээ хийж бэлдэх зэргээр цаашид байгуулах худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүдийн ач холбогдлыг бататгах.<br>• Зах зээлийг задлан шинжилж, худалдааны таатамжтай нөхцлүүд болон өрсөлдөх чадварын дүн шинжилгээ хийх. Эдийн засгийн шалгуурын дагуу ашиг сонирхлыг эрэмбэлэх<br>• Бараа, үйлчилгээнд хамаарах зах зээлд нэвтрэх нөхцлүүд (үүнд худалдааны техникийн саад тотгорууд) болон Монгол Улсын бүтээгдэхүүнүүдийн нэвтрэх боломжийг хязгаарлаж байж болох хилийн арга хэмжээг шалгаж нягтлан үзэх<br>• Шинээр худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээр байгуулснаар бий болох боломжууд, сорилтуудыг хянан үзэх<br>• Орчин үеийн хэлэлцээрүүдэд хамрагдах болсон үйлчилгээний худалдааны хэлэлцээрүүд, хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах талаарх хоёр талт хэлэлцээрүүд болон худалдаатай холбоотой талбаруудад хэлэлцээ хийх чадварын талаар сургалт зохиох. Чадавхи дутмаг байгаа нарийн, түвэгтэй салбаруудад техникийн болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх. | 1 | | | | | | • Боломжит худалдаа, хөрөнгө оруулалтын харилцааны талаар жил бүр 5 тайлан<br>• Худалдааны бодлогын зорилтуудтай уялдсан шинэ хэлэлцээрт зориулсан, хяналт, үнэлгээний тогтолцоог бий болгосон байна | | ГХЯ, ҮХГ<br>ХХААХҮЯ, БОАЖЯ, Сангийн яам, МҮХАҮТ, МГЗЗХ, хувийн хэвшлийн холбоод |

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1: БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫГ ХАНГАХ ЗАМААР УРТ ХУГАЦААНЫ ӨСӨЛТИЙН ЗАМЫГ БИЙ БОЛГОХ

| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэмбэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх боломжтой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 1.4. Худалдаа, хөрөнгө оруулалтын үндсэний бүтэц тогтолцоо ба үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг нэмэгдүүлэх | 1.4.1. Худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулалтыг хянах, үнэлж дүгнэх, энэ талаар мэдээлэл авахад зориулсан орчин үеийн, тогтмол шинэчлэгддэг нийтийн портал үүсгэх.<br>Үндэсний хөгжлийн газрын цахим порталд суурилан тус порталыг үүсгэх боломжтой эсэхийг үнэлэх. Одоо буй болон шинээр үүсгэх порталуудын нийцэл, харилцаа холбоог хангах.<br>Хэлцлийн талаар шинэ мэдээлэл, хэлцлүүдийг хүснэгт бүрээр дүгнэсэн хураангуй, тодорхойлсон бизнесийн боломжууд зэрэг 2 талт болон олон талт худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүдтэй холбоотой мэдээллийг нэгтгэх цахим порталыг хөгжүүлэх | 3 | | ■ | ■ | ■ | ■ | • Нийтэд зориулсан порталыг үүсгэсэн, тогтмол шинэчилсэн байна | АйЭфСи (Дэлхийн банк) | ГХЯ, ҮХГ<br>МҮХАҮТ, хувийн хэвшлийн холбоод, МССБА |
| | 1.4.2. "Худалдаа хөнгөвчлөх үндэсний хөтөч зураг"-тай нийцүүлэн, Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн зүйл заалтуудыг хэрэгжүүлэх үүднээс худалдааны бодлогыг уялдуулах | 1 | | ■ | ■ | ■ | ■ | • Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн (ХХХ) зүйл заалтуудыг, дэмжлэг үзүүлсэн тохиолдолд А, Б, С ангиллын дагуу хэрэгжүүлсэн байна | СиАйТиЭй (CITA) (Азийн хөгжлийн банк) | Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо<br>ГХЯ, гадаад худалдаанд оролцогч холбогдох бүх талууд |
| | 1.4.3. Хоёр талт болон олон талт худалдаа, хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүдийг хэлэлцэх үед хувийн хэвшлийнхний оролцоог хангах, тэдэнтэй зөвлөлддөг байхаар техникийн хороодыг зохион байгуулах | 1 | ■ | ■ | ■ | ■ | ■ | • Техникийн хороодыг байгуулсан байна | | ГХЯ, ҮХГ, МҮХАҮТ<br>хувийн хэвшлийн холбоод |
| 1.5. Худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, хуулийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий цогц байгууллагуудыг байгуулан, чадавхжуулах | 1.5.1. Худалдаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч, төр болон хувийн хэвшлийн салбарын оролцогч талуудын гол төлөөллийн байгууллага болох Монголын Улсын Экспорт, хөрөнгө оруулалтын зөвлөл (МУЭХОЗ)-ийг байгуулах.<br>• Зөвлөл нь Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо (ТХХЗХ), Экспортын зөвлөл болон Хөрөнгө оруулагчдыг хамгаалах зөвлөл зэрэг одоо байгаа төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны бүтэц, байгууллагууд болон тогтолцоонд суурилан байгуулагдана.<br>• Зөвлөл нь ХХОЗЗ-ийн биелэлтийг хангах үүднээс нөөц эх үүсвэрүүдийг зохицуулах, хянах, үнэлэх болон эргэлтэнд оруулах зэрэг чиг үүрэгтэй байна. Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газар Зөвлөлд дэмжлэг үзүүлж ажиллана. МУЭХОЗ-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газар нь төр болон хувийн хэвшлийн санхүүжилттэй байна.<br>• Зөвлөлийн гишүүдэд, шаардлагатай бодлого эсхүл эрх зүйн зохицуулалтын өөрчлөлтийг хийхэд нь дэмжлэг үзүүлэхийн тулд хэрэгцээтэй өмгөөлөл, ухуулга сургалчилгааны үйл ажиллагаар зохион байгуулахад нь туслалцаа үзүүлнэ. | 1 | | | ■ | | | • Монголын Улсын Экспорт, хөрөнгө оруулалтын зөвлөлийг байгуулсан байна | | Ерөнхий сайдын ажлын алба<br>ГХЯ<br>ҮХГ, ХХААХҮЯ, МҮХАҮТ, хувийн хэвшлийн холбоод<br>Хөрөнгө оруулагчдыг хамгаалах зөвлөл, ХХҮХ, ТХХЗХ |
| | 1.5.2. ХХОЗЗ-ийн тэргүүлэх ач холбогдолтой салбарууд дахь ашиг сонирхлыг төлөөлөх зорилгоор Зөвлөл дотор салбар бүрийн хороонуудыг байгуулах. Хороодод Нарийн бичгийн дарга нарын газар зэрэг нь байнгын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж, хөрөнгө оруулалт бодлого боловсруулалт ил тод байхыг хангах. Давхцалаас сэргийлэхийн тулд хороод нь МҮХАҮТ дэх Салбарын зөвлөлүүд болон салбаруудын холбоод зэрэг үндэсний болон бүс нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд дээр тулгуурлана.<br>Салбарын хороод нь зорилтот хөрөнгө оруулалтыг тодорхойлох, эрх зүйн зохицуулалтын шинэтгэл, санхүүжилт авах зэрэг ХХОЗЗ-ийн гол сэдвүүдийн талаар зөвлөлдөнө. | 1 | ■ | | | | | • Салбар бүрийн хороодыг Зөвлөл дотор байгуулсан байна | | ГХЯ, МҮХАҮТ<br>ҮХГ, ХХААХҮЯ,<br>хувийн хэвшлийн холбоод |
| | 1.5.3. Худалдааг дэмжиж сурталчилан таниулах болон зах зээлийн бусад дэмжлэг үзүүлэх дараах үйл ажиллагааг бүхэлд нь хариуцсан агентлагийг байгуулах:<br>• бүтээгдэхүүн, зах зээлийг тодорхойлж, хөгжүүлэх,<br>• худалдааны мэдээллийн үйлчилгээ,<br>• мэргэшсэн дэмжих үйлчилгээ<br>• гадаадад сурталчилан таниулах үйл ажиллагаа | 1 | ■ | | | | | • Худалдааг дэмжих агентлагийг байгуулсан байна | | ГХЯ<br>ХХААХҮЯ, МҮХАҮТ, хувийн хэвшлийн холбоод |
| | 1.5.4. Хөрөнгө оруулалтыг дэмжих үүрэгтэй, үр дүнд суурилсан, эрх зүйн зохицуулалт, бодлого боловсруулахаас ангид үйл ажиллагаатай, ажлын үр дүн нь хөрөнгө оруулагчийг тодорхойлох, ГШХО ба ЖДҮ-ийн холбоо харилцааг хөнгөвчилсөн хөрөнгө оруулалтын нөлөөллийг бий болгох чадвараар үнэлэгддэг дагнасан хөрөнгө оруулалтын агентлаг байгуулах. | 1 | | | ■ | ■ | | • Хөрөнгө оруулалтын шинэ агентлаг байгуулагдсан байна. | | ҮХГ, МҮХАҮТ |

TIR MON 1 - Final_Fi.indd 72
07.05.2020 09:16:31

| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1: БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫГ ХАНГАХ ЗАМААР УРТ ХУГАЦААНЫ ӨСӨЛТИЙН ЗАМЫГ БИЙ БОЛГОХ | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэмбэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх боломжтой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 1.5. Худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, хуулийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий цогц байгууллагуудыг байгуулан, чадавхжуулах | 1.5.5. ҮХГ болон салбарын асуудал хариуцсан Яам (тухайлбал, ЗТЯ зам, төмөр замыг, БОАЖЯ эрчим хүчийг, ЭМЯ усны эмнэлгийг гэх мэт)-дын харилцаа, хамтын ажиллагааг хөнгөвчлөх зохицуулалтын механизмыг бий болгох. Хамтын ажиллагаа нь дараах салбаруудыг хамаарна:<br>• салбарын түвшин дэх төр болон хувийн хэвшлийн түншлэлийн төлөвлөгөө, хэлэлцээ, удирдлага болон хэрэгжилт<br>• Тэргүүлэх салбаруудад хөрөнгө оруулагчдыг оролцоог нэмэгдүүлэх аян зарлан, хэрэгжүүлэх. Энэхүү үйл ажиллагааг шинээр байгуулагдах Хөрөнгө оруулалтын агентлаг хариуцан хэрэгжүүлнэ (1.5.4-т заасан үйл ажиллагаа) | 2 | | | | | | • ҮХГ-ийн чиг үүргийг салбар хариуцсан Яамдтай гүйцэтгэх хамтын ажиллагаатай уялдуулан шинэчлэх Зохицуулалтын механизмыг албан ёсны болгосон байна<br>• Мөн холбогдох яамдын чиг үүргийг ҮХГ-тай хэрэгжүүлэх хамтын ажиллагаатай уялдуулан шинэчилсэн байна. | | ҮХГ<br>МҮХАҮТ, Сангийн яам,<br>ГХЯ, ЭМЯ, ХХААХҮЯ, БОАЖЯ, ЗТЯ |
| | 1.5.6. Концессийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдуулан ҮХГ-ийн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх. | 2 | | | | | | • Чадавхи бэхжүүлэх хөтөлбөр бий болсон байна. | | ҮХГ, МҮХАҮТ<br>салбар хариуцсан Яамд |
| | 1.5.7. Хөрөнгө оруулагч нарын төрийн байгууллагуудтай үүссэн маргааныг шийдвэрлүүлэх боломжтой, хөрөнгө оруулалтын омбудсманы чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх мэдэл, нөөц бололцоог Хөрөнгө оруулагчдыг хамгаалах зөвлөлд олгох. Хөрөнгө оруулалтын омбудсман нь дараах үндсэн чиг үүрэгтэй байна (жишээ нь, БНСУ-ын Гадаадын хөрөнгө оруулалтын омбудсман):<br>–Гадаадын компаниудад тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар мэдээлэл цуглуулж, судлах<br>–Холбогдох төрийн байгууллагад хамтран ажиллах хүсэлт гаргах болон шийдвэрлэх арга зам санал болгох<br>- Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тогтолцоог сайжруулахад чиглэсэн шинэ бодлого санал болгох<br>- Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад гомдлоо шийдвэрлүүлэхэд нь туслалцаа үзүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээг авах. | 2 | | | | | | • Хөрөнгө оруулагчдыг хамгаалах зөвлөлийн эрх үүргийг шинэчлэн тогтоох | | ҮХГ (Хөрөнгө оруулагчдыг хамгаалах зөвлөл), МҮХАҮТ |

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2: ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ, ТЭДГЭЭРИЙН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ**

| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэм-бэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх боломжтой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 2.1. ХХОДБ-уудын харилцан уялдаатай үйл ажиллагаа ба үр ашигтай байдлыг сайжруулах | 2.1.1. ХХОДБ-уудын санал асуулгын судалгааны үр дүнд суурилан, худалдаа, хөрөнгө оруулалтын мэдээлэл ба экспортыг дэмжих, худалдааны мэдээлэл, нарийвчилсан мэдээллийн баазанд нэвтрэх гэх мэт худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны нэхцлийг оновчтой зохицуулах үүднээс, худалдааг дэмжих гол байгууллагуудаас бүрдсэн албан ёсны сүлжээг байгуулах.<br>• Дэмжлэг үзүүлж буй худалдаа, экспортыг хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэгч төр болон хувийн хэвшлийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагаар улам сайжруулах үүднээс Сүлжээ нь хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой заасан баримт бичгийн үндсэн дээр байгуулагдана.<br>• ХХОДБ-уудын үүрэг хариуцлагыг тодорхой болгосноор үзүүлэх үйлчилгээний давхардал болон цоорхой үүсэхээс сэргийлэх ач холбогдолтой юм. | 1 | | | | | | • ХХОДБ-уудын сүлжээг бий болгон албажуулж, байгууллага тус бүрийн эрх үүргийг тодорхойлсон байна.<br>• Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагуудын алсын хараа, зорилтыг тодорхойлсон байна. | | ГХЯ<br>ХХААХҮЯ, БОАЖЯ, МХЕГ, ГЕГ, СХЗГ, Сангийн яам МҮХАҮТ, хувийн хэвшлийн холбоод |
| | 2.1.2. Гадаад харилцааны яам, МХЕГ, ҮХГ ба МҮХАҮТ зэрэг худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагуудад зориулсан, тэдгээрийн чанартай үйлчилгээ үзүүлэх чадавхийг нэмэгдүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулах бөгөөд энэ хөтөлбөр нь тодорхойлсон үүрэг хариуцлага болон чадавхийн үнэлгээ (ХХОДБ-уудын дүн шинжилгээ)-нд суурилсан байх. Чадавх нэмэгдүүлэх хөтөлбөрүүдийг ХХОЗЗ-ы дагуу хүлээх хэрэгжилтийн үүрэг хариуцлагуудтай уялдуулах. | 1 | | | | | | • ХХОДБ-ийн чадавхи нэмэгдүүлэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлсэн, ХХОЗЗ-ийн дагуу хэрэгжилтийн хүлээх үүрэг хариуцлагатай уялдуулсан байна. | Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл (Азийн хөгжлийн банк)<br>СиАйТиЭй (CITA) (Азийн хөгжлийн банк) | ГХЯ, ҮХГ<br>МҮХАҮТ, ХХААХҮЯ, БОАЖЯ, Сангийн яам, МХЕГ, ГЕГ, СХЗГ, хувийн хэвшлийн холбоод |
| | 2.1.3. Гадаадын хөрөнгө оруулалтын урсгал нэмэгдэх, төрөлжсөн байхыг хөнгөвчлөх үүднээс хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх чадавхийг бататган сайжруулах.<br>• Үндэсний хөгжлийн газрын хөрөнгө оруулалтыг тухайлан олж татах, сурталчилан дэмжих үйл ажиллагааны стратегийн алсын хараагаа тодорхойлох болон бодитоор хэрэгжих нөөц боломжоор хангах. | 1 | | | | | | • Хөрөнгө оруулалтын шинэ агентлаг байгуулагдсан байна. | | ҮХГ |
| | 2.1.4. ҮХГ-ын хөрөнгө оруулалтыг дэмжих, тээвэрлэлтийн төлөвлөлт болон Эдийн засгийн онцгой бүсийн төлөвлөлт хийхдээ хөргөлттэй тээвэрлэлтийн сүлжээ, мах савлах, боловсруулах махны үйлдвэр, ноолууран эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн бөсөө тогтолцоо бүхий бүтэц, арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон барилгын материал зэргийг тэргүүн ээлжинд ач холбогдол өгч анхаарах. | 1 | | | | | | • Хөрөнгө оруулалтыг дэмжих төлөвлөгөө нь дурьдсан тэргүүлэх ач холбогдолтой асуудалд анхаарсан байх. | | ҮХГ |
| 2.2. Худалдааны мэдээлэл, сурталчилгааны дэмжлэг үзүүлж буй байгууллагуудын сүлжээг бэхжүүлэх | 2.2.1. Хувийн хэвшлийн салбарын холбоод, МҮХАҮТ зэрэг худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжигч байгууллагын удирдлага зохион байгуулалт ба үйл ажиллагааны биелэлтийн хувьд тодорхойлсон дутагдлыг арилгах зорилготой шатласан хөтөлбөр болох Гүйцэтгэлийг сайжруулах замын зураг (ГСЗЗ)-ийг хэрэгжүүлэх, байгууллагын чадавхийг сайжруулах ажлыг үргэлжлүүлэх. | 1 | | | | | | • Хөрөнгө оруулалтыг дэмжих төлөвлөгөө нь дурьдсан тэргүүлэх ач холбогдолтой асуудалд анхаарсан байх. | | ҮХГ<br>Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо<br>МҮХАҮТ ба салбарын болон экспортын холбоод |
| | 2.2.2. Худалдааны мэдээлэл болон худалдааг дэмжих үйл үйлчилгээг хангахын тулд, ГХЯ эсхүл бусад худалдааг сурталчилан дэмжих чиг үүрэг бүхий байгууллагын чадавхийг бэхжүүлж, гүйцэтгэлийг сайжруулах иж бүрэн төлөвлөгөөг гаргах.<br>• Бусад төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын одоогоор хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийг өргөжүүлэх дэмжих.<br>• Дараах чиглэлээр тусгайлсан зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах:<br>• Худалдааны мэдээллийн үйлчилгээ эрхлэх<br>• Худалдааны мэдээллийн холбогдох эх сурвалжийг сонгох<br>• Бизнесийн мэдээлэл болон холбогдох үйлчилгээг борлуулах<br>• Худалдааны мэдээллийн үйлчилгээний гүйцэтгэлийн үр дүнг хэмжих | 1 | | | | | | • МҮХАҮТ-ийн боловсруулсан ГСЗЗ бүрэн хэрэгжсэн байна.<br>• МҮХАҮТ-ийн боловсруулсан ГСЗЗ аргачлалаар бусад байгууллагын ГСЗЗ боловсруулж, гүйцэтгэлийг нэмэгдүүлэх. | | ҮХГ<br>Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо<br>МҮХАҮТ ба салбарын болон экспортын холбоод |

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2: ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ, ТЭДГЭЭРИЙН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ**

| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэм-бэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх боломцоотой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 2.2. Худалдааны мэдээлэл, сурталчилгааны дэмжлэг үзүүлж буй байгууллагуудын сүлжээг бэхжүүлэх | 2.2.3. Зах зээлийн судалгаа/тайланг цуглуулах, бэлтгэх, дүн шинжилгээ хийх болон экспортлогчдод өндөр чанартай зөвлөх үйлчилгээ үзүүлэх ХХОДБ-ын чадавхийг сайжруулах үүднээс өнөөгийн сургалтын хөтөлбөрийг нэмэгдүүлж, байгууллагын түвшинд зохион байгуулах. Дараах зүйлст анхаарна:<br>• Худалдааны мэдээлэл<br>• Зах зээлийн дүн шинжилгээ (хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээрийг оруулна)<br>• Бизнесийн орчин<br>• Экспортын нэмүү өртгийн сүлжээг оновчтой болгох<br>• Экспортыг сурталчилан дэмжих | 2 | | | | | | • Одоогоор хэрэгжиж байгаа худалдаа ба хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хянан үзэж, нэгтгэх<br>• Сургалтын хөтөлбөрийг нэмэгдүүлж, бүс нутгуудад өргөжүүлэхэд анхаарсан байна | | ГХЯ, МҮХАҮТ<br>ХХААХҮЯ, БОАЖЯ, Сангийн яам, МГЗЗХ, хувийн хэвшлийн холбоод |
| | 2.2.4. Сонгосон зах зээлд үр дүнтэйгээр тодорхой бүтээгдэхүүнийг таниулахын тулд экспортлогчдын авах ёстой арга хэмжээнүүдийг хянан шалгадаг зах зээлийн нарийвчилсан судалгаа (ихэнхдээ "Зах зээлийн товч танилцуулга" эсхүл МҮХАҮТ-ийн "Экспортын замын зураг" гэж нэрлэдэг)-г хийх талаар ХХОДБ-д сургалт хийх. Дараах зүйлс чухал ач холбогдолтой:<br>• Бүтээгдэхүүний талаарх тусгайлсан шаардлагууд болон Гарал үүслийн журам: экспортлогч хөнгөлөлтэй худалдааны хэлэлцээрүүдийг (жишээ нь Японы ЧХХ, Европын холбооны EU GSP+) ашиглан, дэлхийн нэмүү өртгийн сүлжээний ертөнцөд хэрхэн амжилттай ажиллах боломжтой вэ? Одоо үйлчилж буй хэлэлцээрүүдийн үр дүнг экспортлогчид хүртэх боломжийг ихэсгэхийн тулд сонгосон зах зээл дэх тарифын бус арга хэмжээ болон Гарал үүслийн журмын нарийвчилсан заалтыг анхааралтай судлах.<br>• Худалдан авагч ба бүтээгдэхүүний нарийвчилсан ангилал: Сонгосон зах зээлд эцсийн бүтээгдэхүүнийх нь борлуулалт сайн байхыг хангахын тулд экспортлогч юу анхаарвал зохих вэ.<br>• Шошгожуулалт ба савлалт: гаалийн хяналтын журам, тээвэрлэлт болон брэндинг-т нөлөөлдөг чухал асуудлуудыг агуулсан байх.<br>• Сайн дурын стандартууд: таны бүтээгдэхүүн, зардал болон үйл ажиллагаанд тухайн зүйл шаардлагатай эсэхийг ойлгох.<br>• Бүтээгдэхүүн байрлуулах эсхүл түгээх суваг: сонгосон улс дахь зах зээлийн бүтцийг олж мэдэх, тайлбарлах.<br>• Сурталчилан дэмжих: худалдан авагч, борлуулалтын баг, түгээгч нартай хэрхэн ашигтай харилцаа, хамтын ажиллагаа үүсгэж, тогтвортой байлгах вэ. Худалдаанаас ашиг олохын тулд хэрхэн худалдааны үзэсгэлэн яармаг, хэлэлцүүлэгт оролцох тараах ярилцах. | 1 | | | | | | • Зах зээлийн нарийвчилсан судалгаа хийх талаар ХХОДБ-д жил бүр сургалт явуулсан байна | | ГХЯ, МҮХАҮТ<br>ХХААХҮЯ, БОАЖЯ, Сангийн яам, ХБ, хувийн хэвшлийн холбоод |
| | 2.2.5. Монголын нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бус бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээг экспортлогчдод илүү сайн зөвлөгөө өгөх болон сонгосон зах зээлд тодорхой бүтээгдэхүүнийг экспортлох боломж, нөхцөлийг мэдээлдэг байлгах үүднээс Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайдын яамдын худалдааны төлөөлөгч, дипломат албан хаагчид, худалдааны газруудын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх. | 2 | | | | | | • Худалдааны төлөөлөгч, дипломат албан хаагчдад зориулсан чадавхи сайжруулах хөтөлбөрийг жил бүр хэрэгжүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьсан байх. | | ГХЯ<br>ХХААХҮЯ, БОАЖЯ, Сангийн яам, МҮХАҮТ, хувийн хэвшлийн холбоод |
| | 2.2.6. Төрийн байгууллагууд, ХХОДБ-ууд, хэвлэл мэдээлэл, академи, судалгааны байгууллагууд болон хувийн хэвшлийнхэн дунд худалдааны мэдээлэл түгээх, солилцохыг дэмжих хамтын ажиллагааны бүтцийг бий болгох. | 1 | | | | | | • Хамтын ажиллагааны бүтцийг бий болгосон байна | | ГХЯ<br>ХХААХҮЯ, БОАЖЯ, Сангийн яам, МҮХАҮТ, хувийн хэвшлийн холбоод |
| | 2.2.7. Үндэсний брэндинг, зах зээлийн төлөвлөгөөнүүд, дэд брэндүүдийг салбар хороонуудтай хамтран, байнга харилцан ярилцаж хөгжүүлэхийн тулд, байгууллагдаад үйл ажиллагаа явуулж буй "Монголын Үндэсний Брэндийн зөвлөл"-ийг гадаад улсад сургалт, семинар зохион байгуулах замаар бэхжүүлэх (1.5.2-т заасан үйл ажиллагаа) | 2 | | | | | | • Монголын Үндэсний Брэндийн зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн байна | | Монгол Үндэсний Брэндийн зөвлөл ХХААХҮЯ<br>ГХЯ, МҮХАҮТ |

| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2: ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ, ТЭДГЭЭРИЙН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэм-бэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх боломжтой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 2.3. Хилийн боомтын шалган нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар экспортын хурдыг нэмэгдүүлэх | 2.3.1. Хилийн боомтоор нэвтрэх зорчигч, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй уялдуулан, хилийн боомтын дэд бүтцийг хөгжүүлэх, боомтын шалган нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлэх:<br>• Хөрш улсуудтай хамтран хүлээн зөвшөөрөхүйц уялдаа холбоо бүхий системийг судлах<br>• Бүтээгдэхүүнд хяналт шалгалт, үзлэг хийх шаардлагатай тоноглол бүхий нэмэлт тоног төхөөрөмжийг хилийн боомтод суурилуулах. Шаардлагатай тоног төхөөрөмж, хөрөнгийг үнэлэх судалгаа явуулах. Судалгаанд тулгуурлан, экспортлогчдын хил нэвтрэх сонголтыг өргөжүүлэх зорилгоор хилийн боомтын байгууламжийг сайжруулахад шаардлагатай арга хэмжээг авах.<br>• Шинэ болон одоо байгаа тоног төхөөрөмжийг ашиглах хил гаалийн ажилтнуудын чадавхийг сайжруулахад чиглэсэн сургалтын хөтөлбөр төлөвлөж, хэрэгжүүлэх | 1 | | | | | | • Хилийн боомтын дэд бүтцийг хөгжүүлэх судалгаа хийх<br>• Хилийн хяналтын ажилтнуудын хамтарсан хяналт тавих, хяналтын тоног төхөөрөмжтэй ажиллах чадавхийг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах | Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсад хэрэгжүүлж буй Бус нутгийн ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг шинэчлэн сайжруулах замаар худалдааг дэмжих төсөл | МХЕГ, ГЕГ<br>Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар |
| | 2.3.2. Экспортын зардал, хугацааг бууруулах үүднээс салбар хариуцсан Яам, агентлагууд хооронд экспортын бараанд тавих хяналт шалгалтыг харилцан хүлээн зөвшөөрөх механизм бүхий хилийн хяналтын үндсэний хэмжээний удирдлагын зохицуулалтыг төлөвлөн хэрэгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх.<br>Хилийн хяналтын байгууллагуудын албан хаагчдад шинэ зохицуулалтын талаар мэдлэг олгох үүднээс тэдгээр албан хаагчдын чадавхийг сайжруулах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх. | 2 | | | | | | • Хилийн хяналт шалгалтын одоогийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн байна<br>• Харилцан хүлээн зөвшөөрөх механизм бүхий зохицуулалтыг бий болгож, шаардлагатай хууль тогтоомжид өөрчлөлт оруулсан байна.<br>• Албан хаагчдын чадавхийг сайжруулах сургалтыг зохион байгуулсан байна. | | ГЕГ<br>салбар хариуцсан Яамд, МХЕГ, СХЗГ, МҮХАҮТ, ба салбарын холбоод |
| | 2.3.3. Итгэмжлэгдсэн экспортлогч хөтөлбөрийг төлөвлөн, хэрэгжүүлж, экспортын орны гаалийн байгууллагатай хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх боломжийг бүрдүүлж, экспортын бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулах.<br>Экспортлогчдийг чиглэсэн мэдээлэл өгөх аян зарлах. | 2 | | | | | | • Итгэмжлэгдсэн экспортлогч хөтөлбөрийн нэвтрүүлж, хөтөлбөрийн ач холбогдлыг экспортлогч нарт сурталчилсан байна. | Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл (Азийн хөгжлийн банк) | Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо<br>МҮХАҮТ, ГЕГ |
| | 2.3.4. Хилийн үйлчилгээний чанарыг хянах үүднээс Нэг цэгийн үйлчилгээний үр дүнгийн талаарх харилцагчийн сэтгэл ханамжийн санал асуулга явуулах.<br>Судалгааны дүнд тулгуурлан гаалийн үйлчилгээг бэхжүүлэх. | 2 | | | | | | • Сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хугацаанд үр дүнтэй зохион байгуулсан байна.<br>• Судалгааны үр дүнгээр шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж, үр нөлөөг худалдаа эрхлэгч нарт тухай бүр танилцуулах. | | Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо<br>ГЕГ, МХЕГ, СХЗГ, МҮХАҮТ, ба салбарын мэргэжлийн холбоод |
| 2.4. Олон улсын түнш байгууллагуудад хүлээн зөвшөөрүү-лэхийн тулд, үндэсний чанарын дэд бүтцийг бэхжүүлэх | 2.4.1. "Монгол Улсын стандарчилалтын тогтолцоог шинэтгэхэд дэмжлэг үзүүлэх" хүрээнд, хүнсний аюулгүй байдал болон тохирлын баталгаажуулалтын талаар үндэсний хууль тогтоомжийн шинэчлэлийг дэмжих.<br>• Хууль эрх зүйн орчин дахь давхацсан, үл нийцсэн зохицуулалтыг олж тогтоох.<br>• СиЕуДиИИкс (CODEX) батлахын тулд хуулийн нэмэлт өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх<br>• ЖДҮ нарт үр ашгаа өгөх, эрсдэлд суурилсан хүнсний аюулгүй байдлын удирдлага болон мөрдөгдөх чанарын орчин үеийн тогтолцооны талаарх удирдамж боловсруулах<br>• Бодлогын шинэчлэлийг өргөн хүрээнд дэлгэрүүлэх үүднээс энэ талын ойлголтыг нэмэгдүүлэх цуврал сургалтуудыг зохиох. | 1 | | | | | | • Тохирлын баталгаажуулалттай холбоотой хууль тогтоомжийг хянаж нягтлах<br>• Багадаа 200 сонирхол нэгдсэн төлөөллүүд оролцсон 4 сургалт зохиосон байх<br>• Тохирлын баталгаажуулалттай холбоотой нийтэд мэдлэг олгох аян зохиох | Азийн хөгжлийн банк | СХЗГ |

| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2: ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ, ТЭДГЭЭРИЙН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэм-бэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх бололцоотой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 2.4. Олон улсын түнш байгууллагуудад хүлээн зөвшөөрүү-лэхийн тулд, үндэсний чанарын дэд бүтцийг бэхжүүлэх | 2.4.2. Үндэсний чанарын дэд бүтцийг бэхжүүлэхэд оролцогч байгууллагууд, холбогдох яамд болон салбарын холбоод (жишээ нь ХХААХҮЯ, МХЕГ, ГЕГ, СХЗГ, итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагууд (лабораториуд, техникийн хяналтын ба баталгаажуулалтын байгууллагууд) эсхүл олон улсын байгууллагууд дундын хамтын ажиллагаар сайжруулах тогтолцоог бий болгох.<br>Механизм нь Ургамал амьтны эрүүл ахуй, хорио цээрийн олон улсын болон дотоодын стандартын арга хэмжээний ажлын хэсэг гэх мэт одоо байгаа бүтэц, тогтолцоонд суурилах.<br>Чиг үүрэг, үйлчилгээний давхардал, зохицуулалтгүй хэсгийг тодорхойлж, тэдгээрийг засах арга хэмжээ авах. | 2 | | | | | | • Хамтын ажиллагааны тогтолцоог бий болгосон байна.<br>• Үндэсний хяналт шинжилгээ, тохирлын үнэлгээ хийж, гэрчилгээ олгодог байгууллагуудыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх боломжуудыг нягталж үзсэн байна. | Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсад хэрэгжүүлж буй Бүс нутгийн ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг шинэчлэн сайжруулах замаар худалдааг дэмжих төсөл | СХЗГ<br>ХХААХҮЯ, МХЕГ, ГЕГ, итгэмжлэгд-сэн тохирлын үнэлгээний лабораториуд, байгууллагууд, холбогдох олон улсын байгууллагууд |
| | 2.4.3. Худалдааг хөнгөвчлөх зорилгоор техникийн зохицуулалтуудыг гаргах ба түүнтэй дүйцэхүйц тохирлын үнэлгээний журмын талаарх Харилцан хүлээн зөвшөөрсөн хэлэлцээрүүд/Тохиролцоог байгуулах эрх зүйн зохицуулагч хуулийн этгээдүүдийн чадавхийг бий болгох журам, механизмуудыг боловсруулан гаргах.<br>Тэргүүлэх ач холбогдолтой бүтээгдэхүүний талаарх үндэсний чанарын стандартыг олон улсын стандарт, жишигт үндэслэн бий болгох.<br>Хүнс болон хөдөө аж ахуйн салбарын экспортыг дэмжихийн тулд шаардлагатай баталгаажуулалтыг олгох талаарх МХЕГ-ын чадавхийг бэхжүүлэх замын зургийг бүтээх. | 2 | | | | | | • Багадаа 2 Харилцан хүлээн зөвшөөрсөн хэлэлцээр байгуулсан байна | СиАйТиЭй (CITA) (Азийн хөгжлийн банк) | Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо<br>СХЗГ<br>ХХААХҮЯ, МХЕГ, ГЕГ, итгэмжлэгд-сэн тохирлын үнэлгээний лабораториуд, байгууллагууд, холбогдох олон улсын байгууллагууд |
| | 2.4.4. Туршилтын хүрээнд төвлөрч ажиллах салбаруудад мөшгих тогтолцооны сургалт явуулах зэргээр мөшгих тогтолцооны (Тухайлбал, зураасан код гэх мэт) системийг бий болгож, үйл ажиллагаанд оруулах. Хамгийн тохиромжтой, тухайн орон нутагт зохицсон, ашиглахад хялбар технологийн талаар судалгаа хийх.<br>Малын халдварт өвчнөөс ангид, эрүүл ахуй хорио цээрийн нөхцлийг хангасан бүсүүдийг бий болгох бэлтгэл ажил | 2 | | | | | | • Сонгосон туршилтын салбаруудаа багадаа 30 хувьд чанарын мөшгих тогтолцоотой байх<br>• Эрүүл ахуй хорио цээрийн нөхцлийг хангасан бүсүүдийг бий болгох ажлыг хянах | ЭсДиСи Ногоон алт ба амьтны эрүүл мэнд төсөл<br>ЕХ ба ЭйВиЭсЭф: Свитч Эйжиа хөтөлбөрийн ЭсТиПи ЭкоЛаб төсөл<br>Тогтвортой ноос нолуурын эвсэл<br>НҮБ-ын ХХААБ | ХХААХҮЯ<br>СХЗГ<br>МХЕГ, ГЕГ, итгэмжлэгд-сэн тохирлын үнэлгээний лабораториуд, байгууллагууд, холбогдох олон улсын байгууллагууд |
| | 2.4.5. Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх | 2 | | | | | | • Хуулийг дагаж мөрдөх журмыг сурталчилан таниулж, бэлтгэл ажлыг хийх | | ХХААХҮЯ<br>СХЗГ |
| 2.5. Санхүү-гийн байгууллагууд болон ЖДҮ-ийн хоорондын орон зайг холбох гүүр болгож санхүүжилт авах боломжийг нэмэх | 2.5.1. Экспортын чиг баримжаатай компаниудад ээлтэй байх татварын бодлогод дүн шинжилгээ хийхийн тулд судалгаа явуулах, хувийн хэвшилтэй хэлэлцүүлэг хийх. | 2 | | | | | | • ЖДҮХС-ийн зээлийн үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн байх | | Сангийн яам<br>МҮХАҮТ<br>Монгол Улсын Хөгжлийн банк, ГХЯ |
| | 2.5.2. Экспортлогчдын хувьд зээл авах боломжийн талаарх зээлийн барьцааны тухай шинэ хуулийн нөлөөллийг тодорхойлохын тулд бүрэн дүүрэн үнэлгээг хийх. Зээлийн батлан даалтын сангийн барьцааны шаардлагыг бууруулах, уян хатан байдлыг нэмэгдүүлэх эрсдэлийн үнэлгээний шинэ хэрэгслийг бий болгох. | 1 | | | | | | • Үнэлгээ хийсэн, арга хэмжээг зохих ёсоор авсан байна.<br>• Эрсдэлийг үнэлэх шинэ хэрэгслийг бий болгосон байна | Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг төрөлжүүлэлт, хөдөлмөр эрхлэлтийн төслүүдэд зээлийн батлагаа гаргах тогтолцоог | Монгол банк |



TIR MON 1 - Final_Fi.indd 77
07.05.2020 09:16:32

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2: ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ, ТЭДГЭЭРИЙН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ

| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэм-бэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх боломжтой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 2.5. Санхүү-гийн байгууллагууд болон ЖДҮ-ийн хоорондын орон зайг холбох гүүр болгож санхүүжилт авах боломжийг нэмэх | 2.5.3. ЖДҮ-ийг Хөгжүүлэх сангаас зээл авах хүсэлт гаргаж буй компаниудад зориулан байгуулах нэг цэгийн үйлчилгээний хэрэгжих боломжийг тодорхойлох үүднээс техник эдийн засгийн үнэлгээ боловсруулах. Нэг цэгийн үйлчилгээг хэрхэн ашиглах талаарх компаниудын чадавхийг сайжруулах.<br>Судалгааны үр дүнд зөвлөсөн арга хэмжээг авах | 2 | | | | | | • Техник эдийн засгийн үнэлгээ хийсэн байна<br>• Судалгааны үр дүнд зөвлөсөн арга хэмжээг авсан байна | | Сангийн яам<br>Монгол Улсын Хөгжлийн банк, ГХЯ |
| | 2.5.4. ЖДҮ-ийн хэрэгцээ шаардлагыг санхүүгийн байгууллагууд мэдэрч ажилладаг байдлыг нэмэгдүүлэх үүднээс сургалт, урамшуулал, шинэ санхүүгийн бүтээгдэхүүн бий болгох зэргийг хэрэгжүүлэх. Санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх талаар хувийн хэвшил, ЖДҮ-ийн төлөөлөгчидтэй хамтран хэлэлцүүлэг зохиох. | 2 | | | | | | • Санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх талаар хувийн хэвшил, ЖДҮ-ийн төлөөлөгчидтэй хамтран жилд нэг удаа хэлэлцүүлэг зохиосон байна | Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжих төсөл болон Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байр бий болгох төсөл | Сангийн яам, Монгол Улсын Хөгжлийн банк, Монгол банк<br>ГХЯ |
| 2.6. Төрийн үйлчилгээг, төрийн удирдлагын олон улсын хамгийн өндөр стандартад нийцсэн тогтвортой, мэргэжлийн болгох | 2.6.1. Төрийн албаны тухай шинэ хуулийг 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болж хэрэгжүүлэхтэй холбоотойгоор олон улсын жишгийн дагуу шинээр батлан гаргах дүрэм журмыг олон нийтэд түгээх | 1 | | | | | | • Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх журмыг баталсан байна | | Монгол Улсын ЗГХЭГ |
| | 2.6.2. Төрийн удирдлагын чадавхийг бий болгох, эдийн засгийн бодлого боловсруулалтыг эрэмбэлэх, санхүүгийн менежмент, хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх, газар ашиглалтын төлөвлөгөө, хот төлөвлөлт (Эдийн засгийн онцгой бүс, аж үйлдвэрийн паркын төлөвлөгөө боловсруулах, менежмент зэрэг), төрийн худалдан авах ажиллагаа (ТХХТ ба төрөөс зарласан концессийн удирдлага) зэрэгт хөрөнгө оруулах. | 2 | | | | | | • Үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлсэн байна | СиАйТиЭй (CITA) (Азийн хөгжлийн банк) | Монгол Улсын ЗГХЭГ |

| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 3: ЗАХ ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА ХАНГАХ, МӨН ЭКСПОРТЫН ХАРИЛЦААГ ТОГТВОРТОЙ БАЙЛГАХ ЧИГЛЭЛЭЭР КОМПАНИУДЫГ ЧАДАВХЖУУЛАХ | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэмбэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх боломжтой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 3.1. Салбарын холбоодыг дэмжих, хувийн хэвшлийн салбар дахь зохицуулалтыг нэмэгдүүлэх | 3.1.1. Салбарын холбоод нь (i) дотроо зохион байгуулалтанд орж, эрх ашгаа хамгаалах (ii) төрийн бодлогын талаарх мэдээллийг түгээх, зах зээлд нэвтрэхэд нь чиглүүлэх, гишүүд нэг нэгнээсээ суралцах санаачлага гаргах зэргээр гишүүддээ үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх. | 1 | | | | | | • Аж үйлдвэрийн салбарын бүлгүүдийг ангилж, хувийн хэвшлийг хамруулсан байгууллагуудыг байгуулсан байна. | | ГХЯ, МҮХАҮТ<br>ХХААХҮЯ, Сангийн яам, хувийн хэвшлийн холбоод |
| | 3.1.2. Хамтарсан санаачилгууд болон тогтмол давтамжтай арга хэмжээ зохион байгуулах замаар одоогоор байгаа өөр өөр бизнесийн байгууллагууд болон салбарын холбоод хоорондын уялдаа холбоог сайжруулах. | 2 | | | | | | • Хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр батлуулсан байна;<br>• Жилд 2-оос доошгүй санаачилга/ арга хэмжээ зохиосон байна. | | ГХЯ, МҮХАҮТ<br>ХХААХҮЯ, Сангийн яам, хувийн хэвшлийн холбоод |
| | 3.1.3. Бизнесийн дуу хоолой болсон аж үйлдвэрийн салбарын холбоодыг сайжруулахад чиглэсэн хөтөлбөр бий болгох. Салбарын холбоодод зориулж тэдгээрийн бизнесийн үйл ажиллагааны үр нөлөөтэй байдлыг тодорхойлон үр ашгийг нэмэгдүүлэх байгууллагын хүчин чадлын харьцуулалтын хөтөлбөр зохион байгуулах. Хөтөлбөр нь стратеги ба засаглал, нөөц баялаг ба үйл ажиллагаа, бүтээгдэхүүн ба үйлчилгээ дуу хоолой болсон аж үйлдвэрийн салбарын холбоодыг сайжруулахад чиглэсэн хөтөСалбарын холбоодыг зорилтот тэргүүлэх ач холбогдолтой зах зээлд тэдний өрсөлдөгчтэйгөө хамтран ажиллахад нь дэмжих. | 2 | | | | | | • Байгууллагын хүчин чадлын харьцуулалтын судалгааг 10-аас доошгүй холбоодод зохион байгуулсан байна. | | ГХЯ, МҮХАҮТ<br>ХХААХҮЯ, Сангийн яам, хувийн хэвшлийн холбоод |
| 3.2. Боловсролын системийн санал болгож буй хөтөлбөрүүдийг байгууллагууд, нэн ялангуяа ЖДҮ-ийн хэрэгцээтэй уялдуулах | 3.2.1. Дараах үе шатуудыг дамжин, нэн ялангуяа ХХОЗЗ-ийн тэргүүлэх салбаруудад эдийн засаг дахь эрэлт хэрэгцээнд илүү тохирсон ур чадвар байх нөхцөлийг хангах:<br>• Аж үйлдвэрийн салбар болон академи/ боловсролын байгууллагууд хоорондын харилцан яриаг тодорхой албан ёсны хэлбэрт оруулах үүднээс Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөл болон тэдний салбарын түвшний Зөвлөлүүдтэй хамтран ажиллах хэлбэрийг дэмжиж ажиллах.<br>• Аж үйлдвэрийн салбарынхан болон академи/ боловсролын байгууллагууд хоорондын харилцаа холбоог нэгтгэхийн тулд хувийн хэвшил болон академи/ боловсролын байгууллагуудын дунд дугуй ширээний уулзалтыг тогтмол хийх.<br>• Тэргүүлэх ач холбогдолтой салбаруудад (нэн ялангуяа мэргэшсэн инженер, технологич) ур чадварын дутагдалтай талыг тогтоох дүн шинжилгээ хийж, холбогдох сургалтуудыг зохион байгуулах<br>• Аж үйлдвэрийн салбарынханы хувьд удаан хугацаанд хөөцөлдөж буй эрэлт хэрэгцээг академи/ боловсролын байгууллагуудын санал болгож буй хөтөлбөрүүдэд хөрвүүлэн тусгаж, анхдагч сургалт, мэргэжлийн боловсролын үргэлжилсэн сургалтаас бүрдэх тусгай сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулах.<br>• Мэргэжлийн сургалт явуулдаг сургуулиудын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг аж үйлдвэрийн салбарын хэрэгцээ шаардлагатай уялдуулан шинэчлэх.<br>• Ерөнхий боловсролын дунд сургуулиудад үйлдвэрүүдэдтэй танилцах аялал хийх зэргээр олон нийтийг хамарсан үндэсний компанит ажил, семинар зохион байгуулах замаар залуу үе, эцэг эхчүүдэд Техник мэргэжлийн боловсрол сургалтыг сурталчилан таниулах | 1 | | | | | | • Тэргүүлэх ач холбогдолтой салбарт ур чадварын дүн шинжилгээг хийж, эрэлт нийлүүлэлтийг шинжлэн судалсан байна.<br>• Ур чадварын эрэлт хэрэгцээний зураглалд үндэслэн боловсрол, сургалтын хөтөлбөрүүдийг шинэчилсэн байна.<br>• Бүтээгдэхүүн дээрээ ажиллах сургалтыг зохион байгуулсан байна. | | Боловсрол соёл шинжлэх ухааны яам (БСШУЯ), ХНХЯ<br>ГХЯ, ХХААХҮЯ, МҮХАҮТ, хувийн хэвшлийн холбоод |
| | 3.2.2. ерөнхий боловсролын дунд сургуульд гадаад хэлний боловсрол (сурагч Англи эсхүл Хятад хэлийг өөрөө сонгоно)-ыг албан ёсоор олгох төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх | 3 | | | | | | • Төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байна.<br>• Англи болон Хятад хэлний сургалтын хөтөлбөрийг шинэчлэн бүх ангиудад олгох | | БСШУЯ, ХНХЯ<br>МСҮТ, салбарын мэргэжлийн холбоод |
| | 3.2.3. Машин механизмын удирдлага, нэхмэл, хөдөө аж ахуйн боловсруулалт зэрэгт дадлагажих, дагалдан ажиллах, гардан суралцахад чиглэсэн боловсруулах үйлдвэрлэл дэх мэргэжлийн сургалтыг ерөнхий боловсролын сургуульд санал болгох | 3 | | | | | | • Боловсруулах үйлдвэрлэлд сургалт зохион байгуулахыг хөтөлбөр боловсруулсан | | БСШУЯ, ХНХЯ |

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 3: ЗАХ ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА ХАНГАХ, МӨН ЭКСПОРТЫН ХАРИЛЦААГ ТОГТВОРТОЙ БАЙЛГАХ ЧИГЛЭЛЭЭР КОМПАНИУДЫГ ЧАДАВХЖУУЛАХ**

| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэмбэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх бололцоотой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 3.2. Боловсролын системийн санал болгож буй хөтөлбөрүүдийг байгууллагууд, нэн ялангуяа ЖДҮ-ийн хэрэгцээтэй уялдуулах | 3.2.4. Монгол Улсын Их Сургуульд байдагтай адил бизнес, олон улсын харилцааны сургалтын хөтөлбөрүүдийг бэхжүүлэн өргөжүүлэх ба тэдгээр хөтөлбөрүүдийг Монгол Улсын худалдаа, хөрөнгө оруулалтын хэрэгцээтэй (жишээ нь хөдөө аж ахуйн боловсруулсан бүтээгдэхүүний хил дамнуулан худалдаалах) уялдсан, өргөдлийн журмаар элсэж суралцаад гэрчилгээ авах сургалтын хэлбэрийг илүү хүртээмжтэй болгох. | 2 | | | | | | • Боловсруулах үйлдвэрлэлд сургалт зохион байгуулахыг хөтөлбөр боловсруулсан | | БСШУЯ, ХНХЯ |
| | 3.2.5. Улам олон оюутан, төрийн албан хаагчид, үйлдвэрлэлийн салбарын ажилтнуудыг хамруулахын тулд Монгол Улс болон тус улсын тэргүүлэх худалдаа, хөрөнгө оруулалтын түншүүд нарын хоорондох олон улсын солилцооны хөтөлбөрийг өргөжүүлэх | 2 | | | | | | • Солилцооны хөтөлбөрүүдийг өргөжүүлэхийн тулд хамгийн багадаа 3 Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан байна | | БСШУЯ, ХНХЯ<br>ГХЯ ба худалдаа, хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх холбогдох байгууллагууд |
| | 3.2.6. Бодлогын орчныг тодорхой болгож, тулгарч буй саад бэрхшээлтэй асуудлыг хөндөж, нөөц боломжийн талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх замаар, хувийн хэвшлийн салбарынханыг МСҮТ-ийн салбар болон үр чадвартай хүний нөөцийг бэлтгэх зорилтот ажилд илүү ихээр татан оролцуулах, үүнд 60% нь дадлага туршлага хуримтлуулах чиглэлээр зохион байгуулах.<br>Улмаар засварлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | 2 | | | | | | • МСҮТ-ийн салбарт хувийн хэвшлийн салбарынхан илүү өргөн хүрээнд оролцож ажиллахад тулгарч буй саад бэрхшээлүүд болон нөөц боломжтой талуудыг нягтлан үзэх,<br>• Засварлах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна | Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны агентлаг | БСШУЯ<br>МҮХАҮТ, хувийн хэвшлийн холбоод |
| | 3.2.7. Судалгаа хийх замаар тэргүүлэх ач холбогдолтой салбаруудад мэргэжлийн сургалт боловсролын үргэлжилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжуудыг үнэлэх<br>• Техникийн ур чадварт төвлөрсөн боловсролын үргэлжилсэн сургалтыг хөгжүүлэхийн тулд тэргүүлэх салбарыг (тухайлбал махны) сонгох.<br>• Сонгосон салбарт зориулсан сургалтын хөтөлбөр болон сургалтын хэрэглэгдэхүүнийг бий болгох. Үүнд дараахыг хамруулах:<br>- Насанд хүрэгчид нэг нэгнээсээ суралцах бүлгүүд.<br>- Хамтран ажиллагч удирдагч нараас суралцах ба мэдээлэл солилцох<br>• Шаардлагатай тохиолдолд зохицуулагч нарыг сургасан байних | 2 | | | | | | • Туршилтын төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна | Монголын боловсрол, сургалтын хамтын ажиллагааны төв | БСШУЯ,<br>хувийн хэвшлийн холбоод |
| 3.3. Бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд таниулах ААН/ компаниудын чадавхийг сайжруулах | 3.3.1. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаас одоогоор нээсэн худалдааг хөнгөвчлөх хоорондоо ялгаатай, олон тооны "цонхнуудыг" нэгтгэх замаар худалдааг хөнгөвчлөх цогц, олон талт нэг цонхны систем хэрэгжүүлэх.<br>Хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэгч байгууллагуудтай нягт хамтран ажиллах замаар нэг цонхны бодлогыг үе шаттайгаар хөгжүүлэхийн тулд хамтын зорилт, хүрэх хугацааг тодорхойлсон хөтөлбөр боловсруулах | 1 | | | | | | • Гадаад худалдааны нэг цонхны бодлогыг хэрэгжүүлсэн байна | Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл (Азийн хөгжлийн банк) | ГХЯ, МҮХАҮТ,<br>ГЕГ |
| | 3.3.2. ААН/ Компаниудад, "Гадаад худалдааны нэг цонхны систем"-ийг ашиглахад нь зориулж, хувийн хэвшлийн холбоодтой хамтран семинар (бүсүүдийг хамарсан) зохион байгуулах замаар компани/ ААН-үүдийн чадавхийг бэхжүүлнэ. | 2 | | | | | | • Улаанбаатар хот болон бүсүүдэд 10 семинар зохион байгуулсан байна | Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл (Азийн хөгжлийн банк) | ГХЯ, МҮХАҮТ<br>ГЕГ |

| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 3: ЗАХ ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА ХАНГАХ, МӨН ЭКСПОРТЫН ХАРИЛЦААГ ТОГТВОРТОЙ БАЙЛГАХ ЧИГЛЭЛЭЭР КОМПАНИУДЫГ ЧАДАВХЖУУЛАХ | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэмбэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх боломжтой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 3.3. Бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд таниулах ААН/компаниудын чадавхийг сайжруулах | 3.3.3. Экспортын зах зээл дэх худалдааны нөхцөл, худалдаан дахь тарифын болон тарифын бус хязгаарлалтууд (Ургамал амьтны эрүүл ахуй, хорио цээрийн олон улсын болон дотоодын стандартын арга хэмжээ ба Худалдааны техникийн хязгаарлалтын талаарх мэдэгдэл зэргийг оруулан)-ийн талаар тодорхой, салбараар тусгайлсан цахим болон бусад мэдээллийн материалыг бэлтгэж, тогтмол шинэчлэх.<br>• Аж үйлдвэрийн салбарынханы бүлгүүдтэй хамтран ААН/ компаниудад зориулан худалдаанд дагаж мөрдөх зүйлсийн талаар тогтмол семинар зохион байгуулах.<br>• Баталгаажуулалтын байгууллагаар худалдаанд дагаж мөрдөх зүйлс болон баталгаажуулалтын талаар дотоодын аудит хийлгүүлж, шалгах хуудас бэлтгэн түгээх.<br>• Экспортын зах зээл дэх ургамал амьтны эрүүл ахуй, хорио цээрийн олон улсын /болон дотоодын/ стандартын арга хэмжээ болон бусад журмуудад орсон өөрчлөлтийг ААН/ компаниудад мэдэгдэх харилцаа холбооны тогтолцоонуудыг сайжруулах.<br>• Экспортод тавигддаг шаардлагууд болон чанарын түвшинг хангах мэдлэг болон ур чадварыг сайжруулах чиглэсэн, сургалт зохион байгуулах чиглэлээр малчид, тариаланчидтай хамтран ажиллах<br>Худалдааны бодлого, зах зээлд нэвтрэх боломж, хөрөнгө оруулалтын талаар аж үйлдвэрийн салбарын бүлгэмүүдтэй харилцах илтгэгчдийг сургах. | 1 | | | | | | • Худалдааны мэдээлэл ба ААН/компаниудын дагаж мөрдөх зүйлсийн тухай цахим хэрэгслийг хөгжүүлж, бэлэн болгосон байна<br>• Аж үйлдвэрийн салбарын бүлгэм тус бүрт 5 илтгэгчийг сургасан байна<br>• Улирал бүрт семинар зохиосон байна<br>• Шалгах хуудсыг бэлтгэн, олон нийт ашиглахад бэлэн болгосон байна | Монголын боловсрол, сургалтын хамтын ажиллагааны төв<br>Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл (Азийн хөгжлийн банк)<br>Монгол Улсад хэрэгжүүлж буй Бүс нутгийн ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг шинэчлэн сайжруулах замаар худалдааг дэмжих төсөл (Азийн хөгжлийн банк) | ГХЯ, ХХААХҮЯ |
| | 3.3.4. Хөрөнгө оруулалт, хамтарсан ААН/компани байгуулах болон харилцагч-нийлүүлэгчийн харилцаа үүсгэх зэргээр гадаадын ААН/компаниудтай хамтран ажиллах болон олон улсын хөрөнгө оруулалтаас үр ашиг хүртэх арга замыг ААН/ компаниудад олгоход чиглэсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулах.<br>Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад дээрх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр гадаадын ААН/компаниудтай хамтран ажиллах боломжийг судлан, тодорхойлох. | 1 | | | | | | • Хөтөлбөрийг боловсруулан зохицуулагч нарыг сургасан байна | | ҮХГ, МҮХАҮТ<br>ГХЯ |
| | 3.3.5. ЖДҮ болон экспортлогчдод зориулж, хэрхэн харилцан ашигтай гэрээ байгуулах талаар тэдэнд хууль эрх зүйн мэдлэг олгох богино хугацаатай сургалтыг зохион байгуулах | 2 | | | | | | • ХХААХҮЯ-наас зохион байгуулдаг улирал тутмын богино хугацаатай сургалтын агуулга, хэлбэрийг сайжруулж, тоо хэмжээг нэгээс доошгүй хэмжээгээр нэмэгдүүлсэн байна. | | ГХЯ, МҮХАҮТ<br>ХХААХҮЯ |
| | 3.3.6. Салбарын холбоод болон ХХОЗЗ-ийн тэргүүлэх ач холбогдолтой салбаруудаас сонгогдсон жижиг дунд үйлдвэрлэгчдийн хэсэгт өгөх тусгай зөвлөх үйлчилгээнүүд:<br>• Зах зээлийн судалгаа ба дүн шинжилгээ<br>• ААН/Компаниудын үнэ цэнийн баталгаа, брэндийн хүчин чармайлтыг үнэлэх<br>• Жинхэнэ хэрэглэгч нар болон мэргэжлийн худалдан авагчдын туслалцаатайгаар бүтээгдэхүүний эрэлтийг турших<br>• Зах зээлийн шаардлагад тохирсон, бүтээгдэхүүний давуу талын харуулсан сав, баглаа боодол бүтээхэд зөвлөх<br>• Брэндийг олон нийтэд таниулах: Салбар, зах зээлд дасан зохицсон брэнд төлөвлөлт, төсөл зохиолт, хэрэгжүүлэлтийн талаарх хамгийн шилдэг туршлагаас суралцах<br>• Брэнд төлөвлөлт: Дизайн загвар хийц, харилцаа холбоо тогтоох ба бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд ашиглах төлөвлөгөө зохиох.<br>• Брэндийн иж бүрдэл: Брэндийн дизайн зохиомжтой холбогдсон маркетингийн нэмэлт хангамжийг төлөвлөж, бүтээх. | 2 | | | | | | • Богино сургалтыг жил бүр зохион байгуулсан байна<br>• ААН/Компаниудад тусгайлсан үйлчилгээг бэлэн болгосон байна | Эрх мэдэлтэй иргэд – сайжирсан амьжиргаа, Европын холбоо ба Бүгд найрамдах Чех Улсын Хөгжлийн газар<br>Монголын боловсрол, сургалтын хамтын ажиллагааны төв | Монголын Үндэсний Брэндийн зөвлөл, МҮХАҮТ<br>ГХЯ, ХХААХҮЯ, Хувийн хэвшлийн байгууллагууд |

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 3: ЗАХ ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА ХАНГАХ, МӨН ЭКСПОРТЫН ХАРИЛЦААГ ТОГТВОРТОЙ БАЙЛГАХ ЧИГЛЭЛЭЭР КОМПАНИУДЫГ ЧАДАВХЖУУЛАХ

| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэмбэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх бололцоотой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 3.3. Бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд таниулах ААН/ компаниудын чадавхийг сайжруулах | 3.3.7. Зорилтот зах зээлд тэргүүлэх ач холбогдолтой салбаруудыг онцолсон, зах зээл дотор нь худалдааг сурталчлах үйл ажиллагааг өргөжүүлэх.<br>• Гадаадын ААН/компани болон хөрөнгө оруулах боломжтой этгээдүүд Монгол Улсаас хамтрагч олох явцыг хялбарчлах үүднээс Бизнесээс бизнес рүү чиглэсэн загвар болон хамтрагч түншээ олох үйлчилгээг хэрэгжүүлэх.<br>• Монголын ААН/компаниудын олон улсад танигдах байдлыг сайжруулах, олон улсын худалдан авагч нартай танилцах боломж олгох үүднээс олон улсын худалдааны үзэсгэлэн, яармагт идэвхтэй оролцуулах.<br>• Монголын экспортлогчдыг дэмжих хөшүүрэг болгох үүднээс худалдааны уулзалтууд зохион байгуулах.<br>• Дотоодын бүтээгдэхүүнүүдийг олон улсын худалдааны үзэсгэлэн яармагуудад оруулж дэмжих.<br>• Зах зээлийн харилцаа холбоог хөгжүүлэхийн тулд худалдааг хөнгөвчлөх хоёр талт хэлэлцүүлгийг зохион байгуулах. | 1 | | | | | | • Бизнесээс бизнес рүү чиглэсэн болон хамтрагч түнш олох үйлчилгээний тоо нэмэгдсэн<br>• Монголын ААН/компаниудын худалдааны үзэсгэлэн яармаг дахь оролцоо нэмэгдсэн<br>• Худалдааг хөнгөвчлөх хоёр талт уулзалтын тоо нэмэгдсэн байна | Дэлхийн банкны Экспортыг дэмжих төсөл | ГХЯ, МҮХАҮТ<br>ХХААХҮЯ,<br>Хувийн хэвшлийн байгууллагууд |
| | 3.3.8. Экспортлогч нарыг тусгайлсан зах зээлийн судалгаагаар хангах боломжтой бие даасан зөвлөхүүд, бизнес эрхлэгчдийн талаарх мэдээллийн санг ХХААХҮЯ-нд үүсгэх. | 2 | | | | | | • Мэдээллийн санг боловсруулан олон нийт ашиглах боломжтой болгосон байна | | ГХЯ, ХХААХҮЯ, МҮХАҮТ<br>Хувийн хэвшлийн байгууллагууд |

**СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4: БИЗНЕС ЭРХЛЭХ УР ЧАДВАР, ГАРААНЫ БИЗНЕСИЙН ОРЧИН НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛЖ, МЭДЛЭГТ СУУРИЛСАН САЛБАРУУДРУУ НЭВТРЭХ ЗАМААР ИННОВАЦИ, БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ**

| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэмбэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх боломжтой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 4.1. Гарааны бизнесүүдэд зориулсан журмыг хялбарчилж, ил тод байдлыг нэмэгдүүлэх | 4.1.1. Гарааны бизнес эрхлэхэд ихээхэн хүндрэл учруулсан, бүхий л хэрэгцээгүй нөхцөл шаардлагуудыг олж тогтоон, хүчингүй болгох. Эдгээр журам, дүрэм, зөвшөөрлүүдийг засварлахад шаардлагатай арга хэмжээг авах. | 1 | | | | | | • Засварлах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлсэн байх | | Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар<br>ГЕГ, МХЕГ, ГХЯ, ХХААХҮЯ, МҮХАҮТ, хувийн хэвшлийн холбоод, инкубаторууд |
| | 4.1.2. Ил тод байдал болон урьдчилан таамаглах байдлыг нэмэгдүүлэхийн тулд бизнесийн бүхий л бүртгэлийн шаардлагууд болон дүрэм журмыг олон нийтэд нээлттэй болгох. | 1 | | | | | | • Бизнесээ бүртгүүлэхэд тавих шаардлагуудыг холбогдох цахим хуудсуудад нээлтэй болсон байна | | Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар<br>ГХЯ, ХХААХҮЯ, МҮХАҮТ, хувийн хэвшлийн холбоод |
| | 4.1.3. Бизнес эхлүүлэхэд ямар журмыг дагах, ямар алхмууд хийх шаардлагатай тухай хураангуй мэдээлэл бүхий товч зааварчилгаа бэлтгэх, мөн холбогдох мэдээллийг аж ахуй эрхлэгч нарт тогтмол түгээх товч зааварчилгаар бэлдэж, хөтөлбөр боловсруулах. Өнөөгийн болон шинээр гарах дүрэм журмуудыг талаар мэдээлэл өгөх үүднээс бизнесийн холбоод болон гарааны бизнес эрхлэгч нартай тогтмол уулзалт зөвлөгөөнүүдийг хийх. | 2 | | | | | | • Богино хэмжээний удирдамж бэлэн болсон байх<br>• Улирал тутам журмуудтай холбогдолтой зөвлөгөөн хийх | | Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, МҮХАҮТ |
| | 4.1.4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай шинэчилсэн хуультай (2015) уялдуулан бизнесийн цахим бүртгэлийг боловсруулан хөгжүүлж, эхлүүлэх. | 1 | | | | | | • Бизнесийн цахим бүртгэл бэлэн болсон байна. | | Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| | 4.1.5. Экспортод чиглэсэн гарааны бизнесийг татвараас чөлөөлөх, түүхий эд, үндсэн бараанд татварын хөнгөлөлт олгох зэргээр урамшуулал олгох. | 2 | | | | | | • Урамшууллаа тодорхойлоод хэрэгжүүлсэн байна. | | Сангийн яам<br>МҮХАҮТ, Монголын гарааны бизнес, хувийн хэвшлийн холбоод |
| 4.2. Бизнес эрхлэх боловсролыг дэмжих, инженер, техникийн ажилтнуудыг бэлтгэн нийлүүлэлтийн чанар, тооны түвшинг сайжруулах, боловсролын байгууллага болон боловсруулах үйлдвэрүүдийн хооронд дахин нягт харилцаа холбоо тогтоох замаар үр дүнтэй сургалтын хөтөлбөр боловсруулах | 4.2.1. Дараах хоёр зорилгоор бизнес эрхлэлтийг боловсролын бүхий л түвшинд таниулах хөтөлбөр боловсруулах :<br>• Бизнес эрхлэх хандлагыг оюутнуудад бий болгох, ба оюутнууд бизнесээ эхлүүлж удирдахад нь холбогдох мэдлэг, чадварыг суулгаж өгөх<br>• Хувийн хэвшлийн холбоод болон малчид тариаланчдыг хамруулсан бусад гол хамтрагч талуудтай хамтарсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалт ба хүмүүжүүлэн зөвлөх арга зэргийг багтаасан үйл ажиллагаанд оролцохыг нь дэмжих. | 1 | | | | | | • Хөтөлбөр тодорхойлоод (хэрэгжилтийг хангах үүрэгтэй яамд, агентлагууд, хөгжлийн түнш байгууллагууд) хэрэгжүүлсэн байх | Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны агентлаг | БСШУЯ МҮХАҮТ<br>ХНХЯ, хувийн хэвшлийн холбоод |
| | 4.2.2. Мэргэжил сонголтын нэгэн боломж гэж ойлголт өгөх болон бизнесийн эрт үеийн практик боломжуудаар хангахын тулд бизнес эрхлэлт, боловсруулах үйлдвэрлэл, шинэ бүтээгдэхүүний судалгаа ба хөгжүүлэлттэй холбоотой боловсролыг бага болоод дунд сургуулиудад нэвтрүүлэх санаачлагыг турших.<br>• Сургалтын чанар, элсэлтийн түвшин, дэд бүтэц гэх мэт дээр суурилан дунд сургуулиудаас шалгаруулж туршилтад ашиглах<br>• Шилдэг туршлага дээр тулгуурлан сургалтын материалууд бүхий бизнес эрхлэх сургалтын модуль хөгжүүлэх. Тус модуль нь дараах үйл ажиллагаануудыг багтааж болно:<br>• Хийнгээ суралцах: бизнесийг багаар босгох болон авч явах арга туршлагыг олгох<br>• Үлгэрлэгчид: манлайлагчдыг урьж оюутнуудтай харилцан ярилцуулах<br>• ААН/Компаниудаар зочлох<br>• Шалгарсан дунд сургуулиудын багш нарыг сургаж эдгээр модулиудыг түгээх | 2 | | | | | | • Туршилтаа тодорхойлсон мөн 25 дунд сургуулиудад эхлүүлсэн байх | | БСШУЯ, МҮХАҮТ<br>хувийн хэвшлийн холбоод |

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4: БИЗНЕС ЭРХЛЭХ УР ЧАДВАР, ГАРААНЫ БИЗНЕСИЙН ОРЧИН НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛЖ, МЭДЛЭГТ СУУРИЛСАН САЛБАРУУДРУУ НЭВТРЭХ ЗАМААР ИННОВАЦИ, БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ ХӨХИУЛЭН ДЭМЖИХ

| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэмбэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх боломцоотой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 4.2. Бизнес эрхлэх боловсролыг дэмжих, инженер, техникийн ажилтнуудыг бэлтгэн нийлүүлэлтийн чанар, тооны түвшинг сайжруулах, боловсролын байгууллага болон боловсруулах үйлдвэрүүдийн хооронд дахин нягт харилцаа холбоо тогтоох замаар үр дүнтэй сургалтын хөтөлбөр боловсруулах | 4.2.3. Техник, мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдэд туршилтын арга замаар бизнес эрхлэлтийн сургалтыг нэвтрүүлэх ажлыг албан ёсны болгох. Үндэсний болон бүсийн санаачлагуудаас сурсан сургамж туршлагыг цуглуулах.<br>• Техник, мэргэжлийн боловсрол сургалтын түвшинд зориулсан, хийнгээ суралцдаг ойлголтыг дэмждэг, бизнес эрхлэлтийн боловсролын хөтөлбөрийг тусгайлан боловсруулах. Дараах 3 гол салбарын сэдвүүд багтана:<br>- Зөөлөн ур чадвар (жишээ нь багийн хамтын ажиллагаа, шүүмжлэлт сэтгэлгээ, асуудлыг шийдвэрлэх чадвар)<br>- Үндсэн ур чадвар (жишээ нь тооны, мэдээлэл, харилцааны технологи, харилцаа холбоо)<br>- Бизнесийн ур чадвар (жишээ нь туслан гүйцэтгүүлэх гэрээ байгуулах, мэргэшсэн салбартаа бага хэмжээний бизнесээ хэрхэн эхлүүлэх, зах зээлийн судалгаа)<br>• Тухайн нөхцөл, зорилтот судалгаа, үлгэр жишээ манлайлагч нарт таарuulсан бизнес эрхлэх ерөнхий ур чадварын боловсролын материал бэлтгэх. Мэдээлэл, харилцааны технологийг сургалтанд уялдуулан оруулах.<br>• Бизнес эрхлэлтийн талаарх хичээлийг заахаар сонгогдох багш нарт тусгайлан зориулсан сургалт зохион байгуулах. Мэдээлэл, харилцаа холбоо технологийг хичээлд нь оруулах<br>• Сургалтанд хамрагдсан төгсөгчдийг цаашид хянаж байх системийг бий болгох.<br>Бусад Техник, мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдэд хөтөлбөрийг хэрэглэж, түгээн дэлгэрүүлэх | 1 | | | | | | • Туршилтаа тодорхойлж, 20 Техник, мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдэд эхлүүлсэн байх | | БСШУЯ, ХНХЯ<br>МҮХАҮТ, МСҮТ Холбоо |
| | 4.2.4. Үндэсний болон олон улсын хэмжээнд хуримтлуулсан арга туршлага, үр дүнд суурилсан судалгаа, сургамжуудыг харилцан солилцох зорилго бүхий бизнес эрхлэлтийн сургалтын багш нарын сүлжээг бий болгох. Уг сүлжээ нь амжилттай яваа бизнес эрхлэгчдийн мэдээллийн санг үүсгээд зогсохгүй ирээдүйн бизнес эрхлэгчдийн сургагч нь болох боломжийг бий болгоно. Энэхүү агуулгын дор, Шинжлэх ухаан технологийн их сургууль (ШУТИС), Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС), Монгол Улсын их сургууль (МУИС) зэрэг их сургуулиудын бизнесийн удирдлага, маркетинг, борлуулалт, салбар дундын мэргэжлийн чиглэлээр суралцаж буй оюутнуудын хооронд холбоо тогтоох | 3 | | | | | | • Сүлжээг бий болгосон байх<br>• Шилдэг туршлагуудын мэдээллийн санг үүсгэж нээлттэй болгосон байх | | • Сүлжээг бий болгосон байх<br>• Шилдэг туршлагуудын мэдээллийн санг үүсгэж нээлттэй болгосон байх<br>• Сүлжээг бий болгосон байх<br>• Шилдэг туршлагуудын мэдээллийн санг үүсгэж нээлттэй болгосон байх |
| | 4.2.5. ХХОЗЗ-ийн тэргүүлэх ач холбогдолтой салбаруудыг хамруулсан мэдээлэл, ажил мэргэжлийн үзэсгэлэнтэргүүлэхажил мэргэжлийн уралдаан, бизнес боломжуудын талаар форум зэргийг зохион байгуулах. | 2 | | | | | | • Жилд нэг удаа ХХОЗЗ-ийн тэргүүлэх ач холбогдолтой салбарыг хамруулсан ажил мэргэжлийн яармаг<br>• Жилд нэг удаа ХХОЗЗ-ийн тэргүүлэх ач холбогдолтой салбарыг хамруулсан ур чадварын тэмцээн<br>• Жилд нэг удаа ХХОЗЗ-ийн тэргүүлэх ач холбогдолтой салбарыг хамруулсан бизнесийн боломжийн талаарх хэлэлцүүлэг | | БСШУЯ ба ГХЯ<br>ХНХЯ, МҮХАҮТ, ХХААХҮЯ<br>инкубаторууд |
| | 4.2.6. Монголын шилдэг жишээ бүхий ЖДҮ, гарааны бизнес эрхлэгчдийг тодорхойлж, дээд боловсролын байгууллагуудыг төгсөөд гарсан "амжилттай яваа тэргүүний" бизнес эрхлэгчидтэй хурал зохион байгуулах. | 2 | | | | | | • Тэргүүлэх салбар бүрээс 5 аварга тодорхойлоод оролцуулсан байх<br>• Жилд нэг удаагийн хурал зохион байгуулсан байх | | БСШУЯ, ГХЯ,<br>ХХААХҮЯ, ХНХЯ, МҮХАҮТ,<br>инкубаторууд |
| | 4.2.7. Салбар хоорондын нягт хамтын ажиллагааг дэмжих буй семинар, ажлын санал тавих уулзалт сургалт, бизнес төлөвлөгөөний уралдаануудыг зохион байгуулах замаар их сургуулиудын дэргэдэх Оюутан Бизнес эрхлэгчийн Клубуудыг батжуулах. | 3 | | | | | | • Жилд нэг удаа семинар, ажлын санал тавих сургалт, бизнес төлөвлөгөөний уралдаануудыг их сургуулиудын дэргэдэх Оюутан Бизнес эрхлэгчийн Клубууд дунд зохион байгуулах | | БСШУЯ, ГХЯ<br>ХНХЯ, МҮХАҮТ,<br>инкубаторууд |
| | 4.2.8. Бизнес эрхлэгчдэд зориулан тогтмол уулзалт зохион байгуулах, зөвлөх болон хувиараа аж ахуй эрхлэх сургалтуудыг зохион байгуулахын тулд нийгмийн сүлжээг бий болгоно | 2 | | | | | | • Төгсөгчдийн сүлжээ бий болсон байх | | БСШУЯ, ХНХЯ, МҮХАҮТ,<br>инкубаторууд |

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4: БИЗНЕС ЭРХЛЭХ УР ЧАДВАР, ГАРААНЫ БИЗНЕСИЙН ОРЧИН НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛЖ, МЭДЛЭГТ СУУРИЛСАН САЛБАРУУДРУУ НЭВТРЭХ ЗАМААР ИННОВАЦИ, БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ ХӨХИУЛЭН ДЭМЖИХ

| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэмбэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх боломжтой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 4.3. Гарааны бизнес эрхлэгч нарт хүрч ажиллаж, хангалттай хэмжээний үйлчилгээг хүргэхийн тулд инкубаторуудын чадавхийг бэхжүүлэх | 4.3.1. Гарааны бизнесийг тэмдэглэх болон бий болсон бизнес инкубаторуудыг (жишээ нь Мэдээлэл, Технологийн Үндэсний Парк, МҮХАҮТ Инкубатор төв, Монголын Старт ап/Гарааны бизнесс) үнэлэх зорилгоор олон улсын жишиг хэмжээтэй харьцуулан судалгаа явуулах.<br>Хэрэгцээтэй нь тогтоогдсон тохиолдолд чадавхийг бий болгох. | 1 | | | | | | • Жишиг хэмжээг тогтоох судалгаа явуулсан байх ба чадавхи бүрдүүлэх ажил хийгдсэн байх | | ГХЯ, ХХАХҮЯ<br>Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, ҮХГ, МҮХАҮТ, Монголын гарааны бизнес, хувийн хэвшлийн холбоод |
| | 4.3.2. Монголын Эдийн засгийн хөгжлийн бодлого (болон түүний орон зайн төлөвлөлтийн ашиглалт) болон жишиг хэмжээг тогтоох судалгаан дээр үндэслэн шинэ инкубаторуудыг үүсгэн байгуулахыг дэмжих болон хуучин инкубаторуудыг өргөжүүлэх боломжийг дүгнэх.<br>Гарааны үе шатны дараа бизнес санаанд үнэлгээ өгөх, харилцаа холбооны сүлжээнд хамрагдахад нь тусламж олгох, дадлагажуулж сургах зэрэг үйлчилгээнүүдийг багтаасан туршилтын санаачлагыг хөгжүүлэх. Дараах богино хэмжээний сургалтууд байх:<br>• Хэрхэн бизнес төлөвлөгөөг боловсруулах вэ?<br>• Хөдөлмөрийн хуулийн талаарх танилцуулга<br>Мөн түүнчлэн, бүтээгдэхүүнээ экспортлохыг зорьж буй гарааны бизнес эрхлэгч нарт үйлчилгээ нэвтрүүлэх. Төгссөн гарааны бизнес эрхлэгч нарын ахиц дэвшлийг хянах, араас нь холбоотой ажиллах механизмыг тус тус хөгжүүлэх | 1 | | | | | | • Туршилтын санаачилга боловсруулж, тогтсон байх | | ГХЯ, ХХАХҮЯ<br>ҮХГ, МҮХАҮТ, Монголын гарааны бизнес, хувийн хэвшлийн холбоод, инкубаторууд |
| | 4.3.3. Мэдээлэл харилцаа холбоо, технологийн салбар болон ноос, ноолуурын салбар зэрэг ХХОЗЗ-ийн тэргүүлэх салбарууд дахь их сургууль, Техник, мэргэжлийн боловсрол сургалтын төвүүд болон инкубатор төвүүдэд сургалтын болон дадлагажуулах үйлчилгээгээр хангах санаачилгыг эхлүүлэх:<br>• Хувийн хэвшлийн байгууллагуудаас болон амжилттай яваа бизнес эрхлэгчид дундаас сургагч багш, зөвлөхөөр ажиллаж чадах мэргэжилтнүүдийг тодорхойлох.<br>• Ганцаарчилсан дадлагажуулах сургалтын үйлчилгээгээр хангах сургагч нарыг бэлтгэх.<br>• Холбогдох холбоод, төрийн байгууллагууд болон Техник, мэргэжлийн сургалтын төвүүдийн холбооны олон нийтийн сүлжээ болоод цахим хуудсаар нь дамжуулан нөлөөлөл болон амжилтын түүхийг нь сурталчилан таниулах | 1 | | | | | | • Санаачилга эхлүүлсэн байх | | БСШУЯ, ХНХЯ<br>МСҮТ Холбоо, МҮХАҮТ |
| | 4.3.4. Бизнес инкубаторуудаар дамжуулан сонгосон гарааны бизнест хэрхэн санхүүжилт авах талаар сургалт явуулах. Дараах сэдвүүдийг багтаана. Үүнд:<br>• Гарааны бизнес эрхлэгч нарт зориулагдсан зээл, санхүүжилтийн бүтээгдэхүүн болон үйлчилгээнд хамрагдах талаар хэрхэн хүсэлт гаргах вэ<br>• Хэрхэн хөрөнгө оруулагчдад бизнесийн санаагаа танилцуулж, санхүүжилт хайх вэ | 2 | | | | | | • Инкубаторуудаар дамжуулан хөгжүүлсэн сургалтаа хэрэгжүүлсэн байх | | ГХЯ, ХХААХҮЯ<br>Арилжааны банкууд |
| | 4.3.5. Гарааны бизнес эрхлэж буй ААН/компаниудын хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд татварын урамшууллын схемийн боломжит загварт дүн шинжилгээ болон үнэлгээ хийх. | 2 | | | | | | • Техник, эдийн засгийн үндэслэл бүхий судалгааг боловсруулсан байх<br>• Санхүүгийн урамшуулал олгогдсон байна | | Сангийн яам, МҮХАҮТ<br>Монголын гарааны бизнес, хувийн хэвшлийн холбоод |
| | 4.3.6. Гарааны бизнесс эрхлэгч нарыг хувийн хөрөнгө оруулагчидтай холбох харилцаа холбооны сүлжээг өргөжүүлэх (хөрөнгө оруулагчид бизнес эрхлэгчдийг холбоход чиглэсэн санал, туршлага солилцох платформыг бий болгох) арга хэмжээнүүдийг зохион байгуулах | 3 | | | | | | • Харилцаа холбооны сүлжээний нэг арга хэмжээ зохион байгуулсан байх | | ГХЯ, МҮХАҮТ<br>ҮХГ, Монголын гарааны бизнес, хувийн хэвшлийн холбоод |
| | 4.3.7. Гарааны бизнес эрхэлж буй ААН/компаниудад зориулж төлөвлөсөн харилцаа холбооны сүлжээний арга хэмжээг өргөжүүлэх уулзалт зохион байгуулж, боломжит үйлчлүүлэгчидтэй холбох мөн тодорхой салбарууд дахь тэдний зүгээс тавьж буй саналуудыг байр сууриа олсон ААН/компаниудад танилцуулах юм. | 1 | | | | | | • Жилд харилцаа холбооны сүлжээний нэг арга хэмжээг зохион байгуулсан байх | | ГХЯ, МҮХАҮТ<br>ҮХГ, Монголын гарааны бизнес, хувийн хэвшлийн холбоод |
| 4.4. Мэдлэг дамжуулах харилцаа холбоог сайжруулах | 4.4.1. Тэргүүлэх ач холбогдолтой салбаруудад төр, хувийн хэвшил болоод академи/боловсролын байгууллагуудын хамтран бий болгосон "Инноваци болон өсөлт" хэмээх салбар дундын хороонуудыг хөгжүүлэх. Хороонууд нь шаардагдах судалгаанууд зэрэг аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд шаардагдаж буй эн тэргүүний ач холбогдолтой арга технологийн мэдлэгийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн санал хүрэх. | 1 | | | | | | • Салбарын түвшинд комиссууд байгуулагдсан байх ба Ажил үүргийн удирдамжид үүрэг хариуцлагыг тодорхойлсон байх. | | МҮХАҮТ, инкубаторын төвүүд, их сургуулиуд |

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4: БИЗНЕС ЭРХЛЭХ УР ЧАДВАР, ГАРААНЫ БИЗНЕСИЙН ОРЧИН НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛЖ, МЭДЛЭГТ СУУРИЛСАН САЛБАРУУДРУУ НЭВТРЭХ ЗАМААР ИННОВАЦИ, БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ ХӨХИУЛЭН ДЭМЖИХ

| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэмбэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх бололцоотой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 4.4. Мэдлэг дамжуулах харилцаа холбоог сайжруулах | 4.4.2. ШУТИС-ийн лабораторит технологийн шинэчлэл хийхийн зэрэгцээ тодорхой бэрхшээлүүдэд анхаарлаа хандуулах үүднээс үндэсний инновацийн экосистем (ШУТИС-ийн судлаачдыг хамруулна) болон тус улсын тэргүүлэх салбаруудын (сүү цагаан идээг оруулна) хоорондын хамтарсан судалгааны болон хөгжлийн төслүүдийг дэмжих төлөвлөгөө бий болгох.<br>Судалгааны гол хэсэг нь ХХОЗЗ-ийн тэргүүлэх ач холбогдолтой салбаруудтай уялдана. Үр дүнг нь мэдээлэл холбооны сүлжээ, их сургуулиуд болон хувийн хэвшлийн ажлын хэсгүүдээр дамжуулан тараах. Тодорхойлсон шийдлүүдээ үлгэр жишээ санаачилгуудаар дамжуулан хэрэгжүүлэх. | 2 | | | | | | • Хөтөлбөрөө боловсруулсан байна<br>• ШУТИС-ийн лабораториудыг шинэчилсэн байна<br>• Жилд ХХОЗЗ-ийн тэргүүлэх салбар тус бүрээр 8, судалгааг дэмжсэн байна<br>• Жилд хүлээн авсан судалгаатай холбогдох 2 туршилтын төсөл | | БСШУЯ ГХЯ<br>МҮХАҮТ, инкубаторын төвүүд, их сургуулиуд |
| | 4.4.3. ЖДҮ-үүдийг судалгааны байгууллагуудаас Судалгаа хөгжүүлэлттэй холбоотой судалгааны материалыг (Польш, Австри болон бусад орнуудын Инновацийн эрхийн бичгийг харах) худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгох | 2 | | | | | | • Санхүүгийн механизм бий болгосон байх | | Сангийн яам, БСШУЯ<br>ГХЯ, МҮХАҮТ, инкубаторын төвүүд, их сургуулиуд |
| | 4.4.4. Хувиараа бизнес эрхлэхэд үзүүлдэг дэмжлэгийг сайжруулах, судалгааг түгээх, оюуны өмчийн эрхүүдийн талаар сургалт зохион байгуулах, технологийн шийдэл олохын тулд ажилтан авах, гэрээлэх эсхүл хамтарсан компани байгуулах сонирхолтой компаниудтай танилцах зэрэг зорилгоор Инкубаторууд, старт-аппыг санхүүжүүлэгч, хувиараа аж ахуй эрхлэх санаачлагууд, Монгол Улсын Оюуны өмчийн газар (ОӨГ) зэргийг хамаарсан технологи, инновацийг дэмжих сүлжээ байгуулах. | 3 | | | | | | • Сүлжээ бий болсон байх<br>• Улирал тутам уулзалтууд зохион байгуулсан байх | | БСШУЯ ба ОӨГ<br>ГХЯ, МҮХАҮТ, инкубаторын төвүүд, их сургуулиуд |
| | 4.4.5. Тус улсын судалгааны их сургуулиудад зориулан оюуны өмчийн өмчлөлийн талаарх бодлого боловсруулж, улмаар иргэдэд нээлт хийх болон хийсэн нээлтээ эдийн засгийн эргэлтэнд оруулах урам зориг өгөх. | 3 | | | | | | • ШУТИС болон бусад судалгааны байгууллагуудад шинэ бодлого баталсан байна | | БСШУЯ<br>ШУТИС, ОӨГ |
| | 4.4.6. Гадаадын түншүүдтэй инновацын хөгжил бий болгохын тулд тусгай семинарууд болон солилцооны хөтөлбөрүүдээр дамжуулан мэдлэг хуваалцах үйл ажиллагаа, технологи дамжуулалт болон хамтын ажиллагаар хөхүүлэн дэмжих. | 2 | | | | | | • Олон улсын судалгааны төвүүдтэй 2 Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан байх /яг ямар мэдлэг хуваалцах, ямар технологи дамжуулах зэргийг тусгах/ | | БСШУЯ<br>ГХЯ, МҮХАҮТ, инкубаторын төвүүд, их сургуулиуд |
| | 4.4.7. Хангаан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч болон хамтарсан компани байгуулах сонирхолтой дотоодын ААН/компаниудыг гадаадынхантай холбох хөтөлбөрийг Үндэсний хөгжлийн газарт бий болгох (жишээ нь дотоодын хүнсний нийлүүлэгчийг гадаадын сүлжээ зочид буудал, Мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэгчдийг гадаадын томоохон ААН/ компаниудад) | 1 | | | | | | • Хангаан нийлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгч дотоодын ААН/компаниуд болон гадаад хамтрагч нарын талаарх мэдээллийн санг үүсгэсэн байна.<br>• ҮХГ цахим порталаар дамжуулан гадаадын хөрөнгө оруулагч нарт мэдээллийн санг нээлттэй болгосон байна. | | ҮХГ<br>ГХЯ |
| | 4.4.8. Засгийн газрын урт хугацааны алсын хараа дэмжих үүднээс мэдээ, сонин, олон нийтийн сүлжээ болон академийн форумуудаар дамжуулан Монгол Улсын хөгжлийг хурдасгахад гадаадын шууд хөрөнгө оруулалт хэрэгтэй тухай олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх олон жилийн аянг зохион байгуулж бусад эдийн засгийн туршлагыг хуваалцах мөн Монгол Улсын өөрийн амжилтын түүхийг олон нийтэд сурталчлах. | 2 | | | | | | • Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тухай олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх хэд хэдэн жилийн аянг зохион байгуулсан байна. | | ҮХГ<br>ГХЯ |

| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4: БИЗНЕС ЭРХЛЭХ УР ЧАДВАР, ГАРААНЫ БИЗНЕСИЙН ОРЧИН НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛЖ, МЭДЛЭГТ СУУРИЛСАН САЛБАРУУДРУУ НЭВТРЭХ ЗАМААР ИННОВАЦИ, БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ ХӨХИУЛЭН ДЭМЖИХ | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны зорилтууд | Үйл ажиллагаанууд | Эрэмбэ 1=их 2=дунд 3=бага | Хэрэгжүүлэх хугацаа | | | | | Хүрэх үр дүн | Хэрэгжиж буй хөтөлбөр эсхүл дэмжлэг үзүүлэх бололцоотой төсөл | Хэрэгжилтийг хангахад тэргүүлэх үүрэгтэй болон дэмжлэг үзүүлэх байгууллагууд |
| | | | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | | | |
| 4.5. Мэдээллийн технологи, технологийн инноваци, цахим худалдаа болон бусад мэдлэг дээр суурилсан үйлчилгээ-нүүдийн олон улсын манлайллыг идэвхитэй эрэлхийлэх | 4.5.1. Төрийн худалдан авалтыг хийх замаар мэдээллийн технологийн бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний өргөн зах зээлийг бий болгож, Засгийн газрыг яаралтай цахим 3Г болон өргөтгөсөн төрийн үйлчилгээ рүү чиглүүлэн хөгжүүлэх (жишээ нь төрийн зүгээс олон нийтийн үнэгүй Вай Фай цэгүүд) | 2 | | | | | | • Цахим Засгийн газар луу чиглүүлсэн үндэсний хөтөлбөрийг боловсруулан баталсан байх | | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар |
| | 4.5.2. Мэргэжлийн сургалтын байгууллагууд, тусгай дэд бүтэц, тэтгэмж бүхий инновацын төв болон нэг цэгт зангидсан, хамтын ажиллагааны байршил дээрхи салбарын нэмэлт урамшуулал зэргийг нэг доор багтааж буй эдийн засгийн онцгой бүс байгуулсанаар салбарын өсөлтийг дэмжих. Мэдээлэл, Технологийн Үндэсний Паркаас сурсан туршлагад суурилах | 3 | | | | | | • Эдийн засгийн онцгой бүс байгуулагдсан байх | СиАйТиЭй (CITA) (Азийн хөгжлийн банк) | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар |
| | 4.5.3. Бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх технологи болон инженерийн их сургуулиудыг Монгол Улсад салбараа байгуулах талаар санал тавьж, байгууллагын үйл ажиллагаа, маркетингийг дэмжих бүх талын туслалцаа үзүүлэх санал тавих. | 2 | | | | | | • Олон улсын технологи, инженерийн их сургуулиудтай 2 Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан байна | | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, БСШУЯ |
| | 4.5.4. Ирээдүйд голлох салбаруудад ажиллах Монгол Улсын ажилтнуудыг бэлтгэх зорилгоор бага дунд, ерөнхий боловсролын болон Техник, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагуудад тухайн улсын сургуулиудад шаардлагатай сургалтын хөтөлбөр (компьютер болон мэдээллийн шинжлэх ухааныг хамруулна), тоног төхөөрөмж (бүх сурагчдад компьютер, ширээ хүрэлцээтэй байх) болон дэд бүтцийг (бүх хичээлийн өрөөнүүд өндөр хурдны интернеттэй байх) үйл ажиллагаатай уялдуулан санал болгож, мэдээллийн технологийн боловсролын ач холбогдол, түвшинг нэмэгдүүлнэ. | 2 | | | | | | • Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн, хэрэгжүүлсэн байна<br>• Хичээлийн өрөөний хэрэгслүүд байршсан байна<br>• Хичээлийн өрөө тус бүрт өндөр хурдны интернет | | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, БСШУЯ |
| | 4.5.5. Оюуны өмчийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг дэмжих тодорхой санал боловсруулах. Улсын байцаагчдийн чадавхийг нэмэгдүүлэх, Оюуны өмчийн зөрчлийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг саналд тусгах. | 3 | | | | | | • Санал боловсруулж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна | | ОӨГ<br>ГХЯ, МҮХАҮТ, ҮХГ |
| | 4.5.6. Бие даасан, дэвшилтэт инженерийн сургууль байгуулах тухай ШУТИС-ийн төлөвлөгөөнд дэмжлэг үзүүлэх. | 2 | | | | | | • Элсэлт, сургалтийн хөтөлбөр, удирдлага, санхүүжилт гэх мэт дэмжлэг үзүүлэх шаардлагатай салбарын талаар төлөвлөгөө гаргах | | БСШУЯ ШУТИС |
| | 4.5.7. Судалгааны төвүүд, инкубатор болон инновацийг дэмжих төвүүдэд Оюуны өмчийн эрхийн талаар сургалтын курсууд боловсруулж, явуулах. ялангуяа ШУТИС-д холбогдох сургалтыг явуулж буй багш нарын сайжруулах шаардлагатай чадавхийг тогтоох. Тэдгээрийг сайжруулах хөтөлбөр боловсруулах. | 3 | | | | | | • Сургалтыг жил бүр зохион байгуулсан байна.<br>• Боловсон хүчнийг чадавхижуулсан байна | | ОӨГ<br>ГХЯ, МҮХАҮТ, инкубаторын төвүүд, их сургуулиуд |





Photo: ©Ministry of Foreign Affairs

# ХАВСРАЛТ: МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ХЯЗГААРЛАЛТУУД (3С ХАМРАХ ХҮРЭЭ)

Монгол Улсын экспортын салбарын өрсөлдөх чадвар нь компаниудын чадавх, байгууллагын дэмжлэг болон үндэсний бизнесийн орчин зэрэгтэй холбоотой хэд хэдэн хүчин зүйлсээр хязгаарлагддаг. Монгол Улсын экспортын хөгжил, хөрөнгө оруулалтын дэмжлэгийг саарулж буй өрсөлдөөний чадварын гол хязгаарлалтуудыг 3С хамрах хүрээнд тусгасан болно. Хязгаарлалтуудын 3 хэсгийг дор харуулав. Үүнд:

- Өрсөлдөх: Дотоодын ба гадаадын зах зээлд өрсөлдөх үндэсний чадавхийг хязгаарлаж буй асуудлууд. Үүнд, түүхий эдийн хүртээмж, бүтээмж, бизнесийн ур чадварууд болон үндэсний дэд бүтцийн дэмжлэг зэрэгтэй холбоотой сорилтуудыг хамаардаг.
- Холбох: Ханган нийлүүлэгч, үйлчлүүлэгч ба зах зээлийн харилцаа холбоог хязгаарлаж буй асуудлууд. Үүнд, зах зээлийн мэдээлэл, маркетинг болон худалдааны дэмжлэг, брэндинг болон худалдааны хэлэлцээртэй холбоотой сорилтуудыг агуулна.
- Өөрчлөх: Өөрчлөн буй чиг хандлагатай уялдуулан өөрчлөлт, шинэчлэлт хийх экспортын салбарын чадавхийг хязгаарлаж буй асуудлууд. Үүнд, дадлагажсан/ур чадвартай ажиллах хүчний хүртээмж, оюуны өмчийн хамгаалал, шинэчлэл хийх талаар байгууллагын дэмжлэг, хөрөнгө оруулалтын дэмжлэг болон хамгаалал, компанийн нийгмийн хариуцлага болон залуучууд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт зэрэгтэй холбоотой сорилтууд хамаарна..

## ӨРСӨЛДӨХ

Түүхий эдийн хүртээмж нь таварлах боломжгүйгээс гадна ихэнхдээ хангалтгүй хэмжээтэй байдаг. Уул уурхайн бус салбарын Монгол компаниудын нэлээд хэсэг нь (39%) түүхий (чанартай) эдийн таслахгүй байхад бэрхшээлтэй тулгардаг тухайгаа мэдээлсэн байна (Европын холбооноос Монгол Улсын худалдаанд дэмжлэг үзүүлэх төслийн судалгаа). Монгол Улсын уул уурхайн бус экспортын тэргүүлэгч салбар болох мал аж ахуйн салбар нь, салбарыг хамарсан тодорхой шийдэлгүй байгаа бөгөөд, зуд гэх мэт цаг уурын нөхцөлд маш эмзэг байдаг. Түүхий эдийн шатны үр дүнгүй байдал (тухайлбал, газар, бэлчээрийн нөхцөл, тэжээл, ус, технологийн шилжилтэд шаардлагатай үйлчилгээ болон судалгаа хязгаарлагдмал, зах зээлийн дэд бүтэц, ложистик сул, санхүүгийн хүртээмж хязгаарлагдмал) зэрэг хүчин зүйлсээс хамаарч бүтээмж өндөр биш байдаг.

Дэд бүтэц дутмаг, засвар үйлчилгээ хангалтгүй, мөн бүтээгдэхүүнтэй зөв харьцаагүйн улмаас их хэмжээний боловсруулалтын хорогдол гардаг. Энэ нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын нөөц бололцоог тодорхой хэмжээгээр хязгаарладаг. Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хангалтгүй, хөргөлттэй дэд бүтцийн сүлжээ сул, байгаль цаг уурын нөхцөл болон сайн туршлагын талаарх мэдлэг муу зэрэг тусгайлсан хязгаарлалтуудыг хамаардаг.

Чанар болон эрүүл ахуйн хорио цээрийн асуудлууд нь экспортын өрсөлдөх чадвар ба зах зээлийн төрөлжилтийг хязгаарладаг. Монголын гол бүтээгдэхүүнүүд нь чанар болон эрүүл ахуйн асуудлаас хамаарч олон улсын зах зээл дээр өрсөлдөөний нөөц бололцоондоо хүрч чаддаггүй. Тэр дундаа дотоодын хүнсний үйлдвэрлэл нь олон улсын аюулгүй байдлын стандартыг хангаж чаддаггүй бөгөөд улмаар импортын хүнсний бүтээгдэхүүнээс ихээхэн хамааралтай байдалд оруулдаг. Аймаг хоорондох малын хөдөлгөөний хяналт байдаггүй, вакцины чанар,

хэрэглээний хяналт сул, хүнсний аюулгүй байдлын талаарх малчдын мэдлэг, сонирхол хангалтгүй, технологийн хэрэглээ доогуур зэрэг нь үндсэн шалтгаан болж байна. Аж ахуй эрхлэгчийн хувьд үндсэн шалтгаан нь, зах зээлийн мэдээлэл болон экспортлогчдод үзүүлэх дэмжлэг хангалтгүйгээс улбаалсан бүтээгдэхүүний техникийн шаардлагын талаарх ойлголт муу байдагтай холбоотой.

Техникийн зохицуулалт, стандартыг мөрдөж ажиллах нь экспортын зардлыг нэмэгдүүлдэг.

Олон улсын итгэмжлэгдсэн лабораторид хандах боломж хязгаарлагдмал, бусад улстай байгуулсан тохирлын үнэлгээний гэрээ байдаггүйн улмаас Монгол Улсад хийсэн баталгаажуулалтыг гадаад улсуудад хүлээн зөвшөөрдөггүй. Иймээс олон салбаруудад экспортлогч нар нь олон улсын стандартыг мөрдөж ажиллах, улмаар зах зээлээ өргөжүүлэх боломжгүй байдаг. Экспортлогчид Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ)-ыг үйл ажиллагааг удаан, экспортын зөвшөөрөл гаргахад их хүлээлгэдэг хэмээн шүүмжилдэг. Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) Үндэсний чанарын хөтөлбөр боловсруулсан байна. Гэвч байгууллагын чадавх сул, нөөцийн хязгаарлагдмал байдал нь сорилт хэвээр байгаа бөгөөд энэ нь олон улсын стандарттай нийцэх үндэсний стандартыг боловсруулж хэрэгжүүлэх СХЗГ-ын чадавхийг хязгаарлаж байна. Үүний улмаас компаниуд гадаадын стандартыг тодорхой тохиолдлуудад мөрдөж байна.

Бизнес эрхлэх дэмжлэг сул ба эдийн засгийг төрөлжүүлэх талаар үндэсний нэгдсэн алсын хараа байхгүй.

Бодлогын үүднээс авч үзвэл төрөөс ЖДҮ-д санхүүжилтийн боломж олгох замаар шинэ санаачилга, бизнес эрхлэлтийг урамшуулах тодорхой арга хэмжээ авсан хэдий ч, бизнес эрхлэлтийг ил тодоор дэмжсэн хууль байхгүй байна. Хамтын ажиллагаа сул, худалдаатай холбоотой асуудлуудыг төрийн бодлого, хөтөлбөрт тусгах явц хангалтгүйн улмаас экспортын хөгжил, төрөлжүүлэлтийг дэмжих орчин нөхцөлийг үүсгэх боломжийг хязгаарлаж байна. Энэ нь экспортыг дэмжих чиг үүргийг өөр яамдад тогтмол шилжүүлж, бусад төрийн бус байгууллага эсхүл хувийн хэвшлийн оролцоог хангаагүйгээс шалтгаалсан. Түүнчлэн, эскпортыг төрөлжүүлэхтэй холбоотой хүчин чармайлтыг удирдах, зааварчилгаа өгөх үүрэгтэй экспортод дэмжлэг үзүүлэх байгууллага байдаггүй.

Бизнес эрхлэлтийн индекмээр Монгол Улс нь бусад улсын эдийн засагтай харьцуулвал доогуур зэрэглэлтэй байгаа бөгөөд үйл ажиллагаа нь тогтворгүй байна.

Хэдийгээр тус улс нь зарим үзүүлэлтээр зохистой түвшинд байгаа боловч, цахилгаан эрчим хүч авах, хил дамнасан худалдаа, төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэх болон гэрээг биелүүлэх зэрэг асуудлаар дийлэнх улсын хойно эрэмбэлэгдэж байна. Монгол Улсын гүйцэтгэл нь 2017 онд сайжирсан боловч, доогуур эрэмбэлэгдсээр байгаа нь тус улсын хувийн хэвшлийн салбарын хөгжил доогуур байгаатай шууд холбоотой. Эрчим хүчний хүртээмж, хил дамнасан худалдаа хийхэд хялбар байдал нь гарааны бизнесийн тоо доогуур болон татварыг тшинээр бизнес эрхлэх үзүүлэлт бага, татвар төлөхөд хөнгөлөлт үзүүлэх зэрэг нь Монголөлбөрийг хоцроохоод амархан байдал зэрэг нь өрсөлдөх чадварын сорилтуудыг үүсгэж байна. Гэрээний хэрэгжилт хангалтгүйн улмаас тус улсын бизнесийн орчинд бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдын итгэх итгэлийг алдагдуулна.

# УЯЛДАА ХОЛБООГ ХАНГАХ

Тээвэрлэлтийн дэд бүтэц сул байгаа нь эдийн засгийн өсөлтөд саад учруулдаг.

Монгол Улсын үеэ өнгөрөөсөн тээвэрлэлтийн дэд бүтэц нь далайд гарцгүй улсад тулгардаг асуудлыг улам ч хүндрүүлдэг. Хэдийгээр тус улсын Ложистикийн гүйцэтгэлийн индекс (ЛГИ) нь 2014 онд 135 байснаас 2016 онд 108 болж сайжирсан боловч, Монгол Улс нь дэд бүтэц, олон улсын тээвэрлэлт болон тээвэрлэлтийн чанар, өрсөлдөх чадварын байр ухарсан байна.

Монгол Улсыг Хятад болон Орос улсуудтай холбодог төмөр зам нь 1949–1955 оны хооронд баригдсан ба техник, бүтцийн шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай тулсан боловч төмөр замын салбар дахь хөрөнгө оруулалт бага байгаа нь түүнийг шинэчлэх боломж олгохгүй байна. Энэ нь улмаар Монгол Улсын Хятад болон Орос улсуудын хоорондох транзит коридор болох нөөц бололцоог үгүй хийж байна. Хамтын ажиллагаа хангалтгүй байгаа нь Монгол Улсын тээвэрлэлтийн салбарын хөгжлийг зогсонги байдалд оруулж байна.

Гаалийн бүрдүүлэлтийн хэт их шаардлагууд нь Монгол Улсын гадаад уялдаа холбоог хязгаарлаж байна. Монгол Улс нь хил дээрх хүнд суртал, гааль дээр экспортын баримт бичгийн бүрдүүлэлт болон журмуудтай холбоотойгоор экспортын зардал, экспортлох хугацаа нэмэгдэх зэрэг гадаад худалдааны боломжийг хязгаарлагч хэд хэдэн сорилттой тулгараад байна. Энэхүү удаан ажиллагаа нь гэрчилгээг гараар олгодог байдал, зохистой хяналт шалгалтын төхөөрөмж хангалтгүй, бэлтгэгдсэн ажилтнууд дутмаг зэрэг шалтгаанаар тайлбарлагдана. Экспортлогч компаниуд нь гааль дээр харилцааны ихээхэн хүндрэлтэй тулгардаг ба энэ нь ихэвчлэн баримт бичиг, дүрэм журам, дагаж мөрдөх шаардлагуудыг ойлгож хэрэгжүүлэхтэй холбогдон үүсдэг.

ЭЗТХ/ЧХХ дутагдалтайн улмаас Монголын ЖДҮ нар олон улсад танигдаж чаддагүй. Одоогоор Монгол Улс нь Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг (ЭЗТХ) зөвхөн Япон Улстай байгуулаад байна. Худалдаатай холбоотой хууль эрх зүйн орчин Монгол Улсад дутагдалтай байна. Засгийн газрын мэдээлснээр Монгол Улс нь ашиггүй нөхцөлтэйгээр ДХБ-ын гишүүн болсон нь тус улсын ирээдүйн хэлэлцээрүүдэд нөлөөлж байгаа ажээ. Иймээс хэлэлцээрүүд нь харилцан ашигтай байх нь ховор бөгөөд Япон Улстай байгуулсан ЭЗТХ нь хүлээгдсэн үр дүнг хараахан бий болгож чадаагүй байна. Энэ нь мөн Монгол болон Япон улсын холбогдох төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа муу байгаагаас үүдсэн экспортлогчдын мэдлэг сул байдалтай холбоотой байж болзошгүй.

Экспортлогчид Монгол Улсад олгосон зах зээлд нэвтрэх давуу эрхийг ашигладаггүй ба худалдааны үзэсгэлэн яармагт тогтмол оролцож чаддаггүй Монголын компаниудад худалдааны хэлэлцээр болон түүнээс бий болох боломжийн талаар мэдлэг хангалтгүй байдаг. Тухайлбал Европын холбооноос Монгол Улсын худалдаанд дэмжлэг үзүүлэх төслийн судалгаанд дурдсанаар оролцогчдын 40% нь ЭЗТХ/ЧХХ-ийн үр ашгийн талаар мэддэггүй гэж хариулсан байна. Зах зээлд үр дүнтэйгээр нэвтрэхэд саад учруулж буй өөр нэг хязгаарлагч хүчин зүйл нь Монгол компаниудын гадаад хэрэглэгч, агент болон дистрибютортой харилцан үр ашигтай гэрээ байгуулах чадваргүй байдал юм. Зарим Монгол бизнес эрхлэгчид гэрээгээр ашиггүй нөхцөл байдал үүссэн эсвэл нөгөө талдаа хэт ашигтай нөхцөл байдлыг бүрдүүлж байсан гэж үздэг байна.

Олон улсын зах зээлд нэвтрэх шаардлагын талаарх хязгаарлагдмал мэдлэг нь экспортын хөгжлийг сааруулдаг Хэрэглэгчийн шаардлагыг ойлгоно гэдэг нь зайлшгүй анхаарах асуудал бөгөөд үүнийг ойлгоогүй тохиолдолд экспортын нэг хязгаарлалт болдог. Жижиг бизнес эрхлэгчид нь санхүүжилтгүйн улмаас гадаад зах зээлд хэрэглэгчийн судалгаа хийх зэргээр зах зээлийн судалгаа хийх боломжгүй байдаг. Европын холбооноос Монгол Улсын худалдаанд дэмжлэг үзүүлэх төслийн судалгаанд дурдсанаар, таван оролцогчийн нэг нь гадаад зах зээлийн судалгааг ховорхон эсхүл огт хийж үзээгүй байжээ. Мөн түүнчлэн, Монгол компаниудын дийлэнх нь ISO22000 Эрүүл ахуй, аюулгүйн шаардлага гэх мэт тэдгээрийн бүтээгдэхүүнд олон улсад тавигдах техникийн шаардлагыг ойлгохгүй байсан.[74] Иймд экспортлогчид нь эдгээр стандартыг хэрэгжүүлдэггүйгээс тэдний бүтээгдэхүүнийг аюулгүй байдлын шалтгаанаар тодорхой зах зээлд нэвтрүүлэхээс татгалздаг.

Сурталчилгааны үйл ажиллагаа дутагдалтай байдаг нь Монголын бүтээгдэхүүнүүд гадаадад танигдах боломжийг хязгаарладаг Зах зээлийн ерөнхий стратегийн дутагдалтай байдал, гадаад худалдааны үзэсгэлэн худалдаа, чуулга уулзалтад оролцоо байхгүй байх, гадаад зах зээлд танигдсан үндэсний брэнд ховор байдгийн улмаас Монголын экспортын нөөц бололцоо нь хязгаарладдаг. Экспортыг нэмэгдүүлэхэд Засгийн газар нь тодорхой стратеги, төсөв, Монголын үйлдвэрлэлийг таниулан сурталчлах үйл ажиллагааны төлөвлөгөөгүйгээр бэрхшээлтэй тулгарах болно. Мөн түүнчлэн дэлхийн хамгийн том бэлчээрээс ноолуур үйлдвэрлэл гэх мэтээр Монголын онцлог шинж чанаруудыг товойлгосон үндэсний маркетинг болон брэндингтэй холбоотой хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт дутагдалтай байна. Монголын бүтээгдэхүүний маркетинг болон брэндингийн асуудлыг хариуцан анхаарах байгууллагатай байвал компаниуд зөвхөн бүтээгдэхүүн үйлдвэрлэлдээ анхаарах боломж бүрдэнэ гэсэн саналыг компаниуд илэрхийлдэг.

Бизнесийн үйлчилгээний хүрэлцээ болон чанарыг сайжруулах шаардлагатай. Бизнесийн үйлчилгээг хувийн хэвшлийн холбоодоор төвлөрүүлэх нь Улаанбаатар хотоос гадна байрлах компаниудад хүрэх дэмжлэгийг хязгаарладаг. Ийнхүү үйлчилгээг төвлөрүүлэх явдал нь зөвхөн МҮХАҮТ-аар хязгаарлагдахгүй бөгөөд, Монголын бизнесийн зөвлөл, СиИӨү Клуб болон бусад олон салбарын холбоод зэрэг Монгол Улсын бүхий л бизнесийн

холбоодод ажиглагдаж байна. Үйлчилгээний чанарын хувьд, яам, агентлагууд хангалттай түвшнээс доогуур түвшинд ажилласан байна.[75] Засгийн газар болон хувийн хэвшлийн салбарууд хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгаа нь төр болон хувийн хэвшлийн салбаруудын аль алинд нь хөрөнгө нөөц хүрэлцээгүй, Засгийн газар нь худалдааны багцын дутагдалтай байхад нөлөөлж байна.

# ӨӨРЧЛӨХ

Монгол Улсын хөрөнгө оруулалтын бодлого нь ихэнхдээ өөрчлөгдөж, тааварлах боломжгүй бизнесийн орчинг үүсгэж байсан. Монгол Улс нь хөрөнгө оруулалтыг дэмжсэн бодлоготой үеийг гэнэт хөрөнгө оруулалтын эсрэг байр суурь болгон өөрчилж, бизнесийн орчинг тааварлашгүй болгож байв. Энэ нь Засгийн газар ойр ойрхон солигддогоос шалтгаалсан төрийн бодлогын өөрчлөлтийн үр дүн юм. Улс төрийн болон бодлогын тогтворгүй байдал нь хөрөнгө оруулагчдыг үргээгээд зогсохгүй, Засгийн газар урт хугацааны хөрөнгө оруулалтын стратегийн үр дүнг хүртэх, тухайн стратегийг хэрэгжүүлэх хангалттай чадавх бий болгох боломжгүй байдалд хүргэдэг. Засаглал, Ил тод байдал хангалттай бус бөгөөд [зарим тохиолдолд] засгийн газрын зүгээс дур мэдэн арга хэмжээ авдаг зэрэг нь тус улс дахь хөрөнгө оруулагчдын хувьд хурцадмал асуудал юм. Дэлхийн банкны хөрөнгө оруулагчдын судалгаанд дурдсанаар оролцогчдын 80 орчим хувь нь хөрөнгө оруулагчдын хамгаалалт байхгүйн улмаас тус улсад оруулсан хөрөнгө оруулалт нь буцаж гарах эрсдэлтэй гэж үзсэн байна.

Монгол Улсад бүтээмжид чиглэсэн хөрөнгө оруулалт бага түвшинд байгаа нь хөрөнгө оруулалтын өрсөлдөх чадвар догуур байгааг харуулж байна. Монгол Улс нь ГШХО-ынхаа дийлэнх хувийг цөөн хэдэн улсаас, цөөн хэдхэн салбарт авдаг нь тус улсыг эдгээр эдийн засаг, салбаруудын хэтийн төлөвөөс шууд хараат, эмзэг болгож байна. Эдийн засгийн төрөлжүүлэлт хангалтгүй байгаа нь Монголын өрсөлдөх чадварын сул байдлын илрэл бөгөөд ГШХО-ын тогтвортой бус орчин үүсгэж, бүтээмжид суурилсан хөрөнгө оруулалтын урсгалыг хязгаарладаг. Ийм хөрөнгө оруулалт нь компаниуд зах зээлд үр дүнтэйгээр нэвтэрч, үйл ажиллагаагаа өргөжүүлэн, дотоодын, бүс нутгийн болон гадаад эдийн засагтай илүү сайн холбоо үүсгэх боломжтой бизнесийн орчинг шаарддаг.

Монгол Улсад хөрөнгө оруулалтын сурталчилгааны чиг үүрэг бүхий байгууллага байхгүй. Хөрөнгө оруулалтын газрын чиг үүргийг Үндэсний хөгжлийн газарт шилжүүлсэн нь хөрөнгө оруулалтын сурталчилгаанд өгөх ач холбогдлын зэрэг буурсан үйл явдал болсон. ҮХГ нь сурталчилгаа, дэмжлэг үзүүлэгчээс илүүтэйгээр зохицуулагч болон зохион байгуулагчийн үүрэг гүйцэтгэдэг. ҮХГ-ийн хөрөнгө оруулалтын сурталчилгааны баг нь цөөн орон тоотой бөгөөд зорилтот сурталчилгааны үйл ажиллагаанаас илүүтэйгээр, ихэвчлэн олон нийттэй харилцах болон ҮХГ-ыг сурталчилах чиглэлд ажиллаж байна. 2018 оны 11-р сард тус ҮХГ-ын шинэчилсэн бүтцээр "Хөрөнгө оруулалтын дэмжлэг, сурталчилгааны хэлтэс" буюу хөрөнгө оруулалтыг татах, сурталчилах үүрэг бүхий хэлтэс байгуулагдсан байгаа бөгөөд даргыг нь томилж байгаа юм байна. Мөн түүнчлэн, сурталчилгааны хэлтэс нь даргагүй байсан бөгөөд төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалтын журмаар ажилд авахдаа тэднийг ажлын туршлага, ур чадварт нь бүрэн дүүрэн үндэслэн ажилд авч чадаагүй тохиолдлууд байгааг харуулж байна. Үүнтэй адилаар ҮХГ-ын хөрөнгө оруулалтын дараах үйл ажиллагаа нь одоо байгаа хөрөнгө оруулагчдад, хүсэлтийн дагуу мэдээлэл өгөх түвшинд хязгаарлагдаж байна. Иймээс, хариуцсан яамд нь ҮХГ-ын нөлөөлөл бага гэж харж байна.

Төрийн өмчийн компаниуд нь хувийн хэвшлийн хөгжлийг саатуулдаг. Засгийн газар банк санхүү, эрчим хүч, уул уурхай болон тээврийн салбарт ТӨК ажиллуулсан хэвээр байна. Эдгээр ТӨК нь гадаад болон дотоодын хувь хөрөнгө оруулагч нараас илүү таатай нөхцөлд ажилладаг тул хувийн хөрөнгө оруулалтыг шахан гаргаж болзошгүй. Хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй ҮХГ нь төр, хувийн хэвшлийн түншлэл болон концессийг зохион байгуулах, хэлэлцээр хийх, сурталчлах чадавхийн дутагдалтай байна. Энэхүү чадавхийн хязгаарлалтын улмаас, (тухайлбал ашигт малтмалын боловсруулалтын салбарт) хувийн хэвшлийн концессоос илүүтэйгээр, ТӨК-ийг ашиглах шинэ хандлага бий болоод байна. Энэ нь эргээд монополь тогтоход хүргэж байна.

[74] ЕХ-ТиАрЭйЭм (2018). Гол асуудлууд болон экспортын хөгжилд дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлагыг тогтоох зорилгоор ЖДҮЖДҮ экспорт хийхэд олдох боломж, тулгардаг хязгаарлалтуудын талаарх судалгаа (Эцсийн төсөл)
[75] ЕХ-ТиАрЭйЭм Судалгаа (2018)

ЖДҮ нарт бизнесээ тогтвортой явуулах, өргөжүүлж хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай эргэлтийн хөрөнгө эсхүл зээл авах боломж хомс байна. Одоогоор ЖДҮ-ийн 16% нь зээлтэй байгаа бөгөөд тэдгээрийн 95% нь ирээдүйд зээл тоног төхөөрөмж авах эсхүл эргэлтийн хөрөнгийн хэрэгцээгээ хангах зорилгоор авах хүсэлтэй талаараа мэдээлснээс үзэхэд санхүүжилтийн хэрэгцээ өндөр байна.[70] Европын Холбооноос хэрэгжүүлж буй Монголын худалдааг дэмжих төслийн судалгаанд оролцогчдын дийлэнх хэсэг нь экспорттой холбоотой санхүүжилт авахад хүндрэлтэй байдагийг илэрхийлжээ. ЖДҮ нар, нэн ялангуяа, эмэгтэйчүүдийн өмчлөлтэй ЖДҮ-ийг зээлийн өндөр эрсдэлтэй бүлэгт хамааруулж үздэг.[71] Мөн түүнчлэн, Монгол Улс нь бизнесийн хөрөнгө оруулалтын зардалтай холбогдон төлсөн НӨАТ-ийг суутган тооцдоггүй нь татвар төлөлтийг илүү бэрхшээлтэй болгосон. Энэ өөрчлөлт нь бизнес эрхлэлтийг улам хүндрэлтэй болгосон.[72]

Бүтээлч байдал хязгаарлагдмал, оюуны өмчийн хамгаалалт сул байдал ба шинэ, илүү цогц бүтээгдэхүүн. Бизнесүүд нь бүтээлч шинж чанарын дутагдалтай бөгөөд шинэ, цогц бүтээгдэхүүн болгоомжлолтой ханддаг[73] нь бүтээгдэхүүний хөгжүүлэлт доогуур байхад нөлөөлдөг. Монголын бизнес эрхлэгчдийн дунд бүтээлч байдлын түвшин доогуур байгаагийн зарим шалтгаан нь СХ-д хөрөнгө оруулдаагүй, шинэ нээлт ба мэдлэгийг түгээх, хүлээн авах хоорондын холбоо сул байгаад оршино. Шинжлэх ухааны байгууллагын чанар доогуур, үйлдвэрлэл, шинжлэх ухааны салбар хоорондын хамтын ажиллагаа СХ-ийн ажлын хүрээнд хязгаарлагдмал байгаа нь Монгол Улсад бүтээлч, инновацийн дутагдал үүсэхэд нөлөөлж байна.

Байгалийн нөөцийн хомсдол нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг эрсдэлд оруулж байна. Монгол Улс нь усны хүртээмж, хөрсний доройтол болон уур амьсгалын өөрчлөлтийг анхааралдаа авах шаардлагатай. Усны хомсдол болон усны чанарын асуудал нь Монголын голлох бүтээгдэхүүн үйлдвэрлэл, боловсруулалтад санаа зовоосон асуудал болоод байна. Хөрсний доройтол нь мөн анхаарал татсан асуудал болжээ. Монгол Улсын газар нутгийн дийлэнх хэсэг буюу 80 орчим хувийг бэлчээр эзэлдэг ба бэлчээрийн даац хэтрүүлсэн, ой модыг устгасан, бэлчээрийг газар тариаланд шилжүүлсэн зэргээс шалтгаалж, ойролцоогоор 70 хувь нь цөлжилтөд өртсөн байна.[74] Бэлчээрийн даац хэтрүүлэх нь ихэвчлэн газрын менежментийг муу хийснээс болдог бол мод бэлтгэл, гал түймрийн улмаас ой мод устаж байна.[1]

Хувийн хэвшлийн салбарын эрэлт, хэрэгцээнд нийцсэн ур чадвар бүхий ажиллах хүчний нийлүүлэлт бага байна. ЖДҮ-үүдийн зүгээс ур чадваргүй ажилтнууд хязгаарлалтын хүчин зүйл болж байгаа тухай мэдээлсэн. Монголын бизнесийн орчны судалгаанд (2017)[75] дурдсанаар маш олон компаниуд боловсруулалт, экспортын үйл ажиллагаанд шаардлагатай цогц ур чадвар, хэлний мэдлэг эзэмшсэн ажилтан олоход бэрхшээлтэй тулгардаг байна. Эдгээр судалгааны үр дүн нь Европын холбооноос Монгол Улсын худалдаанд дэмжлэг үзүүлэх төслийн судалгааны үр дүнтэй таарч байна. Тус судалгаанд дурдсанаар компаниудын 81% нь шаардлагатай ур чадвар эзэмшсэн ажилтан олоход хүндрэлтэй байдаг.

Хэдийн боловсролтой хүн амтай ч, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн түвшинд жинтэй өсөлт гарахгүй байна. Монгол Улсын нийт ажилгүй иргэдийн 17.4 хувийг залуучууд эзэлж, залуучуудын ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь Монголын эдийн засгийг туйлдуулж байна. Мөн түүнчлэн, хэдийгээр үр бүтээлтэй мэт харагдавч залуу хүн амын 25% нь боловсрол эзэмшээгүй, хөдөлмөр эрхлээгүй эсхүл мэргэжлийн сургалт (NEET)-д хамрагдаагүй байна. Ажлын байр бий болгох, эдийн засгийн өсөлт авчрахад хамгийн чухал хөдөлгөгч хүчнүүдийн нэг болох бизнес эрхлэлтийг хөгжүүлэх нь эдгээр асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой байж чадна. Гэвч 20-иод жилийн өмнөхөн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай байсны улмаас Монгол Улсад бизнес эрхлэлтийн соёл хөгжөөгүй байна.

---

[76]ОУСК (2018)
[77]ОУСК (2018)
[78]Дэлхийн банк (2019). Монгол Улс дахь бизнесийн шинэчлэл. Дараах холбоосноос үзнэ үү: http://www.doingbusiness.org/en/reforms/overview/economy/mongolia
[79]Government of Mongolia and the Millennium Challenge Corporation of the USA (2016). Mongolia constraints analysis: a diagnostic study of the most binding constraints to economic growth in Mongolia.
[80]АХБ (2016). Салбарын үнэлгээ (хураангуй): хөдөө аж ахуй, байгалийн нөөц баялаг ба орон нутгийн хөгжил. Түр хугацааны улсын түншлэлийн стратеги: Монгол Улс 2014-2016. Дараах холбоосноос үзнэ үү: https://www.adb.org/sites/default/files/linked-documents/icps-mon-2014-2016-ssa-01.pdf, хуудас 2
[81]МҮХАҮТ (2017) Монголын бизнесийн орчны судалгаа

# НОМ ЗҮЙ


СиБиАй Гадаад харилцааны яамд зориулан Экорн Туризм Консалтинг (2015). СиБиАй-н захиалсан судалгаа: Монгол Улс дахь соёлын аялал жуулчлал. Нидерланд Улс, Хааг хот.

АХБ (2016). Салбарын үнэлгээ (хураангуй): хөдөө аж ахуй, байгалийн нөөц баялаг ба орон нутгийн хөгжил. Түр хугацааны улсын түншлэлийн стратеги: Монгол Улс 2014-2016. Дараах холбоосноос үзнэ үү: https://www.adb.org/sites/default/files/linked-documents/icps-mon-2014-2016-ssa-01.pdf

Харилцаа холбоо ба мэдээллийн технологийн нөлөө (2017) – АйСиТи Товхимол'17

ЕСБХБ (2018). "Ноолуурын тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих нь"

Эдийн засгийн судалгааны институт (2018). Монгол Улс дахь ГШХО-ын урсгал – Тайлан

ЕХ (2016). Монгол Улс ХЕС+ Үнэлгээ - covering the period 2016 – 2017 оныг хамарсан Монгол Улсын тогтвортой хөгжил болон сайн засаглалын ('ХЕС+') үнэлгээний талаарх Европын холбооны Тусгай урамшууллын арга хэмжээ

ЕХ – Монголын худалдаатай холбоотой тусламж (2018) Survey of Opportunities and Barriers to Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам (2017). Монгол Улсын Байгаль орчны нөхцөл байдал 2015-2016

ХХААБ (2016). мал үржүүлгийн үйлчилгээний талаарх сургалт болон зөвлөгөөний өсөлтийн талаарх тайлан. Мал сүрэгт суурилсан амьжиргааг дэмжих нэгдсэн хөтөлбөр. ХХААБ/МОН/009/МОН

ХХААБ (2017). ХХААБ/ДХХ Монгол Улсын тариалан эрхлэлт ба мал аж ахуйн талаарх судалгаа – Тусгай тайлан

Д.Галсандорж (2018). Монгол Улсын экспортийн хөгжлийн хөтөлбөр (2018-2022)

Д.Галсандорж (2014). Монголын уул уурхайн бүтээгдэхүүн ба олон улсын худалдааны асуудлууд

Монгол Улсын Засгийн газар ба АНУ-ын Мянганы сорилтын сан (2016). Монгол Улс дахь хязгаарлалтуудын тухай дүн шинжилгээ: Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг хамгийн их хязгаарлаж буй хүчин зүйлсийн талаарх онош зүйн судалгаа.

ОУСК (2014), Монгол Улс дахь ЖДҮ ба Эмэгтэйчүүд эзэмшдэг ЖДҮ –Зах зээлийн судалгаа. Дараах холбоосноос үзнэ үү: https://www.ifc.org/wps/wcm/connect/d85f65804697b853a598bd9916182e35/Women+SME-Mongolia-Final.pdf?MOD=AJPERES

ОУСК (2018) Монгол Улсын Хөрөнгө оруулалтын шинэчлэлийн газрын зураг. Хөрөнгө оруулалтын бодлого, дэмжлэг үзүүлэх стратегийн шинэ үндэс суурь. Дараах холбоосноос үзнэ үү: https://www.ifc.org/wps/wcm/connect/f2a8f76b-16cf-4a63-a1ee-ffcd35f31d78/Mongolia+Investment+Reform+Map+2018.pdf?MOD=AJPERES

ОУХБ (2017). Залуучуудад зориулсан ажил, ур чадварууд: Монгол Улс дахь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодлогыг тоймлон үзэх нь

ОУВС (2015). Байгалийн нөөц баялгын тэсрэлтээс тогтвортой эдийн засгийн өсөлт рүү: Монгол Улсын туршлагууд

ОУВС (2018) Улсын тайлан. Өргөтгөсөн санхүүжилтийн хэлэлцээрийн дагуух 5 дахь тойм ба үзүүлэлтийн шалгуурын хэрэглээг өөрчлөх, татгалзах тухай хүсэлт —хэвлэлийн мэдээ; Улсын тайлан дугаар18/303 . Дараах холбоосноос үзнэ үү: https://www.imf.org/~/media/Files/Publications/CR/2018/cr18303.ashx

ОУВС (2018) Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын мэдээллийн сан, нэвтэрсэн 2018 оны 8-р сар

ОУХТ (2018): Худалдааны газрын зураг. http ://www.trademap.org/Index.aspx.

АйТиПиТиЭй (2016). Монгол Улсын мэдээлэл харилцаа холбоо технологийн хөгжил – Тайлан

Жефри Рийвс (2011). Монгол Улсын байгаль орчны аюулгүй байдал

ЖАЙКА (2017). Улсын хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт мэдээлэл цуглуулах асуулга

БНСУын олон улсын хамтын ажиллагааны агентлаг, Үндэсний мэдээллийн нийгэмлэг (2017). Монгол Улс дахь цахим засаглал ба мэдээлэл харилцаа холбоо технологийн төслүүдийн үндэсний мэдээлэлжүүлэлтийн үнэлгээ ба тодорхойлолт

КэйПиЭмЖи (2016). Монгол Улс дахь хөрөнгө оруулалт

Массачусетсийн Технологийн институт - Мэдээллийн лаборатори.

ГХЯ (2017). Монгол Оросын эдийн засгийн коридор: шинжлэх ухаан, технологийн парк байгуулах.

ГХЯ (2018). Монгол Улсын экспортын хөтөлбөр

ЭмАйСиСи (2017). Эрүүл мал, Монголын баялаг: Монгол Улсын бусад эрдэнэсийн авдрыг нээх нь

Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам (2014). Монгол Улс ногоон эдийн засагт шилжих ньg within SMEs to Identify Key Issues and Export Development Support Needs (Final draft)

МҮХАҮТ (2017) Монголын бизнесийн орчны судалгаа

Монголын махны холбоо (2016). Монголын махны үнэ цэнийг өсгөх үйл ажиллагааны нөхцөл байдлын дүн шинжилгээ

Монголын статистикийн мэдээллийн үйлчилгээ

ХААИС (2018). Монгол Улсын тогтвортой мал аж ахуй талаарх хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө (ХААИС)

Монгол Улсын Үндэсний статистикийн газар. 2011 оны хөдөө аж ахуйн тоо бүртгэл

ЭЗХАХБ (2016). Тойм: Монгол Улс дахь бичил, жижиг болон дунд хэмжээний бизнес эрхлэгчдэд зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь . Дараах холбоосноос үзнэ үү: http://www.oecd.org/eurasia/competitiveness-programme/eastern-partners/Eurasia-Peer-Review-Note-Mongolia-ENG.pdf

ПиДаблюСи (2015). Монгол Улсад бизнес эрхлэх удирдамж

Швейцарын хөгжил, хамтын ажиллагааны байгууллага (2014). Дотоод болон гадаад зах зээл дэх эрэлтийн талаарх судалгаа. Ногоон алт төсөл

ЭсИСиАйЭм (2016). Цагаан идээ боловсруулагчдын үндэсний зөвлөлийн нөхцөл байдлын дүн шинжилгээ

Монгол Улсын Их Хурлын тамгын газар (2016). 2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр

Монгол Улсын Их Хурлын тамгын газар (2016). Монгол Улсын тогтовортой хөгжлийн үзэл баримтлал 2030

Тогтвортой ноос ноолуурын эвсэл (2018). Сонирхогч талуудын уулзалтын тайлан. Хамтран ажиллаж тогтвортой, найдвартай ноолуурын нийлүүлэлтийн сүлжээ үүсгэх

АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын газар (2017). Монгол Улсын хөрөнгө оруулалтын нөхцөл байдлын талаарх мэдэгдэл

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (2013) Хөрөнгө оруулалтын бодлогын тойм – Монгол Улс. Дараах холбоосноос үзнэ үү: https://unctad.org/en/PublicationsLibrary/diaepcb2013d3_en.pdf

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (2017). Дэлхийн хөрөнгө оруулалтын тайлан 2017. Дараах холбоосноос үзнэ үү: https://unctad.org/en/PublicationsLibrary/wir2017_en.pdf

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (2019). Олон улсын хөрөнгө оруулалтын гэрээний чиг заагч

UniterraЮнитерра, ДабльюЮЭсСи, Канад (2016) Монгол Улсын ноос ноолуурын бүтээгдэхүүний үнэ цэнэ ба зах зээлийн тогтолцоонд хийсэн дүн шинжилгээний тайлан

Дэлхийн банк (2015). Хөдөө аж ахуйн үр ашигтай байдал ба маркетингийн тайлан

Дэлхийн банк (2015). Монгол Улсын хөдөө аж ахуйн шинэчлэл: Урагшлах зам. Монгол Улс –Хөдөө аж ахуйн салбарын товч дүгнэлт

Дэлхийн банк (2015). Монгол Улс - Хөдөө аж ахуйн салбарын эрсдэлийн үнэлгээ

Дэлхийн банк (2015). Дэлхийн банк Монгол Хөдөө аж ахуйн үр нөлөө, маркетингийн судалгаа

Дэлхийн банк (2017). Монгол махны үнэ цэнэ

Дэлхийн банк (2019), Бизнес эрхлэгчдийн талаарх асуулга, Mongolia – 2013. Дараах холбоосноос үзнэ үү: http://www.enterprisesurveys.org/data/exploreeconomies/2013/mongolia

Дэлхийн банк (2019). Монгол Улс дахь Бизнесийн шинэчлэл. Дараах холбоосноос үзнэ үү: http://www.doingbusiness.org/en/reforms/overview/economy/mongolia

Дэлхийн банк (2019). Дэлхийн банк Монгол Улсад. Дараах холбоосноос үзнэ үү: http://www.worldbank.org/en/country/mongolia/overview

Дэлхийн банк (2019). Дэлхийн банкны мэдээлэл. http://data.worldbank.org/

Дэлхийн эдийн засгийн форум (2018), Дэлхийн жендерийн тэгш бус байдлын тайлан 2018. Дараах холбоосноос үзнэ үү: https://www.weforum.org/reports/the-global-gender-gap-report-2018

Дэлхийн эдийн засгийн форум (2018). Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2017–2018 – дэлгэрэнгүй тайлан

Дэлхийн аялал жуулчлал ба аялал жуулчлаын зөвлөл,(2018). Аялал & Жуулчлал: Эдийн засгийн нөлөө 2018: Монгол Улс. Дараах холбоосноос үзнэ үү: https://www.wttc.org/-/media/files/reports/economic-impact-research/countries-2018/mongolia2018.pdf

ДХБ (2014). Худалдааны бодлогын тойм – Монгол Улс. WT/TPR/S/297